



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-34
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	35-186
<hr/>	
1. Хууль, тогтоолын төсөл эцэслэн батлах /Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/	35-41
2. Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	41-124
3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	124-156
4. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	156-160
5. Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал	160-169
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	169-186

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 53.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 09 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, П.Анужин, Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Сарангэрэл, Ц.Сэргэлэн;

Хоцорсон: Ц.Анандбазар-5 цаг 30 минут, С.Батболд-2 цаг 13 минут, Х.Болорчулуун-29 минут, Д.Ганбат-56 минут, Т.Доржханд-27 минут, Б.Жавхлан-1 цаг 07 минут, М.Оюунчимэг-42 минут, Б.Саранчимэг-37 минут, Ж.Сүхбаатар-33 минут, Г.Тэмүүлэн-16 минут, Н.Учрал-35 минут, Д.Цогтбаатар-2 цаг 00 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг татан авах тухай 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн ЗГ-1/74 тоот албан бичгийг уншиж, танилцуулав.

Нэг.Хууль, тогтоолын төсөл эцэслэн батлах /Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	41
Татгалзсан:	6
Бүгд:	47

87.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 6
Бүгд: 47

87.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 3
Бүгд: 47

96.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 4
Бүгд: 47

91.5 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 3
Бүгд: 48

93.8 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

6.“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 4
Бүгд: 48

91.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

7.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 4
Бүгд: 48

91.7 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 18

Бүгд: 48

62.5 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

9.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 26

Бүгд: 49

46.9 хувиар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 16

Бүгд: 50

68.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 21

Бүгд: 49

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 13

Бүгд: 49

73.5 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 9
Бүгд: 49
81.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 8
Бүгд: 49
83.7 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 8
Бүгд: 49
83.7 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 4
Бүгд: 49
91.8 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 5
Бүгд: 50
90.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 4
Бүгд: 50
92.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 3
Бүгд: 50
94.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 3
Бүгд: 50

94.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 6
Бүгд: 50

88.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 5
Бүгд: 51

90.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулж дууслаа.

Уг асуудлыг 10 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны сайдын зөвлөх П.Оюунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга А.Мөнх-Оргил, Цахим бодлого, статистикийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах шинжээч А.Цолмон, мөн хэлтсийн шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн ахлах шинжээч Д.Адилбиш, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ц.Даваасүрэн, С.Одонтуяа, Б.Энх-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Г.Тэмүүлэн, А.Адъяасүрэн, Ц.Туваан, Д.Батлут, О.Цогтгэрэл, Ж.Батжаргал, Н.Ганибал, Ц.Сандаг-Очир, Ц.Идэрбат, Т.Доржханд, Г.Ганболд, Н.Учрал, Э.Бат-Амгалан, Б.Баярсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Ш.Адъяаа, Х.Болорчулуун нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ч.Ундрам, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 22 минутаас хуралдааныг даргалав.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, С.Чинзориг, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 26
Бүгд: 44
40.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт,” гэснийг “зорилго, зарчим, тогтолцоо” гэж, “холбоотой” гэснийг “холбогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль болон түүнтэй” гэснийг “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай, Дээд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “нэр томьёо” гэснийг “нэр томьёоны тодорхойлолт” гэж, мөн зүйлийн 3.1.1 дэх заалтын “12 жилийн сургалтын агуулгын түвшинг” гэснийг “бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсролыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “төлөвшилийг” гэснийг “төлөвшилийн цогцыг” гэж, 3.1.3 дахь заалтын “мэргэжлийн болон дээд гэсэн ангиллыг” гэснийг “мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг” гэж, 3.1.5 дахь заалтын “танхимын бус хэлбэрээр явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 3.1.6 дахь заалтын “олгох” гэснийг “эзэмших” гэж, 3.1.7 дахь заалтын “бүх насны иргэн албан боловсролоос гадна хэрэгцээ, сонирхолдоо” гэснийг “хүний хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө” гэж, мөн заалтын “албан бус” гэснийг “албан болон албан бус” гэж, 3.1.8 дахь заалтын “хэрэгцээг ханган, тухайн түвшний” гэснийг “үр дүнг” гэж, 3.1.11 дэх заалтын “иргэнийг” гэснийг “хүнийг” гэж, 3.1.13 дахь заалтын “түүний үнэлгээ” гэснийг “зорилго, зорилт, үнэлгээ” гэж,

мөн заалтын “багц” гэснийг “цогц” гэж, 3.1.15 дахь заалтын “хандлагыг” гэснийг “хандлага, эрхэмлэх үнэт зүйлийг” гэж, 3.1.16 дахь заалтын “иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийг” гэснийг “хүний эзэмшсэн чадвар, чадамжийг” гэж, “эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдлийг” гэснийг “эрэмбэлсэн бүтцийг” гэж, 3.1.18 дахь заалтын “мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан явуулах” гэснийг “цахим технологи ашиглан зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.11 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 3.1.8 дахь заалтын “хөтөлбөрийн” гэсний өмнө “сургалтын” гэж нэмж, 3.1.11 дэх заалтын “элсэн” гэснийг, мөн зүйлийн 3.1.14 дэх заалтыг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 3.1.10, 3.1.17, 3.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.9.“албан бус боловсрол” гэж иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.10.“амьдралын орчинд суралцахуй” гэж хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.17.“хувьсах зардал” гэж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэг суралцагчид ногдох шууд болон шууд бус өртөгт суурилсан зардлын дундаж хэмжээг;

3.1.19.“цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.20-3.1.25 дахь заалт нэмэх:

“3.1.20.“боловсролын үнэлгээ” гэж боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, цахим технологи ашиглан тайлагнах үйл явцыг;

3.1.21.“чанарын баталгаажуулалт” гэж боловсрол, сургалтын чанарыг хууль тогтоомжид заасан шаардлага, чанарын шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх, сайжруулах, үр дүнг баталгаажуулах үйл явцыг;

3.1.22.“хөндлөнгийн үнэлгээ” гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг;

3.1.23.“магадлан итгэмжлэл” гэж боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар нь эрх бүхий байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж буй эсэхэд мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг;

3.1.24.“эндаументын сан” гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг;

3.1.25.“ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “шинжлэх ухаан, олон улсын” гэснийг “шинжлэх ухааны” гэж, 5.1.5 дахь заалтын “оролцоо” гэснийг “оролцоог хангасан” гэж, 5.1.7 дахь заалтын “үндэслэсэн” гэснийг “нийцсэн” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.3 дахь заалтын “уялдаатай” гэсний дараа “, уян хатан” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.11 дэх заалт нэмэх.

“5.1.11.хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.1, 5.1.8, 5.1.9 дэх заалтыг төслөөс хасаж, 5.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмэх:

“5.1.Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд бодлого, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил, тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшний” гэж, 6.2 дахь хэсгийн “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн” гэснийг “монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.6, 6.7 дахь хэсэг нэмэх:

“6.6.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.7.Боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “албан бус” гэсний дараа “боловсрол” гэж нэмж, мөн 7.1 дэх хэсгийн “орчноос суралцах боловсролоос” гэснийг “орчинд суралцахуйгаас” гэж, 7.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг

“мэргэжлийн болон техникийн боловсрол” гэж, “шаттай” гэснийг “түвшинтэй” гэж, 7.3 дахь хэсгийн “орчноос” гэснийг “орчинд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5, 8.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 8.3 дахь хэсгийн “дэмжигч болон явуулын багшийн, цахим” гэснийг “хувилбарт болон цахим, дадлага” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.7 дахь хэсэг нэмэх.

“8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь энэ хуулийн 8.1-д зааснаас гадна хосмог болон ажлын байрны сургалтын хэлбэртэй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “мэргэжлийг” гэснийг “мэргэжил болон чадамжийн түвшнийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон дээд боловсрол эзэмшсэн төгсөгчид диплом олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Боловсролын” гэсний дараа “болон сургалтын” гэж, “олгох” гэсний өмнө “түүнийг хөтлөх,” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “хувийн хэрэг” гэснийг “бүртгэл мэдээлэл” гэж, 9.6 дахь хэсгийн “боловсролын” гэснийг “боловсролын болон сургалтын” гэж, 9.7 дахь хэсгийн “болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс” гэснийг “эсхүл, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын

байгууллагаас” гэж, “сургалтын баримт бичгийг” гэснийг “суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж,” гэж, 9.8 дахь хэсгийн “шатлалын” гэснийг “түвшний” гэж, “олгохыг хориглоно” гэснийг “олгохгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.10 дахь хэсэг нэмэх.

“9.10.Боловсролын баримт бичиг цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	13
Бүгд:	42

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтын “байгууллага” гэснийг өмнө “сургалтын гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.12, 10.1.13, 10.1.14, 10.2.7, 10.2.8 дахь заалт нэмэх.

“10.1.1.эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;

10.1.12.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш, боломж нөхцөлөөр хангагдах;

10.1.13.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сорилд хамрагдахгүй байх;

10.1.14.ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах.

10.2.7.ерөнхий боловсролыг заавал эзэмших;

10.2.8.бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	12
Бүгд:	43

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар хандлагаа” гэснийг “чадамжаа” гэж, 10.1.6 дахь заалтын “төлөөллийн” гэснийг “өөрийн удирдлагын” гэж, 10.2.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилтэй холбоотой боловсролын байгууллага, багшаас тавьсан” гэснийг “багш, ажилтны” гэж, 10.2.4 дэх заалтын “багш, суралцагч, анги” гэснийг “багш, ажилтан, суралцагч,” гэж өөрчилж, мөн төслийн 10.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 10.2.1 дэх заалтын “хугацаанд нь бүрэн” гэснийг, 10.2.5 дахь заалтын “сургуулийн дотоод журам” гэснийг хасаж, мөн төслөөс 10.1.4, 10.1.10, 10.2.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад” гэж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “нэн шаардлагатай” гэснийг эрэлтгүй” гэж, “тэтгэлэг” гэснийг “хөнгөлөлт, тэтгэлэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “зардлын дундаж нормативт “ гэснийг хасаж, 11.3, 11.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Гадаад болон дотоодын мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно.

11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “Хууль тогтоомжид” гэсний өмнө ”Холбогдох” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.7 дахь хэсэг нэмэх.

“11.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат хэрэглэгдэхүүн, дэмжих үйлчилгээгээр хангагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал болон ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл. Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1.Багш, ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, багш бэлтгэх хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандарт болон энэ хуулийн 5.1.4-д заасан тэгш хамруулан сургах зарчимд үндэслэсэн байна.

12.6.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.7-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.

12.9.Аймаг, сум, дүүргийн захиалга, эсхүл өөрөө хүсэлт гаргаж 3 буюу түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багшийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, багш, мэргэжлийн бүлэг, судлаач, эрдэмтдийн оролцоотой зохион байгуулна.

12.12.Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна.

12.13.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.10-д заасан сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.14.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.15.Энэ хуулийн 12.14-д заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.16.Багшлах хүний нөөц хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.17.Багш үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой аливаа хэлбэрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, С.Чинзориг, Ш.Раднаасэд нар үг хэлэв.
Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.11 дэх заалт нэмэх.

“13.1.11.цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцлөөр хангагдах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Г.Дамдинням нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	12
Бүгд:	43

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “албан тушаалын тодорхойлолтод” гэснийг “хууль тогтоомжид” гэж, “ажлын үр дүн, гүйцэтгэлд” гэснийг “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ” гэж, 13.2.7 дахь заалтын “эрхэмлэн, ажил амьдрал үйл ажиллагаагаараа үлгэрлэх” гэснийг “эрхэмлэх” гэж, 13.2.9 дэх заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийг” гэснийг “цахим технологи, хэрэглэгдэхүүнийг” гэж, мөн заалтын “платформыг” гэснийг “цахим системийг” гэж, 13.2.10 дахь заалтын “багшийн мэргэжлээ дээшлүүлэх” гэснийг “ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж” гэж, 13.2.3 дахь заалтын “мэдлэг, чадвар, дадлыг” гэснийг “чадамжийг” гэж, 13.2.11 дэх заалтын “цэцэрлэг, сургуулийн” гэснийг “сургалтын” гэж, 13.3.3, 13.3.5 дахь заалтын “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 13.3.4 дэх заалтын “дэмжлэг үзүүлэх” гэснийг “дэмжлэг авах” гэж, 13.3.3 дахь заалтын “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын” гэж, 13.3.5 дахь заалтын “сургуулийн захирал” гэснийг “ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал” гэж, 13.3.6 дахь заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, 13.3.5 дахь заалтын “5” гэснийг “эхний 5 дахь жил болон дараагийн 3 дахь” гэж, 13.5 дахь хэсгийн “бүх шатны” гэснийг “бүх түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.2.2, 13.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.2.суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;

13.2.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	19
Бүгд:	46

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн, Т.Энхтүвшин, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 15 цаг 45 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: 27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш,” гэж, “саад учруулах” гэсний өмнө “зориуд” гэж нэмж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9, 13.10, 13.11 дэх хэсэг нэмэх.

“13.2.17.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18.ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль болон политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

13.9.Багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3, 13.1.7, 13.2.13, 13.3.1, 13.3.2 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлийн 13.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 13.2.3 дахь заалтын “суралцагчийг идэвхжүүлсэн сургалтын арга зүйг сургалтад ашиглах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	18
Бүгд:	47

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 дэх заалтын “хэл зохиол” гэснийг ”монгол хэл, уран зохиол” гэж, 14.4.4 дэх хэсгийн “ёс зүйн” гэснийг “ёс зүйн болон зан төлөвийн” гэж, “14.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын” гэж, 14.3 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол болон” гэснийг “мэргэжлийн болон техникийн,” гэж, “нарийвчилсан харилцааг” гэснийг “харилцааг” гэж, 14.5, 14.9 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.4, 14.6, 14.7, 14.8 дахь хэсэг, 14.4.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.4.Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, өмчийн хэлбэр харгалзахгүй боловсролын сургалтын байгууллага хэрэгжүүлнэ:

14.4.6.хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол;

14.6.Гадаад улсад монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулах, Монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг байгуулж болно.

14.7.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байна.

14.8.Цахим сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 14.2-т заасан хөтөлбөрт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	14
Бүгд:	47

70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Боловсролын сургалтын байгууллага нь” гэж, 14.4.3 дахь заалтын “жендэрийн” гэсний өмнө “хүний эрхийн боловсрол,” гэж, 14.4.9 дэх заалтын “сэргийлэх” гэсний дараа “талаар” гэж, 14.9 дэх хэсгийн “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	15
Бүгд:	47

68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “албан боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмэх.

“15.3.Албан бус боловсролын сургалтыг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага бүртгэж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	16
Бүгд:	47

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “багшийн” гэснийг “эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14
Бүгд: 47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмэх.

“16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дадлага сургалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14
Бүгд: 47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “**ГУРАВДУГААР БҮЛЭГ**”-ийн нэрийг “**БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА**” гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

“17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв болон сургалтын байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага байх бөгөөд дэргэдээ боловсролын сургалтын байгууллага, ажил олгогчийн түншлэл хамтын ажиллагаа хариуцсан төвтэй байна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирц, нийцлийг шалгах, турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.4.1.энэ хуулийн 17.4-д заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас тохирц, нийцлийг шалгах, турших үед сонгосон цэцэрлэг, сургууль хэрэгжүүлэх;

17.5.Насан туршийн суралцахуйн төв нь хүний насан туршийн суралцахуйг чиглүүлэх, түгээн дэлгэрүүлж, дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.5.1.Энэ хуулийн 17.5-д заасан төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах;

17.5.2.Эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага, эсхүл төрийн бус байгууллага гэрээгээр гүйцэтгэж болох бөгөөд шаардагдах зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

17.5.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших, тасралтгүй сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллуулж болно.

17.5.4.Дэмжих төвийн хүний нөөц болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

17.5.5.Энэ хуулийн 17.6-д заасан төв нь сургалт, үйлчилгээний хамрах чиглэлээс хамаарч салбар дундын санхүүжилттэй байх;

17.6.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүрэгтэй байна.

17.7.Энэ хуулийн 17.8-д заасан үнэлгээ болон элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.8.Боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага нь сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасан байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, гадаадын хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийг бүртгэх, дүйцүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

17.10.Энэ хуулийн 17.8-д заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, С.Чинзориг, Г.Дамдинням нар үг хэлэв.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн Б.Пүрэвдорж ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 5 өдрийн завсарлага өгөв./16:15/

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга Б.Батмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх итгэлийг хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ш.Адъяаа, Д.Өнөрболор, С.Бямбацогт, Ц.Анандбазар, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж, М.Оюунчимэг, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Б.Баярсайхан, Ц.Цэрэнпунцаг, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 17 цаг 45 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, Н.Учрал нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 5

Бүгд: 52

90.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, мөн комиссын гишүүн Б.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын Ц.Даваасүрэн, Ж.Чинбүрэн нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	21
Бүгд:	49

57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Ж.Золзаяа, Н.Монсор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Засгийн газрын саналыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт, эрх бүхий албан тушаалтны санал болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Батсуурь, Ч.Ундрэм, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад нэр дэвшигч Ж.Золзаяа, Н.Монсор нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн Хайдавын Чилаажавыг Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	18
Бүгд:	43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Жаргалсайханы Золзаяаг Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	28
Татгалзсан	15
Бүгд	43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Нямдаваагийн Монсорыг Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	28
Татгалзсан	15
Бүгд	43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын

тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:13/

Уг асуудлыг 19 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны газрын дарга Г.Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Монгол Улсын Үндэсний Аудитын газрын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, мөн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.3.7 дахь заалт нэмэх:

“3.3.7.Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	29
Татгалзсан	13
Бүгд	42

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалтын “орон нутгийн өмчит,” гэснийг “орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	15
Бүгд	42

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4.3 дахь заалт нэмэх:

“11.4.3.чанар ба үнийн хосолмол.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	26
Татгалзсан	14
Бүгд	40

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.7, 11.8 дахь хэсэг нэмэх:

“11.7.Захиалагч энэ хуулийн 11.4.3-т заасан шалгуурыг хэрэглэх бол чанар ба үнийн шалгуур тус бүрд өгөх оноог тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.8.Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	29
Татгалзсан	13
Бүгд	42

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ц.Туваан, М.Оюунчимэг нар үг хэлэв.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “баримтжуулж тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.” гэснийг “баримтжуулна.” гэж өөрчлөн үүнтэй уялдуулан 48 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 48.4.10 дахь заалт нэмэх:

“48.4.10.энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	28
Татгалзсан	13
Бүгд	41

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.6 дахь хэсэг нэмэх:

“27.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	29
Татгалзсан	12
Бүгд	41

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “тэнцүү” гэсний өмнө “, эсхүл оноо” гэж, 27.15 дахь хэсгийн “өртөг” гэсний дараа “, чанар ба үнийн оноо” гэж тус тус нэмэх .” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	28
Татгалзсан	13
Бүгд	41

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын Тайлбар хэсгийн “дуусах” гэснийг “дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	30
Татгалзсан	10
Бүгд	40

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.1.3 дахь заалт нэмэх:

“35.1.3.шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	24
Татгалзсан	15
Бүгд	39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

11.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгч, олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	19
Татгалзсан	20
Бүгд	39

48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Х.Булгантуяа, Н.Учрал, Г.Ганболд, С.Чинзориг, Ж.Чинбүрэн, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

12.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг дахин боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх заалтын “банкны” гэсний дараа “, эсхүл Монгол Улсын даатгагчийн” гэж нэмэн, үүнтэй уялдуулж 42.3.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	23
Татгалзсан	16
Бүгд	39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.1.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	14
Бүгд	39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “энэ хуульд заасан” гэснийг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна” гэж, мөн зүйлийн 49.4.5 дахь заалтын “үйл ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах,” гэснийг “ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар” гэж өөрчлөн, мөн зүйлийн 49.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.4.1.цахим системийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	24
Татгалзсан	15
Бүгд	39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.10 дахь заалтын “, судалгаанд үндэслэн” гэснийг хасаж, мөн заалтын “ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах” гэсэн чиг үүргийг 49.4.11 дэх заалт болгон салгаж, үүнтэй

уялдуулан мөн заалтын “судалгаа хийж” гэснийг “судалгаа хийх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	24
Татгалзсан	15
Бүгд	39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.11 дэх заалтын дугаарыг “49.4.12” гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.4.12.энэ хуульд заасан баталгааг цахим системээр гаргах эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	12
Бүгд	39

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсгийн “өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг” гэснийг “энэ хуулийн 49.4.5, 49.4.8, 49.4.10-т заасан чиг үүргийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	23
Татгалзсан	16
Бүгд	39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.8.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.8.3.худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 49.4.10-т заасан судалгаа хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	14
Бүгд	39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6. Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

21. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.15 дахь хэсгийн “урамшуулал олгох, мэргэшсэн ажилтан бэлтгэх” гэснийг “үнэлгээний хорооны гишүүнд урамшуулал олгохтой холбогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	14
Бүгд	39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.10 дахь хэсгийн “байцаагчид гаргана” гэснийг “байцаагчид гаргаж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	12
Бүгд	39

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “гэрээ байгуулах эрх олгохгүй” гэснийг “энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гаргахгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	14
Бүгд	39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

24. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “2023 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	26
Татгалзсан	13
Бүгд	39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25. Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, мөн төслийн үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	24
Татгалзсан	15
Бүгд	39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “өргөтгөх,” гэсний дараа “буулгах,” гэж, 56 дугаар зүйлийн 56.5.3 дахь заалтын “хохирол” гэсний дараа “барагдуулахыг” гэж, 56.11 дэх хэсгийн “байцаагч” гэсний дараа “энэ хуулийн 56.10-т заасан” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хөгжлийн болон хүнд,” гэснийг “хөгжлийн, хүнд болон” гэж, мөн зүйлийн 8.4.3, 8.7.1 дэх заалтын “хотод хамаарахгүй” гэснийг “хотоос бусад харьяалалтай” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “аргад үндэслэн” гэснийг “аргаар” гэж, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “нууцалж, бусад хэсгийг ил болгохоор” гэснийг “энэ хуулийн 29.2-т зааснаар ил болгохгүйгээр” гэж, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Засгийн газрын баталсан жагсаалтад” гэснийг “энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад” гэж, 49 дүгээр зүйлийн 49.4.9 дэх заалтын “дүгнэлт” гэснийг “дүн шинжилгээ” гэж, 49.8.1 дэх заалтын “хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж,” гэснийг “хууль тогтоомжийн хэрэгжилтийн” гэж, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “зааснаар улсын байцаагчийн гаргасан санал, дүгнэлтийг” гэснийг “заасан дүгнэлт, зөвлөмжийг” гэж, мөн хэсгийн “биелэлтийн талаар” гэснийг “дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар” гэж, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “сонирхолтой” гэснийг “хохиролтой” гэж, төслийн 9, 37, 45, 49, 53, 54, 58 дугаар зүйлийн гарчиг болон холбогдох хэсэг, заалтад тусгагдсан худалдан авах ажиллагааны болон өрсөлдөөний асуудал “эрхэлсэн” гэснийг тохиолдол бүрд “хариуцсан” гэж, төсөлд тусгагдсан “энэ зүйлийн” гэснийг тохиолдол бүрд “энэ хуулийн” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “уг ажиллагаанд” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтын “эрх бүхий” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын эшлэлийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.2.13 дахь заалтын “эрх, үүрэг” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.4.14 дэх заалтын “чиг үүрэг” гэснийг, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “болон бусад” гэснийг, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “зохих” гэснийг, 55 дугаар зүйлийн 55.1.7 дахь заалтын “тоо баримт,” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.8, 56.12 дахь хэсгийн “худалдан авах ажиллагааны” гэснийг болон 56.8 дахь хэсгийн “тушаал гаргаж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	24
Татгалзсан	16
Бүгд	40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмэх:

“5.2.Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад энэ хуулийн хэмнэлттэй байх буюу бага үнийг сонгох аргыг хэрэглэхгүй.”

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд гаргасан саналаа татаж авсан тул, санал хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын “төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн	7
Татгалзсан	33
Бүгд	40

17.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “мөрдөгдөхөөс” гэснийг “болохоос” гэж, 2 дугаар зүйлийн “бүртгэлд бүртгэгдсэн этгээд бүртгэлийн үлдсэн хугацаагаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэлтэй” гэснийг “бүртгэл хүчинтэй хэвээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	15
Бүгд	40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлд” гэснийг “33 дугаар зүйлд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	13
Бүгд	40

67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	24
Татгалзсан	16
Бүгд	40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	13
Бүгд	40

67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	15
Бүгд	40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	26
Татгалзсан	14
Бүгд	40

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	13
Бүгд	40

67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, үүнтэй уялдуулан төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “62.1.5 дахь” гэснийг “62.1.4 дэх” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж, төслийн нэрийн “нэмэлт” гэснийг “нэмэлт, өөрчлөлт” гэж, мөн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 112 дугаар зүйлийн 112.10 дахь хэсгийн “цахимаар татан авч” гэснийг “цахимаар авч” гэж тус тус өөрчлөх:

“3 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтын дугаарыг “62.1.5” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	27
Татгалзсан	13
Бүгд	40

67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2, 3 дугаар зүйлийг хасаж, 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “томилон” гэснийг “сонгон шалгаруулан” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	28
Татгалзсан	12
Бүгд	40

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг болон төслийн нэрийн “нэмэлт,” гэснийг тус тус хасаж, үүнтэй уялдуулан 2, 3 дугаар зүйлийн дугаарыг “1”, “2” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	28
------------	----

Татгалзсан 12
Бүгд 40
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван нэг. Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6^{1.4} дэх хэсэг нэмсүгэй:

6^{1.4}. Даатгагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гаргах баталгааны үнийн дүн даатгалын нөөц сангийн энэ хуулийн 6^{1.1}-д заасан баталгаанд хамаарах эрсдэлийн сангаас хэтэрсэн бол давхар даатгалд хамрагдаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байхыг шаардана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 25
Татгалзсан 15
Бүгд 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Унгар Улсын Үндэсний ассамблейн дарга ноён Көвер Ласло тэргүүтэй төлөөлөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 10 цаг 17 минут үргэлжилж, 73 гишүүнээс 60 гишүүн хүрэлцэн ирж, 82.2 хувийн ирцтэйгээр 20 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 09 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нийт 8 асуудал хэлэлцэнэ.

Хуулийн төслийг эцэслэн батална.
Нийт 18 төсөл.

2 дугаарт Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 76 саналтай. 90 байсан буурсан байна.

3-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

4-д Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

5 дугаарт Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах

арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

6 дугаарт Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

7 дугаарт Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

8 дугаарт Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-д хууль, тогтоолын төслөө татан авах хэлэлцүүлгийн аль ч шатад тодорхой үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснээр Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд албан бичгийг уншиж, танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай бичиг ирүүлснийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танаа. Хуулийн төсөл татан авах тухай. Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн төслийг тус тус татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ гэсэн байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргасан байна. Ингээд

эдгээр хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4.-д заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа албан бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж бичиг ирүүлсэн байна. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Маргааш Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл орж ирэх юм байна. 152 гишүүнтэй болох юм гэнэ. Тэгэхээр өнгөрсөн 7 сарын 15-аас хойш өнөөдрийг хүртэл би Ховд аймагт 60 гаруй уулзалт хийсэн. Бусад 5 аймгаар явж томоохон сумуудаар явж иргэдтэй уулзалт хийсэн. Тэгээд уулзалтаараа бол гишүүдийн тоог 98-аас дээш нэмж болохгүй ээ. Яах вэ тэр сонгуулийн холимог тогтолцоо бол сонгогчдын саналыг гээдэггүй сайн тогтолцоо, тэр бас орж болох юм. Тэгэхдээ жагсаалтын ард янз янзын хулгай зэлгий хийдэг намыг санхүүжүүлчхээд буцаад баахан мөнгө олдог ийм нөхдийг жагсаах нь буруу л гэж ярьж явсан. Ингэж би сонгогчдоо ухуулж, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн өөрчлөлт бас хийж болох юм гэдэг ийм саналаа л хэлж явсан байгаа. Тэгээд 1 дэх өдрөөс хойш Их Хурлын гишүүд бүгдээрээ тойрог дээрээ очиж Үндсэн хуулийн өөрчлөлтийг 152 гишүүнтэй болгох тухай асуудлаа ярих юм байна. Би бол өөрийнхөө урьд нь ярьж байсан зүйлээ л ярина. Ер нь улс төрч хүн бол нэг байр суурин дээрээ л байх ёстой гэж би боддог. Ер нь Их Хурлын гишүүн хүн бол сонгогчдын саналыг л төрд дамжуулах л үүргээ хийх ёстой. Гэтэл тэндээсээ сонгогдож гарч ирчхээд энд өөр юм ярьдаг, өөр өөрсдийгөө хуурдаг ийм л юм болчхоод байна шүү дээ. Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 3 дарга

нэгнийгээ ухуулаад л 152 ямар үр ашигтай л яриад байдаг. Их Хурлын гишүүд нь 152 ямар үр ашигтай гээд хоорондоо л нэгнийгээ ухуулаад байдаг. Засгийн газрын гишүүд нь бас тэгж ухуулаад нэгнийгээ ухуулаад байдаг. Тэгээд ард түмэн дээр чинь шал ондоо юм ярьж байна шүү дээ. Юун 152 вэ. 100 ямаанд 60 ухна гэгчээр яасан их гишүүн бэ. Энэ 76-г чинь яая гэж байхад чинь гээд. Тэгээд 1 дэхээс та нар энэ үнэнтэй тулгарна л даа. Тэгээд сонгогчдоо л сайн ухуул л даа. Тэгээд өөрсдийгөө л ухуулаад байх юм. 152 болгохын ашиг тусыг. Тэгээд манай ард иргэд Ардын намын хүн очихоор Ардын намын гишүүдийн ярьсан талд нь гарч зогсchoод л, Ардчилсан намын гишүүд очоод гишүүдийн тоог нэмж болохгүй гэхээр бас тэд нарын талд орж зогсchoод ингээд бас нэг ийм гишүүдийгээ аялдан дагалдсан байдалтай л байгаад байх юм. Тэгсэн мөртөө ингээд яг Ардчилсан намын ч юм уу сөрөг хүчнийхээ энэ асуудлаар яриад байгаа тэр хүмүүс рүү болохоор ингэж хэлээд өгөөч, тэгж хэлээд өгөөч гээд. Тэр сонгогдсон гишүүдийнхээ нүүрэн дээр хал пал, сал пал гэтэл хэл л дээ. Энэ асуудлаа ийм болохгүй байна, тийм болохгүй байна. Тэгэхгүй бол ингээд 1 дэхээс 5 дахь өдөр явж явж ирчхээд, 152 болохыг дэмжиж байна гээд чимээгүй байгаад байх юм бол тэгээд ингээд л 152 гишүүнтэй болох нь байна шүү дээ. Энэ чинь арай хэтэрч байна. Тийм учраас иргэдтэй уулзах уулзалт дээр энэ асуудлуудыгаа сайн бүр 152 гээд гэдгийгээд байгаа тэр Их хурлын гишүүнийг дахиж сонгогдохгүй болтол нь сайн хэлж ярьж өгөөрэй гэж та нарт ард түмэндээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Хууль тогтоомжийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу 7 хоногийн Баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороод төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг бэлтгэж, гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Байнгын хороо хуралдаагүй ээ. Төсвийн байнгын хороог цуцалсан. Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг өглөө 9 цагаас хуралдана гэж байсан. Тэр дуусаагүй байна. Чинзориг сайд суугаарай. Санал хураалт явуулах уу Тогтохоо дарга аа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг орж ирье. Яамныхныг дуудаад үнийн өсөлт, тэр цалин хөлсний асуудлаар уулзалт хийж байгаа гээд байсан. Жилийн төлөвлөгөөг ярина гээд байсан. Мөнхбаатар дарга санал хураалтад бэлтгэцгээгээрэй. Ажлын хэсгийг оруулж ирье. Ингээд санал хураалтаа явуулъя. Жаргалмаа гишүүн ээ танай ажлын хэсэг дуусчихсан уу. Дарга чинь хаачсан юм. Санал хураалт явуулна. Батсуурь гишүүн, Баттөмөр гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн 2 өндөр хүн хааж зогсохоор чинь яасан эвгүй юм. Балжиннямын Баярсайхан гишүүн орж ирлээ. Санал хураалтаа явуулъя. Өнөөдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүнийг, Эдийн засгийн байнгын хорооны даргыг дуудаач. Балжиннямын Баярсайхан гишүүн, Дамбын Батлут гишүүд уг нь дэмжсэн юм байна. Тэгээд өөрсдөө бичиж өгөхгүй бол би эндээс хэлээд дэмжсэн гээд хэлчхэж болохгүй байх л даа. Санал нь ийм гарчихсан юм чинь. Та дэмжсэнд тооцох боломж байна уу. Тамгын газар үзээрэй тэгэхгүй бол протоколд үлдчихнэ.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, 87.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Чиний карт уншигдаагүй байна. Картаа уншуул. Баярсайхан гишүүн уншигдчихлаа. Санал хураалт явуулъя.

Дараагийнх нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

6. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал гэж байхгүй ээ. Эцэслэн батлах санал хураалт, эцсийн үе шат дээр эцэслэн батлах л үе шат гэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл эцэслэн батлагдсангүй ээ.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал энэ дээр байхгүй. Ер нь энэтэй холбогдуулаад бас буруу зөрүү ойлголт зарим гишүүдийн зүгээс болон зарим хуульчдын зүгээс ярьж байгаатай холбогдуулаад тодруулга хийе гэж бодож байна.

1 дүгээрт Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хэлний зөвлөл ажиллах болсонтой холбогдуулаад Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль

боловсруулахад тавигдах шаардлага, түүнийг бүрдүүлбэрийг хангахыг шалгах шаардлага, хэлний жигдрэлтийг хангах асуудал Улсын Их Хурлын Тамгын газар бүрдүүлбэрийг хянадаг, Хууль тогтоомжийн тухай уялдуулаад энэ асуудлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн статусыг дээшлүүлж, яамны дэргэд байгааг Улсын Их Хурлын дэргэд болгож, статусыг нь дээшлүүлж байгаа асуудал 1-д.

2-т нь бол Хууль зүйн үндэсний хүрээлэн бол Улсын Их Хурлын дэргэд ажиллана гэсэн агуулгаар энэ тогтоол батлагдаж байгаа юм.

2 дугаарт нь Хууль зүйн үндэсний хүрээлэн бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийх, энэ асуудал Хууль тогтоомжийн хуулийн 49.1, 49.2-т зааснаар Улсын Их Хурлын дэргэд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж холбогдох бүтцийн нэгжийг Улсын Их Хурлын дэргэд ажиллуулна гэж заасан. 49.2-т Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ. Ийм бүтцийн нэгжтэй байна гэж заасан.

3 дугаарт хууль тогтоомжийн үнэлгээ хийх асуудал бол үндсэндээ хаягдаж байгаа. Өөрөөр хэлбэл хэлний асуудал, хэлний жигдрэлт, хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн асуудлыг хэлэлцэн шийднэ гэдэг асуудал хаягдаж байгаа. Тэр битгий хэл зарим яам тамгын газрууд хүртэл Хууль зүйн үндэсний хүрээлэнг авах гэж санаархдаг болсон. Ийм учраас хууль Улсын Их Хурлын дэргэд авч хамгаалалтад авч, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн институтийг хууль тогтоомжийн хуульд нийцүүлж, Улсын Их Хурлын дэргэд ажиллуулснаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт

шалгалт хийх онцгой бүрэн эрх бол Улсын Их Хуралд хадгалагддаг. Ингээж институтжиж байж Улсын Их Хурлынхаа, парламентынхаа чадавхыг бэхжүүлэе. Монголын хууль бодитой хэрэгждэг болъё, тэр шаардлагыг хангая гэсэн ийм шаардлагын үндсэн дээр тавьж байгаагийн зарим буруу ойлголт төрж, тэр байшинг нь авч байгаа юм шиг. Цаашилбал Хуульчдын холбоо маань Улсын Их Хуралтайгаа иүүд хамтран ажиллах, нээлттэй сонсгол бусад хууль тогтоомж боловсруулах ажил дээр хуульчдын холбоотойгоо хамтран ажиллаж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороонд ажлын хэсэгт орж ажилладаг болсон Хүний эрхийн Үндэсний Комиссын нэр дэвшүүлэх хороо бүх ажлууд хамтран ажилладаг болсон. Энэ нягт хамтын ажиллагааг уялдуулж, цаашидаа ингээж холбогдож ингээж ажиллах асуудлыг энд ямар санаа агуулалгүйгээр томоор харж, Улсын Их Хурлын өргөтгөл барих агуулгаар анх газар нь бол Улсын Их Хурал эзэмшиж байсан газар боловч ингээд явж байгаа. Тэгэхдээ яамны дэргэд бол хэчнээн ч бүтэц ажиллуулах газар, хэлтэс ажиллах бүрэн бололцоотой. Улсын Их Хурлын дэргэд бол ийм бололцоо байхгүй байгаа учраас парламентын судалгааны хүрээлэн бол хууль босуулах шатад л гишүүдэд тусалж байгаа. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ энэ 2-ыг уялдуулж, боловсруулах үе шат, хэрэгжилтийн үнэлгээ хийхийг уялдуулж, цаашаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалтын сонсгол хийх, үнэлгээ хийх бүх ажил дээр ингээж Хуульчдын холбоо, хуульчидтай холбоотой ажиллах амьд холбоог бий болж байгаа. Яагаад парламентаа чадавхжуулж төлөөлөх чадавхыг сайжруулъя гэж ярьчаад ард иргэдтэйгээ холбогдож ажиллах, хуульчидтай хамтран ажиллах бололцоог бий болгож статусыг нь дээшлүүлж байгааг буруу зөрүү тайлбарлаад байгааг ойлгохгүй байна. Ийм учраас энэ асуудлыг “Хууль

хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Энэ дээр Энх-Амгалан гишүүн, холбогдох гишүүд боловсруулсан. Энэ бол парламентын чадавхыг сайжруулж байгаа. Яагаад парламентынхаа эсрэг дандаа ийм юм ярьж байгааг ойлгохгүй байна. Ямар сонирхол байгааг ч ойлгохгүй байна. Ингээд “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Миний санал хүртэл эсрэг гарсан байх юм. Яагаад би дараад байхад эсрэг гарч байна. Миний санал хүртэл эсрэг гарсан байна. Яагаад ямар нөлөөлөл явагдаад байна. Эсрэг дараад байхад чинь. Парламентын эсрэг, парламентыг хүндлэхгүй байгаа, парламентын эсрэг ямар ажил яваад байна. Миний санал дарж байхад эсрэг гарлаа. Тэгээд хамаагүй. Энэ тогтоолыг батлахгүй байж болно. Тэгээд Хууль зүйн үндэсний хүрээлэн хууль тогтоомжийн чанар, парламентын чадавхыг сайжруулах бүх ажил орхигдоно. Хууль тогтоомжийн хуулийн 49.1, 49.2-т заасан юм ерөөсөө хэрэгжихгүй байгаа. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх.

Ингээд миний санал эсрэг гарсан учраас санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт явуулъя. Эцсийн хэлэлцүүлэг дээр завсарлага гэсэн юм байхгүй. Эцэслэн батлах дээр санал хураалт гэсэн байна. Завсарлага гэсэн юм байхгүй дэг зөрчигдөнө. Хуулиараа л явъя. Унагаавал унагаацгаа. Надад хамаа байхгүй. Би ямар хувьдаа авах гэж байгаа биш, парламентыг л чадавхжуулахын төлөө ажиллаж байна. Парламентынхаа эсрэг санал өгцгөөвөл өгцгөө. Хамаа байхгүй. Горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүйд

тооцох санал хураалтыг 34 гишүүн дэмжиж, 68 хувийн саналаар санал тооцогдож, хүчингүйд тооцогдлоо. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Дараагийн асуудалд оръё. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Би уг нь дэмжсэн санал өгсөн. Тэгээд төхөөрөмж л гацчих шиг болох юм.

Г.Занданшатар: Төхөөрөмжийн шалгалтын мониторинг хийхгүй бол гацалт үүсээд байна. Ингээд Цэрэнпилийн Даваасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. Адьяасүрэн гишүүн эсрэг гараад байна лээ шүү. Туваан гишүүн. 40 гишүүн дэмжиж саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Ингээд санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа. Хамт өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 46 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 47 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хуулийн төсөл батлагдлаа.

10.47 цаг.

Хоёр.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дарааллаа өглөө баталсан. Горимын санал гараагүй, яригдаагүй. Ингээд төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд.

1.Хүний боловсрол эзэмших явц нь дан ганц албан боловсролоор бус албан

бус хувилбартай байх бөгөөд ажил, амьдралын орчин, сурч, эзэмшсэн чадварыг хүлээн зөвшөөрч, цаг хугацаа хэмнэх, богино хугацаанд ажил, хөдөлмөр эрхлэх, орлоготой болох, бүтээмжээ бодитой үнэлүүлэх, бие даан эзэмшсэн ур чадвараа үнэлүүлж гэрчилгээ, үнэмлэхтэй болох эрх зүйн орчин зохицуулалтыг бий болгох,

2.Боловсрол, цахим технологийн дэвшил нэвтэрч байгаа хэдий ч эрх зүйн зохицуулалтгүй байгааг шийдвэрлэж хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгах. Хүн бүр суралцах боломжоо нэмэгдүүлэх, хоцрогдлоо нөхөх. Хүүхэд залуучууд чөлөөт цагаараа ур чадвараа хөгжүүлэх,

3.Англи хэлийг үндсэн гадаад хэлээр судлах,

4.Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш боломж бүрдүүлэх, холбогдох санхүүжилт, хөтөлбөр, орчин, хэрэглэгдэхүүний эрх зүйн орчныг сайжруулах,

5.Багш бэлтгэх хувилбарт сургалтыг бий болгох, багшийг давтан сургадаг, хөгжүүлдэг тогтолцоог шинэчлэх, багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил гүйцэтгүүлэхийг хориглох,

6.Салбарын санхүүжилтийг гүйцэтгэлд, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлэх зэрэг зохицуулалтууд туслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал чанарын баталгаажуулалт магадлан итгэмжлэл нь хоорондоо зохицож байгаа эсэх талаар, мөн хөндлөнгийн үнэлгээ эндаументын сан ялгаатай хэрэгцээ хэрхэн тайлбарлаж байгаа талаар, гадаад олон гадаад улсын болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс Монгол Улсад шилжин суралцах хөтөлбөрийг

Боловсролын ерөнхий газар батлах нь зүйтэй эсэх талаар, төсөлд тусгагдсан багийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоо, тусгай шаардлагыг Багийн хөгжлийг дэмжих тухай хуультай нийцүүлэх талаар, Ерөнхий боловсролын сургуулийн багийн эцэг эх, суралцагчийн хүсэлтэд үндэслэн ажлын бус цагаар нэмэлт орлого олох боломжийг нээж өгөх талаар, Боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллагын үйл ажиллагааны талаар, Боловсролын байгууллагын удирдах албан тушаалтанд тавигдах шаардлагыг уян хатан болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг багш нарын танхимын цагийн ачааллыг бодитой үнэлэх, цалин, урамшууллыг нэмэгдүүлэх талаар, Эцэг эхийн орлого, гарал үүслээс хамаараад хүүхдүүдэд тэгш бус боловсрол олгогдож байгааг хэрхэн хязгаарлах талаар, Хувийн сургуулийн сургалтын төлбөрөө огцом нэмснээр тухайн нэмсний тухай орлого, хүүхдийн боловсролд зарцуулагдаж байгаа эсэхийг хэрхэн шалгаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Бүх шатны боловсролын байгууллагын багш нар Төрийн албаны тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 36 сарын цалингийн 1 удаагийн буцлалтгүй тусламж олгоход хамрагдах эсэх талаар, мөн боловсролын салбарт хэт ашигийн төлөө ажиллах нь зөв эсэх талаар, боловсролын тогтолцоо нь хүүхдүүдэд ялгавартай байдал үүсгэж байгаа эсэх талаар, ашигийн төлөө ажиллаж байгаа сургуулиуд татвар төлөх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн сурагчдын хичээлийг тасалдуулах нөхцөл байдал үүсгэх шалтгаанаар үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд халдаж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаас гаргасан зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг төсөл санаачлагчид буцаах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх тус Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гамигаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай,

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны сайдын зөвлөх Пүрэвдоржийн Оюунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Төмөр-Очирын Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Жадамбын Мягмар, Боловсрол, шинжлэх

ухааны яамны Санхүүгийн хэлтсийн дарга Алтаньямын Мөнх-Оргил, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Адьяагийн Цолмон, Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн ахлах шинжээч Даваадоржийн Адилбиш, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Чимэдрэгээний Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Жамцын Нарантуяа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Цахим бодлого, статистикийн хэлтсийн дарга Түвшинбатын Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч Ухнаагийн Туяа, Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Дондогдуламын Тунгалаг.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Боловсролын багц хууль Улсын Их Хурлын хаврын чуулганд төлөвлөсөн ёсоороо багтаж орж ирж байгаа нь бол маш чухал. Нийгэм тэр чигээрээ энэ хуулийг маш чанартай, Монголын боловсролын салбарт үнэхээр реформ, шинэчлэл хийсэн одоо ингээд тэгээд уруугаа харчихсан тогтолцоог нэг өөд нь харуулаад, Монгол хүний дэлхийд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн ийм болоосой гэж хүсэж байна. Өнөөдөр дэлхийд боловсролын салбараараа бүр эхний нэгд ордог Финлянд улс гэвэл яг багштайгаа маш сайн ноцолдчихсон, ер нь багшаа хамгийн сайн багштай сургууль хамгийн сайн сургууль байдаг гэдгийг нотлоод өгчихсөн ийм жишиг байгаа. Тэгээд өнөөдөр Боловсролын багц

хууль, Байнгын хороо, ажлын хэсгүүдийн нөхцөл байдлаас харж байхад бас хэд хэдэн зүйл дээр анхаарал татах зүйлүүд байна. Хэлэлцүүлгийн явцад ялангуяа Боловсролын багц хуулийг хүн бүр нухацтай, маш сайн хэлэлцэх ёстой. Тэгээд ёстой нөгөө 7 хэмжиг, 1 огтол гэдэг шиг сайн хууль гаргаж Монголын боловсролын салбарыг сэргээх цаг нь хэдийнээ болчихоод байгаа гэдгийг бас юуны өмнө хэлье гэж бодож байна. Тэгээд ер нь ингээд хамгийн сайн багш бэлтгэсэн сургуулиуд үнэхээр өөр байдаг. Би жишээ нь Чингэлтэй дүүргийнхээ Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн оюутнууд дунд сүүлийн 6 жил дандаа нөгөө элсэлтийн шалгалтад бэлтгэх ийм уралдаан болоод тэд нарыг боломж өгөх тийм шалгалтууд уралдаан олимпиадууд байнга зохион байгуулдаг. Эндээс харахад төвийн сургуулиуд маш хүүхдүүд нь тэр математикийн олимпиадад, англи хэлний олимпиадад, элсэлтийн ерөнхий шалгалт өгөх, бэлтгэх тэр олимпиадууд маш амжилттай оролцоход захын сургуулиудын хүүхдүүд маш өрөвдөлтэй байдалтай байдаг. Тэгээд учир шалтгаан нь юу юм гэхээр багшийн асуудал байгаад байгаа юм. Тэр хотын захын сургуулиудад очиж багшлах багш өнөөдөр дутмаг байна. Бас хангалтгүй байна. Зарим сургуулиудын багш нарын үнэлэмж өндөр байхад зарим сургуулиуд нь үнэлэмж бага байх. Ингээд нь өөрөө боловсролын ялгааг бий болгож Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хүүхэд багачууд маань ялгавартай эдэлж байгааг харахад үнэхээр харамсалтай байсан. Тэгээд бид боловсролын ерөнхий багц хуулиар энийг л халах ёстой гэж бодож байгаа. Би тэгээд Энх-Амгалан сайд болон боловсролын салбарынхнаас боловсролын ялгааг, багшийн чадамж, тэр сурч байгаа хүүхдүүдэд нөхцөл орчин, сурч байгаа боловсрол, эзэмшиж байгаа орчин энэ тэрийг хуулиар яг ийм ийм зүйлээр бид халж чадаж байгаа гэсэн тэр тодорхой заалтуудыг та бүхэн минь нэгдүгээрт надад хэлж өгөөч.

Хамгийн гол нь бид багшаа яаж бэлтгэх юм. Энд ингэж байна л даа. Албан боловсролоос гадна албан бус боловсрол эзэмшүүлэх гэж байна. 1 дүгээрт энийг чухалчилж сая ажлын хэсгийн ахлагч ярьж байна л даа. Гэхдээ албан бусыг эзэмшүүллээ гээд багшийн боловсрол, чадамж шууд бол дээшилчихгүй. Багшийг бэлтгэх институт тогтолцоогоо үнэхээр өөрчлөх хэрэгтэй. Бид нар Финлянд улс яаж багшаа бэлтгэдэг юм. Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон улс. Тухайн их, дээд сургуулийн хамгийн мундаг төгссөнийг нь тухайн сургуульдаа багшаараа үлдээдэг байхад, манайд багшийн сургууль маань өнөөдөр ямар байгаа билээ. Тийм учраас боловсролын багц хуулиар багш бэлтгэх, багшийг чанаржуулах, тэр багш үнэхээр хүүхэд сургахын тулд бүхий л сэтгэл зүрхээ зориулахад яаж ажиллах ёстой юм, яаж энэ тогтолцоог бүрдүүлэх ёстой юм. Энэ дээр 1 дүгээрт тодорхой хариулт өгөөч гэж хэлмээр байна.

2-т нь Энх-Амгалан сайд аа, сая англи хэлийг үндсэн гадаад хэл болгож оруулж байгааг бол би 100 хувь дэмжиж байгаа. Энэ бол маш сайн. Харин хүүхдүүд 1 дүгээр ангиасаа шууд ингэж гадаад хэлээр сурах нь өөрөө эрсдэлтэй. Тийм учраас 1 дүгээр ангиасаа гэсэн юм сүүлийн үед олон нийтийн сүлжээнд явснаас нэлээд их маргаан дагуулж байна л даа. Хүүхэд 1 дүгээр ангид орохдоо нөгөө бичиг, үсэг сайн сурах, тоо математик гээд ачаалал их байдаг. Тэгэхээр та 3 дугаар ангиасаа юм уу, 1 дүгээр ангиас юм уу. Энийг маш тодорхой болгож хариулт өгөх хэрэгтэй байна. Тэгээд эдгээр зүйл дээр асуулт аваад, шаардлагатай бол тодруулъя.

Г.Занданшатар: Байнгын хороо, Гонгорын Дамдинням гишүүн. Хариулах хүн байгаа юм уу. Уг нь Байнгын хороо л ажиллах ёстой, хариулах ёстой л доо. Эхний хэлэлцүүлэг шүү дээ. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн ахлагч орж ирэх байх. Оюунчимэг гишүүн ээ, Ерөнхийдөө Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, хувийн сургууль, төрийн сургуулиудын ялгааг арилгах, хамгийн сайн багшаар хичээл заалгах, ер нь боловсролын чанарын асуудал бол багшийн чанарын асуудал гэдэгтэй бол санал нэг байгаа. Тэгэхээр бид нар 6 зүйл дээр өөрчлөлт хийхээр зориод байгаа юм. Яг үндсэн багц хууль дээр.

1 дүгээрт одоогийн өнөөдөр явж ирж байгаа боловсролын санхүүжилтийнхээ тогтолцоог өөрчилж. Нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал дээр хотын хүүхэд, хотын сургуулийн хүүхэд, хөдөөгийн сургуулийн хүүхэд, хотын төвийн сургуулийн хүүхэд хотын захын сургуулийн хүүхэд гэж ялгаад бид нар үнэлж, үзэж тэр хувьсах зардал дотор нь тэр сургалтын орчнуудын ялгаа, яг тэр нөгөө хөтөлбөрүүдийн ялгаа, багшийн арга зүйн чадваруудын ялгаануудыг ингэж дээр арилгая. Ер нь үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бид нар бий болгоё. Өнөөдрийг хүртэл явж ирж байгаа тогтолцоо нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал бол байгууллага санхүүжүүлсэн байна. Цэцэрлэг санхүүжүүлсэн байна. Сургууль санхүүжүүлсэн байна. Одоо бол 1 хүүхдийг сургаж байгаа хувьсах зардлууд хүүхдээ дагаж явдаг. Хүүхдийн өөрийнх нь авьяас чадвар, сургалтын түвшин, сургалтын орчнуудын ялгааг нь арилгаж санхүүжүүлдэг ийм үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо руу оруулъя. Ингэх юм бол боловсролын чанарын ялгааг арилгахад бол хамгийн чухал санхүүжилтийн хөшүүрэг байна гээд 1 дүгээр асуудал, 1 дүгээр шинэчлэл.

2 дугаар асуудал хөтөлбөрийн шинэчлэлийн асуудал байгаа юм. Тэгэхээр өнөөдөр манай ерөнхий боловсролын сургуулиудын хөтөлбөрийн шинэчлэл бол цаг үеэсээ хоцорсон байна. Тийм учраас

хөтөлбөрийн шинэчлэл хийж 21 дүгээр зуун буюу аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд амьдрах Монгол хүнийг бэлдэх ийм хөтөлбөр байна гэдэг асуудал.

3 дугаар асуудал бол өнөөдрийн Монгол Улсад байгаа багш бэлдэж байгаа тогтолцоо. Багш төгсөөд ажлын байран дээр ажиллах тасралтгүй хөгжих, багшийн ажлын хөдөлмөрийн үнэлэмжийн асуудлууд, багшийн нийгмийн баталгааны асуудлууд дээр тодорхой ахиц дэвшилүүд гаргая. Хамгийн сайн нь Ерөнхий боловсролын сургууль төгсөөж байгаа хамгийн сайн нь багш болдог энэ тогтолцоо руу бид нар шилжих ёстой юм байна. Тийм ээ, өнгөрсөн 30 жилийн түүхэнд бид нар тодорхой алдаа дутагдлууд гарсан. Шилжилтийн маш хүнд үеүд байсан. Тэгэхээр яг үнэхээр цаашидаа багш бэлдэж байгаа тогтолцоо, ер нь бол багш бэлдэж байгаа сургуулиуд дурын сургуулиуд багш бэлддэг байдлаасаа больё. Ер нь өнөөдөр багш бэлдэж байгаа 40 гаруй сургуулиуд байсан. Одоо 20 орчим болж цөөрсөн байгаа. Цаашидаа багшийг бэлдэхдээ энэ хөтөлбөр нь заавал ч үгүй магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр багш бэлддэг сургуулиуд байх ёстой гэсэн ийм шаардлагууд бас тавьж өгөөд 1 дүгээрт, 2 дугаарт багшийг ажлын байран дээр очиход нь тасралтгүйгээр хөгжүүлдэг тогтолцоог бид нар бий болгоё. Өнөөдөр хүртэл Монгол Улсад явж ирсэн нөгөө багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн тогтолцоог бид нар халж байгаа. Энэ бол үеэ өнгөрөөсөн ийм тогтолцоо. Багш өөрийнхөө хэрэгцээ шаардлага дээр тулгуурласан сургалтуудыг ажлын байран дээрээ үргэлж авдаг. 3 дугаарт яг ажлынхаа хөдөлмөрийн үнэлэмжийг бодитойгоор үнэлүүлдэг тогтолцоо руу шилжүүлж гээж.

4 дүгээр асуудал шинэчлэлийн асуудал бол үнэлгээний шинэчлэлийн асуудлууд байгаа юм. Тэгэхээр өнөөдөр хүртэл манай Монгол улсын бид нарын

хийж чадаагүй зүйл бол үндэснийхээ үнэлгээний тогтолцоог бид нар хийж чадаагүй байна. Өнөөдрийн хүүхдийн дүн тавьж байгаа энэ тогтолцоо бол шударга бус тогтолцоо, хуурамч тогтолцоо. Тийм учраас цаашидаа бид нар хүүхэд бүрийн боловсролынх нь түвшин, тэр хүүхэд бүрийнх нь сурах чадвар хурдтай нь тулгуурласан ийм үнэлгээний ахиц дэвшлийн үнэлгээний тогтолцоонд шилжүүлбэ. Хүүхдийн үнэлгээ, багшийн үнэлгээ, сургуулийн үнэлгээ гэсэн үнэлгээний тогтолцоонд шилжүүлбэ. Ер нь нөгөө хэмжиж чадахгүй бол үнэлж чадахгүй, үнэлж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гэдэгтэй адилхнаар өнөөдөр Монгол Улсад боловсролын үнэлгээний тогтолцоог шинээр бий болгох ийм зайлшгүй шаардлага бий болсон байна гэж харж байгаа юм.

4 дүгээр асуудал мэдээж боловсролын засаглалын асуудал байгаа. Сургууль, цэцэрлэгүүдийн удирдлагуудыг улс төрөөс хэт хараат томилгоо байна. Тийм учраас энийг тодорхой яг мэргэжлийн чадавхын чадамж дээр үндэслэсэн ийм тогтолцоонд шилжүүлэх нь зүйтэй юм байна гэж. 5 дугаар.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням. Байнгын хороо л хариулах ёстой л доо уг нь.

Г.Дамдинням: Оюунчимэг гишүүн их зөв санаа тавьсан асуулт асууж байна. Манай боловсролын салбарыг өөд нь татахын тулд багш нарыг л ерөөсөө сайжруулах ёстой юм байгаа юм. Тэгэхээр хамгийн сайн хүмүүс, хамгийн сайн төгсөгчид багш болгохын тулд бид нар эдийн засгийн болон нийгмийн баталгааг нь энэ ажлыг хийж байгаа хүмүүст олгох ёстой юм. Боловсролын ерөнхий хуулиар хэд хэдэн зүйл заалтыг оруулж байгаа. Ялангуяа та захын дүүргүүд болон бас хөдөө орон нутаг, алслагдмал аймгуудад байдаг

хүүхдүүдийн багш нарын чанар болон тэдгээрийн сургалтын чанартай холбоотой асуудал асуулаа. Боловсролын ерөнхий хуулиар орж ирж байгаа нэг том зохицуулалт бол сум, тосгон, баг дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын багш ажилтнуудыг эхний 5 жилдээ 6 сар, тэгээд цаашаа 3 жил тутамд 6 сартай тэнцэх үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг өгч байхаар хуульчилж байгаа. Энэ бол бас нэг том дэмжлэг болно. Дараагийнх нь Боловсролын ерөнхий хуулийн төсөлд бас нэг зүйл орж ирж байгаа. Юу вэ гэхээр боловсролын салбарт ажиллаж байгаа багш, мөн ажиллах хүчин гэж байгаа. Ажилтнууд гэсэн үг. Өөрөөр хэлбэл боловсрол чинь дан ганц багш нараар явагдахгүй. Тэр орчин нөхцөлийг бүрдүүлж байгаа ажилтнууд байгаа. Энэ хүмүүст бас 15 жилээс доош тасралтгүй ажилласан, 15 жилээс дээш тасралтгүй ажилласан хүмүүсийн нэг хүүхдийг Монгол Улсын эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуулиудад үнэ төлбөргүй сургана гэсэн ийм заалт байгаа. Өөрөөр хэлбэл одоогийн байдлаар 23,700 хүн салбартаа тасралтгүй ажиллаж байна. Ингээд цаашидаа хэрэгжээд явна гэсэн ийм зорилготой байгаа. Мөн бас цалин урамшууллын тогтолцооны асуудал хуулиар орж ирэхгүй. Яагаад гэвэл цалин урамшуулал болон тэтгэвэртэй холбоотой асуудал маш их яригддаг ч гэсэн салбарын хуулиар зохицуулахгүй байх ийм зохицуулалт ороод ирчихсэн байгаа. Үр дүнгийн санхүүжилттэй холбоотой асуудлууд явж байгаа. Өөрөөр хэлбэл хэн хамгийн сайн үр дүнтэй ажиллаж байна тэр нь өөрөө илүү цалин аваад явдаг ийм боловсролын санхүүжилтийн цогц реформ хийгдэж байгаа юм. Хуучин бид нар тогтмол болон хувьсах зардлаар сургуулиудыг санхүүжүүлдэг байсан бол одоо үр дүнгийн урамшууллын санхүүжилт гээд хагас бие даасан санхүүжилтийн

тогтолцоо руу шилжүүлж байгаа нь бас нэг том ахиц болчихоод байгаа юм. Одоогийн байдлаар үндсэндээ бараг 50 орчим хувь нь нэмэгдэл цалин авах ийм боломжтой явж байгаа. Санхүүжилтийнхээ хувьд. Тэгээд үр дүнд суурилсан санхүүжилтийн систем гэдэг нь бас нэг том реформ юм. Энэ нь орон нутгуудад шийдэгдэнэ.

Түрүүн бас Энх-Амгалан сайд хэлж байна лээ. Хувьсах болон тогтмол зардлууд дээр алслалын байрлалаас хамаарч хүүхдийг санхүүжүүлж байгаа. Өөрөөр хэлбэл төв суурин газрын хүүхэд эсвэл Баян-Өлгий аймагт юм уу эсвэл Дорнод аймагт байгаа сургуулийн хүүхэд дээр очиж байгаа хувьсах зардлын хэмжээ өөр тооцооллоор очно гэсэн үг. Алслагдаж байгаа бол илүүг аваад явна гэсэн үг. Боловсрол авах тэгш хэрэгцээний суурь зарчмыг хангах ийм санхүүжилтийн өөрчлөлтүүд орж байгаа.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн тодруулъя. 1 минут.

М.Оюунчимэг: Салбарын сайд хэлж байна. Өнөөдрийг хүртэл байгууллагыг санхүүжүүлж ирсэн, одоо бид хүнээ санхүүжүүлнэ гээд. Гэтэл яг өнөөгийн нөхцөл байдлаас харахад өнөөдрийн манай сургууль, цэцэрлэгүүдийн байдал нь 19 дүгээр зууны модон сандал ширээ 00-той, 20 дугаар зууны үнэхээр өрөвдмөөр сурах бичигтэй. Тэгээд багш нарын маань чадавх дахин давтан мэргэшүүлэх тал нь хоцрогдчихсон. Санхүүжилтээр дамжих механизм маань үр дүнд суурилсан гүйцэтгэл гэдэг нь бараг 0 заалттай ийм байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хууль ердийн горимоор буюу батлагдсан даруйдаа хэрэгжиж эхэлнэ гэсэн ойлголттой би байгаа. Хэрвээ ингэж хэрэгжиж эхэлбэл бэлтгэл ажил, дэд бүтэц, бид нарын энд яриад байгаа юм маань бэлэн үү. Яг үнэнийг хэлэхэд өнөөдөр сурах бичиг, багш, хүний нөөц үнэхээр асуудалтай байгаа. Сая жишээ

нь нөгөө Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын салбарын сайд бас айлчилж байсан. Хөгжлийн гол нууц бол хүн өөрөө байдаг. Хүн гэдэг нь өөрөө хөдөлмөрлөх чадвартай хүний нөөц. Тэрнээс их, дээд сургууль төгссөн нь биш гэж ярьж байсан. Тэгэхээр бид асуудал.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсгийг ахлагч Гонгорын Дамдинням.

Г.Дамдинням: Би түрүүний асуусан асуулт дээр нь бас дутуу хариулсан байна. Англи хэлтэй холбоотой заалт бол орж байгаа. Оюунчимэг гишүүн ээ, англи хэлтэй холбоотой заалтыг Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль байхгүй юу. Боловсролын ерөнхий хууль. Тэгэхээр Монгол Улсын бүх боловсролын тогтолцоонд жигд үйлчилнэ. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, дээд, мэргэжлийн боловсрол гээд тэгээд насан туршийн боловсрол. Тэгээд тэнд юуг тавьж байгаа вэ гэхээр ялангуяа ерөнхий боловсролын салбар дээр гэх юм уу эхлээд үзэх үндсэн гадаад хэл нь Англи хэл байна л гэж орж байгаа болохоос 1 дүгээр ангиас орох уу, 5 дугаар ангиас орох уу тийм тухай хуульд бол орох боломжгүй шүү дээ. Энэ бол хөтөлбөрийнхөө дагуу явж байгаа. Боловсролын яамныхан маань 3 дугаар ангиас орно гээд явж байгаа. Мэдээж бид нар гадаад хэлийг оруулж ирэх, олон улс, дэлхийтэй холбогдох нь зүй ёсны асуудал боловч нөгөө талдаа бид нар Монгол хүн Монголын боловсролын тогтолцоог хийж байгаа шүү дээ. Тийм ээ. Хууль хэрэгжиж эхлэх тухайд Ерөнхий хуулийг дагаад дахиад 3 хууль орж ирнэ. Энэ 3 хууль батлагдсаны дараа бүрэн хэмжээнд хэрэгжиж явна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Улс орны хөгжил бол хүний хөгжил гэж. Хүний хөгжлийн асуудлыг ярих юм бол боловсролын

хуультай салиггүй холбоотой. Олон улсын байгууллагууд танай хөгжлийн мухардал бол юутай холбоотой вэ гэхээр уул уурхайдаа тавьдаг анхаарал халамж, анхаарал шигээ боловсролдоо та нар анхаарал тавьсангүй гэдэг ийм дүгнэлтийг бол хэлдэг л дээ. Боловсролын шинэчлэлийг ярихдаа бол бид өнгөрсөн 30 жилийн алдаандаа хариулт өгөх ёстой. Өнгөрсөн хугацаанд боловсрол эзэмшсэн бүх хүн ажил хийж чадаж байна уу. Нөгөө 200 хэдэн дээд сургууль маань хэд болчихоод байгаа юм. Хүссэн болгонд нь ингээд өгөөд 200 хүргээд байх юм. Энэ маань зөв юм уу, үгүй юу. Боловсрол эзэмшсэн хувийн болон хувьсгалын сургуулиуд боловсрол эзэмшсэн хүмүүс, залуучууд хаа явж байна. Хэчнээн хүн өнгөрсөн хугацаанд боловсрол эзэмшсэн бэ. Хэчнээн ажилтай байдаг юм бэ. Боловсролын түвшин хөдөлмөрийн зах зээлд оролцоход хэр зэрэг нөлөөлдөг юм бэ. Боловсролтой байхын давуу тал юу байдаг юм бэ. Хүүхэд, залуучууд хүссэн боловсролоо эзэмшиж чадаж байна уу. Боловсролд хөрөнгө оруулалт оруулах ямар хөшүүрэг байна гээд маш олон асуудлуудад хариулт өгөх ёстой энэ хууль. Маш том хууль энэ. Тэгээд энэ болгоныг яг шийдэж чадаж байна уу, үгүй юу гэдэг асуудал их чухал болчихоод байгаа юм. Хүүхдийн ирээдүйн боловсролын түвшинд хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг бол эцэг эхийн боловсролын асуудал. Хүүхдээ боловсролтой болгоход эх эцгийн нөлөө бол асар их байгаа. Тэгээд энэ тэрд хариулт өгч байгаа байх гэж ингэж бодож байна. Тэгээд би 2, 3 асуултууд байна.

1 дүгээрт нь олон улсын байгууллагууд, хүүхдийг, ялангуяа сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэг энэ тэрд хүүхдүүдийг аль болохоор ачааллаас багасгах, тэр хүүхдийнх нь, өөрийнх нь зоргоор тэр боловсролыг нь олгох тодорхой хэмжээний ийм зүйлийг ярьсан байдаг л даа. Манайд ер нь хийсэн судалгаа ямар байдаг юм. Монгол хүүхдүүдийн хувьд бол ямар байдаг юм.

Тухайлбал миний сая ярьж байгаа бол Финландын боловсролын тэр юмнаас ярьж байна л даа. Манайд ер нь хийгдсэн судалгаа байдаг юм уу, үгүй юм уу. Сургуулийн өмнөх тэгээд дунд сургуулиуд, дээд сургуулиудад сургалтын Монголд онцлогтой ямар хөтөлбөрүүд байна. Мэдээж олон улс дээр ИТ, тэгээд байгаль орчин, шинжлэх ухаан, технологи, тогтвортой хөгжил, эрүүл мэнд, ёс зүй, мэдээллийн технологи, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хүртэл оруулж ингэж харуулсан байгаа юм. Манайд яг онцлогтой ямар хөтөлбөрүүд байна. Энийг товч хэлж өгөөч ээ гэж.

Дараагийн асуулт бол яг өнөөдөр Монгол Улсын боловсролдоо дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ боловсролд оруулж байгаа санхүүжилт, дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ хэдэн хувьтай тэнцэж байна. Төсвийн хэдэн хувь байдаг юм. Энэ хууль хэрэгжиж эхэлснээр хувь хэмжээ яаж нэмэгдэх вэ. Ер нь аливаа ажил эдийн засгаар баталгаажуулаагүй бол амь сүнсгүй байдаг. Боловсролын салбарын доголдол бол эдийн засгаар баталгаажуулаагүй байгаа. Тэгэхээр эдийн засгаар баталгаажуулах чиглэлд ямар ажлууд хийгдэж, ямар санаанууд энд орж ирж байна.

Сүүлийн асуулт Боловсрол, шинжлэх ухааны холбоо. Боловсрол, шинжлэх ухааны яам гэж байгаа шүү дээ. Тэгэхээр сургуулиуд боловсролын асуудлыг шинжлэх ухаанаас салгаж ойлгох арга байхгүй. Тэгэхээр энд шинжлэх ухаантайгаа холбогдсон энэ асуудлууд ер нь яаж холбогдож орж ирж байна. Өнгөрсөн хугацаанд ямар алдаа, оноо байв. Одоо яаж.../минут дуусав/

Г.Занданшатар: Энх-Амгалан сайд хариулна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Баттөмөр гишүүн их чухал асуудал хөндөж байна.

Боловсрол угаасаа мэдээж улс орны хөгжил, тэр тусмаа эдийн засагтай шууд холбоотой Өнөөдрийн ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн асуудал бол цэвэр боловсролын тогтолцоо. Боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалтын өгөөж байгаа юу, байхгүй юу л гэдгээр бид нар хэмжиж үзмээр юм байна лээ. Би таны асуусан сүүлийн асуултаас нь хариулчихъя гэж бодож байна.

Өнөөдөр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 4.2 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг бид нар боловсролд зарж байна. 2.2 их наяд гэсэн үг шүү дээ. Урсгал төсвийн 16 орчим хувийг өнөөдөр боловсролд зарж байгаа юм тоогоороо. Тэгээд 1 сурагчид ноогдож байгаа зардал гэх юм бол 500 орчим доллар байна. Тэгээд энэ дүн бол яг дотоодын нийт бүтээгдэхүүний 4.5, төсвийн урсгал зардлын 16 хувь бол энэ үзүүлэлт их сайн үзүүлэлтүүд. Бусад улсуудтай харьцуулахад. Хамгийн гол нь яг 1 сурагчид ноогдож байгаа тэр сургалтын зардал нь 500 доллар гэдэг бол арай дэндүү бага үзүүлэлтүүд байхгүй юу. Одоо жишээ нь бид нарын хамгийн наад захын Мексик гэж улсаас л бид нар даруй 5 дахин бага мөнгө боловсролдоо зарж байна л гэсэн үг шүү дээ. Мексикээс бид нар боловсролын чанараар 5 дахин бага байна л гэсэн үг. Бид нар Финлянд нөгөө Нортикийн орнууд, Солонгос, Япончуудыг хэлэх юм бол бид нар 20 дахин, 30 дахин боловсролд зарж байгаа мөнгө бага байна л гэж ойлгож болно. Тэгэхээр ийм учраас бид нар цаашидаа яг энэ Боловсролын багц хуулиар хийх гэж байгаа асуудал бол ерөөсөө боловсролын санхүүжилтийн механизмын тогтолцоог нь өөрчилмөөр юм байна. 1 хүүхдэд сургаж байгаа тэр хувьсах зардлуудын аргачлалуудыг нь өөрчилмөөр юм байна. Тэр хүүхэд өнөөдөр хаана сурч байна, хаана амьдарч байгаагаасаа үл шалтгаалж яг тэгш чанартай боловсрол авах санхүүгийн механизмуудыг нь бид нар 1 хүүхдийг сурах хувьсах зардлаараа

хийж өгч, түүгээр нь тодорхой үр дүнг нь хэмждэг ийм тогтолцоо руу бид нар шилжүүлж гэж байгаа юм. Одоо жишээ нь ингэхэд бид нар чинь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй харьцуулахад 1 талдаа хөдөлмөрийн ажиллах хүчний хомсдол бий болчихсон байдаг. Гэтэл нөгөө талдаа 100 гаруй мянган хүн ажилгүй байгаад байдаг. Тэр ажилгүй байгаа залуучуудын дунд дээд мэргэжилтэй 35-аас доош насны залуучууд чинь зонхилох хувийг нь эзэлж байгаа ийм нөгөө хөдөлмөрийн зах зээлийн гажуудал үүсчихсэн. Тэр тусмаа цаашидаа хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ур чадварын гажуудал, ур чадварын гаанууд үүсчихсэн. Нөгөө ажил олгогч нарын хүсэж байгаа хүмүүсийг бид нар бэлдэж, нийлүүлж чадахгүй байна л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр бид нар ерөнхийдөө өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа хууль бол Боловсролын ерөнхий хууль. Боловсролын ерөнхий хуулиар сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын түвшинд санхүүжилтийн тогтолцоо нь ийм тогтолцоо байх юм гэдэг санхүүжилтийн гол зарчмаа бид нар өнөөдөр ерөнхий хуулиараа ярилцаж байгаа юм. Тэгээд цаашидаа бид нар сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын хуулиудыг бид нар бие даасан хуулиуд орж ирнэ шүү дээ. Энэ хуулиудаараа бид нар таны ярьж байгаа тэр боловсролын түвшин хооронд хийгдэх гэж байгаа асуудлуудыг шийдэх шийдлүүдээ яриад ямархуу эрх зүйн шинэчлэл хийгдэх гэж байгаа юм бэ гэдэг зүйлүүд дээрээ тодорхой ойлгоцлоо бий болгоод явчих болов уу гэж бодож байна.

Таны тэр хэлж байгаа эцэг эхийн боловсролын түвшнээс хүүхдийн боловсролын түвшин шууд шалтгаалдаг. Шууд шалтгаалдаг. Эцэг эх нь өнөөдөр дунд боловсролтой байна уу, дээд боловсролтой байна уу гэдгээс цаашидын хүүхдийн ирээдүй шалтгаалдаг. Ийм

фактор ийм үзүүлэлтүүд байдаг. Тийм учраас бид нар ерөнхий боловсролын заавал 12 жилийн тогтолцоог заавал 12 жилийн тогтолцоотой болгож байгаа. Энэ бол манай боловсролын салбарын том шинэчлэл хийж байгаагийн нэг том алхам гэж харж байгаа юм. Тэгэхээр хүүхдийн нэг сургуульд сурах нэг жил нэг жилээр нэмэгдэх тусам тэр хүүхэд ирээдүйдээ амжилт олох ирээдүйн орлого нь нэмэгдэх бас тэрэнтэй иууд хамааралтай ийм үзүүлэлтүүд байдаг юм байна. Тэгэхээр тэр боломжуудыг бид нар олгох ийм эрх зүйн шинэчлэлүүд л хийж байгаа юм гэж бас хэлэхийг хүсэж байна.

Г.Занданишатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Өнөөдөр бол маш чухал хууль хэлэлцэж байна. Бид нар бол 2 том гүрний дунд хүн ам ихтэй улсуудтай зэрэгцэж амьдарч байгаа. Энэтэй зэрэгцэж амьдаръя гэх юм бол бидний гол анхаарах зүйл бол боловсролтой иргэдтэй байж байж л ийм хүн ам ихтэй улс орнуудтай зэрэгцэж амьдрах боломжтой. Боловсролын асуудал бол 1 дүгээр зэргийн чухал асуудал. Тийм учраас Боловсролын хуульд хийх гэж байгаа юм дотор орлого багатай иргэдээ л орхиж болохгүй. Энэ бол хамгийн чухал анхаарах зүйл. Том улс орнууд бол ялгаад, салгаад явчихдаг. Мөнгөнийх нь хэмжээгээр. Манайд бол тэгж болохгүй. Тэнд ажилчин ангиа бэлддэг сургалтын тогтолцоо нь өөр. Элитээ бэлддэг тогтолцоо нь өөр. Үгүй. Манайд бол ер нь хуучин Оросын бидэнд үлдсэн байгаа элит сургалтын тогтолцоо бол хамгийн сайн. Энийг бол ерөөсөө агуулга стандартыг бол өөрчилж болохгүй. Ер нь боловсролын гол зорилго бол ёс суртахуунтай иргэн бэлдэх л асуудал шүү дээ. Боловсролтой. Тэгээд сургалтын агуулга стандарт, сургалтын хөтөлбөр боловсруулна гэдэг бол хамгийн чухал зүйл. Хуучин бол шинжлэх ухаанд үндэслэж эрдэмтэн, судлаачид хийдэг байсан сурах бичгийг.

Сүүлд нь явцуураад 2000-аад оны эхэн үеэр багш нар хамгийн сайн сурах бичиг хийдэг гээд ингээд солиороод эхэлсэн. Тэгээд нөгөө шинжлэх ухааны үндэстэй хийж байсан юмаа нурааж эхэлсэн байхгүй юу. Нөгөө хүнээ бэлдэж байсан юмаа, эх оронч хүн бэлдэж байсан юмыг, Монгол хүн бэлдэж байсан юмнуудаа нураагаад эхэлчихсэн. Тэгээд янз бүрийн гаднын хөтөлбөр оруулж ирээд. Тэгэхээр хүн бэлдэх асуудал 1 дүгээрт хамгийн чухал гэдгийг би хэлье. Тэгээд энд нэг ийм асуудал байгаа юм. Үндсэн хуулийн 16.7 дээр ерөнхий боловсрол төрөөс ерөнхий боловсролыг үнэгүй олгоно гэж байгаа байхгүй юу. Үнэгүй олгоно гээд байна шүү. Тэгээд төрөөс тавьсан шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулж болно гэж байгаа байхгүй юу. Төрөөс тавьж байгаа шаардлага нь юу юм үнэгүй олго гэж байна шүү дээ. Гэтэл өнөөдөр төлбөртэй хувийн хэвшлийн сургуулийн тухай яриад байна шүү дэ. Энэ чинь Үндсэн хуулийнхаа эсрэг байгаад байна. Энийг яаж зохицуулж байгаа юм. Үндсэн хууль дээр ерөнхий боловсрол үнэгүй олгоно гэсэн байна. Энэ дээр би нэг хариулт авъя. Тэгээд одоогийн яриад байгаа энэ нэг үр дүнд суурилсан гээд байгаа санхүүжилтийн тогтолцоо чинь явж явж хувийн хэвшлийг дэмжинэ шүү. Одоо та нар анхаараарай. Эрүүл мэнд дээр бид нар яг ингэсэн. Үр дүн суурилна гээд л тэгсэн. Улсын том поликлиникин эмнэлгүүд бол яах вэ гайгүй байгаа. Жижиг нөгөө яг хүн амд хүрэх ёстой жижиг суурин газруудын эмнэлгүүд өрхийн эмнэлгүүд бол маш хүнд болчихсон. Хувийн хэвшлийн том эмнэлгүүд нь сайжраад явчихсан. Тэгэхээр ер нь зах зээлийн эдийн засагт нэг хэцүү юм байдаг нь ерөөсөө ингээд хувийн хэвшлийн салбарыг хэтэрхий дэмжих нь боловсрол эрүүл мэндийг хохироодог. Нөгөө төлбөр нь. Яагаад гэвэл нийт иргэд нь ядуу байдаг учраас тэд нар хохирдог. Өнөөдрийг хүртэл Монголын боловсролын санхүүжилтийн тогтолцоо, одоогийн боловсролын систем бол ядуу ч гэсэн иргэн сурч, боловсорч болдог. Үр дүнд суурилна гээд л

ингээд л гоё юм яриад эхлэх юм хазайж эхэлнэ гэж би ингэж бодож байгаа юм. Энэ үнэлгээний тогтолцоо бол удирдах санхүүжилтийн хуулиар хийх гээд үзсэн юм. Тэгээд дампуурсан юм. Одоо дахиж хийх гээд байна шүү дээ. Тэгээд би яаж хэрэгжихийг нь мэдэхгүй байна. Тэгээд багш нарын асуудал бол чухал. Тэгээд нийгмийн баталгаа цалингийн асуудал бол чухал. Гэхдээ хуучин социалист системд байсан багш нарын тэр үнэлэмж одоогийн зах зээлийн системд тэр хэмжээнд бий болоход маш хэцүү зүйл. Маш хэцүү зүйл. Тийм учраас энэ асуудлыг маш зөв явахгүй бол ялангуяа санхүүжилтийн тогтолцоо дээр их анхаарахгүй болохгүй шүү. Хувь.../минут дуусав/

Г.Занданишатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Даваасүрэн сайд аа, энэ манай Засгийн газраас өргөн барьсан хууль шүү дээ. Тийм учраас Засгийн газрын гишүүд Засгийн газрынхаа өргөн барьсан хууль дээр нэг зарчимтай байх болов уу. Танхимын, кабинетын зарчим байх болов уу гэж бас би бодож байна. Тэгээд Засгийн газар нь өөрөө шийдээд үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог эрүүл мэндийн салбар, боловсролын салбараасаа хэрэгжүүлж гэж манай Оюун-Эрдэнийн Засгийн газрын реформын хамгийн гол реформын нэг нь энэ 2 болов уу гэж би бодож байгаа. Энэнээсээ бид нар нэг ч алхам ухарч болохгүй. Тэр тусмаа Засгийн газрын гишүүн маань өөрөө үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо бол ухралт болно. Хувийн хэвшлийг дэмжсэн ийм тогтолцоо болно гэдэг нэг ийм буруу ойлголт бас нийгэмд бас төрүүлж болохгүй ээ. Даваасүрэн гишүүн ээ.

Тэгэхээр ерөнхийдөө үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж байж л бид нар хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг л

арилгах гээд байгаа юм шүү дээ. Өнөөдөр нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал 800 мянган төгрөгөөс 1.2 сая төгрөгөөр санхүүжүүлж байна. Энэ дээр чинь ямар ч чанарыг хэмжиж байгаа, үр дүнг хэмжиж байгаа ямар ч зүйл байхгүй байгаа байхгүй юу. Өнөөдөр сумын сургууль дээр байгалийн ухааны лаборатори, мэдээллийн технологийн лаборатори байхгүй, чадварлаг багш байхгүй байхад бид нар хот, хөдөөгийн сургуулийн ялгаа байдгаараа л байна шүү дээ. Өнөөдөр үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо гэдэг чинь энэ ялгааг арилгахын тулд хийх гэж байгаа тогтолцоо байгаа байхгүй юу. Энэ ялгааг. Өнөөдөр Баян-Өлгийн Цэнгэл сум дээр байж байгаа хүүхдийн сурч байгаа хүүхдүүдийн сурах орчин Улаанбаатар хотын сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн сурах орчинтой нийцүүлэхийн тулд хувьсах зардлын тогтолцоог бид нар шинэчилж оруулж ирж өгч байгаа байхгүй юу. Эндээс чинь ийм зөрүүний индексүүд тооцдог больё гэж байгаа юм. Тэгэхээр энэ тогтолцооноос бол бид нар ямар нэгэн байдлаар ухарч болохгүй. Энэ дээр харин ч хувийн хэвшлийн сургуулиуд дээр санхүүжилт өгдгийг бид нар больж байгаа шүү дээ. Олон улсын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургуулиуд дээр бид нар хувьсах зардал өгдгийг болиулсан. Тийм учраас цаашидаа бид нар ерөнхийдөө үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургуулиудыг санхүүжүүлэх ийм л юм байгаа юм. Үндсэн хуулиар олгогдож байгаа зохицуулалтууд байгаа. Бид нар чинь хувийн сургуулиудыг хаана гэж хэлээгүй шүү дээ. Төрөөс тавьсан шаардлагын дагуу гэж байгаа. Тийм учраас цаашидаа бид нарын оруулж ирж байгаа Засгийн газраас өргөн барьсан хууль дээр бол төрийн байна уу, хувийн хэвшлийн сургууль байна уу ямар ч байсан өнөөдөр Монгол Улсын үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг тэр үндэсний хөтөлбөрөөр дамжиж байгаа тэр боловсролын стандартуудыг хэрэгжүүлдэг тэр тогтолцоо руу л бид нар байх ёстой гэж ойлгож байгаа.

Би тантай нэг зүйл дээр маш санал нэг байна. Яагаад гэвэл орлого багатай иргэдийн хүүхдүүд дундаж давхарга гэж бид нар ярьж байгаа. Энэ дундаж давхаргын хүүхдүүдийг бид нар тэгш боломж олгохын тулд өнөөдрийн үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бид нар нэвтрүүлэхээр оролдож байгаа юм. Тэгэхгүй бол өнөөдөр хувийн сургуульд сурч байгаа 40 мянган хүүхдүүд нь хамгийн өндөр хэлний боловсролтой. Олон улсын хамгийн өндөр шалгалтуудын босго давдаг, тэгээд гадаадын их, дээд сургуулиудад явдаг. Ийм нөгөө яг жинхэнэ утгаар нь баян хоосны ялгаа гарч байгаа ийм тогтолцоо байгаа байхгүй юу. Одоо бид нарын хийх гэж байгаа хувьсах зардлаар нь өөрчилж байгаа санхүүжилтийн тогтолцоо, үр дүнгийн тогтолцоог нэвтрүүлж чадах юм бол өнөөдөр хүүхэд хаана сурч байна, хаана амьдарч байгаагаасаа үл шалтгаалаад хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарын орлого нь ямар байхаас үл шалтгаалж хүүхэд бүрд тэгш сурах тэр боломжуудыг л олгоё гэсэн ийм санхүүжилтийн тогтолцоо руу л бид нар нэг алхам урагшилж байгаа юм гэдэгтэй бас санал нэг байна.

2 дугаар асуудал бол үнэлгээний тогтолцоо. Өмнөх бид нарын хийх гэж байсан тэр байгууллагын үнэлгээний тогтолцоо гэдгээс жаахан өөр юм Даваасүрэн гишүүн ээ. Энэ бол яг бид нарын ярьсан нөгөө олон улсад байдаг Кембриж гэж олон улсын хөтөлбөрийн байдаг яг боловсролын чанарын үнэлгээний тогтолцоо бид нар яриад байгаа байхгүй юу. Чанарын үнэлгээний тогтолцоо. Тэгэхээр өнөөдөр үндсэндээ хүүхдийн дүн тавьж байгаа энэ тогтолцоо чинь бол хуурамч тогтолцоо байгаад байна шүү дээ. Сая Дэлхийн банкны тайлан хэвлэгдэж гарлаа. Монгол Улс ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоонд шилжчихсэн мөртөө 12 дугаар анги төгсөж байгаа хүүхэд чинь 8 дугаар ангийн түвшний мэдлэг ур чадвартай гарч байна. Та нарт

боловсролын түвшинд чинь 3-аас 4 жилийн мэдлэгийн чадварын ийм хоцрогдол бий болчихсон.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Даваасүрэн: Тийм би бас Улсын Их Хурлын гишүүн юм Энх-Амгалан сайд аа. Би Хөвсгөлийн ард түмнийг төлөөлдөг юм. Тийм учраас би Хөвсгөлийн ард түмний үг, багш нарын дуу хоолойг хүргэх эрхтэй юм. Тэр бол Үндсэн хуулиар олгогдсон надад байгаа эрх. Тийм учраас би тэр ард түмний төлөөлөл болсон хүний хувьд тэд нарын санал, гомдлыг хэлэх нь миний эрх. Та харин тэр тойргоос сонгогдсон хүний хувьд миний үгийг дэмжих ёстой байхгүй юу? Харин. Тэр үнэлгээний хувьд бол удирдлага санхүүжилтийн тогтолцоо чинь өөрөө бас ялгаа байхгүй олон улсын аргачлал байсан юм. Тэгээд яваагүй байхгүй юу? Үгүй ээ, багш нарыг үнэлдэг байсан юм. Чи юу ч мэдэхгүй байгаа байхгүй юу. Тэр үед нөгөө төрд ажиллаж байгаагүй учраас. Би мэдээд байна шүү дээ. Тэр багш нарын чинь үр дүнгээр нь үнэлнэ гэсэн юу болсон. Манай намын багш гээд л намын багш нар нь өндөр үнэлгээ аваад л, цалин өндөр аваад л, намын бус багш нар нь бүүр хаягдаад л хамгийн бага цалин аваад л, намын захиралтай сургууль нь хамгийн сайн цалин аваад л.../минут дуусав/

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: Даваасүрэн гишүүн ээ, Удирдлага санхүүжилтийн тэр хууль хэрэгжиж байсан үе, тэрний үед барьж байсан үнэлгээний асуудлаас өнөөдрийн бид нарын нэвтрүүлэхээр оролдож байгаа үнэлгээ арай жаахан өөр юм. Энэ бол бид нар нөгөө сурагчийн үнэлгээ, сурагчийн ахиц дэвшлийн үнэлгээ, багшийн үнэлгээ, байгууллагын үнэлгээ гэсэн яг олон улсад нэвтэрсэн үнэлгээний зарчмуудыг л нэвтрүүлэх гэж

байгаа. Монголын хөрсөнд бий болгож байгаа Өмнө нь гарч байсан алдаа, дутагдлууд байхыг би үгүйсгэхгүй ээ. Тэрийг үгүйсгэхгүй. Гэхдээ бид нар үнэхээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын түвшин, боловсролын хөтөлбөртэй больё л гэх юм бол бид нар үнэлгээнийхээ тогтолцоог бэхжүүлэхээс өөр арга байхгүй. Ерөнхийдөө манай байгууллагын яг тэр үед тийм зүйл гарч байсныг үгүйсгэхгүй. Сургуулийн удирдлагаас гэдэг юм уу, цэцэрлэгийн удирдлагаас, өөрийнхөө тэр багш нарт юу гэдэг юм тийм зөв үнэлгээ тавигдаж чаддаггүй. Тийм үзэл бодлоор нь гэдэг юм уу, намын харьяаллаар нь гэдэг юм уу тэр цаг үе өнөөдрийн цаг үе 2 чинь шал 2 өөр үе байхгүй юу. Тэр ч.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Өнөөдрийн улс төржүүлэх хандлага алга болоогүй, хэвээрээ. Тухайн үед ингэдэг байсан юм. Нөгөө аймгийн боловсролын газар санхүүжилт хуваарилдаг, өөр намын захиралтай сургуулиуддаа нөгөө удирдлага санхүүжилтийн хуулийн зарчмаар дутуу хуваарилаад байдаг нэг иймэрхүү байсан юм. Ер нь бол улс төрждөг. Одоо ч гэсэн хэвээрээ. Тэгэхдээ удирдлага санхүүжилтийн хууль чинь бас л олон улсын хэмжээнд бас л туршигдчихсан хэрэгжчихсэн манайхаас матриц бодлогын хүрээнд хэрэгжүүл гээд балетын сангаас үүрэг авчихсан. Ингээд л нэг хэрэгжүүлчих гэж оролдоод л бүтээгүй л ийм зүйл. Энэ бол амьдрал би ярьж байгаа байхгүй юу. Бүтээгүй юм гэдгийг. Үр дүн суурилна гэдэг бол эрүүл мэнд дээр яаж байна вэ. Жижиг газрууд сумууд багууд будаа болж байгаа байхгүй юу, санхүүжилт байхгүй. Тэгэхээр үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо чинь ийм нөхцөл байдлыг үүсгэх вий гэж би болгоомжилж хэлээд байна шүү дээ. Одоо амьдрал дээр тийм байгаа учраас би хэлээд байгаа байхгүй юу. Нөгөө багийн сургуулиуд чинь дуусна. Нөгөө

сумын сургуулиуд чинь дуусна.../минут дуусав/

Г.Занданишатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр боловсролын хууль бас нэлээд олон сар дунилаа. Тэгэхээр ер нь зүгээр олон сард уншсаны бас шалтгааныг харахад бол нөгөө л хувийн хэвшилээ л нөгөө үзэн ядсан, хэдэн хувийн сургуулиудаа илүү харсан энэ зүйл бол нэлээд бол яригдсан шүү. Харин хувийн сургуулиуд бас гишүүдтэй олон удаа уулзаж, зовлон жаргалаа ярилцаж, ингэсний хүчинд бол энэ хууль бас арай ч бас анх орж ирснээсээ гайгүй батлагдах гэж байна. Тэгэхээр би бол сайд бол харин хувийн хэвшлийнхэн болон гишүүдийн саналыг бол яг чиглэлээр бол нэлээд сайн хүлээж авч байсанд бол талархаж байна. Ялангуяа ковидын үед бол маш олон хувийн сургууль, цэцэрлэг бол хаагдсан шүү дээ. Манай Дамдинням гишүүн ч гэсэн дээр бас нэлээд хүчин зүтгэл гаргасан. Тэгэхээр 1 ийм зүйл яриад байх юм. Амьдралаас тасархай юм яриад байх юм. Солонгост хувийн сургууль байдаггүй, бүгд улсынх, Сингапурт. Тэнд хүртээмж нь байдаг байхгүй юу. Өнөөдөр та нар манай Монголд байгаа бүх хувийн сургуулийг хаахад энэ сургууль чинь хаана ч хүртээмж байхгүй. Хот төлөвлөлт юу болсон билээ. Шинэ баригдаж байгаа хотхонууд чинь нэг ч сургууль, цэцэрлэггүй л баригдаж байгаа шүү дээ. Бүгд авлига аваад хэдэн орон сууцын газар өгчихсөн. Тэгээд хүүхдүүд чинь хаана сурах юм. Энэ ачаалал эцэг эхийн уур бухимдлыг чинь хэдэн хувийн сургуулиуд нуруундаа үүрээд явж байгаа. Ковидын үеэр дийлэнх нь хаагдсан. Ямар ч төрөөс дэмжлэг туслалцаа бас хэцүү хувийнх. Тэгээд л бүгд л хаагдаад л, хаалгаа барьсан шүү дээ. Тэгээд ийм хүртээмжгүй үед ингэж нэг амьдралаас тасархай юм ярьдгаа боль. Өнөөдөр гэрээсээ шууд гараад өгдөг тэр улсын сургуулиуд чинь тэр болгон ерөөсөө алга байна.

Дээрээс нь та нар судалгаагаа хараад үз. Өнөөдөр улсын сургуульд ямар олон хүүхдүүд сурч байгаа билээ. Тэгээд сургуулиуд чинь ингээд нэмэгдэж баригдаад баригдаад энэ чинь хүн намын өсөлтөө дийлэхгүй байна шүү дээ. Тэгэхээр хувийн сургуулиуд бол энэ ачааг үүрэлцэж байгаа. Ер нь манайх шиг ийм цөөхөн хүнтэй газар бол хүүхэд бүрд нь таарсан боловсролын бодлого явуулсан ч болно шүү дээ. Израил тэгдэг шүү дээ. Цөөхөн хүнтэй тэр хүмүүсээ л бүгдийг нь өндөр боловсролтой болгох гээд л дэлхийн хамгийн мундаг багш нарыг хөлслөөд л ажиллаж байна. Яах вэ тэр олон сая хүнтэй газар бол бүгдийг нь ингээд тэгшитгээд явж болно. Тэгэхээр ялангуяа манай хэдэн эмэгтэй гишүүд л энэ дээр бүр улайраад, хувийн сургуулиудыг л үзэн ядаад байгаад би бол гайхаж байна. Хүүхдүүдээ бүгдээрээ ямар сургуульд өгдөг юм бол.

Дээрээс нь би Энх-Амгалан сайдаас нэг ийм юм асууя. Англи хэлийг зарим нь 1 дүгээр ангиас заана гээд л, зарим нь 3 дугаар ангиас заана гээд л. Тэгэхээр энэ багшийн хүртээмжээ яаж шийдэх юм бэ. Би сая дүүргийнхээ сургуулиудаар явсан чинь ерөөсөө багшийн хүртээмж маш муу болсон байна. Хүмүүс ерөөсөө ажил хийгээд ядуураад байна. Тийм учраас гадагшаа явлаа гээд л багш нараа байлгаж дийлэхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ англи хэлний багш нар чинь хүртээмж нь хэр байгаа юм. Дээрээс нь академик боловсролоор Монгол хүүхдүүд ер нь гологддоггүй юм байна лээ. Амьдрах ухааны боловсрол, зөв хүн болж төлөвших, дэлхийд өрсөлдөх чадвартай иргэн болоход. Тэгэхээр энэ дээр ямар дэвшилт зүйлүүд орсон бэ гэдгийг асуумаар байна. Дээрээс нь энэ хүүхэд харах үйлчилгээний асуудал юу болов. Ингээд улам бүдгэрээд явчихлаа. Энэ бол өөрөө маш хэрэгтэй хөтөлбөр шүү дээ. Хөдөө баг дээр ч тэр, манай алслагдсан гэр хороололд ч тэр хүүхэд харах үйлчилгээ чинь улам л багасаад байгаа харагдах юм.

Дээрээс нь би танд нэг санал хэлсэн. Том том хотхонуудад улсын сургуулийн харьяа бага ангийг нээж болохгүй юу гэж. Яагаад гэхээр бага ангид нэг л багш заадаг. Тэр 30, 40 хүүхдийг заавал хэдэн гудамж дамнаад эцэг эх нь бүгд хүргэж өгч байхаар тэр хотхонд нь тэр салбар ангийг нь нээгээд ингээд санал хэлсэн. Энэ дээр ямар нэгэн урагшилж байгаа зүйл байна уу.../минут дуусав/

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн хариулъя.

Г.Дамдинням: Би Одонтуяа гишүүний асуултын эхний хэсэгт хариулъя. Тэр хувийн сургуультай холбоотой, төрийн сургуультай холбоотой асуудлууд ажлын хэсэг дээр яригдсан. Улсын Их Хуралд орж ирсэн байгаа Байнгын хороогоор хэлэлцэгдээд, дэмжигдээд орж ирсэн байгаа хуулийн төсөлд хувийн сургуулиудыг ялгаварласан ч гэдэг юм уу тийм зүйл заалтууд бол байхгүй. Ер нь бол тантай санал нэг байна. Одоогийн байдлаар 65 мянга орчим суралцагч нийтдээ 5000 гаруй багш нар энэ салбарт ажиллаж байна. Бид нар Монгол Улсын Үндсэн хуулиараа чөлөөт зах зээл, иргэний нийгмийг байгуулна, өрсөлдөөнтэй байна гэдэг зарчмыг барьчихсан байгаа учраас эндээс ухрахгүй. Ухрахгүй байх ёстой.

Боловсрол бол нэг талдаа их үнэтэй бүтээгдэхүүн. Нөгөө талдаа бол боловсрол сонголттой байх ёстой. Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуульд ч гэсэн иргэд хувийн сургууль байгуулж болно гэдэг заалттай байгаа. Солонгосын жишээг та ярьж байна. Солонгосын жишээнд ямар хувийн сургуулиудыг хаасан бэ гэхээр үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байгаа сургуулиудыг л болиулсан. Түүнээс биш үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа сургуулиуд байгаа. Манай өргөн баригдаад одоо хэлэлцэгдэж байгаа энэ Боловсролын ерөнхий хуулийн хүрээнд үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа

хувийн сургуулиудад хувьсах зардлыг нь олгодог, гэрээний үндсэн дээр олгодог ийм зохицуулалтууд хийнэ. Хийсэн байгаа. Орж ирж байгаа. Яагаад вэ гэвэл бид чинь Монгол хүнийг нэг стандарт, нэг бодлогоор бэлдэх ёстой. Тийм учраас энэ хөтөлбөрийнхөө хүрээнд орж ирж байгаа.

2 дугаар асуудал бол хувийн сургуулиуд дээр эцэг эхчүүдээс гардаг бас нэг шүүмж байдаг. Юу вэ гэхээр кембрижийн ч гэдэг юм уу IB ч гэдэг юм уу эсвэл Финландын, Японы ч гэдэг юм уу хөтөлбөрүүд хэрэгжүүлээд байна. Яг зааж байгаа юу, үгүй юу гэдгийг хэн хянаад байгаа юм бэ гэж. Үнэн. Тэгэхээр одоо бол Боловсролын ерөнхий хууль дээр 2 чухал заалт орж ирж байгаа.

Нэгдүгээрт бол тус сургуулиуд бүгдээрээ Боловсролын яаманд тухайн хөтөлбөрийнх нь олон улсын стандартаар 2 жилд бол 2 жил, 3 жилд бол 3 жил, 1 жил тутам бол жил тутам магадлан итгэмжлэлээ хийлгээд Боловсролын яам болон эцэг эхчүүдэд мэдээлэлдэг үүргийг олгож байгаа. Хэрэв энэ үүргийг биелүүлээгүй бол тухайн сургуулийн эрхийн асуудлыг ярина.

Хоёрдугаар асуудал бол тухайн сургуулийн TVЗ /удирдах зөвлөл/, эцэг эхийн төлөөлөл заавал орно. Эцэг эхийн төлөөлөл зардлын тухайн сургуулийн сургалтын төлбөрийн зардлыг танилцаж олон нийтэд мэдээлэлдэг эрхийг нь нээж өгч байгаа хуулиар. Ийм зохицуулалтуудыг хийж байгаа. Тэгээд зарчмын хувьд бол тантай санал нэг байгаа.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Нэгдүгээрт энэ сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын, мэргэжлийн болон техникийн боловсролын, дээд боловсролын энийг олгодог, энийг сургадаг багшийн хөгжлийг дэмжих

тухай асуудал энэ хуулийн гол ноён нуруу болов уу гэж би бодож байгаа юм. Тэгэхээр Багшийн сургуулиа дэмжсэн юм энд яг юу байна. Монгол Улсын багшийн их сургууль 4, 5 жил сураад сургалтын хөтөлбөрийг нь хангаад, заах арга заалгаад, багшийн ёс зүй сурч сурч гараад ирэхээр өөр сургууль төгссөн нөхөр давхиж очоод тэр албан бус боловсрол гэсэн юмаар сертификат аваад

Монгол Улсын багшийн их сургууль 4, 5 жил сураад сургалтын хөтөлбөрийг нь хангаад заах арга заалгаад багшийн ёс зүй сурч гараад ирэхээр зэрэг өөр сургууль төгссөн нөхөр давхиж очоод тэр албан бус боловсрол гэсэн юмаар нэг сертификат аваад тэгээд багшлах юм бол Багшийн сургуулийн ач холбогдол юу байгаа юм. Тэгвэл багш болохын шаардлага юу байгаа юм. Ямар ч хамаагүй сургууль төгсчихвөл тэгээд I багшийн сертификат аваад багшилчихвал багш багшилчхаж болно шүү дээ гэсэн ийм хандлага руу орвол яах вэ. Энийг юу гэж бодож байна.

2 дахь нь үндсэн гадаад хэл гэж ямар юм байдаг юм. Туслах гадаад хэл гэж ямар юм байдаг юм. Монголчууд заавал бүгдээрээ англи хэл сурах албатай юм уу. Тэгээд та нар Баян-Өлгийд яах юм. Үндсэн гадаад хэл чинь Монгол хэл байна гэж хэлэх юм уу. Эсвэл англи хэлээр Монголчууд бүгд ярьдаг болох учраас үндсэн гадаад хэл чинь англи хэл байна гэх юм уу. Хэл дагаж сэтгэлгээ явдаг юм шүү дээ. Хүүхдүүдийн чинь сэтгэлгээ хар багаасаа ингээд харьжчихна шүү дээ. Монгол хүн биш болно шүү дээ. Тэр хэлээр дамжуулж бүх өв соёл, зан заншил тэр хүн гэдэг үндсэн сууриа авдаг. Юу яриад I дүгээр ангиас нь заана, 3 дугаар ангиас нь заана гээд юм яриад байна. Энийгээ нэг хэлээдхээч. Өмчийн бүх хэлбэр байж болно, ашигийн төлөө байж болно, ашигийн төлөө бус байж болно, холимог өмчтэй байж болно гэж юу оруулж ирээд байгаа юм бэ. Үндсэн хуулийн чинь 16.7-д Монгол хүн

бүр сурч боловсрох эрхтэй. Бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно л гэж байгаа биз дээ. Тэгээд ерөнхий боловсролоор ашиг хийгээд байх нь тэгээд зөв юм уу. Ийм байдлаар тэгээд бид нар ингээд мөнгөө төлж чадаж байгаа нь тэр ашгийн төлөө хувийн сургуульдаа ор, мөнгөө төлж чадахгүй нь тэгээд захынхаа хувийн сургуульд ор гэх юм уу. Эсвэл тэр дунд зэрэг нь холимог сургуульдаа ор гэх юм уу.

4 дэх нь эндуаментийн сан гэж ямар юм байдаг юм бэ. Сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгжээс ашиг хүртэх зорилгогүйгээр шилжүүлсэн хөрөнгө, эх үүсвэрүүдийг өгнө. Яаж өгөх юм. Энэ чинь шашны байгууллагад л ийм юм өгдөг юм байна лээ шүү дээ. Тэгээд шашны байгууллагаас хандив авах гээд байгаа юм уу. Ашгийн бус зориулалттай гэдэг мөнгө чинь шашны байгууллагаас л гараад байдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд одоо бид чинь шилэн данстай болчихсон шүү дээ. Эцэг эхчүүд яаж энийг чинь ашгийн бус зорилготой гэж та нарт өгөх юм бэ. Тэгээд энийгээ хадгална гэнэ, өсгөнө гэнэ, цаашид бий болгох орлого өгөөжийг нь нэмэгдүүлнэ гэнэ. Үүнийхээ тодорхой хэсгийг сургалтынхаа үйл ажиллагаанд чиглүүлнэ гэнэ. Энэ чинь нэг санхүүгийн бохир механизаци болчих юм биш биз. Механизм болчих юм биш биз. Энэ асуудлууд дээр нэг хариулт өгөөдхөөч.

Г.Занданишатар: Дамдинням гишүүн хариулна. Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Өмчийн хэлбэртэй холбоотой асуулт асууж байна. Өмчийн хэлбэр дээр Монгол Улс түрүүн хэлсэн. Бид Үндсэн хуулиараа бүх төрлийн өмчийг зөвшөөрдөг ийм улс. Ардчилсан улс. Хувийн өмч байна. Төрийн өмч байна. Төр, хувь хамтарсан өмч байж болно л гэсэн үг. Олон улсын хөрөнгө оруулалттай бас байж болно л гэсэн үг. Одоогоор бол ерөөсөө төр, хувь гэдэг 2

чиглэлд л яваад байгаа. Тэгэхээр бид нар өмчийн хэлбэрийн хувьд бол ардчилсан зарчмынхаа хүрээнд хөрөнгө оруулалт боломжийг энэ салбарт татаж оруулж ирэх ёстой. Тэгж байж бид шийднэ.

Дараагийн асуудал бол энэ заавал төр үнэгүй сургана гэдэг зарчим байгаад байхад хувийн сургууль байх ямар хэрэгтэй юм бэ гээд байна. Төр дангаараа боловсролыг тэр чигт нь авч явдаг улсуудын татварыг та нар нэг хараадхаарай. Герман, Финланд 43 хувь, 40 орчим хувийн татвартай байгаа. Үгүй ээ, тэгвэл бүгдээрээ төр бүгдийг нь хийе гээд шийдэж болно. Тэгвэл тэгээд татвараа л нэмэх болно доо. Орлогоо л нэмэх болно. Төсвийнхөө орлогыг л нэмэх болно. Ингээд л төр өөрөө үүрээд явъя. Ийм л шийдэл байна бид нарт. Одоо бол бид нарт эдийн засгийн тийм боломж алга. 1 дүгээрт.

2 дугаарт бол суурь зарчмын хувьд бид нар ардчилсан улс учраас хувийн хэвилийг хориглох ямар ч боломж байхгүй ээ.

2 дугаарт заавал англи хэл гэж. Заавал орос хэл үзээд ирж болсон юм даа. Дэлхий нийтийн эдийн засгийн бас харилцааны бүх л хэл англи хэл дээр явж байна. Шинжлэх ухааны бүх хэл англи хэл дээр явж байна. Монгол залуучууд дэлхийд өрсөлдөх хэрэгтэй байна. Бид нар олон улсын том сургуулиудад тэнцчихсэн байгаа хүүхдүүдээр бахархаад л бүгдээрээ шуугьдаг мөртөөсөө яагаад тэнд тэнцэж байгааг нь харах ёстой байхгүй юу. Англи хэлтэй учраас тэнцээд байгаа юм. Тийм учраас бид англи хэлийг зайлиггүй оруулж ирж байгаа юм. Бусад хэлийг үзэх нь нээлттэй шүү Энх-Амгалан гишүүн ээ. Бусад хэл нээлттэй. Бүх төрлийн хэлийг үзэж болно. Үндсэн хэл нь л англи хэл байх юм гэж. Үндсэн гэдэг нь хамгийн түрүүнд аль хэлийг төрийн бодлогоор дэмжиж явуулах юм бэ л гэсэн санаа.

Эндуаментийн сан бол та жоохон буруу л ойлголттой байх шиг байна. Эндуаментийн сан гэдэг бол жишээ нь бидний мэддэг Харвардын Их Сургууль 30 тэрбум долларын Их сургуулийн сан байна. Миний төгссөн Канадын Бритиш Колумби их сургууль 3 тэрбум долларын санхүүжилттэй байна. Дэлхийн бүх томоохон шилдэг их сургуулиуд бүгдээрээ хөгжлийн сантай байгаа юм. Энэ бол сан юм. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд судалгаа, шинжилгээг хамтарч хийх, боловсролыг дэмжих зорилгын хүрээнд Сан руу мөнгө хийдэг. Энэ Эндуаментийн сан бол их, дээд сургуульд хамаатай заалт юм. Энэ санд орж ирсэн хөрөнгөөс үүссэн ашгаар сургууль өөрийнхөө эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг санхүүжүүлдэг эрх хэмжээг бид нар нээж өгөх ёстой. Бид нар олон улсынхаа зарчмаар явах ёстой гэдэг энэ зарчмаар л ерөнхий утгаар энд орж ирж байгаа. Дээд боловсролын хууль удахгүй орж ирнэ. Энэ хуульд тодорхой заагдаад зохицуулалтууд нь хийгдээд явахаар ингэж явж байгаа юм.

Г.Занданшатар: Асуулт хариулт тэнцүү л баймаар юм. Олон хүн асууна. Өнөөдөртөө юмнууд амжихгүй л болж байна. Ажлын хэсэг нэг л уур амьсгалтай хариулахгүй бол. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулж асууна.

Б.Энх-Амгалан: Үндсэн хуулиар Монгол Улсын үндсэн хэл Монгол хэл байна. Үндсэн гадаад хэл гэж юм байхгүй. Та нар заавал сургалтын системд үндсэн гадаад хэл гэж юм оруулж ирж байгаад Орос хэлийг үндсэн гадаад хэл гэж сурч байсан юм. Одоо Англи хэлийг бүгдээрээ сурна гэдэг юм юу яриад байгаа юм. Сурч чаддаг нь сураад л тэр гадааддаа яваад л юмаа үздэг л юм байгаа биз. Бүх хүүхдүүдийг харь сэтгэлгээтэй болгож яах гээд байгаа юм. 1 дүгээрт тэр чинь.

2 дугаарт тэгвэл Үндсэн хуулиа өөрчлөх гэж байгаа юм байна тийм үү 16.7-г. Бүх нийтийн ерөнхий

боловсруулалтыг төлбөргүй болгоно гэдэг юмаа төлбөртэй болгоно гэж өөрчлөх гэж байгаа юм байна тийм үү. Би тэгж ойлголоо.

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Жоохон буруу зөрүү л ойлголт байх шиг байна. 1 дүгээрт бол боловсролын хэл Англи хэл байх юм л гэж зааж байгаа юм. Би түрүүн хэллээ. Судалгаа шинжилгээний хэл бол ерөөсөө тэр чигтээ л Англи хэл дээр байна. Бид нар энэ чиглэл рүү явахаас өөр арга алга. Ардчилсан улс.

2 дугаар асуудал бол боловсролыг үнэ төлбөргүй олгох тухай заалт ерөнхий боловсролыг байгаа. Нөгөө талд нь яг доод талынх нь заалт нь хувийн хэвилийн сургууль байхыг Үндсэн хуулиар бас зөвшөөрчихсөн байгаа. Тэр зарчмынхаа хүрээнд л хууль явж байгаа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Боловсролын хууль нэлээн эгзэгтэй ийм хууль шиг байгаа юм. Яах вэ Боловсролын сайд Энх-Амгалан сайд бол зүтгээд л байх шиг байгаа юм. Тэгэхдээ боловсролын салбарт сүүлийн 30 жил ужгирчихсан айхтар даа айхтар ер нь. Одоо зах зухаасаа л хэвлэл мэдээллээр яваад л байх юм. Хэцүү хэцүү юмнууд ер нь гарч ирэх юм байна шүү дээ. Боловсролын сангийн зээлийн дарга нь яалаа яалаа ч гэнэ үү. Өөрөө зээл аваад төлөөгүй ч гэх шиг л. Тэгээд л тэрнээс улбаатай өчнөөн л юм ярих юм. Нөгөө хүрээний булайг уудалбал далай далай гэдэг шиг л юм байгаа юм даа.

Тэгээд яагаад би энийг юу гэж хэлээд байна вэ гэхээр сүүлийн 30 жилийн хугацаанд манай боловсролын тогтолцоо, боловсролын салбарын хууль, эрх зүйн зохицуулалт, боловсролын

салбар дахь төрийн бодлого цаашилах юм бол боловсролын бүх шатанд ажиллаж байгаа хүмүүсийн сэтгэл зүтгэл, хариуцлага, хандлагатай бүгдийг нь хэлж байгаа юм биш шүү. Ер нь холбоотойгоор өнөөгийн нийгмийн маань өнгө төрх, дүр байдал биднийг л өнөөдөр илтгэж байна тийм ээ. Нийгмийн хэмжээнд эрүүл мэндийн байдал ямар байна, гэмт хэрэг зөрчлийн байдал ямар байна, хөдөлмөр эрхлэлт, нийт нийгмийн бүтээмж хаашаа байна вэ гээд ингэх юм бол нээрээ мөн арай л дэндүү ийм л зүйлүүд л харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ бүхэн дээр бид нар нэг эргэж дүгнэлт хийхгүй бол болохгүй ийм нөхцөл байдал тулгарсан нь арга байхгүй ээ. Яах вэ би Боловсролын салбартай бас холбоотой. Би бол хувийн сургууль үүсгэн байгуулсан, ашиг сонирхлын зөрчилтэй учраас би энэ талд холбоотой нэг ч юм хэлдэггүй. Би Их Хуралд хэлээд би санал хураалтад орохгүй, би ашиг сонирхлын зөрчил байна гээд би гардаг ийм хүн байгаа юм.

Гэхдээ энэ салбарт зүгээр хараад суухыг боддоггүй. Ерөөсөө бид нар чинь нэг үер ус гэх юм бол нэг уулын амны үер биш, ерөөсөө нийгмийн хүрээнд ингээд сад тавиад ороод ирчихсэн. Нөгөө тал газрын үер шиг ингээд ороод ирчихсэн учраас бид бүх түвшинд өргөн хүрээтэй л цаг алдахгүй ажиллах л ийм шаардлагатай байгаа юм. Тийм учраас сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол бага ангиас нь яаж хүүхдийг хүмүүнлэг, бүтээлч, эрүүл чийрэг ийм иргэнийг бэлдэх вэ гэдэг энэ хөтөлбөрийг мөн санаачлаад, оролдоод хөдөөгийн, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 170 дугаар цэцэрлэг, 151 дүгээр сургууль дээр 3, 4 жил ноцолдож байж босгоод, ямар үр дүн гарч байгааг нь Боловсролынхоо сайд Энх-Амгаланг урьж үзүүлээд, очсон хүмүүс бүгд л үгүй ээ, энэ чинь манай боловсролын салбарт хийх гэж байгаа цогц шинэчлэлийн цөм хөтөлбөр энэ байна шүү дээ. Энийг л ухаан тас, алга ташаад л дэмжье гэсэн тэгээд л тэрнээс хойш таг чиг л байгаа. Бодвол өөр ажил

нь дийлддэггүй байлгүй дээ. Ер нь бол бид сууриас нь л эхэлмээр байгаа юм. Их, дээд сургуулийг хамт өөрчилмөөр байгаа юм. Ингэж байж нэг жаахан өөр байдал руу бид нар гаргахгүй бол болохгүй байна. Тэгээд бид бол ер нь эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр технологи, урлаг, гоо зүйн 3 хичээлийг нь бусад улс орнууд хөгжил дэвшилд хүрсэн Япон тэргүүтэй улс орнуудын жишгээр боловсролын тогтолцоондоо, энэ хөтөлбөр сургалтдаа гол цөм болгоё гэж ингэж л зорьсон энэ маань.../минут дуусав/

Г.Занданшатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Бат-Эрдэнэ гишүүн, Бат-Эрдэнэ сайдтай санал нэг байна. Энэ үнэхээр бас тогтолцооны, олон жилийн тогтолцооны гажгийг нэг өдөр өргөс авчихсан юм шиг сайхан арилгана гэж бол байхгүй. Гэхдээ ямар ч байсан өнөөдөр Монгол Улсад олдож байгаа нэг боломж, магадгүй манай Их Хурлын, парламентын түүхэн үүрэг бол анх удаа Боловсролын хуулийг багцаар нь хэлэлцэж байгаа анхны тохиолдол. Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол тэгээд насан туршийн боловсролын тогтолцоо дээр суурилсан энэ тогтолцоог бий болгоё гэж зорьж байгаа бид нарын анхны тохиолдол байхгүй юу. Тийм учраас энэ хуулийг бид нар өргөн барихын өмнө сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, дээд боловсролын төлөөллүүдийг хангасан маш их том судалгааны ажлууд хийгдсэн. Маш их том судалгааны. Одоогийн явж байгаа бүх түвшний хөтөлбөр дээрээ бид нар анализ, үнэлгээ, оношилгоонууд хийгдсэн. Бүх сурах бичгүүд дээр бид нар анализ, оношилгоо, үнэлгээнүүд хийгдсэн. Санхүүжилт өнөөдрийн явж байгаа боловсролын бүх түвшинд явж байгаа санхүүжилтийн тогтолцоонууд нь яг үр өгөөжтэй, үр дүнд суурилсан ийм

санхүүжилтийн тогтолцоо байж чадаж байна уу, чадахгүй байна уу гэдэг энэ тогтолцооны асуудал дээр нэлээн анализ, судалгаа хийж байж, энийгээ дүгнэж байж нөгөө зөв онош тавихын тулд ийм судалгаанууд хийгдэж байж бид нар энэ хуулийн концепцуудыг өргөн барьсан юм байгаа юм. Тэгэхээр ерөөсөө л бид нарын яг яриад байгаа бүх гишүүддээ зориулж 2 удаа ийм судалгааны 2 том номууд хүргэсэн. Өнөөдөр ингээд бүх гишүүдийн ширээн дээр манай Боловсролын үндэсний хүрээлэнгээс гаргасан бүх судалгааны ажлуудын дүгнэлтүүдийг, яагаад боловсролын салбар түвшин бүрдээ шинэчлэл хийх шаардлагатай болчихоод байгаа юм бэ гэдэг энэ асуудлуудыг бид нар ингээд үндэслэлтэй гаргаж ирж шийдлүүдийг нь өнөөдөр танилцуулж байгаа. Манай ажлын хэсгийг ажиллаж, энийг томъёолж танилцуулж байна.

Тэгэхээр мэдээж яг таны ярьж байгаа хүмүүнлэг боловсролын асуудал. Ер нь бол хүнийг хүн болгох боловсролыг л бид нар илүү өгөх ёстой. Тийм учраас манай өнөөдрийн боловсролын хөтөлбөрийн нэг сул тал бол илүү академик мэдлэг тал руугаа их давамгайлчихсан байна. Хүүхдийг дандаа ийм академик мэдлэгээр сургаж байна. Үзэж байгаа хичээлүүдийн тоо гэдэг юм уу, үзэж байгаа хичээлийн цаг бусад улсуудтай харьцуулахад бол бага анги дээр ачаалал өндөртэй байна. Агуулга хоорондоо уялдаагүй байна. Дандаа ингээд хүүхдэд мэдлэг өгөх гээд оролдоод байна. Гэтэл нөгөө мэдлэгээ амьдралд ур чадвар болгож байгаа тэр чадварыг бид нар бий болгож чадахгүй байна. Хүүхдийг шалгалтад, хүүхдийг олимпиадад бэлддэг тогтолцоог бид нар бий болгочихсон байна. Хүүхдийг амьдралд бэлддэг энэ тогтолцоог бид нар бий болгох ёстой юм байна. Тийм учраас мэдлэг, чадвар, төлөвшил гэсэн энэ цогц чадамжийг бид нар үндэснийхээ хөтөлбөр дээр хийж өгч байж одоо энэ хүмүүжил сайтай, төлөвшил сайтай ирээдүйн Монгол иргэнийг бэлтгэх ийм л

хөтөлбөртэй болох ёстой юм байна. Тэрний хүрээнд таны ярьж, санаачилж хийж байгаа зүрх сэтгэлийн боловсролын хүрээнд хийгдэж байгаа асуудлууд, хүнийг хүн болгох чиглэл рүү хийж туршигдаж байгаа энэ асуудлууд бол энэ хөтөлбөр, одоо бид нар чинь хуулиа баталчихна шүү дээ Бат-Эрдэнэ гишүү ээ, Хууль батлагдсаны дараа бид нар хөтөлбөрийн шинэчлэл хийнэ. Хөтөлбөрийн шинэчлэл хийхэд бид нар яг энэ хөтөлбөрөөр дамжиж мэдлэг, чадвар, төлөвшилийг яг ямар хичээлээр олгох вэ гэдэг чинь энэ хөтөлбөрийн шинэчлэлээр хийгдэх асуудал байгаа байхгүй юу.

Тийм учраас биеийн тамирын хичээлээр олгогдож байгаа ур чадварууд, эрүүл мэндийн хичээлээр олгогдох ур чадварууд, технологийн хичээлээр олгогдох ямар ур чадваруудыг бид нар ямар ямар хичээлүүдээр олгогдох вэ гэдэг нь энэ хууль батлагдсаны дараа хийгдэх хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хийгдэх ёстой ийм л ажил юм байгаа юм.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна.

Б.Бат-Эрдэнэ:

Хүмүүнлэг боловсролын хуулийг уг нь Энх-Амгалан сайд бид 2 гишүүн байхдаа санаачилсан юм. Тэгээд энэ хууль дотор оруулаад бүр аль ч үгүй юм болгохоо шахаад Их Хурлын дарга зүтгэж байж тусад нь бие дааж хууль гаргахаар ингээд явж байгаа юм. Энэ бол сайшаалтай асуудал. Нэрээ яг үнэндээ бол Боловсролын хуульд боловсролын байгууллагын зорилт бол хүнлэг, хүмүүнлэг иргэний бэлдэнэ гээд зорьсон, хуулийн зүйл заалт байгаа гэж хэлж байгаа. Байгаа байгаа. Энэ чинь Боловсролын хуульд байтугай Үндсэн хуульд бид нар нэгдүгээрт хүмүүнлэг иргэний гэж байгаа шүү. Тэгээд ардчилсан нийгмийг цогцлооно гэсэн. Тэгээд 30 жил зүтгээд юун Ардчилсан нийгмээ тогтоож чадсан байх, иргэний нийгмээ байгуулсан байх. Хүмүүнлэг

тухай асуудал бол бүр хойно хаягдсан шүү. 1998 онд биднийг хувийн сургууль байгуулаад байж байхад хүмүүнлэгийн тухай асуудал огт байхгүй байхад бид зөрөөд энэ хүмүүнлэг, төлөвшил, амьдралд бэлтгэдэг ийм боловсролын тогтолцоо руу гээд жижиг сургууль явсан.../минут дуусав/

Г.Занданишатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Боловсролын багц хуулиуд маань бол Улсын Их Хурлаар орж ирж байна. Анхны хэлэлцүүлгээ хийж байна. Ингээд үндсэндээ анхны хэлэлцүүлгийг давсны дараагаас бол Монголын нийгэм тэр дундаа боловсролын салбарт хүлээлттэй байгаа хууль маань хэрэгжиж эхлэхэд бэлэн боллоо гэж харж байгаа.

Хувь хүнийхээ үүднээс нэр бүхий гишүүдийн хамтаар боловсролын салбарт улс төржилт байх ёсгүй гэдэг үндсэн дээр Боловсролын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан. Ингээд Засгийн газраас өргөн барьсан хуультай хамтад нь ингээд хэлэлцэгдээд явж байгаа. Бид бүхний тавьсан гол боловсролын салбарт улс төржилтийг арилгах үүднээс тавьж байгаа томилгоотой холбоотой, сонгон шалгаруулалттай холбоотой энэ асуудал бол ерөөсөө суурь зарчмын асуудал байгаа. Монгол Улсад нийтдээ төрийн өмчийн оролцоотой 1700 гаруй сургууль, цэцэрлэг байгаа. Дийлэнх нь 70 орчим хувь нь хөдөө орон нутагт байдаг. Ингээд 2017 онд батлагдсан Боловсролын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн үндэслэлийн хүрээнд өнөөдөр үндсэндээ сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын 1700 гаруй бүх сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нарыг бүгдийг нь халаад, солиод дуусгасан. Тэгэхээр энийг бол цаашид өөрчилж байж, боловсролын салбараа тогтвортой байлгаж байж, ажлын байр дахь дарамтыг алга болгож байж, эргээд ажиллах нөхцөлийг нь хангаж

байж энэ сайн чанартай боловсролыг бид нар Монголынхоо ирээдүй болсон хүүхдүүдэд олгох энэ боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Үндсэн хууль дээрээ зааж өгсөн асуудал бол ерөөсөө хүний эрх, эрх чөлөө тэр дундаа хүний хөдөлмөрлөх эрхийн баталгааг бий болгох. Энэ бол Үндсэн хуулиар заасан төрийн үүрэг байгаад байгаа. Тэгэхээр бид нар энийг л бүрдүүлж өгье гэдэг асуудлыг энэ хуулийн өөрчлөлтийг энэ өргөн барьсан хууль дээрээ хийж өгсөн. Ингээд ямар ч бай ажилласан. Ингээд Улсын Их Хурлаас ажлын хэсэг ажилласан байна. Бид бүхний өргөн барьсан хуулийг нэгтгээд ингээд бүх сонгон шалгаруулалт томилгоог хийж өгсөн байна.

Тэгэхээр би Боловсролын сайдыг хэлэх гээд байгаа юм. Энэ 1700 гаруй сургууль, цэцэрлэгийн цаана байгаа 60, 70 мянган багш нар, түүний ард байгаа 1 сая гаруй хүүхдийн эцэг эхчүүд үүнийг хүлээж хараад байна. Дурын нэг сумын Засаг дарга, дурын дүүрэг, нийслэлийн Засаг дарга нар дураараа боловсролын байгууллагын тогтолцоо, удирдлагаар нь захирал, эрхлэгчийг нь халдаг, сольдог тэр 1700 хүн солигдсоны дор тэр байгууллага дотор ажлын байрны хүчирхийлэл нэг талдаа, ажлын байрны дарамт үүсэж байгаа. Халаа сэлгээний асуудлууд үүсэж байгаа. Мянга, мянган багш нар сүүлийн 5 жилийн хугацаанд шүүхээр явсан. Хөдөлмөрийн маргаан үүсгэсэн. Гомдол гаргасан. Асар их сэтгэл зүйн дарамт болоод хохиролд орсон. Тэгэхээр энэ болгоныг бид нар таслан зогсоох ёстой. Тэгэхээр та одоо хариуцлагатайгаар хэлж өгөөч ээ. Бид нар энэ асуудлыг боловсролын тогтолцоо болоод засаглалын асуудлыг өнөөдөр энэ хууль ингээд батлагдлаа. Өнөөдөр анхны хэлэлцүүлэг хийгдээд, батлагдаад явна. Үүнээс цаашид хөдлөх гарц байхгүй болж байгаа. Тэгэхээр энэ өнөөдөр батлагдсанаар цаашид Монголын мянга, мянган багш нар энэ халаа сэлгээнээс айх, шүүхээр явах аюулгүй

болно. Мэргэжлийн байгууллага нь томилдог, чөлөөлдөг, үнэлдэг босоо тогтолцооны асуудал хийгдэж өгнө. Дурын нэг захын улс төрч нөхөр боловсролын байгууллагаар тоглодог, энэ системийг эвддэг юм байж болохгүй гэдэг асуудал дээр та тодорхой хэлээч. Цаана мянга, мянган багш нар хүлээгээд, хараад сууж байна. Энийг бид нар тунхаглаж, зарлаж хэлэх ёстой гэж харж байгаа.

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Тэмүүлэн гишүүнд бид нар талархах ёстой. Яагаад гэвэл манай боловсролын салбарын 6 том реформын 1 бол боловсролын засаглалын асуудал байгаа. Тэгэхээр Боловсролын хууль өргөн баригдахаас өмнө бас яг ганцхан боловсролын салбарт ч биш би эрүүл мэндийн салбар гэж ойлгосон. Энэ дээр байгаа мэргэжлийн бус томилгоонуудыг мэргэжлийн томилгоо болгох энэ чиглэлийн хууль өргөн барьж, боловсролын багц хуультай Тэмүүлэн гишүүний хууль маань хамт нэг хууль болж батлагдах гэж байна. Энэ бол манай боловсролын салбарт хамгийн том реформын 1 бол Тэмүүлэн гишүүний өргөн барьсан хуулийн концепц, үзэл баримтлал дээр суурилж, энэ тогтолцоог бид нар бий болгох гэж байна. Тийм учраас Монголын мянга мянган багш нарын нэрийн өмнөөс Тэмүүлэн гишүүндээ бид нар баярлаж хэлэх ёстой. Яагаад гэвэл улс төрчдийн савраас, улс төрчдийн гараас салгах ийм тогтолцоо руу бид нар шилжүүлж байгаа. Жишээ нь цаашидаа Монгол Улсад боловсролын тогтолцоо бол яг хэн чаддаг нь, хэн туршилагатай нь, хэн чадвартай нь цэцэрлэг, сургуулиа удирдаж явдаг ийм тогтолцоо руу бид нар шилжүүлэхээр ийм шаардлагыг тавих тогтолцоо руу алхам хийж байгаа нь манай салбарын реформын нэг гэж ойлгож болно.

Өнөөдөр хэн тухайн сумынхаа намдаа үнэнч, хэн тухайн сумынхаа Иргэдийн Хуралд үүрэг гүйцэтгэснээрээ сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, захирал болдог биш, хэн нь тухайн сумынхаа цэцэрлэг, сургуулийн хамт олонд хүлээн зөвшөөрөгдсөн удирдагч багш, сургалтын менежерүүд нь шатлан дэвшдэг энэ тогтолцоо руу оруулж байгаагаар үнэхээр цоо шинэ тогтолцоо болж чадна. Тийм учраас бол энэ хууль маань яг таны өргөн барьсан хуулийн үзэл баримтлал дээр бүтнээрээ батлагдаж чадах юм бол боловсролын салбарт олон жил нүүрлэсэн улс төрчдийн үзгийн үзүүрээр шийдэгддэг олон зуун мянган багш нарын шахалт, дарамтын асуудал дээр цэг тавьсан ийм хууль болох болов уу гэж бодож байна.

Энэ дээр би энэ боломжийг ашиглаад нэг зүйлийг жишээ татъя гэж бодож байна Тэмүүлэн гишүүн ээ, юу гэхээр Солонгос улсын Ерөнхийлөгч ерөнхий боловсролын сургуулийн захирлуудыг батламжилдаг юм байна. Тийм учраас Солонгос улс өнөөдөр боловсролоороо тэргүүлж байгаа юм. Солонгос улс боловсролд ийм их ач холбогдол өгч байна. Гэтэл өнөөдөр бид нар сум, дүүрэг, нийслэлийн Засаг дарга нарын намын үзэмжээр томилгоо тавьдаг. Ер нь судалгаагаар бол энэ иргэдийн Хурлын сонгууль болсны дараа орон нутгийн сонгууль болсны дараа, Улсын Их Хурлын сонгууль болсны дараа маш их халаа сэлгээ хийгддэг. Одоогийн байдлаарх сүүлийн 8 жилд манай цэцэрлэг, сургуулийн нийт удирдлагуудын 80 гаруй хувь нь солигдсон байгаа ийм жишээ байна. Тийм учраас яг мэргэжлийн чадавхын зарчим дээр үндэслэсэн ийм сонгон шалгаруулалтууд, ийм томилгооны тогтолцоо руу бид нар нэг алхам урагшлах гэж байна.

Г.Занданшатар: Амгалангийн Адъяасүрэн гишүүн.

А.Адъяасүрэн: Ингээд иргэдийн маань маш их хүлээлттэй байгаа хууль

өнөөдөр орж байгаад миний бие ч гэсэн баяртай байна. Боловсролын салбарын ажиллаж байгаа багш нар, эцэг эхчүүд боловсролын хуулиар ямархуу шинэчлэлийн зүйлс яригдах гэж байгаа талаар хүлээлттэй байгаа. Бид нар ч гэсэн нэлээд олон удаагийн хэлэлцүүлгүүд хийгээд, орон нутгаар яваад маш олон тооны саналуудыг бол авч байсан.

Би давхардахгүйгээр нэг зүйлийг онцгойлон яримаар байна. Энэ нь 1 дүгээр ангид элсэж байгаа хүүхдийг 6 настайгаас нь элсүүлж байгааг эргэж харах, ялангуяа малчдын хүүхдийг онцгойлон авч үзэх талаар төслийн хэлэлцүүлгийн үед бол маш их санал ирж байсан. Орон нутгийн иргэдээс. Жишээлэх юм бол малчдын хүүхэд 6 настай орж байгаагаас шалтгаалаад залуу малчид маань тусдаа амьдарч эхэлсэн. Ээж нь хүүхдээ аваад сумын төвд амьдардаг. Аав нь малаа хараад гэртээ үлддэг. Үүнээс болоод энэ залуу малчин гэр бүлийн өрхийн төсөв хуваагдаж байна.

Хоёрдугаарт, залуу малчдын гэр бүл салалтын асуудал бас маш их болж байна гээд иргэд маань энэ дээр их санаа зовниж байгаа. Мэдээж бид нар хууль баталж байгаа учраас хууль маань амьдралд нийцсэн байх ёстой. Иргэддээ ээлтэй байх ёстой хуулийг бид нар батлах ёстой байх гэж би боддог. Ийм учраас энэ дээр энэ талаар малчдын хүүхдийг 6 настай сургах талаар Боловсролын ерөнхий хуулийн төсөлд туссан зүйл харагдахгүй байх шиг байх юм. Энэ талаар товч тайлбар авъя.

Хоёрдугаарт одоогийн мөрдөгдөж байгаа Боловсролын тухай хуулийн 35.4.9 энэ заалт маань одоо нэлээд олон юм байгаа. Тэр дундаа 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй бол малчин эцэг эхийн гаргасан хүсэлтийг үндэслэн шийдвэрлэнэ гэсэн заалт энэхүү шинэчилсэн найруулгын төслөөс хасагдсан юм уу. Эсвэл хэрхэн яаж

өөрчлөгдөж байгаа талаар тайлбар авах гэсэн юм.

Г.Занданишатар: Байнгын хорооны дарга Гомпилдоогийн Мөнхцэцэг.

Г.Мөнхцэцэг: Адъяасүрэн гишүүний гаргаж байгаа санал хийгээд ярьж байгаа зүйлтэй санал нэг байгаа. Тэгэхээр Боловсролын ерөнхий хууль маань өчигдөр дөнгөж гарч ирээд өнөөдөр хэлэлцэгдээд ингээд явж байгаа биш. Бид 2 жил гаруй ярьсан. Маш олон эрдэмтэн, судлаачид тэгээд бүхий л салбарт судалгаа, шинжилгээг хийсэн. Та ч бас Байнгын хорооны гишүүний хувьд оролцоод явж байсан. Ялангуяа хөдөөгийн малчин ард иргэдээс маш олон саналуудыг гаргаж байсан. Ялангуяа хүүхдийн сургалт дээр тэр тусмаа 1 дүгээр ангид орж байгаа хүүхдүүдийн өнөөдрийн нөхцөл байдал ямар байгаа билээ. Яг насны хувьд хөдөөгийн орчин нөхцөлд 1 дүгээр ангид 6 настай хүүхэд орж байгаа нь асуудалтай, хүндрэлтэй байна. Ялангуяа гэр бүл салалтууд хөдөөд хүүхдээ дагасан энэ аж байдлаасаа болоод их гарч байна гээд олон саналуудыг хаа сайгүй л ярьж байсан. Тэгэхээр ер нь бол энэ хууль маань ерөнхий хууль. Бид нар дагалдаад Ерөнхий боловсролын хууль, дээрээс сургуулийн өмнөх боловсролын, ерөнхий боловсролын хуулиудыг бас дагаад хэлэлцээд явах учраас энэ хуулиудад яг 6 настай хүүхэд сурах уу, 7 настайгаар сурах уу гэдэг энэ сонголтуудыг энэ хуульдаа хэвээрээ үлдээж байгаа учраас энэ хуулиараа зохицуулна гэдгийг та ойлгоорой гэж хэлэхийг хүсэж байна.

Дээр нь зарим гишүүд асуугаад байна. Хэлний асуудлыг нэлээн асууж байна. Тэгэхээр ер нь бол үндсэн хэл нь ямар хэл байх юм. Мэдээж бид нар Монгол хүн. Монгол хэлээрээ л анхныхаа суурь боловсролыг эзэмших нь зүйтэй. Тийм учраас үндсэн хэл маань Монгол хэлээрээ байна. Дагалдах гадаад хэл нь бол өөрөө англи хэл байна гэж хуульчилж заасан байгаа. Гагцхүү ямар байдлаар

хэдэн настайгаас заах юм бэ гэдгийг бол 1 дүгээр ангиасаа гэдэг юм уу, 2 дугаар ангиасаа гэсэн ийм заалтуудыг энэ хуульд огт тусгаагүй. Тийм учраас энийг анхаарах нь зүйтэй гэж бодож байгаа. Ер нь бол хөтөлбөрөөрөө хэддүгээр ангиас заах, ямар цаг хугацаанд англи хэлийг заах юм бэ гэдгийг бол хөтөлбөрөөрөө тусгаж заах ёстой. Дээр нь бид нарт англи хэлнийхээ багшийг бэлтгэх гээд суурь олон зүйлүүдийг хийх ёстой. Шаардлагатай байгаа учраас 1 дүгээр ангиасаа заана гэдэг энэ зүйлийг заагаагүй гэдгийг зориуд албан ёсоор хэлье гэж бодож байна.

Г.Занданишатар: Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Эхэнд нь нэг уриалга дэвшүүлье. Улсын Их Хурал руу Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирэх гэж байна. Тэгэхээр Улсын Их Хурлын дарга чиглэл өгөөд гишүүд орон нутагт ажиллана. Энэ ямар уриалга вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүд ээ, Анхан, дунд шатны энэ байгууллагууд дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ярьж суманд очихдоо нэг ороодхооч ээ. Энэ бол Төв аймгийн Баян-Өнжүүл сумын цэцэрлэгийн эрхлэгч Шандассайхан гэдэг хүний гаргасан санал, уриалга. Тэгэхээр бид нар яадаг гэхээр тэд нарын яг газар дээрээ нөхцөл байдал ямар байгааг очиж үзэхгүй байгаа. Мэдэхгүй байж байж асуудлууд руу нь ингэж хууль батлах замаар ороод байна. Тэгэхээр энэ асуудлуудтай яг энэ орон нутагт ажиллах үеэрээ очиж танилцаач гэдэг уриалгыг эхлээд хэлье.

Хоёрт нь энэ багш, ажилчдын, багш нарын тэнд сургууль цэцэрлэгт ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн асуудал бол үнэхээр чухал асуудал байгаа. Цэцэрлэгийн багш, бага ангийн багш, биеийн тамирын багш гээд энэ хүмүүс дээр тэтгэврийн насыг маш их ярьж байгаа. Энэ дээр яг тухайлан энэ хуульд биш ч гэсэн яг боловсролын сайд,

Байнгын хорооны бодол санааг сонсмоор байна. Одоо парламент дээр Нийгмийн даатгалын багц хууль явж байгаа. Энэ хүмүүс бол дээшээ тэтгэврийн нас сонголттой хууль явж байгаа шиг доошоо сонголттой буюу 50-55 насны хооронд тэтгэвэрт гарах энэ сонголтнууд заавал хэлж өгөөч гэж бүх сумдын сургуулиуд хэлж байна. Тэгэхээр энэ дээр ямар бодолтой байдаг юм бол.

Дараагийн асуудал багш нарын орон сууцны асуудал. Тэгээд багш нарын 1 хүүхдийг бас сургалтын төлбөрийг нь төрөөс даадаг байсан. Энэ асуудлыг уламжилж өгөөч гэдэг асуудлыг маш их тавьж байна.

Гуравдугаарт хувийн сургуулиуд дээр тийм нэг ялгаварлал яваад байгаа юм шиг санагдаад байгаа юм. Энэ сургуулиудын бүртгэлийн асуудлыг ер нь яаж шийдэх гэж байна. Тусад нь компани ч юм уу, төрийн бус ч юм уу нэг юм яриад байгаа юм. Тэгэхээр яаж шийдэх гэж байна.

Дээрээс нь хувьсах зардлыг нь яагаад ялгаварлах байдал сүүлийн үед сонсогдоод байх болов. Тэнд адилхан Монгол хүүхдүүд сурч байгаа. Хувийн сургуулиуд бас төрийн ачааллаас үүрч байгаа. Тэгээд тэнд байгаа хүүхдүүдийг хувьсах зардлыг нь өгөхгүй, багасгах чиглэл энэ хууль дээр баримталж байна уу, үгүй юу. Энэ дээр тодорхой хариулт авъя. Дээрээс нь ерөнхий хууль дээр харж байхад хууль нэг л тийм Улаанбаатарын юм уу, төв суурины юмыг маш их яриад байх юм. Сумын сургуулийн асуудлыг яагаад ярихгүй байгаа юм бэ. Сумдын сургууль гэж байгаа. Улаанбаатарын боловсролын хууль бол биш шүү. Юу гэж байна гэхээр хөдөө, орон нутагт мэргэжилтэй боловсон хүчин, багш, ажилчид чинь Солонгосын давалгаанд нэрвэгдээд явчихлаа шүү дээ. Маш олон хүн Солонгост ажиллаж байна шүү дээ. Энийг бүгд мэдэж байгаа. Тэгээд дээрээс нь ингээд ирэхээр багш хүрэлцэхгүй болж байна. Нэг багш нэг хичээл заахгүй 2-3

хичээлийг зааж байна. Тэгэхээр чадавх, төрөлжилтийн асуудал чинь яаж явах юм бэ. Тэгэхээр багш хүрэлцэхгүй байгаа энэ асуудал байхад дээрээс нь дахиад бага ангиас нь англи хэл заана гээд энэ асуудал яригдаад байна. Тэгэхээр би бол эхэндээ багш нарынхаа чадавхын асуудлыг, багш нараа заах хэмжээнд нь бэлдчихээд дараа нь энэ асуудлыг яриач ээ. Тэгэхгүй бол бид нар сүүлээс нь эхэлж яриад байна шүү гэдэг ийм асуудлыг асууя. Багш нарын чадавх дээр. Ялангуяа англи хэлийг 2 дахь хэл болгоод явахад багш нар маань бэлэн байгаа юу гэсэн асуулт. Хариултаа аваад дараа нь тодруулъя.

Г.Занданишатар: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Туваан гишүүн их чухал асуудлуудыг ярьж байна. Бид нар ажлын хэсгийн хүрээнд 2 жилийн хугацаанд нийтдээ 50 гаруй удаагийн хуралдаан хийж, хэлэлцүүлгүүдийг хийж явсан. 2 санал маш их орж ирдэг юм. Ялангуяа манай боловсролын салбарынхнаас.

Нэгдүгээрт цалингаа нэмээч ээ.

Хоёрдугаарт тэтгэврийн насыг сонголттой болгож өгөөч.

Тэгэхээр бид бол хуулийн төслийн хүрээнд ярилцаж үзсэн. Тэгээд энэ бол ерөөсөө Боловсролын ерөнхий хуулийн хүрээнд шийдэж болохгүй асуудал болоод байна лээ. Тэгээд бид бол энэ асуудлыг Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тавьсан. Хүргүүлсэн байж байгаа. Тэгээд засаг дээр бол багш нарын цалингийн асуудал тусдаа яригдах юм байна лээ. Ер нь цалин, урамшуулал, нийгмийн даатгал, тэтгэвэртэй холбоотой асуудлыг салбарын хуулиар шийдэхгүй байя гэдэг зарчим дээрээ буусан шүү.

Орон сууцтай холбоотой асуудал дээр болон хөдөө орон нутгийн багш нар

дээр ирж байгаа дэмжлэг бол Боловсролын ерөнхий хуульд Туваан гишүүн ээ маш тодорхой туссан шүү. Жилдээ нийт багшлах боловсон хүчний 20 хувьд нь хүрэх хэмжээнд тооцоолоод Боловсролын ерөнхий хууль дээр боловсролын салбарын ажилтан, боловсон хүчний орон байрны асуудлыг төрөөс дэмжинэ гээд бүр тодорхой заагаад өгсөн байгаа. Энэ бол их том дэмжлэг шүү. Өмнө нь ер нь байгаагүй.

Дараагийн асуудал бол хүүхдийн сургалтын төлбөр. Энийг бас их тодорхой суулгаж өгсөн. Өөрөөр хэлбэл боловсролын салбарт ажиллаж байгаа багшлах боловсон хүчин болон ажилтан, албан хаагчдын нэг хүүхдийг үнэ төлбөргүйгээр төрийн өмчийн сургуульд сургана гэдэг заалт орж байгаа. Та бас сонгогчдодоо хэлнэ биз. Уулзсан хүмүүстээ. 15 жилээс дээш ажилласан байх хэрэгтэй.

Хувийн сургуулиудын бүртгэлтэй холбоотой асуудал бол маш бэрхшээлтэй асуудал. Хувийн гэхгүй ер нь төрийн сургуулиудын. Одоогийн байдлаар бүртгэлийн хууль дээр үндсэндээ тэгээд бараг 6, 7 төрлөөр бүртгүүлчихдэг юм байна лээ. Зарим нь төрийн өмчит үйлдвэрийн газраар бүртгүүлж байна. Зарим нь төрийн бус байгууллагаар бүртгүүлж байна. Сангаар бүртгүүлж байна. Нөхөрлөлөөр бүртгүүлж байна. Янз янзаар бүртгүүлж байгаа. Энэ замбараагүй байдлаасаа болоод татвар, хураамжтай холбоотой асуудал бүртгэлийн асуудал замбараагүйтчихээд байгаа юм. Тэгэхээр бид нар бүртгэл дээр ямар асуудал оруулж ирж байгаа вэ гэхээр боловсрол, сургалтын байгууллага гэдэг шинэ заалт оруулж ирж байгаа. Дагалдах хуулиараа. Тэгэхээр өөрөөр хэлбэл төр, хувийн хэвшлийн хамаагүй бүгдээрээ боловсрол сургалтын байгууллага гэж бүртгүүлнэ. Ингэж бүртгүүлснийхээ дараа ашигийн, ашигийн бусаа анх бүртгүүлэхдээ шийднэ. Анх бүртгүүлээд ороод ирэхээрээ ашигийн, ашигийн бусаа шийдвэрлээд, тэгээд

татвар хураамжтай холбоотой асуудлууд нь яг холбогдох хуулиудаараа дагаад явна. Тэгэхээр энэ хуулиар бүртгэлтэй холбоотой асуудлыг нэг мөр шийдэж байна гэж ойлгох хэрэгтэй.

Хувьсан зардлыг ялгавартай олгож байгаа тухай асуудал дээр бол төр, хувийн хэвшлийн сургуулиуд дээр ерөнхий хууль дээр гэрээний дагуу Монголын үндэсний хөтөлбөрийг зааж байгаа сургуулиуд дээр төрийн хэрэгжүүлэх үүргийг хуваалцаж байгаа хувийн сургуулиудад олгоно гээд тусад нь бүр тодорхой заасан байгаа. Тэгэхээр энэ дээр санаа зоволтгүй байх.

Хөдөөгийн сургуулиуд дээр анхаарах дээр түрүүн хэллээ. Бас нэг том заалт орж байгаа. Хөдөө орон нутагт багшийн хомсдол асар их байгаа. Ямар том заалт орж байгаа вэ гэхээр алслагдсан аймаг, тосгон, сум, дүүрэг тосгонд багшилж байгаа багшийн багшлах боловсон хүчний эхний 5 жилийн дараа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгоно. Энэ урамшуулал 3 жил тутам цаашидаа олгогдоод явна гэсэн заалт орж байгаа шүү.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Тэгээд тодруулах зүйл байна. Одоо энэ цэцэрлэгийн хоолны мөнгө. Одоо Засгийн газрын шийдвэр гарчихсан. Боловсролын сайд дээр ирчхээд байгаа. Энэ дээр нэг ч цэцэрлэг нэгхэн багш надтай таарсан. Тэр эцэг эхээс гаргуулах гэдгийг нэгхэн багш дэмжсэн. Бусад бүх сум дээр сөрөг байна лээ шүү. Энэ дээр ямар байр суурь байна.

Сургуулийн хүүхдийг 7 настайгаас оруулах гэдэг дээр сонголттой болгохоор би энэ хуульд ажлын хэсэг дээр саналаа хэлсэн. Энийг нь бол дараа нь ярихад хэлэлцэнэ гэж ингэж ойлгож байгаа.

Хөдөө аж ахуйн салбар бол боловсон хүчин байхгүй болсон. Тэгэхээр

одоо үүний учир шалтгаан нь бол хөдөө аж ахуйн дунд мэргэжилтэн бэлтгэх асуудал бол бүр байхгүй болсон юм байна лээ. Энэ дээр тодорхой яг ямар бодлого явж байгаа талаар хариу өгөөч.

Г.Занданишатар: 1 л хүн хариулна. Асуулт хариулт дэгээрээ тэнцүү цагтай байх ёстой. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Бид нар цэцэрлэгийн хоолны төлбөрийг саяхан хүртэл эцэг эхчүүдтэй нь хуваалцаж байсан. Одоо ч гэсэн эцэг эхчүүдтэй хуваалцдаг эрх зүйн зохицуулалт одоо хэвээрээ байгаа шүү дээ Туваан гишүүн ээ. Тэгэхээр бид нар хэт их ард түмэнд таалагдах маягаар явж болохгүй. Бид нар тооцоо судалгаа хийж үзсэн. Тэгээд нийт эцэг эхчүүдийн дунд ч гэсэн бид нар судалгаа хийсэн. Одоо гол асуудал бид нар 2240 төгрөг байна уу. 2470 төгрөг байна уу. Энэ чинь бол хүүхдийнхээ өдөр авах ёстой калорийн дөнгөж 30, 40 хувийг л авч байгаа ийм тооцоо байгаа. Тэгээд бид нар цаашидаа ингээд яваад байх уу. Мэдээж яг сургуулийн өмнөх боловсролын хоолны зардал дээр төрөөс нийт 70 орчим тэрбум төгрөг гарч байгаа. 1-5 дугаар ангийн хүүхдийн хоолны зардал дээр 80 орчим тэрбум төгрөг, тэгээд дотуур байрын хүүхдүүдтэй нийлэхээр яг төрөөс, улсын төсвөөс суутгаж байгаа санхүүжилтийн нийт 180 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт жил бүхэн гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг л дабльдах л асуудал шүү дээ. 360 тэрбум төгрөг.../минут дуусав/

Г.Занданишатар: Өнөөдөр хэлэлцэх 8 асуудалтай. Боловсролын хууль бол чухал асуудал. Боловсрол бол нийгмийн, эдийн засгийн, тэгш байдлын, ардчиллын бүх юмны язгуур үндэс. Тийм учраас Боловсролын хуулийг урт, удаан хугацаанд хэлэлцүүлэг зохион байгуулж, олон ургаж санал бодлыг сонсож ер нь чамбай анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн учраас анхны хэлэлцүүлэгтэй холбоотой

асуултуудаа ярихгүй бол бүх асуудал руу өргөн хүрээтэй, хэлэлцэх эсэх шийдэж байгаа юм шиг ороод байна л даа. Энэ чинь анхдугаар хэлэлцүүлэг, зөвхөн Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гарч байгаа 76 саналтай холбогдуулж, асуулт хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээн өрнөвөл илүү сайн байгаа юм. Ер нь зарчмын хувьд бүх боловсролын салбарт тулгамдаад байгаа хамгийн том асуудал бол нэгдүгээрт, багш нарын цалин, нийгмийн баталгааны асуудал. Энэ хангалтгүй байгаа учраас багшлах боловсон хүчний дутагдалд орсон. Багшийн нэр хүнд, нийгмийн мэргэжлийн статусын дээгүүр эрэмбэлэгддэг байсан бол зөвхөн физикийн багшаар 4-хөн хүн төгслөө гээд хэл ам болж байна шүү дээ. Хөдөөд математик, физикийн багш үндсэндээ байхгүй, дутагдалтай болсон. Багшлах боловсон хүчин дутагдалтай болж байна. Багш нар гадаадад харь ажил хийхээр визэнд орж хөөцөлддөг, аз аваад виз авсан нь явдаг болсон. Тэгээд энэ бүхэн маань боловсролын тогтолцоондоо язгуур үндсийн шинэчлэл хийх төдийгүй хамгийн гол асуудал эцсийн эцэст явж явж боловсролын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох, мэдээж хүн амын бараг 70 хувь нь залуу үе, залуучууд, хүүхэд залуучуудын орон учраас боловсролын зардал харьцангуй өндөр байх нь ойлгомжтой зайлшгүй асуудал. Тийм учраас нийгмийн баялгийн хуваарилалт, үндэсний баялгийн сангийн хуваарилалт, халамж төрийн бодлого ч гэсэн эцсийн эцэст боловсролыг дэмжихэд чиглэгдэх хэрэгтэй. Ер нь дээд боловсролыг үнэ төлбөргүй болгоё гээд санамсаргүй хэлээгүй. Үе шаттай гэдэг нь бүгдийг нь үнэ төлбөргүй социализм болгох гэж байгаа хэрэг биш. Гэхдээ харин элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 600-аас дээш байдаг ч юм уу авсан өндөр чадалтай хүүхдүүдийг заавал санхүүжилтээсээ үл хамаараад тэтгэлгээр сургадаг больё. Заавал Германы, Европын ч юм уу тогтолцоотой гэхээсээ илүү ингэвэл хүүхдүүд илүү чанартай боловсролыг

авах бололцоог олгоё. Ингэж байж ерөнхий боловсролын тогтолцоо тэр байгалийн шинжлэх ухаан үзэж байсан уламжлал, боловсролын тогтолцооны хуучин ололт, ажилтнуудаа улам бататгаад алдаа дутагдлыг нь засах ийм л өөрчлөлтийг хийх, хэрэгжүүлэх, тэгээд технологийн 4 дүгээр хувьсгалын эрин үед технологийн давуу тал, боломжуудыг ашиглах, тэгээд энэ шинэ нийгэм, ардчиллын 3 дахь давлагаа, даяаршлын эрин үед бас дангаар үлдэх Монгол хэл, соёл, хүмүүнлэгийн боловсрол гээд байгаа энэ сэтгэл зүрхний боловсрол, оюун ухааны боловсрол энэ бүх юмыг бид нар цогцоор нь тусгаж, шийдэх нь бол боловсролын хуулийн гол зорилго агуулга, маш өргөн хүрээтэй том суурь тавих асуудал байсан учраас үндсэндээ бараг 2 жил хэлэлцүүлэг явуулсан. Нэлээн өргөн хүрээнд хэлэлцсэн учраас бид нар энийг чамбайруулж, анхны хэлэлцүүлгээ хийх ёстой. Тэгэхээр илүү зарчмын зөрүүтэй саналууд дээрээ дэмжсэн, дэмжээгүй саналуудаа хэлж, сайжруулах агуулгаар явахгүй бол ерөнхий бүх, дээд боловсролтой ч холбоотой, сургуулийн өмнөх боловсролтой ч холбоотой, цэцэрлэг, сургууль гээд бүх асуудлаа яриад байвал боловсролын салбарт тулгамдаж байгаа бүх асуудлыг ярих юм бол Боловсролын сайдад тавьсан асуулгын хариу сонсож байгаа юм шиг болох гээд байна. Тийм учраас энийг манай гишүүд дараа дараагийн асуулт, хариултдаа анхаарвал зүйтэй байна. Ингээд Дамбын Батлут гишүүн асуулт асууна.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Маш чухал хууль хэлэлцэгдэж байна. Өнөөдөр манай Монгол Улс үндсэндээ багшлах боловсон хүчний дутагдалд орж байна. Ялангуяа хөдөө орон нутагт. Байгалийн ухааны чиглэлийн болон бага ангийн багш нарын дутагдалд орсон байгаа. Зөвхөн манай Орхон аймагт гэхэд үндсэндээ бага ангийн багш нар нэг сургууль дээр 1-5 хүртэл анги даах багшгүй, бага ангийн багшийн дутагдалтай явж байх

жишээтэй. Цаашилаад улам гүнзгийрэх хандлага бий болж байна. Түрүүн бас Их Хурлын дарга хэллээ. Монгол Улсын Багшийн Их Сургуулийн физикийн багшийн ангийг гэхэд 4 хүүхэд төгсөж байх жишээтэй гээд. Тэгэхээр энэ нөхцөл байдал нь юунаас үүсэж байгаа вэ гэхээр гишүүн болгон л ярьж байна. Цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар энэ хуулийг хэлэлцэж батлах гэж байгаа юм чинь дорвитой шинэчлэл, өөрчлөлтүүдийг, үр дүнтэй арга барил дээр тулгуурлаж хийх нөхцөл байдлыг бүрдүүлж өгөх ёстой гэж харж байна. Тийм учраас зарим нэг зүйлийг ахин тодруулж асууя гэж бодож байна. Гишүүдийн асуусан асуулттай бас давхцаж байгаа зүйл байгаа гэдгийг хэлье. Багшлах боловсон хүчинтэй холбоотой асуудал. Байгалийн ухааны чиглэлийн болон бага ангийн багш нар дутагдалтай байна. Энийг бид нар ямар бодлогоор яаж дэмжиж, цаашилаад энэ чиглэлийн багш нарыг бэлдэх асуудлыг шийдэх боломжтой байгаа вэ гэж харж байгаа юм бэ. Яах вэ түрүүн хэлж байна. Орон нутагт ажиллаж байгаа багш нарт 3 жил тутамд нь тэтгэлэг өгнө. Нийгмийн баталгаа хангах үүднээс тодорхой байр, орон сууцын дэмжлэг үзүүлэх гээд байх шиг байгаа юм. Тэр нь ямар хэмжээтэй, ямар шалгуур шаардах юм. Өнөөдөр орон нутагт ажиллаж байгаа багш нар голчлон залуу багш нар байна. Тэр багш нарын өмнө тулгамдаж байгаа асуудал ерөөсөө л байрны асуудал гэж байгаа юм. Тэгэхээр яаж шийдэх юм бэ. Бид нар яах вэ хууль дээр ингээд заагаад өгчхөж болно. Мөнгөөр юм уу эсвэл өөр зохицуулалтаар шийдэх гээд байгаа юм уу. Тэр нь яг өнөөгийн бодит нийгмийн өнөөдөр харилцаанд орж ирээд үнэлэгдэхээрээ хэр бодитой дэмжлэг болох юм. Энэ дээр нэг надад хариулт өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт нь Боловсролын багц хууль явж байгаа учраас асууж байгаа шүү. Бид нар өнөөдөр жоохон баримжаа муутай л яваад байгаа. Нэг ёсондоо

хөдөлмөрийн зах зээлийн судалгаа гэж зүйл ерөөсөө хийгдэхгүй байгаа. Монгол Улсад ирээдүйд ямар мэргэжил боловсролтой хүмүүс хэрэгтэй байгаа вэ гэдгээ тодорхойлохгүй байгаа. Шинжлэх ухаан технологийн дэвшилттэйгээ уялдуулж асуудлууд дээрээ судалгаа шинжилгээ хийхгүй байгаа гэж харж байна. Тэгэхээр бид нар нэг тоо тоймоо алдсан их дээд сургуулиудаа хэрхэх юм бэ. Ер нь цаашилаад хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой асуудлыг энэ хууль дээр яаж зохицуулж өгч байгаа юм. Бид ирээдүйд Монгол Улсад хэчнээн тооны ямар мэргэжилтэй боловсон хүчин ямар ямар мэргэжилтэй боловсон хүчин хэрэгтэй байгаа вэ гэдгээ яаж тодорхойлж гаргаж ирэх юм бэ. Магадгүй маргааш банканд теллер хэрэггүй болно шүү дээ. Бид нар магадгүй гар утаснаасаа ингээд бүх гүйлгээнүүдээ хийчихдэг болно гэдэг ч юм уу ингээд одоо байгаа мэргэжил ирээдүйд байхгүй болно. Үүнтэйгээ уялдуулсан тодорхой шийдлүүдийг хуулийн гарц гаргалгаа дээр оруулж өгч байгаа юм уу гэдэг дээр бас нэг хариулт өгөөч ээ. Хариулт авсны дараа тодруулъя. Цаг дуусчихлаа.

Л.Мөнхбаатар: Батлут гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулъя. Шаардлагатай бол нэмж ажлын хэсэг хариулж болно.

Л.Энх-Амгалан: Батлут гишүүн ээ, багшийн хомсдол гэж үнэхээр яг багшийн хомсдол бий болгох ийм чиг хандлагууд байна. Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын боловсрол тэр чигээрээ багшийн хомсдолд орчихсон байна гэдэг энэ дүгнэлт бол жаахан өрөөсгөл гэнэн дүгнэлт байх болов уу гэж би бодож байгаа юм. Одоо бид нарын судалгаагаар хичээлийн шинэ жил эхлэхэд 2200 багш дутагдалтай, тэгээд хичээлийн жилийн хугацаанд ингээд гүйцээгээд нөхөөд явдаг л нэг ийм л тогтолцоо байгаад байгаа байхгүй юу. Тэгээд цаашидаа бол яг багшийн хомсдол үүсэх ийм чиг хандлага төлөв байна уу гэвэл байна. Тэрийг бид нар яаж зохицуулах вэ. Бид нарт богино

хугацааны болон богино хугацааны, дунд хугацааны, урт хугацааны ийм бодлогын шийдлүүд л би хэрэгтэй юм байна гэж хараад байгаа юм. Богино болон дунд хугацааны шийдлүүд дээр бид нар Монгол Улсын Боловсролын их сургуулиуд дээр багш бэлдэж байгаа ангиудын төгсөх ангийн оюутнуудыг өнгөрсөн жилээс бид нар ажлын байран дээр нь ажиллуулаад, тэгээд тодорхой кредитийг нь тооцуулаад ажиллангаа суралцаад төгсөх боломжоор нь бид нар хангаж ажиллаж энэ бол бас нэг шийдэл байгаад байгаа юм.

2 дугаар асуудал бол тэтгэвэрт гарсан багш нарыг бас бид нар нэлээн боломжуудыг нь ашиглаж ажиллаж байна.

3 дугаар хамгийн том шийдэх асуудал бол цаашидаа бид нар сургуулиудынхаа бүтэц хэв шинжүүдийг ер нь эргэж харах цаг нь болчихсон байна. Өнөөдөр 330 сум дээр 12 жилийн тогтолцоотой 12 жилийн сургууль байгаа мөртөө 9, 10, 11, 12 дугаар анги дээр 3-хан хүүхэдтэй, 5-хан хүүхэдтэй ийм сургуулиуд 330 сум дээр байж байна шүү дээ. Тэгэхээр цаашидаа бид нар яг ингээд 12 жилийн тогтолцоотой сургууль ахлах сургууль нь аймагт хэд байх ёстой юм. Дунд сургууль хэд байх ёстой юм. Бага сургууль хэд байх ёстой юм гэсэн сургуулийнхаа хэв шинжүүдийг бид нарыг нэлээн сайн харж байж зөв төлөвлөлтүүд хийх ёстой юм байна. Ингэж байж бид нар багш нарын хомсдолын асуудлуудыг богино хугацаанд шийднэ. Дунд болон урт хугацаанд мэдээж хамгийн зөв шийдэл багшийн үнэлэмжийн асуудал. Тэр тусмаа хөдөлмөрийн үнэлэмжийн асуудлуудыг бид нар шийдэх. Энэ хуулиар бид нар багш нарын суурь цалинг нэмчхээж байгаа гэсэн тийм хүлээлтийг бид нар бий болгож болохгүй. Ер нь цаашидаа бол төрийн үйлчилгээний ажилтнуудын салбарын нэг хуулиар ингээд ийм хөрөөний эрх ашиг болгочихсон байгаа цалин хөлсний тогтолцоонуудыг нэг

жигдэлье гээд Монгол Улсын Засгийн газар ажиллаж байна. Суурь цалингийн тогтолцоо нэг өөр. Энэ хуулиар яг юу оруулж, багш нарт ямар давуу тал олгож байгаа вэ гэвэл ерөөсөө ур чадвартай, чадварлаг, мэргэшсэн багш нар бол цалингаасаа илүү үр дүнгийн урамшуулал авдаг энэ тогтолцоо руу оруулж өгье гэж байгаа юм. Энэ тогтолцоо өнгөрсөн жилээс хэрэгжээд эхэлчихсэн шүү дээ. Манай багш нар бол багш нарын үнэлгээгээр бид нар нийт 30 гаруй мянган багш нараа үнэлгээнд оруулаад 6 түвшинд үнэлдэг болсон. 1-4 түвшинд нийт цалингийнх нь 10-25 хувь дээр бид нар нэмэгдэл өгч байгаа. Би 25 хувийг цаашидаа бол 100 хувь болгох ийм боломжууд бас шинэ хувьсах зардлын аргачлалаар бий болно гэж ойлгож байгаа. Хамгийн сайн багш, хамгийн сайн бүтээмжтэй багш, хамгийн сайн ур чадвартай багш бол хамгийн өндөр цалин авдаг энэ тогтолцоо руу бид нар урагшаа алхах ёстой гэж ойлгож байгаа.

Тэр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтүүдийн асуудлууд дээр судалгаанууд бас нэлээн хийгдэж байгаа. Ер нь бол ирээдүйн 5-8 жилд Засгийн газраас хэрэгжүүлэх шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 38 мянган инженер техникийн ажилтнууд хэрэгцээтэй гэсэн ийм хөгжлийн хэрэгцээ шаардлагууд гарч байна. Тэгэхээр манай өнөөдрийн байгаа мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын тогтолцоо харамсалтай нь хөдөлмөрийн зах зээлийнхээ эрэлт нийлүүлэлттэй хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ур чадварын эрэлт нийлүүлэлттэй ерөөсөө уялдаагүй явж ирсэн учраас өнөөдөр нэг талдаа хөдөлмөрийн зах зээлийн хомсдолд орчихсон нөгөө талдаа ажилгүй 100 мянган залуучуудтай байгаа ийм л улс орон болчихоод байгаа шүү дээ. Тийм учраас цаашидаа бид нар мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, дээд боловсролын тогтолцоогоо их уян хатан болгож, яг хөдөлмөрийн зах зээл дээр байгаа хөдөлмөрийн эрэлт хэрэгцээ гэхээсээ илүү ур чадварын эрэлт

хэрэгцээнд нийлүүлсэн техникийн болон мэргэжлийн боловсролын тогтолцоонд л шилжүүлэх шаардлагатай гэж ойлгож байгаа. ямар ч байсан намайг ажилд авахад 100 гаруй.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух уу? Дамбын Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Ер нь яах вэ нийгмийн асуудал хамгийн чухал байгаа л даа багш нарын хувьд. Тэгээд тэр нэг урамшуулал 3 жил тутамд гээд байгаа. Дээрээс нь тэр орон сууцын дэмжлэг үзүүлэх гэж байгаа гэдэг чинь өнөөгийн бодит нөхцөл байдалд бодит дэмжлэг болж байгаа юм уу гэдэг дээр л би хариулт авах гэж байгаа юм. Зүгээр ямар нэгэн хэлбэрээр асуудалд хандахдаа бүрэн төгс шийдэх хэлбэр дээр орохгүй бол мэдээж нэг хэлбэр төдий байснаараа эргээд хүний нөөцтэй холбоотой багш нарынхаа хомсдолыг багш нарын нийгмийн асуудлыг шийдсэн үр дүн гаргасан шийдэл бас гарахгүй гэж харж байгаа юм л даа. Тийм учраас энэ дээр нэг хариулт өгөөч ээ гэсэн юм. Ер нь зүгээр боловсролын системд асуудал байна. Тухайлах юм бол менежерүүд багш нараасаа бага цалин авдаг, тэгсэн мөртөө маш олон үүрэг гүйцэтгэдэг. Дээрээс нь анги даасан багш нар ямар нэгэн урамшууллын хэмжээ нь маш багаар олгогддог ч гэдэг юм уу. Энэ олон асуудлуудыг зүгээр яамны хэмжээнд ярьж байгаа шийдэх боломжууд зөндөө л байгаа байх гэж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Батлут гишүүний тодруулгад хариулъя. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ер нь манай төрийн үйлчилгээний албан хаагчдын дотор бараг цалин хөлсний нийт 17 төрлийн ангилал зэрэглэлүүд өөр ангилал зэрэглэлүүд бий болчихсон юм байна лээ. Тухайн тухайн салбарынх нь хуулиуд тус тусдаа батлагдахаараа цалин хөлснийхөө тогтолцоо нийгмийн

баталгааг ингээд тухайн салбарын хуулиудаар шийдэж явсаар байгаад ийм хөрөөний ир шиг болчихсон ийм асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр би тантай бол санал нэг байна Батлут гишүүн ээ. Одоо бид нар Боловсролын багц хуулиараа нэг тийм гал унтрааж байгаа асуудал биш. Хамгийн гол нь бодлогын зөв шийдлүүд гаргах ийм эрх зүйн орчнуудыг л бий болгох ёстой гэж ойлгож байгаа. Тэгэхээр мэдээж юу гэдэг юм нийгмийн тэтгэврийн нас гэдэг юм уу нийгмийн баталгаа, суурь цалингийн асуудлууд илүү цалин хөлсний тогтолцоонд нэг л цалин хөлсний тогтолцоог хариуцсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань өөрөө энэ асуудлуудыг оруулж ирнэ гэдэг Засгийн газар дээр ийм суурь зарчим тохирсон.

2 дугаарт Нийгмийн даатгалын багц хуулиуд батлагдаж эхлэхээр цаашидаа Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны тэтгэврийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Боловсролын багц хуулиуд гээд маш том хуулиуд олон хуулиуд бараг 2 жил шахам Их Хурал дээр болоод нийгмийн хэлэлцүүлэг болоод оролцогчдын хэлэлцүүлэг болоод орж ирж байна л даа. Тэгэхээр эндээс дунд боловсролтой болон ерөнхий боловсролтой холбоотой хуулийн зохицуулалтуудыг ингээд харахад яг хуулиас гарч байгаа хамгийн том мессеж нь яг юу юм бэ. Уг нь бол нийгмийн хүлээлт асар их өндөр байдаг. Олон улсын жишиг олон зүйлд нийцэх ёстой гээд асар том хүлээлт байдаг. Эндээс гарч байгаа хүлээлт бол үнэхээр тийм гол мессеж гэдэг зүйл харагдахгүй байна. Яг яагаад энэ боловсролын тогтолцоо энэ хуулийн хүрээнд ийм ахиц дэвшил гарах гэж байгаа юм. Энэ дээр нэг тодруулга өгөөч.

Хоёрдугаарт нь өнгөрсөн хугацаанд явсан хэлэлцүүлгийг харахаар нэг тийм хувийн сургуулиа хавчин гадуурхсан ийм л нөхцөл байдлын маргаан л энд үлдчих ишг болох юм. Тэгэхээр энэ дээр энэ хувийн сургуулиудын холбооны төлөөлөл, ер нь та нар энэ хуулийн боловсруулалт болоод гарч байгаа эцсийн төсөл найруулгуудад ямар санаа бодитой хувийн сургуулиудын төлөөлөл энд үлдэж байгаа вэ. Та бүхэн энэ дээр санаа бодлоо илэрхийлээч. Гол энд ярих гэж байгаа, ярихыг хүсэж байгаа зүйл миний хувьд бол ер нь боловсролоороо бид нар нэгдүгээрт олон улсын жишиг, энэ олон зүйл рүүгээ ойртож очих ёстой. Хоёрдугаарт нь ер нь боловсрол гэдэг чинь өөрөө Монгол Улсын хөгжлийн гарц. Бид нар хавчигдмал, дэд бүтцийн хувьд буурай, алслагдмал, цөөхөн хүнтэй. Энэ боловсрол бол Монгол Улсын тэргүүлэхийн тэргүүлэхийн тэргүүлэх чиглэл гэж байдаг бол боловсрол байх ёстой. Тэгэхээр энэ маань өөрөө явсаар байгаад бид нарын хувьд боловсролын ХАБ гэдэг зүйл байдаг бол Монгол Улсад энийг бий болгох юмсан гэдэг ийм амбицыг бид нар тавих ёстой байх. Монгол Улсдаа, эргэн тойрны бүс нутагтаа, Монгол туургатнууд ирж, Монгол улсад тэр валютаа барьж ирээд сурдаг, боловсродог, дунд боловсрол, их дээд боловсрол. Энэ бол энэ хуулиас болоод боловсролын бодлогоос тийм хэмжээний амбиц үнэртэж, тийм хэмжээний зорилго тавьж байж эндээс олон зүйл явдаг байх. Үүний тэр орой, магнайд нь хувийн хэвилийн сургуулиуд явах ёстой юм болов уу. Тэр боломж, бололцоог нь илүү ихээр нээж өгөх ёстой юм болов уу л гэж харж байгаа. Гэтэл нэг тийм ажлын хэсгийн хэлэлцүүлэг, олон зүйлүүдийг харахад хавчигдсан гадуурхагдсан тийм хэмжээний амбиц байхгүй, өнөөдрийн байгаа байдлын гал унтраах гэсэн. Энэ хуулиас яг л би ажлын хэсэг биш. Нарийн мэдээлэл алга. Гэхдээ ийм түвшний л зүйл харагдаж байна.

Хоёрдугаарт нь Боловсролын сайдаас, ер нь энэ боловсролын ялгаа

орон нутаг, хөдөө энэ боловсролын ялгаа гэдэг зүйл бодит байдал дээр асар их гарчихсан. Бид нарт техник, технологийн янз бүрийн боломж, бололцоо асар их зүйл нээгдэж байдаг. Тэгэхээр энэ хуулийн үзэл санаа болоод ер нь боловсролын салбарын бодлого дээр ялгааг арилгах чиглэлд яг бодитой ямар ажлууд бас хийгдэх вэ. Энэ дээр энэ хуультай ч болоод заавал хуулийн хүрээний биш олон ажлууд байгаа байх. Энэ дээр тодорхой зүйлүүдийг хэлээч. Энэ бол өөрөө Монгол Улсын цаашидын тэр нөхцөл байдал, хаана амьдарч байгаагаасаа хамаараад амьдралын ялгаа, олон зүйл үүсэх, цаад талд нь нийгмийн асуудлын олон асуудал хуримтлагдах ийм нөхцөл байдал үүний цаана үүсэж байна гэж бодож байгаа. Тэгэхээр хувийн хэвилийн төлөөллийг түрүүний асуултад хариулж өгөөч гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Хуулийн ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулна. Дээр нь нэмээд Энх-Амгалан сайд хариулаарай.

Г.Дамдинням: Цогтгэрэл гишүүн маш чухал асуудал хөндөж байна. Боловсролын багц хуулийн реформын гол амбиц, нийгэмд өгөх үр дүн. Бид нар ер нь юу хараад байгаа юм гэж. Бид 2020 онд Улсын Их Хурал бүрдээд, Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл баталж байхад нэр бүхий гишүүдийн санаачилгаар оруулсан Монгол Улсыг олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний боловсролын тогтолцоотой болно гэсэн зорилго тавьсан. Үүний хүрээнд энэ ажил хийгдээд явж байгаа. Өнөөдөр бид нар Монголын боловсрол муу байна гээд янз бүрээр ярьж байгаа. Хэн хэмжсэн юм, яаж хэмжсэн юм, хэнтэй харьцуулсан юм тодорхой бус. Хуульд ямар ч зохицуулалт байхгүй байгаа. Тэгэхээр энэ дээр бол Цогтгэрэл гишүүн ээ, тантай санал нэг байгаа учраас энэ хууль дээр нэлээн гол заалтууд орж ирсэн. Монголын боловсролын тогтолцоо энэ

хууль батлагдсаны үр дүнд олон улсын түвшний үнэлгээнд түвшин бүрдээ орно. Сургуулийн өмнөх, ерөнхий, дээд, насан туршийн боловсролын түвшинд бүх үнэлгээнд жил бүр орно. Тэр тусмаа ерөнхий боловсролын салбарт олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн үнэлгээнд 3 жил тутам орно. Ингээд бид хаанаа алдаад байгаа юм. Хаанаа оноод байгаа юм гэдэг дүгнэлтээ хийж, нөхөж, хаана хөрөнгө оруулалт хийхээ шийдэж явна.

Хоёрдугаарт энэ үнэлгээнд юу багтах вэ. Хүүхдүүдийн чадвар, багийн чадвар ялангуяа сургуулийн менежментийн чадварыг бид нар үнэлнэ. Олон улсын стандартаар үнэлнэ гэсэн үг. Тэгэхээр бидний амбиц бол яг л тийм байгаа. Хэрэв бид олон улсад өрсөлдөх чадвартай энэ суурь зарчмыг тавьж чадах юм бол манай хөрш орнуудаас, бусад орнуудаас таны хэлж байгаа боловсролын ХАБ болох суурь тавигдах ёстой гэсэн ийм зорилготой байгаа. Хот, хөдөөтэй холбоотой асуудал дээр би түрүүн нэлээн хариулчихсан Энх-Амгалан сайд нэмээд хариулчих байх.

Хувийн сургуулиудаас тухайлаад шууд төлөөллөөс нь асуучихсан учраас тэр хүмүүс хариулчих байх. Би бас түрүүн хариултууддаа хувийн сургуулиуд дээр ажлын хэсгээс барьж байгаа байр сууриа бол хэлчихсэн.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд нэмж хариулъя. Дараа нь бас ажлын хэсгээс нэмж хариулах шаардлагатай бол хариулж болно шүү.

Л.Энх-Амгалан: Хурал даргалагч аа, 1 минут биш, 1 минутад бол үнэхээр амжихгүй болчихоод. Яагаад гэвэл Цогтгэрэл гишүүний асууж байгаа асуудал чинь хуулийн концепцын асуудал яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо энэ чинь бид нар чинь 6 реформоо хийх гээд байгаа. 1, 1-ээр нь тайлбарлана гэхээр чинь 1 нь 1 минутад багтахгүй

байгаа л ийм л асуудал болчихоод байна шүү дээ тээ.

Гол асуудал бол Цогтгэрэл гишүүн ээ ийм шүү дээ. Одоо ерөөсөө энэ боловсролын хуулиар хийгдэх гээд байгаа хамгийн гол асуудал бол ер нь Монгол улс өнгөрсөн хугацаанд хүртээмж дээр тодорхой ахиц дэвшил гаргасан байна. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж. Өнгөрсөн жил бид нар сугалааны цэцэрлэгийн тогтолцоог халсан. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж бол бид нар чинь 90 гаруй хувьд хүргэнэ гэдэг чинь бол бүс нутгийн хэмжээнд байхгүй том амжилт гаргасан. Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд бид нар сургуулийн завсарлалд гэдэг ойлголт байхгүй болсон. 98 хувьд хүргэсэн. Одоо бол гол хөндөж байгаа асуудал бол ерөөсөө боловсролын чанарын асуудал л байгаа байхгүй юу. Явал хүүхэд хаана амьдарч байна, хаана суралцаж байгаагаасаа үл шалтгаалаад чанартай боловсролыг авах вэ. Чанартай боловсрол гэдэг яг өөрөө юу юм бэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, хотын төвийн сургууль, хотын захын сургуулийн ялгаа, хувийн сургуулийн ялгаа, төрийн сургуулиудын ялгааг аль арилгах гээд байгаа гол б зүйлийг л бид нар тодруулж гаргаж ирж энэ хуулиар шийдэх гээд байгаа юм.

1 дүгээрт явж байгаа санхүүжилтийнхээ тогтолцоог бид нар өөрчилье. Энэ санхүүжилтээрээ дамжиж хот хөдөөгийн сургуулийн ялгааг бид нар арилгая. Төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудын ялгааг арилгая. Ер нь газар зүйн байрлалын хувьд боловсрол, сургууль, алслагдсан сургууль гэж байх гэдэг ойлголт байна уу гэхээс биш алслагдсан багш, алслагдсан хүүхэд гэж ойлголт байж болохгүй л гэж бодож байгаа. Тийм учраас санхүүжилтийн тогтолцоо нэг хүүхдийг сургах хувьсах зардлаар нь дамжиж тэр орчных нь ялгаа, тэр багш нарын чадварын ялгааг санхүүжүүлдэг тогтолцоо руу 1 дүгээрт шилжүүлье.

2 дугаар асуудал манай хөтөлбөрийн шинэчлэл хийгдэх ёстой. Манай хөтөлбөр бас хоцрогдсон байна. Дэндүү их академик мэдлэг өгдөг болсон байна. Тийм учраас өнөөдөр хүүхэд анги танхимд орсон академик мэдлэгийг амьдралд яг ур чадвар болгож чадаж байна уу. Тэр ур чадвараа амьдралд хэрэгжүүлж чадаж байна уу. Тэр ур чадвараа хөгжүүлж чадаж байна уу гэдэг асуудал дээр бид нар бас сүүл мушгиж байна. Өнгөрсөн жил бид нар анх удаа олон улсын Писа гэдэг үнэлгээнд орсон. Гэтэл Монгол Улс дэндүү их хүүхдүүддээ танхимын мэдлэг илүү олгоод байна. Академик мэдлэг олгоод байна. Хүүхдүүд чинь тэр анги танхимаар авсан мэдлэгээ амьдралд хэрэгжүүлж чаддаг тэр ур чадварт чинь сууж чадахгүй байна гэсэн ийм дүгнэлтүүд урьдчилсан байдлаар гарчхаад байгаа шүү дээ. Тэгэхээр тэр мэдлэг, чадвар, төлөвшил гэдгийг олгодог энэ хөтөлбөрийн шинэчлэлүүдийг хийе. Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд хүүхдүүд илүү бүтээлчээр сэтгэдэг тэр сэтгэлгээ, бие биетэйгээ хамтарч ажилладаг тэр багийн сэтгэлгээг бий болгох. Асуудалд цогц сэтгэлгээгээр хандаж чаддаг ур чадваруудыг суулгах энэ үндэсний хөтөлбөрүүдийг бид нар хэлэх ёстой юм байна. 2 дугаар асуудал.

3 дугаар асуудал бол мэдээж багийн асуудал байгаа. Өнөөдөр багш бэлтгэх, багш ажлын байран дээрээ очоод тасралтгүй хөгжих, тэгээд багш өөрийнхөө ажлыг зөв үнэлэмжээр бүтээмж сайтай, ур чадвар сайтай багш нар бол өндөр цалин урамшуулал авдаг энэ тогтолцоо руу нэг алхъя гэж. 3 дугаар асуудал.

4 дүгээр асуудал бол өнөөдөр хүртэл явж ирсэн дүнгийн тогтолцоо бол буруу тогтолцоо байна. Хуурамч дүнгийн тогтолцоо байна. Хүүхдүүдийг хооронд нь өрсөлдүүлж байна. Тийм учраас цаашдаа хүүхэд дээр ахиц дэвшлийн үнэлгээний тогтолцоо бид нар

бий болгоё. Хүүхэд бүрийг мөшигөө. Хүүхэд бүрийн өнөөдөр сурах чадвар, сурах хурд гэдэг өөр байна. Тийм учраас хүүхэд, сурагч бүрийг мөшигөсөн ахиц дэвшлийн үнэлгээ, багийн үнэлгээ, сургуулийн үнэлгээ гэсэн үнэлгээний тогтолцоо руу шилжүүлбэ.

Дараагийн асуудал нөгөө сургууль цэцэрлэгийн засаглалын асуудал байгаа юм. Хамгийн мэргэшсэн чадвартай хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс нь дээшээ шатлан дэвшдэг, чадавхын зарчим дээр шатлан дэвшдэг тогтолцоо руу оруул.

5 дахь асуудал мэдээж цахим шилжилтийн асуудал. Өнөөдөр цахимаар дамжиж цахим шилжилтийг бид нар аль болох богино хугацаанд хийж чадна. Тэр хэмжээгээрээ бид нар тэгш хамран сургах.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай байх. Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Нэмж хариулах хүн байгаа юу. Номин гэсэн үү. 85.

Н.Номин: Сайн байцаана уу? Ажлын хэсгийн гишүүн төрийн бус өмчийн сургуулийн холбооны тэргүүн Номин байна. Бид ажлын хэсэг дээрээ ярилцаад төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд нь боловсролын зорилгыг хэрэгжүүлэхээр сургалтын үйл ажиллагаа явуулаад, олсон орлогоо өөрсдийнхөө дүрэмд зааснаараа үндсэн үйл ажиллагаандаа зарцуулсан бол ашигийн төлөө бус, ноогдол ашиг хэлбэрээр тараасан бол ашигийн төлөө байхаар зохицуулагдаад, боловсрол, сургалтын байгууллага гэсэн хуулийн этгээдийн хэлбэрт шилжиж үйл ажиллагаа явуулах гэсэн ойлголтоор нэгдсэн байгаа. Хуулийн төсөл дээр хувийн хэвшлийн сургуулийн захирлуудын зүгээс дан ганц өөрсдийнхөө эрх ашиг биш нийт Монгол Улсын боловсролын үндсэн зорилгын хүрээнд санал хүргүүлж ажилласан. Ерөнхийдөө бидний тодорхой хэмжээний саналууд тусаад

өнөөдрийн Байнгын хороо, ажлын хэсгээр ороод чуулганаар ороод хэлэлцэгдээд явж байна.

Л.Мөнхбаатар: Асуулт хариулт 2 тэнцүү байх ёстой гээд байгаа. Тэгээд хариулт бол нэлээн их болж байна. Тодруулах юм уу. Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя. 1 минут.

О.Цогтгэрэл: Би товчхон нэг ганц асуулт нэмээд асуучихъя. Ер нь энэ чинь ерөнхий боловсролын сургуулийн тухай ярьж байгаа. Тэгэхээр статистик байдаг юм уу. Яг өнөөдөр Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхэд гадаад улс оронд сурч байгаа хэчнээн хүүхэд энд ер нь ямаршуу санхүүжилт мөнгө гадагшаа явж байдаг юм бол Монгол улсад өнөөдөр яг боловсролын тогтолцоонд хувь хувьсгалын сургуулиудад гадаад улс орноос хөрш орноос ч юм уу ирж сурч байгаа тоо баримт, тоо ер байдаг уу. Энэ дээр гадагшаа сурч байгаа, дотогшоо ирж сурч байгаа гэдэг дээр.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Гадаад улсаас манай Монгол Улсын их дээд сургуулиудад сурч байгаа 2100 орчим оюутан өнөөдөр байна. Ихэнх нь дандаа Өвөр Монголоос манай Багшийн Их сургууль, Соёлын их сургууль дээр ирж суралцаж байгаа. Сүүлийн өнгөрсөн жил манай анагаах ухааны АШУУИС их сургууль бол 2 хөтөлбөрөө олон улсад магадлан итгэмжлүүлсэн учраас 17 улс орны 70 гаруй оюутнууд бол их эмчээр суралцах элсэлтийг өнгөрсөн жил авсан. Ер нь цаашидаа бол бид нар их дээд сургуулиудынхаа хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлж чадах юм бол дээд боловсролын экспорт хийх бас ийм боломжууд бас байгаа гэж би харж байгаа юм. Энэ бол том боломж. Өнөөдөр хилийн чанадад сурч байгаа хүүхдүүдийн тоог яг эцэслэсэн статистик бол хэлж чадахгүй байна.

Гэхдээ Монгол банкнаас гаргасан саяын валютын нөөцийг бүрдүүлэх тэр чиглэл рүү хийсэн судалгаагаар харахад жилд бид нар ерөөсөө яг хилийн чанадад сурч байгаа хүүхдүүдийнхээ төлбөрт зориулж 400 сая доллар Монгол улсаас гадагшилдаг юм байна. 400 сая доллар энэ бол багагүй.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яах юм гүйцээгээд хариулчихъя. 1 минут. Хэдүүлээ жаахан шуурхай явна.

Л.Энх-Амгалан: Хэрэв бид нар хувийн өмчийн гэдэг юм уу олон улсын хөтөлбөртэй Кембрижийн хөтөлбөртэй дунд сургуулиуд Монгол улсад байхгүй байсан бол энэ дунд сургуулиуд дээр сурч байгаа 40 гаруй мянган хүүхэд байгаа шүү дээ. 47 мянган орчим хүүхэд гадагшаа хилийн дээс алхахаас өөр сонголт байхгүй болно. Харин ч сүүлийн 30 жилд олон улсын хөтөлбөртэй хувийн сургуулиуд Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 40 гаруй мянган хүүхдүүдийг 1 дүгээрт сургаж байгаа. Боловсролын хүртээмж дээр маш чухал үүрэг роль гүйцэтгэж байгаа. Тэгээд цаашидаа мэдээж боловсролын түвшин, боловсролын ялгааг ойртуулах чиглэл рүү төр-хувийн хэвилийн түншлэлийн хүрээнд тодорхой хамтарч ажиллах хамтын хэлбэрүүд байх ийм бололцоонууд нь байгаа болов уу л гэж харж байгаа.

Л.Мөнхбаатар: Өнөөдөр бол ер нь Боловсролын ерөнхий хуулийнхан л шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байгаа шүү дээ. Бусад хуулиуд нь бол ингээд дараа нь уялдаж орж ирнэ. Ийм учраас хэдүүлээ бас хурлаа бас жаахан шахаад явъя. Тэгэхгүй бол одоо 12 гишүүн үг хэлэхээр байна. Үүний дараа зарчмын зөрүүтэй 76 санал байгаа. Гишүүдийн асууж байгаа асуултууд агуулгаараа нэлээн давхацсан ийм асуултууд яваад байна. Энх-Амгалан сайд, Дамдинням дарга нэлээн дэлгэрэнгүй хариултуудыг түрүүнээс хойш өгөөд яваад ирлээ. Одоо жаахан

товчлоод явъя. Ундрaм гишүүн ажлын хэсгийн гишүүний хувьд хариулчих. Ингээд цаашаагаа зөвхөн ажлын хэсгээс нэг хүн хариулаад ингээд явна гэдгийг хэлье. Ундрaм гишүүн тодруулгад нэмж хариулья.

Ч.Ундрaм: Түрүүнээс хойш нэлээн олон асуултуудад хувийн сургуультай холбоотой асуудал, англи хэлтэй холбоотой асуудал гарсан. Тэгээд ажлын хэсгийн гишүүний хувиар бас ажлын хэсгийн гишүүнээр мөн хуульд анхаарал санаа тавьж 2, 3 жил ажилласан хүний хувиар бас хариулт өгөх боломж олгосонд баярлалаа.

1 дүгээрт англи хэлний асуудал байгаа юм. Өнөөдөр яагаад эцэг эхүүд илүү мөнгө төлөөд хувийн сургуульд хүүхдүүдээ сургаж байгаа вэ гэхээр хамгийн том ялгаа нь бол англи хэл байгаа юм. Англи хэлтэй болсноор хүүхэд яаж байгаа вэ гэхээр дэлхийн шинэ инновац, мэдлэгийн 90 хувь нь англи хэл дээр эрдэм шинжилгээний үйл болж, хэвлэгддэг. Дэлхийн хэмжээний утга уран зохиолын 90 хувь нь англи хэл дээр хэвлэгддэг, онлайн байршсан байж байдаг гэх мэтчилэн дэлхийн хэмжээний мэдлэгийг олж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ундрaм гишүүн гүйцээгээд хариулчих. 1 минут.

Ч.Ундрaм: Дэлхийн хэмжээний мэдлэгийг олж авъя гэвэл ерөөсөө англи хэл дээр. Цаашилаад энийгээ ашиглаад өөрөө мэдлэг бүтээе гэвэл, тэрийгээ дэлхийд хүргэе гэвэл англи хэл дээр. Тэгэхээр Монгол Улс хөгжмөөр байна. Шинжлэх ухаанд хувь нэмрээ оруулмаар байна. Тийм учраас англи хэл чухал гэж байгаа.

2 дугаарт гадаад улс орон дэлхийд болж байгаа үйл явдал ихэнх нь ямар нэгэн үзэл суртлын шүүлтүүрээр ороогүйгээр англи хэл дээр хэвлэн нийтлэгддэг. Тийм учраас англи хэлтэй байж байж бид нар дэлхий ертөнцөд юу

болж байгаа, дайн болж байгаа юм уу гэх мэт мэдээллүүдийг англи хэл дээр олж авч байгаа юм.

3 дугаарт болохоор хүний эрх зөрчигддөг юм уу улс орны эрх ашиг зөрчигдөх юм бол бид нар дэлхийд НҮБ-ийн үндсэн 5 хэлний 1 олох ихэнх хүмүүс ойлгодог англи хэлээр өөрийгөө илэрхийлэх юм. Тийм учраас англи хэл чухал юм гэж бид нар энэ хуульд оруулаад байгаа юм. Тэгэхээр энийг ард иргэд маань манай язгуур эрх ашиг гэж ойлгоосой гэж .../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одоо Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Боловсролын багц хууль яригдаж байгаа юм. Тэр дотроос Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагасан хуулиуд өнөөдөр орж ирж анхны хэлэлцүүлэг нь хийгдэж байна. Мэдээж бид нар энэ боловсролын хөгжлийн тал дээр олон жил олон талаас нь ярьцаасан. Тодорхой ахиц гарсан гэдэгт би эргэлздэггүй. Гэхдээ шийдэл яг болсон уу гэвэл эргэлзээтэй зүйлүүд олон байгаад байгаа. Бид бүгдийг төрийн хөрөнгөөр шийдэж чадахгүй л байгаа нь үнэн бол шийдлийг яаж хийх вэ гэдэг юмыг эрэл хайгуул хийх ёстой юм болов уу гэж би боддог. Энэ боловсролын байгууллагуудын өөрийн удирдлагын байгууллага гэдэг юмныхаа эрх хэмжээг их тодорхой болгож өгөх ёстой юм биш үү. Тэр байгууллагынхаа менежментийн төлөвлөгөө юмнуудаа баталж чаддаг төсвөөс өгч байгаа мөнгөнөөс гадна боловсролын ялгаатай байдлыг гаргахгүйн тулд орон нутаг гэдэг юм уу тэр төлөөллүүд ямар хэмжээний бололцоо бүрдүүлж боловсролын байгууллагын орчны хөгжлийг гэдэг юм уу боловсон хүчний чадамжийг бий болгох тал дээр ажиллаж болох юм бэ гэдэг тэр эрх зүйн зохицуулалт, эрх чөлөөг нь нээж өгөх ёстой юм биш үү. Энэ дээр ер нь юу гэж ойлгоод байна вэ гэж.

Дараагийн нэг зүйл төрийн удирдлагын шатлал мэдээж засаг захиргааныхаа нэгжээр бид нар үүрэг хүлээж байна. Гэхдээ олон жил ингэж явсан. Аймаг ингэнэ, сум ингэнэ гээд давхардсан бараг функц хэрэгжүүлээд явчихсан. Хэдэн бие рүүгээ түлхэлт яваад болж өгөхгүй байгаа. Тийм учраас боловсролын салбараа яг аль нэгж дээрээ онцгойлон хариуцаж түүнд шаардлагатай хөгжлийн асуудлыг төсөв хөрөнгийн асуудлыг боловсон хүчний асуудлыг хэнтэй ч хуваалцахгүй шийдэх юм бэ гэдэг юмаа шийдлийг нь гаргаж өгвөл илүү оновчтой юм биш үү. Мэдээж сум, багийн засаг дарга нар тэр боловсролд хамрагдах насны хүмүүсээ хамруулж оруулах барих гээд тийм үүрэг хүлээлгүй яах вэ. Гэхдээ энэ боловсролын салбарын хөгжил тал дээр аймаг нь илүүл үүрэг хүлээх юм уу, сум нь илүү үүрэг хүлээх юм уу гэдэг юмыг ер нь анзаарсан, харсан зүйл байна уу.

Гурав дахь зүйл. Хөгжлийн тэргүүлэх чиглэл эрэлт хэрэгцээндээ суурилсан боловсон хүчин бэлтгэх асуудлыг бид ер нь юу гэж авч үзэх юм бэ. Энэ ерөнхий хуульд ер нь ямар тусгалаар орж байна вэ гэж. Өнөөдөр энэ Азийн улс орнууд нийтээрээ ажиллах хүчний хомсдолтой болж байх шиг байна. Тийм учраас Монголоос ажиллах хүчийг нэлээн авч байна. Тэр дотроо манай нийгмийн салбарынхны талын хүмүүсийн виз мэдүүлэг дээр нэлээн том дэмжлэг үзүүлээд виз гаргаж өгөөд байгаа юм биш үү. Үүнээс болоод цаашид бид нарын энэ боловсон хүчний хомсдолын асуудал татрах биш нэмэгдэх нөхцөл байдал харагдах гээд байгаа юм биш үү. Тэгэхээр бид энэ нөхцөл байдлуудаа харж боловсон хүчнээ яаж бэлтгэх вэ гэдэг асуудал байна. Би боддог юм. Монгол өөрийн гэсэн онцлогтой. Тийм учраас ядаж эмч, багш 2-оо төр өөрийнхөө хөрөнгөөр сургаад тэгээд 5 жил тэр төрийн зардлаар сурсныхаа төлөө орон нутагт очиж ажилладаг гэдэг юм уу, шаардлагатай газар очиж ажилладаг ийм тогтолцоо руугаа

шилжвэл яасан юм бэ. Дан дамаа боловсролын байгууллага дээр элсэлтийн ерөнхий шалгалт дээр нэлээн өндөр оноотой өгсөн хүүхдүүдийг түүж авч, үнэ төлбөргүй сургах асуудлыг хийвэл яасан юм бэ. Тэгж байж сайн багшийн асуудал, түүгээр дамжиж ирээдүйн Монголын авч явах хүмүүсээ бэлтгэх ёстой юм биш үү. Энэ тал дээр ер нь ямар бодлогын зохицуулалт юу хийж байна вэ гэдэг нэг ийм асуудал.

Дараа нь энийг дагаад цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудал байгаа юм. Энэ хөдөлмөрийн хөлсний үнэлэмжийг их тодорхой болгохгүй бол бид цаашид улам л байдал хүндрэх.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Гонгорын Дамдинням ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Г.Дамдинням: Манай Батжаргал гишүүн бас нэлээн амьдралтай, бодитой асуудлуудыг тавьж байна.

1 дүгээрт энэ сургуулиудын өөрийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээг ер нь нэмэгдүүлж та нар бас үүрэг хариуцлагатай болгооч гэдэг асуудлыг тавьж байна. Энэ яг орчихсон байгаа Батжаргал гишүүн ээ. Сургуулийн Удирдах зөвлөл заавал оролцогч бүх талууд буюу эцэг, эхийн төлөөлөл, сурагчдын төлөөлөл орно. Тэр бүхэн сургуулийн хөгжил дэвшил болон санхүүжилттэй холбоотой зардлуудыг төлөвлөхөд хяналт тавьж ажилладаг ийм эрх хэмжээг бүр тусгайлан оруулж өгч байгаа.

2 дугаарт боловсролын салбарын төрийг салбарыг ер нь төрийн аль бүтэц ер нь авч явах юм бэ гэж байгаа. Тэгэхээр энэ дээр хуучин ямар асуудлууд үүсдэг байсан бэ гэхээр ний нуугүй л ярья. Орон нутгуудад орон нутгийн сонгууль болно. Орон нутгийн сонгуульд хамгийн олон хамаатан садантай нь ялна. Засаг дарга болно. Ингээд нэг хүн аваачаад

захирлаар тавьчихдаг. Ер нь жилдээ 110 гаруй захирлууд солигддог юм байна лээ. Захирал, эрхлэгч нар солигддог юм байна лээ. Энэ бол асар өндөр тоо шүү дээ. Тэгээд мэргэжлийн бус нь бараг 40 хувь шахуу 5 жил хүрээгүй хүрсэн хүрээгүй туршилагатайнууд нь 12, 13 хувь байх жишээний. Энэ бол өөрөө боловсролын чанарыг боловсролыг маш ихээр унагааж байгаа юм. Тийм учраас бид бол энэ хуульдаа боловсролд мэргэжлийн удирдлагын тогтолцоог хийе гэдэг ийм зарчмыг барьж орж ирж байгаа. Энэ хүрээнд боловсролын мэргэжлийн удирдлагын тогтолцоог өөрөөр хэлбэл Боловсролын яам түүний доор Боловсролын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газрын доор аймаг, нийслэл, сум дүүргийн боловсролын газрууд удирдаж, хариуцаж зохион байгуулж явна. Өөр өөрийнхөө хамран сургах хүрээллийн хүрээнд.

Дараагийн асуудал бол тэргүүлэх мэргэжилтэй холбоотой асуудал. Батжаргал гишүүн ээ, энэ бол маш чухал асуудал. Боловсролын ерөнхий хууль дээр бид тэргүүлэх мэргэжилтэй холбоотой асуудлыг Монгол Улсын Засгийн газраас зарлаж байхаар тавьж байгаа. Засгийн газар жил бүр хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон холбогдох яамнуудтайгаа ярилцаж байгаад олон нийтэд тэргүүлэх мэргэжлийг зарлаад, тэргүүлэх мэргэжлүүддээ тэтгэлэг өгөөд явдаг энэ хэлбэр лүү эрэлттэй тэргүүлэх мэргэжлүүдэд тэтгэлэг өгөөд явдаг зам руугаа оръё гэж байгаа юм.

Дараагийн асуудал энэ боловсролын салбарыг бас нэг өргөж авч өгөх ёстой юм юу вэ гэхээр багшлах боловсон хүчний асуудал. Багшлах боловсон хүчнээр суралцаж байгаа амжилттай суралцсан хүүхдүүдийг сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд оруулдаг ийм зохицуулалтуудыг энэ хуулиар хийгээд явж байгаа гэж хариулъя танд.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүн тодруулж асуух уу. Тодруулъя 1 минут.

Ж.Батжаргал: Үгүй ээ, тэгээд 1 нь асуугаад 1 нь ингээд хариулаад байж болж байгаа юм. Тэр нэг удирдах зөвлөл, зөвлөл байна л гээд хэлчхээд байгаа юм. Ямар эрх, үүрэгтэй ямар юм байх юм гэдгээ энэ хуулийн хэд дэх ямар зүйл заалтад нь байна. Тэрийгээ их тодорхой болгомоор байгаад байгаа байхгүй юу. Тэр бүгдийг нь мөнгийг нь дааж л гаргаж чадахгүй л байгаа юм бол боловсролын ялгамжтай байдлыг бий болгохгүйн тулд өөр өөрсдийнхөө боломжийг ашиглаж, нөхцөл бүрдүүлэлтийн тал дээр тэр өөрийн удирдлагын байгууллага жоохон ажилламаар байгаа юм. Тэр эрх хэмжээ юмыг нь үүнд нь оруулж өгмөөр байгаа юм. Би бол тэгж хараад байдаг.

Дараа нь би бол аймаг нь яг боловсролынхоо асуудлыг барих уу, сум нь барих уу гэдэг юмыг тогтмоор байгаа юм. Аймаг, сумын хурал, Засаг дарга нар дээр бүгдээр нь дээр нь эрх үүрэг өгчхөөд байгаа юм. Гэхдээ би бол аль нэгэн дээр нь хуваалцахгүй байдлаар тогтоогоод тэр санхүүжилтийнх нь ч.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний тодруулгад хариулъя. Дамдинням дарга хариулъя.

Г.Дамдинням: Батжаргал гишүүн ээ. Боловсролын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлага гээд заагаад өгчихсөн байгаа. Тэгээд 23.2.8 хүртэл ингээд үргэлжлээд явна. Энд бол түрүүний миний хэлсэн зарчмуудаар ажиллахаар зааж өгсөн байгаа.

2 дугаарт аймаг нь илүү үүрэг хүлээх юм уу, сум нь илүү үүрэг хүлээх юм уу гэж боловсрол дээр асууж байна. Одоо Боловсролын ерөнхий хуулиар

аймгийн Засаг дарга илүү үүрэг хүлээх байгаа. Өөрөөр хэлбэл аймгийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээний биелэлтэд шинэ нэмэлт зүйл заалт оруулахаар хуулийн төсөлд орж явж байгаа. Дагалдах хуулиудын хамтаар. Товчхондоо ийм л хариулт өгье.

Л.Мөнхбаатар: Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Баярлалаа. Боловсролын ерөнхий хуульд хуучин бол боловсролд улсын төсвийн нийт санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг зарцуулна гээд ийм заалттайгаар манай систем өөрөө явж байсан. Тэгээд харамсалтай нь өнөөдөр боловсролын төсөв маань нийт төсвийн дөнгөж 11.7 хувь болтлоо буурсан байгаа юм. Энэ асуудал бол 2017 оноос эхлээд ингээд энэ заалтыг ямар нэгэн хулгайгаар аваад авчихсан юм шиг байгаа юм л даа. Тэгээд боловсролд нийт төсвийн 20-оос доошгүй хувийг зарцуулна гээд. Энэ 11.7 гэдэг чинь уг нь тухайн үед зааж байснаас бол бүр 2 дахин буурчихсан ийм төсвийг өнөөдөр бид нар боловсролдоо зарцуулж байгаа. Нөгөө талаас нь хэлэх юм бол бид нар 2017 оноос эхлээд боловсролд зарцуулдаг төсөв маань ерөнхийдөө ингээд царцсан маягтай ингээд өнөөдрийг хүрчихлээ гэсэн үг. Тэгээд ийм байдалтайгаар бид нар цааш нь явах юм бол мэдээж өнөөдөр улсын сургууль, сургуулийн өмнөх боловсрол энэ болгонд өнөөдрийн гарч байгаа бүхий л асуудал санхүүтэй холбоотойгоор гарч ирээд байгаа юм. Дээр нь боловсролын нийт зардлын 25 орчим хувь нь өнөөдөр барилга байшин, тоног төхөөрөмжийн зардалд ороод байгаа юм. Энэ өөрөө юу гэж хэлж байна вэ гэхээрээ яг тэр хүүхдийг сургах багшийн тэр цалин тэр сургалтын асуудлуудыг үндсэн зардал дотроо ингээд зардлаас нь 25 хувиар ингээд багасгаж байна л гэсэн үг. Энэ дотроо сургуулийн эмчийн зардал хүртэл орж байгаа. Уг нь Барилга, хот байгуулалтын салбарын нэг хэсэг зардлыг боловсролын зардал руу оруулаад

байна гэсэн үг. Эрүүл мэндийн зардлыг бас боловсролын зардал руу оруулаад байна л гэсэн ийм ойлголт байгаа юм. Тэгэхээр бид нар бас зардлын асуудал гэдэг дээр маш тодорхой ойлгох хэрэгтэй. Нийт улсын төсвийн 20 хувийг боловсролын зардал энэ бол өөрөө хүүхдийг сургах, тэр багш, эрдэм шинжилгээний бүхий л асуудлуудад нь энийг нь зарцуулж байж өнөөдөр бид нар дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай ийм л боломжоор хангагдана.

2-т нь Юнескогийн гаргасан саяхны судалгаагаар Монгол Улсын боловсролын зардлын дөнгөж 30 хувь нь багшийн цалинд явж байна. Хуучин бол 50 хүртэл хувьтай байсан. Харамсалтай нь жилээс жилд буурсаар байгаад 30 хувь руу орчихсон. Тэгэхээр бид нар яаж ийм чадамжтай багш нарыг бий болгох юм. Яаж тэд нарыгаа цааш нь хөгжүүлэх юм. Яаж улсын сургуулиуддаа авч үлдэх юм бэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Дээр нь гарч байгаа бас нэг асуудал хувьсах зардал. Өнөөдөр бид нар энд хуульдаа заавал оруулж өгөх асуудал бол хувьсах зардлыг Засгийн газар журмаар зохицуулдгийг болиулмаар байна. 2016 онд батлагдсан хувьсах зардлын нормативын асуудал явсаар байгаад 2019 онд л Засгийн газар шинэчилсэн. 2016 онд шинэчилсэн. Тэрнээс хойш шинэчлэхгүй байсаар байгаад уг нь энэ бол жил болгон инфляцтай холбогдуулж хувьсах зардлыг өөрчлөх ёстой. Харамсалтай нь засгийн газрууд энэ асуудал дээр анхаардаггүй. Энэ асуудлууд л ер нь өнөөдөр Монголын боловсролын гол асуудал болоод байгаа шүү дээ. Өнөөдрийн болохгүй байгаагийн суурь асуудал бол мэдээж санхүүгийн асуудал. Энэ санхүүгийн асуудлууд дээрээ л бид нар ерөнхий хууль дээр зайлиггүй тусгаж өгөх ёстой. Ингээд харахаар энэ дээр бол зайлиггүй хийх ёстой юмнууд бол мэдээж улсын сургуулиудын өрсөлдөх чадварыг нэмэх, цэцэрлэгүүдийн өрсөлдөх чадварыг нэмэхийн тулд төсвийн томоохон заалтуудаа эрс шинэчлэлээ л хуульдаа оруулж өгөх ёстой.

Л.Мөнхбаатар: 13 цаг болсон байна. Гэхдээ хэлэлцэх асуудал дуусаагүй байгаа учраас чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулъя. Асуултад хариулна. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганибал гишүүн ээ, та ямар тоо харж яриад байгаа бол доо. Шууд 2016, 2017 оноос таслаад тэрнээс өмнөх нь боловсролын зардал өндөр байсан. 2016, 2017 оноос хойш боловсролын зардал буурчихлаа гэдэг улс төрийн дүгнэлт л хийх гээд байх шиг байх юм. Юнескогийн тоо тийм тоо байхгүй байх Ганибал гишүүн ээ, та надад нэг харуулаач саяынхаа 30 хувь нь багшийн зардалд явж байна гэж. Одоо ингээд тоон дээр үндсэндээ 2017 оноос хойш чинь манай боловсролын зардал ингээд 1.4 их наяд 1.6, 1.7, 1.9 их наяд гээд нэмэгдээд яваад байгаа юм. Нийт манай урсгал зардлын бараг 80, 90 хувь нь ерөөсөө цалин байхгүй юу. Цалингийн сан. Бараг 90 хувь нь гэж ойлгож болно. Тэгэхээр одоо яг хамгийн гол нь урсгал зардал дээр байгаа 80, 90 хувийн цалингийн фонд энэ зардал их байгаа. Мэдээж нөгөө 108 мянган хүнийг санхүүжүүлж байгаа учраас ихэнх нь урсгал зардлын ихэнх нь ингээд цалингийн зардал явж байгаа нэг ийм л юу байгаад байгаа юм. Тэгэхээр цаашидаа бид нар ерөнхийдөө нөгөө хувьсах зардал ч чинь их буруу аргачлалтай байсан байхгүй юу. 2016 оны хувьсах зардал чинь. Юу вэ гэхээр хувьсах зардал дотор яг тэр хөдөөгийн болон хотын сургуулиудын боловсролын чанарын ялгааг орчны ялгааг арилгах, багш нарын хичээл практикийн зардал, интернэтийн хэрэглээ гэдэг юм уу, багшийн эрүүл мэндийн асуудал гэдэг юм уу, багшийн илүү цагийн асуудал. 35-45 хүүхэдтэй, 45-аас дээш хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарын нэмэгдлийн асуудлууд гээд яг боловсролын чанартай холбоотой ерөөсөө ямар ч ийм зохицуулалтууд байхгүй байсан байхгүй юу. Харин Оюун-Эрдэнийн Засгийн газрын хийсэн

боловсролын салбарт хийж байгаа нэг гол шинэчлэлийн нэг зүйл бол үр дүнд суурилсан санхүүжилт буюу боловсролд зарж байгаа 1 төгрөгөөс бид нар яг ямар үр дүн, яг ямар чанар хүлээж байгаа вэ гэдэг үр дүнгийн тогтолцоо руу бид нар алхаж байгаагаараа их том шинэчлэл болж байна л гэж харж байгаа юм. Өнөөдөр бид нар чинь дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 4.1 хувьтай тэнцэх хэмжээний 2.2-2.3 их наядын төсвийн санхүүжилт зарж байна шүү дээ. 1.9 нь урсгал зардал 300-400 тэрбум төгрөг нь цэцэрлэг, сургуулийн зардлууд орж байгаа юм. Тийм учраас юу гэдэг юм таны санааг би хэрэв зөв ойлгосон 300-400 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал чинь барилгын салбар дээрээ яваг. Танайх урсгал зардлаа дангаараа аваад явах ёстой гэсэн нэг ийм зүйл хэлчхэв үү? Яав. Энэ дээр бас би танаас эргээд буцаагаад зөв хариулт өгөхийн тулд тодруулга авъя гэж бодож байна.

2 дугаар асуудал ерөөсөө манай дээр яг ямар асуудал үүсээд байгаа вэ гэхээр өнөөдөр 12 дугаар анги 35-аас 40 мянган хүүхэд төгсөөд. 1 ангид 70-80 мянган хүүхэд орж ирээд байгаа байхгүй юу. Энэ хандлага ингээд 2030, 2032, 2033 он хүртэл явах юм байна. Жил бүхэн 40 мянган хүүхэд доороос нэмэгдэж орж ирээд байгаа учраас жил бүхэн хүүхдийн тоо нэмэгдэж байгаа учраас боловсролын хувьсах зардал, урсгал зардлууд нэмэгдээд тэгээд нөгөө 3 ээлжийн сургууль нэг ангид нөгөө 45-аас дээш хүүхэдтэй сурч байгаа асуудлууд чинь яг энэнээс үүсчхээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр л бид нарын өнөөдрийн боловсролын багц хууль дээр оруулж ирж байгаа гол шинэчлэлийн нэг бол ерөөсөө санхүүжилтийн тогтолцоо. Санхүүжилтийн тогтолцоо нь яг тэр нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал дотор нь аргачлал дотроо яг тэр нөгөө сургууль, хот, хөдөөгийн сургуулийн ялгааг арилгах тэр санхүүжилтүүд тэр индексүүдийг тооцдог тэр асуудлуудыг л оруулж ирж

байгаагаараа тийм онцлогтой ийм санхүүгийн шинэчлэл боллоо л гэж бодоод байгаа шүү дээ. Та тэр Юнескогийн яг ямар тоо баримт дурдаж хэлэв. Тэрийг надад та нэг эх үүсвэр нь хэлээдхээч тэгэх үү.

Л.Мөнхбаатар: Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя. Тэр зардалтай холбоотой бас мэдээллийн зөрүү байж магадгүй.

Н.Ганибал: Зардал дээр үгүй ээ үгүй ер нь зүгээр миний хэлэх гээд байгаа шууд утга нь бид нар дээр боловсролын нийт зардлаа улсын төсвийн 20 хувь гэдгээ л авъя л даа. Үүгээрээ цаашаа явах юм бол үнэхээр бид нар улсын сургуулиуд маань хувийн сургуулиудтай, улсын цэцэрлэгүүд маань хувийн цэцэрлэгүүдтэй тэр өрсөлдөх боломж л нээгдэнэ. Энийг л хэлээд байгаа юм. Тэрнээс бол юу гэдэг юм ямар нэгэн хувийн сургууль цэцэрлэгийг байхгүй болгоно ч гэдэг юм уу заримыг нь санхүүжүүлэхгүй гэдэг нь өөрөө алдаатай бодлого юм. Тэгэхээр шууд утгаараа санхүүжилтийнхээ юуг л аваад явъя. Тэгэхгүй болохоор өнөөдрийн бид нарын барьж байгаа, орж ирж байгаа санхүүжилт маань өнгөрсөн он жилүүдээсээ ингээд буурсаар байгаад нийт төсвийнхөө 11 хувь руу ороод ирлээ шүү дээ. Энэ чинь өөрөө, бид нар, улс орон зөв юмандаа мөнгөө зарцуулж болохгүй байна л гэдэг шууд санаа байхгүй юу. Энийг л хэлээд байгаа юм. Юнескогийнхыг бол манай яамныхан мэдэж байгаа байлгүй дээ. Тайланг жил болгон өгч байгаа байх. Тэр тоо мэдээллээс сайддаа үзүүлчхээрэй. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Би тантай нэг зүйл дээр санал нэг байна. Боловсролд зарж байгаа тэр тусмаа улсын төсвөөс зарж байгаа санхүүжилтийг дор хаяж 2 дахин их болгоё л гэсэн санаа хэлээд

байна шүү дээ. Энд тантай санал нэг байна. Тэгэхдээ цаашдаа бид нар яг мөнгийг нэмэх нэг өөр, хамгийн гол нь мөнгийг бид нар яг эндээс өгөөж хүртэх, үр дүнд хэмжих энэ зүйл рүүгээ л зарцуулах ёстой гэж байгаа юм. Өнөөдрийн хэмжээнд зарцуулагдаж байгаа энэ мөнгө бүр ч их тийм бага байна гэж хэлэхэд бас хэцүү. Гэхдээ бид нарын өнөөдөр хүртэл явж ирсэн санхүүжилтийн тогтолцоо бол яг нөгөө шүүрэн шанага шиг байсан ийм л тогтолцоо байгаа байхгүй юу. Тэгэхээр байгаа мөнгөө бид нар яг зөв зүйлд нь зарцуулж чадаж байна уу. Магадгүй 330 сум дээр бид нар 12 жилийн тогтолцоотой сургууль байх зөв үү, буруу юу гэдэг асуудлаасаа эхлээд боловсролд зарж байгаа нэг төгрөг ямар үр дүн, ямар өгөөж, ямар чанар авчрах юм бэ гэдэг санхүүгийн үзүүлэлтүүд, санхүүгийн механизмуудыг л тэр нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардалтайгаа уяж хийх юм болов.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Зарчмын хувьд хуулийн төслийг дэмжиж байгаа. Хуулийн төсөлд ороогүй ч гэсэн ажлын хэсэг дээр ажиллаад зарчмын зөрүүтэй санал дээр орж ирсэн бас хэрэгтэй заалтууд байна. Тийм учраас бас ажлын хэсэг бас нэлээн сайн, чамбай ажилласан юм болов уу гэж ингэж бодож байна. 2, 3 асуулт байна. Кембрижийн сургалттай 3 улсын сургууль байх юм. Тэгээд өнөөдөр үндсэндээ Улаанбаатарынхан дийлэнх олонх нь л сургуулиуд руу хүүхдээ өгөх гэж нэлээд зүтгэдэг болсон байна. Хичээдэг болсон байна. Тэгээд сургуулиудын юу нь ингэж эцэг эхчүүд, хүүхдүүдийг татаад байна. Энэ чинь өөрөө амьдрал практик дээр шалгараад харагдаад байна шүү дээ. Энэ сургуулийг төгссөн ахлах ангийн хүүхдүүд шууд олон улсын тэтгэлэгт сургалтыг хөтөлбөр сурах эрхийг аваад байна шүү дээ. Юу нь сайн байна. Тэгээд

бусад сургуулиудаа ийм сургууль болгох бололцоо боломж нь хэр байгаа юм. Болгохгүй юм уу. Эсвэл энэ сургуулиудыг зүгээр ийм жишиг болгоод гэдэг юм уу ингээд яваад байх юм уу цаашидаа. Энэ дээр та бүхэн юу гэж үзэж байна вэ гэж.

Англи хэлийг заавал үндсэн хэл гэж оруулах нь хэр оновчтой юм бэ. Тэртээ тэргүй амьдрал дээр эцэг эхчүүд хуультай, хуульгүй англи хэлний ач тус хэрэглээг мэдчихсэн, ойлгочихсон. Зайлиггүй англи хэл хэрэгцээтэй юм байна. Гадагшаа нэвтрэхэд англи хэл нэг номер юм байна. Тийм учраас хуульд тусгасан, тусгаагүй эцэг эхчүүд хүүхдүүдээ англи хэлний хөтөлбөртэй сургалтад явуулахаас гадна дахин давхар сургалт юмнуудад хичээллээд заагаад явуулаад байна шүү дээ. Тийм учраас энийг заавал ингэж хуульчилж заавал нийгмийн ийм талцал, хэрүүл маргаан болгож байх нь ямар юм бол. Харин нөгөө талаар англи хэл гэж ярьж байх хооронд чинь эх хэл Монгол үндсэн хэлээрээ ярьдаг, зөв бичдэг, алдаагүй, бичдэг хүүхдүүд ер нь цөөрч байна шүү. Та бүхэн зурагт телевизээр хараарай. Бөөн алдаа. сошиалаар явж байгаа, хүмүүсийн бичиж байгаа бөөн эр үгийн “ы”-гээ ч юмаа ч ялгахгүй алдаатай бичдэг хүүхдүүд олишрсон байгаа юм. Тийм учраас англи хэл гэж ярихаасаа илүүтэйгээр эх хэл Монгол хэлээрээ зөв бичдэг, зөв ярьдаг ийм сургалтыг тэр тал дээрээ яаж анхаарч байгаа юм бэ гэж.

Дараагийн асуудал удирдлагын тогтолцоо, томилгооны асуудал. Орон нутгийн Засаг даргаас мэргэжлийн байгууллага буюу орон нутгуудынх нь боловсролын байгууллага хэлтэс албад руу нь шилжүүлж байгаа юм байна. Одоо тэртээ тэргүй төрийн албаны хуулиар хуучин шиг орон нутгийн улс төрийн албан тушаалтнууд боловсролын салбарын удирдлагуудыг өөрчилж, солиод байх бололцоо боломж их хомс болсон. Яагаад гэхээр төрийн албаны

сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, захирлуудыг төрийн албаны сонгон шалгаруулалтаар ороод нэг номероор тэнцэж гарч ирсэн хүнийг тухайн томилдог эрх бүхий албан тушаалтан томилохоос өөр гарцаагүй байдал руу орсон. Нэг номероор гарч ирсэн хүнийг. Тэр хүн хэрвээ томилохгүй байвал ашиг сонирхлын зөрчилтэй байна гэж үзэж тодорхой арга хэмжээ авах ёстой. Тийм учраас тэр Засаг даргадаа байна уу боловсролын хэлтэстээ байна уу гэдэг нь нэг их айхтар ач холбогдол багатай болчихож байгаа юм байна лээ. Энэ нь нөгөө талаасаа бас сонгон шалгаруулалт бодитой, үнэхээр шударга явагдаж чадвал цаашидаа боловсролын байгууллагууд дээр хэн ур чадвартай, мэдлэг боловсролтой, туршилагатай нь сонгогдож томилогдоод явах бололцоо боломж нь улс төрөөс хараат байдал нь бол алсарсан. Хязгаарлагдсан гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Тэгээд хуульд бас орж ирж байгаа нь сайн байна.

Нөгөө талаар насан туршийн боловсролын төвийн багш, ажилчдын асуудал хөндөгдөөд байгаа юм. 21 аймаг, 9 дүүрэг, 8 дүүрэг дээр нийтдээ 600 гаруй багш нар ажилладаг юм байна. Хуулиараа болохоор одоо болохоор ТҮБД-ээр боловсролын салбарын багш ажилтнуудын цалин. Гэтэл.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулсны дараа тодруулж асуух шаардлагатай бол асууна. Асуултад ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Манай Сандаг-Очир гишүүн яг л амьдрал дээр байгаа бодитой л асуултыг асууж байна. Кэмбрижийн хөтөлбөртөө 3 сургуульд бүгд л хүүхдээ өгөхийг хичээгээд яваад байгаа юм. Миний биеэр ахлуулаад нэр бүхий гишүүдийн бүрэлдэхүүнтэй Кэмбрижийн сургалтын хөтөлбөрийг дэмжих ийм лобби бүлэг хүртэл байгуулаад ажиллаж байсан. Кэмбрижийн сургалт юундаа сайн

байгаад байгаа вэ гэхээр үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ түүнийг дагаж орж байгаа сургалт эндээ л байгаад байгаа юм. Кембриджийн сургалтын хамгийн том давуу тал нь 1 дүгээрт багшаа үнэлж байна. 2 дугаарт сурагчдаа үнэлж байна. 3 дугаарт менежментээ үнэлж байна. Тэгээд эргүүлээд багш нараа тэр стандартаараа чанаржуулаад, хөтлөөд аваад явчхаж байна. Бид үндэсний боловсролын тогтолцоогоо энэ рүү оруулъя. Нэг улсын тогтолцоо гэж жоохон буруу шүүмжлэгдээд байна лээ. Уг нь бол олон улсын л хөтөлбөр юм байгаа юм. Боловсролын хөтөлбөрүүд бол 1 дүгээрт олон улс, 2 дугаарт гадаад орны, 3 дугаарт үндэсний гээд л ингээд л явж байгаа шүү дээ. Тэгэхээр бид олон улсын хөтөлбөрөөс багцаа авч байгаад үндсэндээ хуульдаа хөндлөнгийн үнэлгээний системийг маш сайн оруулж ирж байгаа. 3 жил тутам олон улсын үнэлгээнд орно.

2 дугаарт үнэлгээний үр дүн нь гарч ирсэн үр дүнгээр сургалт давтан сургалтыг зохион байгуулах чиглэлийг маш сайн оруулж ирж байгаа. Энэ чиглэлд бид нар хуульдаа нэлээн сайн тодорхой тусгаад явж байгаа.

Дараагийн таны хэлсэн асуудал бол хэлний асуудал байна. Хэлний асуудал дан ганц Англи болон Монгол ч гэдэг юм уу асуудал биш. Энэ бас тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй холбоотой хэлний асуудал болоод ер нь хуулийн төслийн 6 дугаар зүйлд боловсрол эзэмших хэл гээд нэлээн том бүлэг болоод орчихсон явж байгаа шүү дээ. Нийгэмд байгаа хэлэлцүүлгийн хувьд англи хэлийг эсэргүүцээд байгаа юм их бага байх шиг байна. Зүгээр гол асуудал нь хэддүгээр ангиас үзэх юм бэ л гэдэг яриа гараад байх шиг байна. Зүгээр зөрүү нь 1 дүгээр ангиас үзнэ, 3 дугаар ангиас үзнэ, 5 дугаар ангиас үзнэ гэдэг л яриа яваад байх шиг байна. Манай одоогийн боловсролын тогтолцоогоор бол бид нар 5 дугаар ангиасаа 7 хоногт 2 удаа хичээл ороод явж байгаа. Энхийг Боловсролын яамныхан маань 3 дугаар

ангиас нь орж эхэлье л гэж байгаа. Тэгэхээр 6 дугаар зүйл дээр 6 дугаар зүйлийн 1 дээр ингээд заачихсан байгаа шүү. Олон нийт бас сонсож байна. Бүх түвшний боловсрол эзэмших сургалт үйл ажиллагааны хэл нь Монгол хэл байна. Энэ Монголын боловсролын хууль. Монголын боловсролын хууль. Энэ манай үндэсний боловсролын тогтолцоо. Бидний нэн тэргүүний зорилго бол Монгол хүнийг бүтээх. Тэр монгол хүн нь дэлхийд өрсөлдөх чадвартай байх ёстой юм гэдэг үүднээс дэлхийн хамгийн түгээмэл байгаа шинжлэх ухааны хэл болох Англи хэлийг бид нар оруулж ирж байгаа юм.

2 дугаар асуудал нь боловсролын энэ ерөнхий хууль бүх түвшний боловсролын тогтолцоонд үйлчилнэ. Би түрүүн хэлсэн. Бүх түвшний боловсролын тогтолцоонд. Дээд боловсрол ч гэсэн гадаад хэл орохоор бол хамгийн түрүүнд англи хэлийг оруулна л гэдэг ийм л утгатай заалт орчихсон юм. Тэгээд эрхэм гишүүд бас ойлгож хүлээж аваарай.

Удирдлага мэргэжлийн тогтолцооны тухайд бас ялгаагүй ээ. Ер нь манай боловсролын тогтолцоо мэргэжлийн удирдлага руу шилжих зайлшгүй шаардлагатай байна гэдэг ийм өөрчлөлтийг л бид нар хийж байгаа. Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум дүүргийн боловсролын газрууд. Тэгээд сургууль, цэцэрлэгийн удирдлагууд гэсэн ийм л шууд босоо тогтолцоогоор удирдагдаад явна. Шалгуур нь бас яг төрийн албаны хууль дээр байгаа шалгуураараа л явна гэсэн ийм хариулт өгье. Сүүлийн асуултад Энх-Амгалан сайд хариулчих уу.

Л.Мөнхбаатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг дарга хариулъя. Байнгын хорооны дарга хариулъя.

Г.Мөнхцэцэг: Эх хэлний дархлаа алдагдаж байна. Ер нь монгол хэл өөрөө бас ер нь дархлаа нь их буурч байна гэдэг

олон гишүүд энэ тухай ярьж байна. Тэгэхдээ энд санаа сэтгэл зовж явж байгаа та бүхэнд бас талархах нь зүйтэй. Тэгээд энэ дээр цаашилаад бид нар бол бас олон арга хэмжээг авч хэрэгжүүлж, хэлнийхээ дархлааг бас сайжруулах тал дээр анхаарч ажиллах дээр та бүхнийг бас дэмжлэг үзүүлээч гэж хүсэх гэж байгаа юм.

Тэгээд 2015 онд Монгол хэлний тухай хуулийг баталсан байгаа юм. Тэгээд ер нь бол Хууль тогтоомжийн тухай хуулиараа бол ер нь үнэлгээ хийгдэх цаг нь болчихсон гэж бас үзэж байгаа. Тийм учраас бол Байнгын хорооноос удахгүй Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт хяналт тавих ийм ажлын хэсэг гаргаж ажиллахаар болж байгааг бас дуулгаж хэлье гэж ингэж бодож байна. Тэгээд зарим нэг асуултууд дээр нэмээд эх хэлтэй холбоотой зүйлүүд дээр бас ингээд нэмээд хариулаад ингээд явчихъя.

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух юм уу. Тодруулж асуухаар нь хариулчихъя. Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Насан туршийн боловсролын төв дээр тэр ТҮБД цалингийн сүлжээнд нь насан туршийн боловсролын төвийн багш нарын цалингийн сүлжээ ороогүй байгаа. Цаашидаа багш нар яаж хэрхэн яаж цалинжиж явах юм бэ гэдгийг тодруулъя. Нөгөө талаар 13.3.8 их сайн заалт орж ирсэн. Боловсролын салбарт 15-аас доошгүй жил ажилласан. Энэ ээр мөн адилхан насан туршийн боловсролын төвд 15-аас доошгүй жил ажилласан гэдэг нь бас гээгдээд л явж байгаа юм. Ер нь насан туршийн боловсролын төвийн багш нарын нөгөө хөдөө орон нутгийн 5 жил тутмын нэмэгдэл эд нар хаягдаад яваад байгаа юм. Тийм учраас 21 аймаг, 8 дүүргийн салбарынхан асуудал яриад байгаа юм. Гээгдүүлэхгүй байх, орхигдуулахгүй байх боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний

байгууллага мөн л юм бол бусад багш нартайгаа адилхан авдаг нэмэгдэл, урамшууллаа адилхан авах ёстой юм. Энийг хуулиас битгий хасаж өгөөрэй гэдэг юмыг зайлигүй хэлээд байгаа. Тэгээд дээр та бүхэн маань бас анхаарч өгөөрэй гэдгийг бас хэлье.

Л.Мөнхбаатар: Хариулах юм уу санал юм уу. Санал хэлж байх шиг байна. Хариулт авах юм уу авъя.

Л.Мөнхбаатар: Энэ дээр их тодорхой хариулт өгчих. Насан туршийн боловсролын багш нарын асуудлыг яах вэ гээд байх байна. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Манай боловсролын ерөнхий хуулийн амин сүнс нь ерөнхийдөө боловсролын бүх түвшний боловсролын гол суурь бол насан туршийн боловсролын тогтолцоо дээр суурилж бид нар боловсролынхоо тогтолцоог ер нь зурж байгаа гэж хэлж болно. Тийм учраас ерөнхийдөө манай өнгөрсөн хугацаанд бид нарын нэг хийж чадаагүй зүйл бол боловсролын бүх түвшин дээр эзэмшүүлж байгаа ур чадвараа бусад улсуудад байдаг мэргэжлийн, үндэсний шаталсан бүтэцтэйгээ уялдуулж чадахгүй явж ирсэн учраас өнөөдөр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн асуудлууд мэргэжлийн боловсрол, дээд боловсролын нөгөө хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ур чадварын эрэлт нийлүүлэлт дээр гажуудал үүссэн ийм тогтолцооны асуудал байгаа юм. Тэгэхээр цаашидаа бид нар насан туршийн боловсролын тогтолцоог зөвхөн сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол олгодог 600 багш биш, харин ч Монголын хүн ам бүх насандаа насан туршидаа суралцах ийм суралцахуйн тогтолцоо хэрэгцээ шаардлага бий болж байгаа учраас насан туршийн боловсролын.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бас их чухал хууль хэлэлцэгдэж байгаа. Монгол Улсын орчин цагийн боловсролын систем үүсээд 100 жил болсон байна. Дараагийн 100 жилийн суурийг бас яаж зөв тавих вэ гэсэн ийм л том агуулгатай хууль орж ирж байгаа гэж ингэж харж байгаа. Хэлэлцэгдээд энэ чинь 2 жил болсон. Чуулганы завсарлагаагаар орон нутагт ажиллах үед бол боловсролын салбарынхны гол хүлээж байсан ийм л хууль орж ирж байгаа. Өнгөрсөн хугацаанд Хэнтий аймгийнхаа гэхэд л 800-аад боловсролын байгууллагынхантай уулзахад энэ хуулийн асуудал дээр бас нэлээдгүй хүлээлт байна гэсэн ийм зүйлүүдийг бас ярьж байгаа. Ер нь бол яах вэ Боловсролын яам Боловсролын ерөнхий газартай болсноос боловсролын салбар дээр бас алдаа байсан юмнуудыг нэлээн сайн зассан юм байна лээ. Орон нутагт очоод уулзахад багийн цалин хамгийн багадаа л 1 сая 50 мянга болсон байна гэж ингэж ярьж байна. Улаанбаатар хотод цэцэрлэгийн сугалаа гэж нэг хүн харахад айхтар юм болдог байсан. Тэр байхгүй болсон байна. Багш нар дээр бол тэр багийн хөгжлийн зардал тэр нэг хэрэглэгдэхүүний зардал гэж олгодог болсон байна. Энэ бол бас яг тэнд ажиллаж байгаа багш нарт бол бас нэлээн тийм хүрсэн ийм зүйл байна гэж ингэж үзэж байгаа.

Боловсролын салбарынхантай уулзаад ингээд явж байх үед бас олон зүйлүүдийг хэлж байна. 1 дүгээрт бид нар боловсролын хууль дээр боловсролын салбар, тогтолцоо багш нарын асуудал гээд олон зүйлүүдийг бол тусгаад ингээд явж байна. Энэ дээр нэг зүйлийг бүүр нэг тодорхой оруулаад бүр нэг үүрэгжүүлээд өгөөч гэж. Энэ юу вэ гэхээр эцэг эх гэр бүлийн үүрэг гэдэг зүйл яг боловсролын юман дээр яг юу байх юм бэ. Өнөөдөр хүүхдээ цэцэрлэгт оруулж байна, сургуульд оруулж байна, тэр хүүхдийн хичээл, сурлагыг хариуцаж байна. Хүмүүжлийг нь хариуцаж байна. Одоо

бүр хоол ундных нь юмыг хүртэл хариуцдаг болоод байна. Тэгэхээр эцэг эх, багш, сурагч гэсэн гуравласан холбоог хөгжүүлэх тал дээр ер нь ямар ч хууль дээр тийм олигтой заалтууд байхгүй байна. Энийг бүр нэг үүрэгжүүлээд өгөөч гэсэн зүйлийг бол олон багш нар бас хэлж байгаа юм.

Дараагийн нэг асуудал бол салбарын нэр хүндийн асуудал. Үнэхээр олон ойлгомжгүй дүрэм журмууд чинь эцэг эхчүүдтэй багш нарыг шууд нүүр тулгаад байна. Жишээ нь тэгээд анги засварын мөнгө авах юм уу, авахгүй юм уу. Авахгүй бол ангийг нь засаж өгөх юм уу. Төсөв дээр нь тийм юм байдаггүй юм байна лээ шүү дээ. Би 12 жил эцэг эхийн хуралд хүүхдийнхээ хуралд суусан. Үндсэндээ анги засварын мөнгө авмаар байна гээд тэр багш нь хулмалзаад л зайлуул, авахгүй орхихоор анги нь гэж нэг навсайсан юм. Тэгээд би аймгийн даргаар сууж байсан. Тэгээд би аргаа барахдаа гараад явчихдаг байсан шүү дээ. Та нар ямар шийд гаргана вэ би тэгээд дагаад явна л гэж. Тэгээд энэнээс чинь авхуулаад л байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр багш нар ийм мэтийн жижиг юм шиг хэр нь ийм асуудлаа нэг мөр шийдээд өгөөч гэдэг ийм зүйлийг яриад байгаа юм.

Дараа нь хоол ундны асуудал. Яг сургалтынхаа ажлыг хиймээр байдаг хоолны асуудал руу ордог. Хоолоо хийе талбай байхгүй. Яг стандартын талбай байхгүй шүү. Хоолоо хийе тогооч байхгүй. Яг мэргэжлийн тогооч бас ховор. Тэр 500 мянгаар ажилладаг тогооч ховор болчихсон. Тэгсэн хэр нь хоол өгнө гээд байгаа. Энийгээ яах юм бэ гээд. Тэгээд боловсролын дараагийн жилүүдийн төлөвлөгөө дээр ер нь энэ хуулийн үзэл баримтлал дээр боловсролын салбар эхлээд багш нарынхаа цалингийн асуудлыг 100 хувь бүр хангалттай шийдэж өгөөд, дараа нь тэр үйлчилгээний ажилчид гэж байгаа тэр хүмүүсийн асуудлыг шийдээд, дараа нь магадгүй 3 биш 2 биш 1 ээлжтэй

болох том зорилго тавиад, дараа нь 1 ээлжтэй болчихоод хоол ундны асуудал руугаа ормоор юм биш үү. Баахан том том зорилт тавьчихаад байгаа төсвөө бүх тийш нь ингэж тарааж хаяад аль нь ч амжилттай болсон юм байхгүй. Багийн цалин амьдралд өнөөдөр 1 сая 50 мянга төрийн албанд нэлээн өндөр цалиндаа орж байгаа ч амьдралд хүрэхгүй байгаа нь үнэн шүү дээ. Ийм маягаар ер нь дараагийн юмаа төлөвлөж байна уу. Одоо ингээд л бүх салбар луу бүх юм руугаа л зэрэг зэрэг ороод л ингээд л шийдээд, шийдээд явна гэсэн ийм зүйл байна уу гэдгийг бас би нэг тодруулж асууя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Ёстой нөгөө загатнасан газар маажна гэдэг шиг асуугаасай гэж бодож байсан асуулт асууж байна Идэрээ гишүүн. Боловсрол бол боловсролын салбарын бүх оролцогч талуудын хамтын ажиллагааны үр дүнд үр дүн гардаг ийм үнэхээр онцлогтой салбар. Идэрээ гишүүний хэлж байгаа үнэн. Манай эцэг эхчүүдийн хамгийн том сул тал бол хүүхдийг боловсруулахад сургууль, цэцэрлэг үүрэгтэй, бид үүрэггүй юм шиг л хандаж байдаг. Тэгэхээр бид Боловсролын ерөнхий хуулийн 6 дугаар бүлэг 45 дугаар зүйлээс эхлээд эцэг эхийн үүргийг маш тодорхой оруулж ирсэн байгаа. Ямар нэг байдлаар бид нар үүрэгжүүлэх ёстой шүү. Боловсролын салбарт оролцож байгаа оролцогчид болгон тэр дундаа хамгийн том оролцогчдын нэг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт тэр дундаа эцэг эхчүүдийг үүрэгжүүлж гэдэг заалт энд орчихсон яваа. Энэ дээр бас тодорхой хэмжээний эхний алхмууд хийгдсэн. Хүүхдийнхээ зардлыг хариуцах, сургууль цэцэрлэгтэй хамтарч ажиллах, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцох, санал тавих, шийдүүлэх гээд эрх хэмжээнүүдийг нь бид нар 6 дугаар

бүлгээр үндсэндээ тодорхойлж өгсөн байгаа. Та бас эндээс харж болно.

Цалинтай холбоотой асуудал дээр санал нэг байна. Үнэхээр болдог бол бид нар багш нарынхаа цалинг 2, 3 битгий хэл нэмчихмээр байна. Ингэж байж салбарын нэр хүнд өснө. Бид нар Финляндын боловсролын салбарыг үргэлж ярьдаг. Финляндын боловсролын салбар хамгийн шилдэг, хамгийн мундгууд нь багш нар болдог учраас л сайн байгаа юм. Өндөр цалинтай учраас, нийгмийн халамж сайтай учраас. Тэгээд бид нар үе шаттайгаар л эдийн засгийн боломж маань нээгдэх юм бол цалин урамшууллаа нэмж, нийгмийн даатгал, тэтгэвэр, урамшуулалтай холбоотой асуудлуудыг нь шийдэж байж л энэ салбараа бүтэн хэмжээнд нь аврах юм байна лээ. Өргөх юм байна лээ.

Хүүхдийн хоолыг Идэрээ гишүүн ээ, ер нь их судалмаар юм байна лээ шүү. Хүүхдийн хоолыг бас хойшоо тавьж болохгүй. Хүүхдийн хоолны хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш хүүхдүүдийн ялангуяа гэр хорооллын захын хорооллуудын хүүхдүүдийн сургалтын чанарт огцом ахиц гарсан гэсэн судалгааны дүн гарсан байна лээ. Эрүүл мэндийнх нь чанарт бас дэвшил гарсан байна лээ. Тэгэхээр хэдүүлээ бас энэ дээр наанатай цаанатай хандах ёстой. Аль алийг нь л аваад явах ёстой юм байна лээ шүү л гэсэн хариулт өгье.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу. Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тэр хоолыг эсэргүүцэж байгаа юм биш. Тэр хоолыг хийх нөхцөлийг л хурдан бүрдүүлж өгмөөр байна. Хоол хий гэдэг хийх гээд байдаг мэргэжлийн хяналт нь ирээд ийм байранд хоол хийж болохгүй гэхээр тэр захирал яах ёстой вэ. Ийм асуудлууд л гараад байгаа юм. Тэрнээс.

2 дугаарт боловсон хүчний асуудал дээр томилох шилжилтийн асуудал яригдаж байна. Ер нь бол дээр ер нь

сургуулийн захирлын асуудлыг ер нь ямархуу байдлаар бэлтгэдэг юм бэ. Сайн багш байх нэг өөр, сайн захирал байх 2 шал өөр. Сайн захирлыг бид нар бэлдэж байж магадгүй энэ Боловсролын яамнаас явуулж байгаа бодлого, шийдвэр тэр сургууль дээр хэрэгждэг юм билээ.

2-т өнөөдөр бид нар оюутны тэтгэлэг явуулж байна л гэж байгаа. Ер нь багш нарын захиад байгаа юм бид нарын цалинг амьдралд хангалттай хүргээд л өгчихвөл болоо. Тэгээд л бид нар өөр юм хүсээд байх юм алга гэсэн ийм л зүйл яриад байгаа шүү дээ. Ер нь бол.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд хариулчихъя.

Л.Энх-Амгалан: Тодруулгад хариулъя. Идэрбат гишүүн ээ, үдийн хоолны асуудал чинь нөгөө хоол үйлдвэрлэлийн тухай хуулиар зохицуулагддаг ийм зохицуулалттай хууль. Тэгээд Сурагчийн хоол үйлдвэрлэлийн тухай хууль дээр ерөөсөө төрийн өмчийн сургуулиуд дээр тэр төрийн өмчийн сургуулиуд нь өөрсдөө хоолныхоо асуудлыг гал тогооныхоо асуудлуудыг шийдвэрлээ. Хувийн өмчийн болон түрээсийн гал тогоо байхгүй гэдэг нэг ийм шийдэл гаргачихсан учраас дээр бас нэлээн хүндрэлүүд учирч байгаа. Тийм учраас цаашидаа бид нар ерөнхийдөө Хоол үйлдвэрлэлийнхээ тухай хууль дээр тодорхой цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж бас тодорхой өөрчлөлт хийх ийм хэрэгцээ шаардлага үүсэж байгаа. Багш нар болон төрийн үйлчилгээний ажилтнуудын цалин хөлсний ялгаа энэ ангиллын асуудлуудыг ер нь Засгийн газар дээр нэг бичсэн маягаар ер нь төрийн үйлчилгээний албан хаагчид бол тухайн салбараасаа үл шалтгаалаад цалингийн ангилал зэрэг дэвийн асуудлуудыг цэгцэлье гэдэг ийм чиглэлүүдийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя. Асуултауд бас нэмж ажлын хэсгийг нь бас хариулаарай.

Т.Доржханд: Баярлалаа. Энэ төслийг бол дэмжиж байна. Тэгээд орж ирээд зоригтой томоохон алхмуудыг оруулж ирсэн юм байна гэж бодож байна. Сайн байна. Ялангуяа англи хэлтэй холбоотой асуудлыг оруулж ирж байгаа нь зөв байна. Тэгээд дэлхий ертөнц чинь дэлхийн 2 дугаар дайнаас хойш их олон хэл үздэг байсан. Одоо сүүл рүүгээ бол ганцхан хэл чухал юм байна гэдэг болчихсон шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол бүгдээрээ англи хэлтэй байхад л цагаа хэмнэх юм байна. Тэгээд мэдээлэл авах юм байна гээд. Тэгээд тийм болохлоор англи хэл бол зайлшгүй юм. Харин англи хэл үзсэнээрээ нөгөө өөр улсын түүх үзээд явчихдаг, тэгээд өөрийнхөө үндсэн уугуул үндэстнээсээ тасарчихдаг гэдэг ийм болгоомжлол байх шиг байна. Тэгээд тийм зүйл байхгүй дээ. Тэгээд бүгдээрээ англи хэлтэй улсууд чинь бүгдээрээ л өөрсдийнхөө хэлээрээ л хэлд ордог, явдаг. Тэгээд л давхар ингээд л явж байгаа шүү дээ. Дэлхий ертөнц хөгжөөд байгаагийн гол шалтгаан нь энэ шүү дээ. Тэгээд тийм болохоор энэ дээр нэг талдаа гараад зоригтой явах нь зөв байх.

Харин нөгөө хөрөнгө оруулалтын өгөөжийн хувьд бол нэг эдийн засагчдын дунд тооцоо байдаг юм шүү дээ. Тэгээд боловсролд оруулсан 1 доллар бол 100 доллар болдог юм буюу 100 нугардаг байхгүй юу. Японд бол 4 жилийнхээ хоолыг бол 4 жилдээ сурч хүн бий болгодог юм гэдэг философи байдаг юм. Тэгээд өөрөөр хэлэх юм бол хөгжиж байгаа эдийн засгийн хувьд ялангуяа цөөн хүн амтай ийм үндэсний хувьд бол боловсролд оруулах хөрөнгө оруулалт бол маш их үр дүнтэй байж чадна, байдаг. Тэгээд тийм болохоор бид нар бол ийшийгээ зоригтой өөрчлөлтөө хийгээд, санхүүгийнхээ схемийг бас зөв зураад

явах нь зүйтэй байгаа юм. 2, 3 асуулт байна.

1 дүгээрт боловсролын салбарт англи хэл гээд оруулж ирлээ. Англи хэлний багш нар нь байна уу. Яаж харж байгаа билээ. Харин миний харж байгаагаар бол нөгөө англи хэлтэй гаднын багш нарыг бас урьж оруулж ирэх тийм механизм хэрэгтэй юм шиг байна.

2 дугаарт зөвхөн төрийн өмчийн сургуулиуд энэ ачааллыг авахаас гадна хувийн секторын оролцоог бол нэмэгдүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр бол илүү анхаарч явах байлгүй дээ. Хэрэгжилт дээрээ. Гэтэл нөгөө боловсролын салбар сургуулиуд нь нэг ашгийн бус байх ёстой гэдэг нэг ийм зүйл ингээд яригдаад байдаг. Тэгэхлээр тэр маань энд яаж тусаж байгаа билээ. Ашгийн төлөө бус байна гэх юм бол энэ салбар чинь хөрөнгө оруулалт байхгүй шүү дээ. Тэгээд хөрөнгө оруулалт байхгүй бол энэ ачааллыг чинь хэн авч явах билээ. Тэгэхээр гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих байдлаар ямар бодлогын зохицуулалт байгаа юм бэ. Дотоодынхоо хөрөнгө оруулалтыг дэмжих байдлаар ямар зохицуулалт байгаа юм. Энэ дээр нэг дахиад тайлбар авчихмаар байна.

Дараагийн нэг зүйл нь болохоор багшийн цалин. Бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Цалин бага болохоор хэн багш болох билээ. Тэгээд сайн хүүхэд багш болохгүй бол хэн үр хүүхдүүдэд маань бас чанартай боловсрол өгөх билээ гээд логик бол маш энгийн ерөөсөө санхүүгийн асуудал байгаа. Тэгэхээр нөгөө багшийнхаа цалинг өсгөх байдлаар, эдийн засгийн хөшүүргээр л чинь явна шүү дээ. Тэгэхээр яг дээрээ тооцоолол нь яаж явж байгаа юм бол. Манай ажлын хэсгийнхэн нэг хариулчихмаар байх юм. Яаж багшийнхаа, багш нарынхаа цалин үнэлэмжийг өсгөх юм бэ. Тэгээд чанартай хүүхдүүдийг наашаага нөгөө хөрвүүлэх тэр боломж нь байгаа юу.

Өөрөөр хэлэх юм бол гадаад, дотоодод сургууль төгссөн залуучууд ирээд багш болъё гэхэд заавал Монгол Улсын Багшийн Их Сургуульд 2 жил зайлигүй сурсан байх ёстой гээд зохицуулалт байдаг юм шиг байна лээ шүү дээ. Тэгээд тэрнээс чинь болоод гагцхиаад байдаг. Тэгэхээр хөрвүүлэх дээр илүү их хөнгөн шуурхай илүү нөгөө чанартай боловсон хүчнийг татах чиглэлээр ямар нэгэн зохицуулалт байна уу. Тэгээд ер нь бол эдийн засгийн чухал салбар бол яалт ч үгүй мөн. Урт хугацаандаа бол өгөөжөө өгнө. Тэгэхлээр төсөв дээр та нар маань ямар тохируулгууд хийхээр Сангийн яамтай ярьсан бэ. Ер нь хэрэгжилт дээрээ та нэг ийм.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн хариулъя. Хуулийн ажлын хэсгийн гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Боловсролын шинэчлэлийн нэг гол зорилт бол сургууль дахь тэгш бус байдлыг багасгах, тэр дотор өмчийн хэлбэрээс шалтгаалаад тодорхой хичээлүүд дээрх ялгаа зөрөөг арилах явдал байсан. Өнгөрсөн хугацаанд бид нар яг англи хэл дээр нэлээн анхааран ажилласан. Англи хэлний үндэсний боловсролын хэлэлцүүлгүүдийг манай мэргэжлийн багш нар эрдэмтэдтэй хамтран хийж байлаа. Ингээд харахаар элсэлтийн ерөнхий шалгалтын онооны хувьд бол төрийн өмчийн болон төрийн бус өмчийн сургуулиудын хувьд хамгийн ялгаатай хичээл бол англи хэл байгаа юм. Тухайлбал төрийн өмчийн сургуулиудын хувьд бол англи хэлний дундаж оноо 497, төрийн бус өмчийнх бол 591 байгаа. Яагаад ийм ялгаатай байдал үүсэж байна гэхээр 1 дүгээрт бол гол ялгаа төрийн бус өмчийн ихэнх сургууль 1 дүгээр ангиас англи хэл үзэж байгаа юм. Манай төрийн өмчийн сургуулиуд болохоороо 5 дугаар ангиасаа. Тэгэхээр яг 4, 5 жилийн хугацааны ялгаа бол тухайн хүүхдийн гадаад хэл эзэмших ой тогтоолтын эхний 7, 8 нас гээд яг энэ насны үед гадаад хэлийг бол сураагүй орхигдсон 5 жилтэй холбоотой байгаа.

Тэгээд энэ дээр бол манай ажлын хэсэг нэлээн судалгаанууд хийсэн. Ингээд олон улсын юунаас харахаар ерөнхийдөө дэлхийн ихэнх улс орнуудад гадаад хэл сурах нас бол 7-9 насны хооронд хоёрдогч юм уу гуравдагч гадаад хэлээ үзэж байна. Тэгээд Европын Холбоо бол 3, 4 дэх гадаад хэл рүүгээ орсон байх жишээтэй. Энэ дээр хамгийн бага настай Сингапур бол 4 настай, Хятадын хотын сургуулиуд бол 6 настай, Итали энэ тэр гээд 6 настай. Тэгэхээр энэ дээр бид нар Боловсролын Ерөнхий хуульдаа үндсэн гадаад хэл гэдгээр бол англи хэл гэж оруулж өгөөд, тэгээд ерөнхий боловсролын хуулиараа яг хэддүгээр ангиасаа гэдгийг бас судалгаа юуныхаа үндсэн дээр бол ярьж хийнэ. Ерөнхийдөө бол Англи хэлийг бол харьцангуй бага наснаас үзэх ёстой байгаа. Ингэхдээ мэдээж эх хэлний боловсрол, үндэсний соёл юугаа бол алдагдуулахгүй эх хэлнийхээ хуулиар бол яваад өгнө. Тэгээд англи хэл дээр бол багшийг бэлтгэх асуудал хамгийн чухал байна. Бид нарын тэр хэлэлцүүлгийн явцад манай багш нарын санал бол яг англи хэлээр сурч байгаа багшийн гадаад болон дотоодод мэргэжил дээшлүүлэх, тэгээд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн TESOL зэрэг мэргэжлийн томоохон шалгалтуудыг бэлтгэх төсвийн зардлыг улсын төсвөөс гаргах эсвэл орон нутгийн төвөөс гаргах гэдэг юм уу ийм төсвийн дэмжлэг үзүүлэхэд бол хамгийн чухал гэж тавьсан байж байгаа. Дээр нь Англи хэлний багш нарын маань тоо хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгээд улсын их дээд сургуулиудад сурч байгаа англи хэлний багшийн тоог нэмэгдүүлэх асуудлыг манай багш нар их ярьж тавьсан байгаа. Тийм учраас бид нар үндэсний англи хэлний боловсролын тогтолцоогоо дэмжихийн тулд багшлах боловсон хүчин түүний сургалтын баазыг зэрэг анхаараад явах ёстой гэдгийг бид нар боловсролын ажлын хэсэг дээр ярьж тохирсон байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. Гонгорын Дамдинням ажлын хэсгийн ахлагч хариулъя. Үлдсэн 2 асуултад.

Г.Дамдинням: Доржханд гишүүн их чухал асуудал хэллээ. Хөрөнгө оруулалтын орчныг яаж дэмжиж байгаа юм бэ гэж. Өөрөөр хэлбэл боловсролын салбарын бид нар төр бүгдийг нь даагаад явна гэдэг концепц бол ерөөсөө ямар ч боломжгүй. Тийм учраас бид нар энэ салбарт хөрөнгө оруулалтыг татах ёстой. Хөрөнгө оруулалт татах хүрээнд бол Боловсролын ерөнхий хуульд ийм л заалт орж байгаа. Бүх хэлбэрийн боловсролын байгууллага байж болно. Өмчлөлийн хувьд. Өөрөөр хэлбэл хувийнх байж болно, төрийнх байж болно, төр-хувь хамтарсан байж болно, олон улсынх байж болно.

2 дугаарт Боловсролын хуулийг дагаад татварын хуулиудад Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон төрийн үүргийг хуваалцаж байгаагийнх нь хувьд өөрөөр хэлбэл боловсролд хөрөнгө оруулалтыг хийж байгаагийнх нь хувьд дэмжлэг үзүүлж, татварын хөнгөлөлтүүдийг үзүүлдэг. Их олон төрлийнхөө татваруудаас чөлөөлдөг. Орж ирсэн тэр орлогоороо боловсролын салбартаа хөрөнгө оруулах юм бол нэмэлт бас татвар авдаггүй ийм зохицуулалтууд бол хөрөнгө оруулалтын орчинд байгаа. Тэгэхээр энэ бол нэг үзүүлэлт.

Багшийн цалин үнэлэмжтэй холбоотой асуудлыг Боловсролын ерөнхий хуулиар бид нар шийдэж чадахгүй. Ер нь бас барьж байгаа зарчим нь зөв гэж бид нар үзээд байгаа. Юу вэ гэхээр салбарын хуулиудаар багшийн цалин тэтгэвэртэй холбоотой асуудлуудыг хийх нь ер нь ямар ч салбарынхыг хийх нь буруу юм гэдэг концепцыг Засгаас тавиад байгаа учраас бид нар оруулаагүй. Гэхдээ багшийн нийгмийн асуудлыг хуульдаа тусгаад явбал багш болох тэр хүсэл тэмүүллийг бас дэмжиж болох юм гэдэг ийм

зарчмаар бид нар түрүүний заалтуудыг оруулсан.

1 дүгээрт хүүхдүүдийг багийн мэргэжлээр суралцаад ороод ирэх юм бол амжилттай сурах юм сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ. Одоо явж байгаа хуульдаа баталгаажуулаад оруулж байгаа.

2 дугаарт өндөр оноотой байх юм бол бүр бүтэн тэтгэлгээр шууд сурна. Орсныхоо дараа амжилттай сурах юм бол төлбөрийг нь буцаах ийм зохицуулалтыг үндсэндээ оруулж байна гэсэн үг энэ хуульд.

Дараагийн асуудал орон байрны дэмжлэгийг үзүүлнэ гээд хуульдаа бүр анх удаагаа тодорхой заагаад өгчихлөө.

3 дугаар асуудал бол боловсролын салбарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид болон багшлах боловсон хүчинд орон нутгийн алслалаас хамаараад 5 жилийн дараа эхний 5 жилд нь 6 сартай тэнцэх хэмжээний үндсэн цалингийн урамшуулал, энэ шатлал цаашаа 3 жил тутамд 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний урамшууллыг олгоно. Мөнгөн урамшууллыг. Мөн нэмээд боловсролын салбарт ажиллаж байгаа хүн болгон нэг хүүхдээ 15 жил ажилласныхаа дараа тэргүүлэх мэргэжлийн улсын сургуулиуд үнэгүй сургана гээд нийгмийн баталгааг нь энэ хуулиараа бид нар шийдэж өгч байгаагаараа бас багийн нэр хүндийг өсгөх тал дээр ажиллаж байна. Өөр мэргэжлийн хүн орж ирэх асуудлыг бас хөнгөвчилж байгаа юм. Мааш зөв. Ер нь бол сайн инженерүүд, сайн математикчид ч гэдэг юм уу багийн мэргэжилгүй хүмүүс ирээд багшлах сургалтад суугаад, тэгээд багшлах эрхийг авдаг энэ зүйл заалтыг хөнгөвчилж өгч байгаа юм. Ингэж байж бид нар багийнхаа хэрэгцээг сайжруулна, хангана, тэгээд багийн чанарыг сайжруулна гэсэн ийм бодлогыг

хуульдаа нэлээн сайн зохицуулж оруулсан байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу. Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Доржханд гишүүн их зөв асуудал хөндөж тавилаа л даа. Төсвийн тохируулга чинь яаж хийх юм бэ гэж. Бид нар их тийм гоё хууль баталж болно. Хамгийн гол нь энэ хуулийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэр аягүй чухал. Ер нь өнгөрсөн хугацаанд бид нар сүүлийн 15 жилд хөтөлбөрийн шинэчлэл хийх гэж 5, 6 удаа оролдсон. Мааш их том амбиц илэрхийлсэн. Яг эргээд хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ тэрнийхээ санхүүжилтийн эх үүсвэрүүд, механизмуудыг бид нар хийж чадаагүйгээрээ л алдаатай байхгүй юу. Тийм учраас энэ удаагийн хуулийн нэг онцлог бол бид нар яг нөгөө хөтөлбөрийн шинэчлэлд шаардлагатай байгаа хөтөлбөрийн өртөг, хичээлийн өртгүүдийг зөв тооцож яг олон улсын нэртэй платформуудыг оруулж ирэхэд тэр нь хувьсах зардалдаа тооцогдож оруулж байгаа. Одоо жишээ нь персон англи хэлний хөтөлбөрийг оруулж ирэхэд тэр нь хувьсах зардалд тооцогдож байхаар ийм зохицуулалтуудыг хийж байгаа учраас энэ дээр хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд шаардлагатай санхүүжилтийн механизм тохируулгыг бол бид нар Сангийн яамтайгаа бас тохироод явж байгаа гэдгийг бас танд хэлчихье гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай байх шиг байна. Тодруулах юм уу. Тодруулж асууя 1 минут. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа зарчмыг нь бол дэмжиж байна. Харин бас яг бодит амьдрал дээр яаж хэрэгжих вэ гэдэг нь л гол асуудал л даа. Тэгээд яах вэ цаг хугацааны хувьд нэг суурь тогтолцооны өөрчлөлт маань ингээд яригдах гэж байгаа болохоор яг энэ дээр суурилагаад салбарын реформ сайн сууж өгнө.

Момент нь бол яг зөв. Тэгэхгүй бол манайх хэчнээн зөв бодлого явуулаад суурь маань буюу тогтолцооны гажгаас болоод бодлого хэрэгжих, бодлогыг санхүүжүүлэх боломж байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр болж байна. Харин асуудал нь юу байна гэхээр Сангийн яаман дээр чинь бол мөнгө байхгүй шүү дээ манайхан. Хэцүү шүү дээ. Тийм биз. Мөнгө байхгүй цалин шууд огцом өсөх бас боломж байхгүй. Тэгэхээр л нөгөө хувийн секторын хөрөнгө оруулалтыг дэмжих тэр юман дээрээ илүү их нөгөө зохицуулалтуудыг л оруулж өгмөөр байгаа юм. Зөвхөн татвараас илүү бас ингээд төрийн зүгээс тухайлбал нөгөө газар худалдаж авлаа гэхэд төр үнэгүй газар олгочихдог бол хувийн сектор чинь бол илүү нөгөө дабльдсан үнээр авдаг шүү дээ. Тэгээд энэ дээр тухайлбал ямархуу.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Энэ хуулийн бас нэг санхүүжилтийн шинэ механизмыг бол бид нар төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр бас зарим боловсролын үйлчилгээг аутсорсинг хийх тэр боломжуудыг бид нар гаргаж ирж байгаа юм. Тэгэхээр төр өөр дээрээ ингээд сургууль, цэцэрлэгүүдийн барилгуудыг бариад байх уу. Эсвэл хувийн хэвшлээр бариулаад олон жил түрээслээд санхүүгийн нөгөө лизинг маягаар түрээслээд явах уу. Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтуудыг нэг удаагийн төсвийн хөрөнгө оруулалтаар биш түрээслээд, санхүүгийн түрээсийн лизингүүдээр явах гэх мэтчилнээр яг боловсролын салбарт аутсорсинг хийж болох хувийн хэвшлүүдээр гүйцэтгэж болох энэ ажлуудыг бас нэлээн боломж нээж байгаа ийм бас хуулиуд байгаа гэж харж байгаа. Ер нь бол юу гэдэг юм яг юуны сургууль шаардлагатай байгаа газрууд байршлууд дээр бид нар хувийн хэвшлүүдийг дэмжих, сая нөгөө цэцэрлэгийг шийдсэнтэй адилхан хувийн

хэвшлийн цэцэрлэгүүд дээр хувьсах зардлыг 2 дахин өгсөнтэй адилхнаар бид нар 3 ээлжид шилжих гэж байгаа байрлалууд дээр ч гэсэн цаашидаа бас ийм шийдлүүд байх нь бас зөв юм болов уу гэж харж байгаа. Тэгээд энэний эрх зүйн зохицуулалтууд механизм нь бол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Доржханд гишүүн тодруулж асууя. 1 минутад багтаагаарай.

Т.Доржханд: Зөв зөв. Энх-Амгалан сайд аа, би яг наадхыг чинь л асуух гээд байсан юм. Цэцэрлэгийн хуртээмжийг бол маш сайн шийдсэн. Хувийн сектороор дамжуулаад түрээслэх байдлаар. Одоо ер нь яг боловсролын салбар дээр яг тийм байдлаар ажилламаар байгаа юм. Яг ингэж ажиллахгүй бол тухайлбал нөгөө 40, 50 хүүхэдтэй анги дотор чинь нэг англи хэлний багш хичээл заагаад ямар ч үр дүн гарахгүй гээд манай мэргэжилтнүүд яриад байгаа байхгүй юу. Ядаж энэ чинь бол 20-25 байж байж үр дүн гардаг юм. Гэтэл баахан ингээд л хөтөлбөр тавиад, зардал гаргаад ингээд яваад байдаг гэтэл сургуулийнх нь хүчин чадал байдаггүй. Тэгээд үр дүнд нь нөгөө яриад байсан бид нарын нөгөө Англи хэлтэй болох зорилт маань ингээд биелэгдэхгүй байх магадлалтай болчихоод байна. Тийм болохоор энийгээ хувийн секторын байшингуудыг бид нар оруулж ирэхгүй бол байшингууд чинь зарагдахгүй байна шүү дээ. Тэгээд байшингуудаа тэр боломжийг нь ингэж нээж өгөөд рентлээд явдаг механизм руу орж байж л ард нь гарна шүү. Тэгээд энэ дээрээ та харин хатуу байгаарай. Тэгээд тэр бодлого чинь зөв байсан юм шүү. Одоо яг хувийн сектортойгоо бид нар ажиллаж сурах хэрэгтэй. Тэгээд тэр эх үүсвэрийг нь ашигладаг байх хэрэгтэй байна.

Л.Мөнхбаатар: Үг хэлчихлээ. Бодлого нь зөв байна. Байр суурь дээрээ хатуу байгаарай л гэж байна шүү дээ.

Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Боловсролын багц хуулийг бол нэлээн удаан хугацаанд хэлэлцэж байна. Ажлын хэсгийнхэн бол би бас сайн ажилласан гэж ойлгож байгаа. Тэгэхдээ ерөнхий хуулиас харахад бол өмнөх хуулиас тийм яг реформын шинжтэй өөрчлөлт бол эндээс ерөөсөө нэг их харагдахгүй байгаа. Ерөнхий хууль дээр. Одоо энд хуучин хуулиудаас нэмэгдсэн нэг юм бол боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын даргын бүрэн эрх гэж баахан юм орж ирсэн байгаа юм. Даргын бүрэн эрх. Ийм зүйлүүд ер нь өөр хуулиуд дээрээ байдаг юм уу. Нэг агентлагийн даргын бүрэн эрхийг энэ дээр тэгээд агентлагийн дарга нь аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн бүтэц орон тоог нь дарга нь тогтоох юм байна. Тэгж агентлаг чинь өөрөө ингээд л бүрэн эрх дээрээ энийгээ оруулаад явахгүй заавал дарга дээр нь баахан бүрэн эрх аваад ирсэн. Төрийн өмчийн олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургуулийн захирлыг сонгон шалгаруулна гэх мэтчилнээр. Би бол 2 дахь нь боловсролын хөтөлбөр агуулга стандарт л даа. Тэгэхээр бид нар ингээд тусад нь явуулаад байгаа олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулиудаа ингээд байлгаад байх юм уу. Олон жил туршлаа шүү дээ. Одоо ингээд олон жил тусад нь лаборатори сургуулиуд гэж явуулаад байна. Энэ үр дүнтэй байгаа бол бүх сургуулиудаа тийм болгоё л доо. Тэгээд ялгаад хэдэн сургуулиудыг ингээд байлгаад байдаг. Илүү цалин өгөөд дэмжээд байдаг. Тэгээд тэр үнэхээр үр дүнтэй байгаа бол бүх сургуулиудад тийм болгоод ийм жишиг рүү оруулаад явмаар байна шүү дээ. Би бол 2 дахь бүлэг дээр стандарт агуулга хууль дээр заавал орж ирэх ёстой. Бид нар гаднын хөтөлбөр Кэмбриж тэр гээд л цөм хөтөлбөр гээд л өчнөөн жил явлаа шүү дээ. Бид нар нэг бие даасан Монгол Үндэсний Хөтөлбөртэй болмоор байна. 1

дүгээр ангиас нь эхлүүлээд ерөөсөө 6 настайгаас нь эхлүүлээд л математик есөн жорын гэрийн даалгавраар дараад явдаг хөтөлбөрөө ер нь болих цаг болоогүй юм уу. Гэтэл дэлхий ертөнц чинь 5, 6 дугаар анги хүртэл нь юу зааж байна гэхээр хүн байхыг, эх орноо хайрлахыг, байгаль дэлхийгээ хайрлахыг, ахмад настнуудыг хүндлэхийг, төрийн өмчийг хайрлаж хамгаалахыг л заагаад байна шүү дээ. Тэгээд төлөвшөөд ирэхээр нь математик, физик, химийг түлхүү явуулаад сонирхлынх нь дагуу явуулж байна шүү дээ. Тэгээд бид нар 1 дүгээр ангиасаа 12 жил тоо заагаад яг хүний амьдрал дээр бид нарт нэмэх, хасах, үржих, хуваахаас нь яг төрөлжөөд явсан хүүхдүүдээс бусдад нь яг хэрэг болж байгаа юм юу байгаа юм. Менделевийн 108-ын үелэх системийг бид нар бүгдээрээ л тоть шиг цээжлээд сууж байгаа шүү дээ. Яг амьдрал дээр хэрэгжээд явж байгаа юм юу байгаа юм бэ. Тэгэхээр өөрийн гэсэн Монгол онцлогт тохирсон ийм хөтөлбөртэй болдог. Тэрийгээ хувийн хэвшилүүдээр мөрдүүлдэг. Түрүүн Дамдинням гишүүн хэлж байна. Солонгост үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхгүй сургуулиудыг жишигээр юм бол шахаж байна гээд. Солонгосын Ерөнхийлөгчийн хамгийн эхлээд гаргасан нэг том зүйл байна шүү дээ. Хувийн өндөр төлбөртэй их, дээд сургуулиудыг хориглож эхэлж байна шүү дээ. Яагаад гэхээр тэр нь өөрөө ард түмнийх нь дунд тэр өндөр төлбөртэй сургуульд оруулах нь өөрөө нэр төрийн хэрэг болчихсон. Тэрэнд хүүхдээ сургахын тулд залуу үе нь юу ч хийхээс буцахаа больсон. Авлига, хээл хахуулийн чинь гол юм нь тэрэнтэй холбоотой байна шүү дээ. Энийгээ бид нар ер нь яаж зохицуулж явах юм бэ гэдгийг Ерөнхий хуульд бид нар жаахан нарийн оруулж өгмөөр байгаа юм. Тэгээд цаашилаад Засгийн газрын бүрэн эрх, сайдын бүрэн эрх дээр их дээд сургуультай холбоотой заалтууд ерөнхий хууль дээр ерөөсөө байхгүй байна. Өнөөдөр чинь хөдөө, орон нутагт их дээд сургууль төгссөн ажилгүйчүүд гэдэг юм бол Монголын

хамгийн том проблем байна. Өвөрхангай аймаг гээд л жишээлбэл нэг аймагт ерөнхий боловсролын сургуулийг жилд 1100 орчим хүүхэд төгсөхөд 1200 их дээд сургуулийн хуваарь ирдэг. Тэгээд бүгдээрээ их дээр сургуульд яваад эргэж очоод ажлын байр байхгүй. Тэгэхээр энийг яг яаж хязгаарлаж явах юм бэ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганболд гишүүн ээ, ер нь энэ хууль энэнээс илүү реформ үнэртсэн хууль гэж би байхгүй болов уу л гэж бодох юм. Тэгээд өмнөх хуультайгаа харьцуулаад харахаар 6 том реформыг л бид нар хийх гээд зарлаад, эрх зүйгээ тодорхойлоод л явж байгаа. Өмнө нь явж байсан санхүүжилт чинь ямар ч тодорхойгүй санхүүжилт өгдөг. Байгууллага санхүүжүүлдэг. Ямар ч үр дүн, чанар тооцдоггүй сургалтын орчин, хот, хөдөөгийн сургуулиудын чанарын ялгааны индексийг санхүүжүүлдэг энэ тогтолцоо байхгүй. Багийн ажлын бүтээмжийг үнэлдэг ийм тогтолцоо байхгүй. Ийм тогтолцоог л бид нар ийм үр дүнд суурилсан тогтолцоо руу шилжүүлж гэдэг санхүүгийн 1 дүгээрт ийм том реформ хийе гэж бас зориод оруулаад ирлээ. 2 дугаар асуудал. Хөтөлбөрийн яг таны хөндөж тавьсан хөтөлбөрийн нөгөө хүүхдүүдэд томъёо цээжлүүлээд, Менделеевийн үелэх системийг цээжлүүлээд байх нь чухал биш. Тэр Менделеевийн үелэх системийг амьдралдаа яаж хэрэглэдэг юм бэ гэдэг ур чадваруудыг бид нар бий болгох ёстой юм байна. Үүгээрээ бид нар бусад улс орноос хоцрогдчихжээ. Өнгөрсөн жил Монгол Улсад анх удаа хийгдсэн Писа гэж олон улсын үнэлгээгээр Монголчууд та бүхэн хүүхдүүддээ дэндүү их тийм академик мэдлэг өгөөд байна. Гэтэл тэр анги танхим дээр өгч байгаа тэр академик мэдлэг чинь амьдрал дээр хэрэглэгддэг ур чадвар болж чадахгүй байна. Тэр ур чадвараа хөгжүүлдэг ур

чадварыг та нар бий болгож чадахгүй байна гэдэг бид нарт ийм үнэлэлт дүгнэлт өгчихсөн шүү дээ. Яг тэгэхээр бид нар дээр бас тодорхой дүгнэлт хийгээд, тэгээд ерөөсөө манай хөтөлбөр илүү академик ур чадвар гэхээсээ илүү мэдлэг, чадвар, төлөвшил, хүн байх төлөвшил байх энэ цогц ур чадваруудыг ер нь бид нар үндэсний хөтөлбөрөөрөө дамжиж олгох ёстой юм байна гэдэг. Тэгэхээр энэ 2 дугаар зүйл дээр боловсролын үндэсний хөтөлбөр агуулга стандарт гэдэг зүйл дээр бид нар ийм ийм зарчмуудыг барина гэдэг дээр бас нэлээн дэлгэрэнгүй л хийж өгсөн л дээ. Мэдээж яах вэ хууль дээр үндэсний хөтөлбөрүүдийг бүгдийг нь заах бол хэцүү. Тэгэхээр бол цаашидаа энэ хууль дээр яг үндэсний хөтөлбөр байхад тэр нь яг ямар зарчимтай, ямар агуулгатай, ямар стандартын хөтөлбөр байх юм бэ гэдэг нь л яг л 21 дүгээр зуун аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд Монгол хүнийг бэлдэх мэдлэгтэй, чадвартай, төлөвшилтэй Монгол хүнийг бэлдэх нэг ийм л хөтөлбөрүүдийг бид нар хийх ёстой юм байна гэж хуулиар харуулаад байгаа юм.

2 дугаар асуудал бол үнэлгээний тогтолцоог бас би нэлээн түрүүн тайлбарласан. Үнэлгээ, цахим шилжилтийн асуудлууд, багийн хөгжлийн асуудлууд, багийн ажлын үнэлгээний асуудлууд, сургуулийн засаглалын асуудлууд гээд. Нэг ийм 6 хүрээнд л бид нар ингээд өөрчлөлт шинэчлэлтүүдийг хийхийг л ингээд томъёолоод оруулж ирээд хэлэлцүүлээд байгаа л ухаантай юм л даа. Яах вэ та хэд бас дээд боловсролын тогтолцооны асуудлыг хөндөөд ярьчих шиг боллоо. Өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа хууль Боловсролын ерөнхий хууль. Боловсролын бүх түвшинд байгаа асуудлуудыг цогцоор нь саяын миний нөгөө санхүүжилтийн тогтолцооны асуудлууд, засаглалын асуудлууд, үнэлгээний асуудлууд, чанарын баталгаажуулалтын асуудлууд, сургуулиудын засаглалын асуудлууд,

цахим шилжилтийн асуудлуудыг ингээд түвшин бүрд нь томъёолоод орж ирж байгаа ерөнхий хууль. Одоо яг таны хөндөж тавьж байгаа мэргэжлийн боловсролын асуудал, дээд боловсролын асуудал бол дараагийн энд холбогдож орж ирэх салбарынхаа түвшин боловсролынхоо хуулиар иийдэгдээд явна.

Тантай нэг зүйл дээр бол санал нэг байна. Өнөөдрийн Монгол Улсад байгаа дээд боловсролын тогтолцоо Монголын ядуурлыг өдөөсөн, Монголын ажилгүйдлийг улам өдөөсөн ийм тогтолцоо байгаад байна. Тэгэхээр тогтолцооноос бид нар салах ёстой хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ур чадварын идэвхт нийлүүлэлтэд нийцсэн мэргэжлийн болон техникийн дээд боловсролын тогтолцоог бий болгох эрх зүйн өөрчлөлтүүд нь хуулиараа л хийгдэх юм л гэж ийм л хүлээлт байгаа шүү дээ Ганболд гишүүн ээ.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүн тодруулж асуух юм уу. Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя.

Г.Ганболд: Ерөнхийдөө ойлгож байгаа. Жишээлэх юм бол үр дүнд суурилсан санхүүжилтийг та үр дүнтэй л гээд байна л даа. Яг амьдрал дээр өөрөө үзэмжийн, удирдлагын үзэмжийн асуудал болоод сургууль дотроо ажлын байрны дарамт ялгаварлалд үүсгэдэг ийм тогтолцоо шүү дээ ер нь бол. Тэгэхээр зэрэг энийг ер нь суурь цалингаа жаахан нэмж явах тэр үр дүнд суурилсан юм нь урамшууллын бас нэг жаахан багахан хэмжээний л юм явахгүй бол одоо яг ингээд хараад байхаар чинь ингээд үр дүнд суурилсан юм чин хэт өндөр болоод ирэхээрээ суурь цалингаасаа өндөр болоод ирэхээрээ ийм юм руу яваад байдаг юм. Тэгэхээр энийг бас бид нар энэ хууль дээр ярих л ёстой.

2 дугаарт нь би дээд боловсролын тухай юм ярьж байгаа нь би зүгээр

Боловсролын ерөнхий хуульдаа Засгийн газрын эрх, сайдын эрх дээр их дээд сургуулиудын юмыг би таныг оруул гэдэг санаагаар хэлээд байгаа байхгүй юу. Ер нь бүрэн эрх дотроо бол эд нарыг жаахан.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулаад хариулт хангалтгүй гэж үзвэл нэмж тодруулдаг дэгтэй. Хэн хариулах вэ. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Шинэ шинэчлэлт реформ бүх юм бас амархан явагдахгүй л дээ. Тодорхой бас шилжилтийн үе гэж байна. Нэг өдөр гоё өргөс авсан юм шиг болохгүй. Гэхдээ цаашидаа бол бид нар үнэхээр боловсролын чанарын ялгааг арилгая. Хот хөдөөгийн сургуулиудын ялгааг арилгая. Чадварлаг багш нар заадаг тогтолцоо хүүхэд хаана амьдарч байна, хаана суралцаж байгаагаасаа үл шалтгаалаад чанартай боловсролыг авах сургалтын орчныг бий болгох тогтолцоо бол ерөөсөө л хувьсах зардлын тогтолцоо Ганболд гишүүн ээ. Тэгэхээр бид нар хувьсах зардлынхаа тогтолцоог улам яаж боловсронгуй болгох вэ гэдэг чиглэл рүү цөмөөрөө хамтраад нэг алхах ёстой гэж ойлгож байгаа. Мэдээж хөдөөгийн багийн сургууль гэдэг юм уу хүүхэд цөөнтэй байгаа сургуулиуд дээр яг үр дүнд суурилсан санхүүжилт дээр тодорхой эрсдэлүүд үүсэх тийм нөхцөл байдлууд бий. Бид нар судалгаа хийж байгаа. 60-70 сургууль дээр нэг ийм асуудал үүсэж байгаа юм. Энэ дээр бид нар тодорхой индексийн урамшууллууд гээд ингээд тодорхой тэр урсгал зардлуудыг нь санхүүжүүлээд явчих ийм зүйлүүд бол байгаа. Мэдээж хууль чинь амьдралаараа л шалгагдана шүү дээ. Тийм ээ. Өнөөдрийн бид нарын хэлэлцээд сууж байгаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя. 1 минут.

Г.Ганболд: Уучлаарай сайд аа, би зүгээр яах вэ ерөнхий хуульдаа бас ингээд их дээд сургуулийн захирлын томилгоог

бол уг нь бусад нөгөө нэг жишээлэх юм бол Анагаахын сургууль гэхэд эрүүл мэндийн сайд ч гэдэг юм уу, МСҮТ-ийг Хөдөлмөрийн сайдтай хамтрах ийм юмнуудыг жаахан оруулчихмаар байгаа юм л даа. Би жишээлбэл нэг зүйл танаас асууя л даа. Одоо сувилагчийг бид нар энд бакалавраар 4 жилээр дээд боловсрол дээр бэлдэж байгаа. Гэтэл хөдөө орон нутагт МСҮТ-ээр 2 жилээр бэлдэж байна л даа. Сувилахуй бол өөрөө тусдаа шинжлэх ухаан. Зүгээр нэг тариа хийж сурсныг сувилагч болчихлоо гэж үзэж болохгүй л дээ. Тэр чинь хэрэв буруу тариа хийгээд хүнд амь насанд нь эрсдэл учирвал яах вэ. Тэгэхээр энийг яг та жишээлэх юм бол Боловсролын яам дэмжээд тэрийг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Энийг яг мэргэжлийн ЭМЯ юу гэж үзэж байгаа бол. Таны саяын яг жишээг хэлэх юм бол та дэмжиж байгаа юу ер нь. Хэрэв тэгэх юм нөгөө сувилагчийн 4 жилийн сургуульд чинь суухгүйгээр МСҮТ-д суугаад ингээд сувилагчийн диплом үнэмлэх аваад явах.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ер нь Ганболд гишүүн ээ, бид нар ерөнхий боловсролын ахлах сургууль. Тийм ээ, 10-12 дугаар анги. Тэгээд мэргэжлийн боловсролын тогтолцоог бид нар чинь 2.5 жил байгаа байхгүй юу. Одоог хүртэл тэгж явж ирсэн. Ер нь бид нар 12 жилийн тогтолцоонд шилжчихсэн мөртөө мэргэжлийн боловсролоо яг хуучнаар нь социализмын үеэр нь 2.5 жилээр авчихсан. Яг ерөнхий боловсролынхоо тогтолцоотой ингэж нийлүүлж 1 тогтолцоо болгож авч явж чадаагүй юм байна лээ. Дахиад дээрээс нь дээд боловсролын тогтолцоо. Тэгэхээр ерөнхийдөө төрөлжсөн ахлах сургууль, мэргэжлийн боловсрол болон техникийн боловсрол тэгээд дээд боловсролын хоорондын түвшин хоорондын уялдаа

кредит шилжилтүүд их уян хатан байх ёстой юм байна лээ Ганболд гишүүн ээ. Тийм учраас өнөөдөр манай хөгжлийн хэрэгцээг хангах шаардлагатай байгаа 38 мянган инженер техникийн ажилтнууд, эрүүл мэндийн ажилтнууд, хөдөө аж ахуйн салбарын ажилтнууд гэхэд бид нар илүү мэргэжлийн боловсролоороо дэмжиж тэр хэрэгцээ шаардлагуудыг хангаад тэгээд цаашдаа тэд нар нь шаталж дэвших юм бол заавал.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ням-Осорын Учрал гишүүн асуултаа асууя. Дэгээрээ явъя. Та 2 удаа тодруулаад, хариултаа авсан. Учрал гишүүний цагийг эхлүүлъя.

Н.Учрал: Боловсролын ерөнхий хуулийг их удаан хэлэлцлээ. Энэ чинь 2 жил гаруй хэлэлцлээ. Тэгээд Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийн төслийг бол би бас дэмжиж байгаа юм. Гэхдээ зарчмын зөрүүтэй олон санал гарсан. Мэдээж Их Хурлын ажлын хэсэг бас өөрчлөх гээд бас шинэ концепц оруулах гээд нэлээдгүй бас ажилласан. Гэхдээ би зүгээр нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Энх-Амгалан сайдад. Энэ хуульд Дээд боловсролын хуульд бол мэдлэг, чадвар, төлөвшил л гэж үздэг. Бага боловсролын хуульд бол мэдлэг, чадвар, дадал л гэж үзэж байгаа юм. Энэ үгийг тухайн хуулийг анх бол боловсруулж байхдаа *attitude, skill, knowledge* гэдэг 3 үгийг орчуулсан. *Attitude* гэдэг бол хандлага гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ хууль өөрөө төлөвшилийг ч биш, дадлыг ч биш, мэдлэг, чадвар, хандлагыг үнэлдэг тогтолцоо руу л явах ёстой юм ер нь бол. Дэлхийн жишиг ч өөрөө ийм болсон. Хандлага. Хандлага дотроо бол түүнийг нь хэлбэржүүлдэг нь өөрөө тэр дадал, төлөвшил байна. Ингээд тэр давхар зөвхөн академик мэдлэгээс илүүтэйгээр өөрөө тасралтгүй суралцах үйл явц чинь өөрөө тэр СРТ гэж нэрлэж байгаа юм. Тасралтгүй хөгжил. Тэгэхээр хуулийнхаа нэр томъёо дээрээ давхардал дээрээ Энх-Амгалан сайд хэлээд байгаа тэр тасралтгүй хөгжил олон орчихсон

байгаа шүү дээ. Энэ үгийгээ ингэж нэг адилтгаж авч үзэхгүй бол болохгүй юм шиг байгаа юм. Дээрээс нь академик эрх чөлөөг дэмжих гээд байгааг нь би Дамдинням гишүүний оруулж ирээд байгаа *endowment fund* гэж бол академик эрх чөлөөг дэмжих гэж байна гэж би аягүй их бодож байгаа. Гэхдээ академик эрх чөлөөг дэмжих гэж байгаа мөртөө боловсролын байгууллага нь өөрөө сургалт судалгааны, эрдэм шинжилгээний байгууллага гэж томъёолсон. Энэ бол бас алдаа. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний болон инновацын үйл ажиллагааг дэмждэг буюу судалгааг эргэлтэд оруулдаг байж байж *endowment fund* үүсдэг. Тэгж байж судалгаанд *commercial* хийж байж сургууль өөрөө төлбөрөөс гадна судалгаагаар инновацыг дэмжсэнээр гарааны компаниудад хөрөнгө оруулснаар санхүүжилт нь нэмэгддэг тогтолцоо руу явна. Тэгээд академик эрх чөлөө дээр тэр *endorsement* гэдэг ойлголт байдаг. *Endorsement* гэдэг бол ерөөсөө тэр хөтөлбөрийг итгэмжилснийг зөвшөөрч байгаа. Гэтэл 2 их дээд сургууль жишээ нь Сингапурын Үндэсний Их Сургууль, МУИС-ийн кредитийг зөвшөөрлөө гэхэд түүнийг нь Боловсролын Ерөнхий Газар зөвшөөрнө гэдэг чинь байж болохгүй шүү дээ. Тэр 2 сургууль хоорондоо кредитээ шилжүүлээд ойлголцчихсон байхад Боловсролын Ерөнхий Газар энийг хийгээд сууна гэж байхгүй байхгүй юу. Тэгэхээр Ням-Очир дарга бол энэ салбарт туршилагатай хүн. Гэхдээ ер нь яг ийм бол ажлаа дийлэхгүй шүү. Ням-Очир дарга бас үнэнээ хэлээрэй. Тэрнээс биш Сингапурын их сургуулийг би зөвшөөрнө гээд сууж хэдүүлээ бас баларсан юм болоод яах вэ. Кэмбриж дээр бол нэг ийм юм байгаа. Кэмбрижийн хөтөлбөрийг сая Ганболд гишүүн их зарчмын зөв санал хэлсэн. Анх туршилтаар тэр Батболд даргын Засгийн газрын үед эхлүүлсэн ажлыг одоо бүх сургуульд тэр стандартыг хэрэгжүүлэх ёстой шүү дээ. Бид ажлаа л хийхгүй байгаа. Кембриж, Ай Би гэж 2 хөтөлбөрийг яагаад 6 дугаар ангиас

хэрэгжүүлдэг юм. Тэгэхээр зарим гишүүд жоохон андуураад нөгөө 1 дүгээр ангиас Англи хэл гээд буруу бодоод байх шиг байна. 1-6 чинь өөрөө Монгол хэл сонгон суралцах нь өөр хэл байгаад. Кембриж ч бай Ай би ч бай 6 дугаар ангиас нь хэрэглэснээрээ англи хэл сургах гэж тэр хувийн сургуульд оруулаад байгаа биш шүү дээ. Энэ чинь тухайн авч байгаа тэр Ай Жи Си Эс Си-ийн гэрчилгээ чинь олон улсад зөвшөөрөгдөөд тэтгэлэг авдаг учраас тэр Кембрижийн хөтөлбөртэй сургуулиудад хүүхдээ өгөх гээд байна шүү дээ. Тэр нь зөв шүү дээ. Тэгэхээр алс хязгаар аймгуудад, сумуудад энэ стандарт хөтөлбөрөө хэрэгжүүлээд илүү үр дүнтэй болгох дээр нь би бас Энх-Амгалан сайдыг их онцгой анхаараач ээ. Энэ стандартыг хэрэгжүүлээд тэр хөтөлбөрийнх нь дагуу аттестат гэрчилгээг нь олон улсын чанарт нийцсэнээр олгоод эхлэх юм бол тэгш боломжийг нь боловсролын салбарт хүртэхээр аяндаа тийм өндөр төлбөртэй сургуульд өгөх сонирхолгүй болно шүү дээ. Өөрсдөө сонгоод төлбөртэй сургуульд өгөх нь тэр хувь хүний л асуудал. Тэгэхээр ийм л байр суурьтай байгаа юм.

Л.Мөнхбаатар: Учрал гишүүд асуултад хэн хариулах вэ. Санал хэлчихсэн үү. Санал хэллээ. Одоо Бат-Амгалан гишүүн асуултаа асууя.

Э.Бат-Амгалан: Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үндсэнд нь бол яах вэ дэмжиж байгаа. Боловсролын хууль бол зүгээр нэг боловсролын хууль биш. Миний ойлгож байгаагаар Монгол улсын цаашидын хөгжлийн ирээдүйн залуу үеийн чиг хандлага ер нь бүр томхон хэлэх юм бол Монгол Улс оршин тогтнох бүрэн эрхт байдлаа хадгалах асуудал орж байгаа нэлээн чухал хууль гэж ингэж харж байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд ч гэсэн бас заасан байгаа. Ерөөсөө хоёрхон салбарыг зааж өгсөн байдаг. Эрүүл мэндийн салбар, Боловсролын салбар. Хүн эрүүл явах эрхтэй. Боловсролын салбарт

бол Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.7-д иргэн бүр сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэгүй олгоно гээд ингээд заачихсан байдаг. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн суурь конвенцод бас яг энэ чиглэлээр зааж өгсөн байгаа. Тэгээд өнөөдөр бол Монголд ямар байдал үйлчилж байгааг бас манай гишүүд, ажлын хэсэгт орсон боловсролын хуулийн ажлын хэсгийнхэн маань бүгд мэдэж байгаа байх. Энэ дээр би нэг асуулт асууя гэж бодож байна. Өнөөдөр нийгмийн ялгамжтай байдал яг Үндсэн хуульд заасан, саяын конвенцод заасан бага боловсролыг үнэгүй олгоно гэсэн энэ хүний эрхийн 2 зохицуулалтаа зөрчиж байгаа юм биш байгаа. Энэ хуульд ер нь яг яаж тусгаж орсон бэ. Энэ талаар асууя.

Нөгөө талаар хувийн хэвшилүүдтэйгээ энэ чиглэлээр хэрхэн зохицож, асуудлыг энэ хуульд яаж оруулж байгаа вэ гэдэг нэг ийм асуулт.

Дараагийн асуудал нийгмийн баталгаа дээр нэлээдгүй юмнууд бас яригдаж байна. 5 жил ажилласан жил тутамд 6 сарын цалингийн урамшуулал гэдэг юм уу энэ асуудлууд яригдаж байна. Энэ хууль дээрээ нэлээд зоригтой алхам хийж Монгол Улсын цаашидын хөгжлийн асуудал яригдаж байгаа гол хууль дээр нэлээн зоригтой ийм шийдлүүд оруулж өгч болоогүй юм уу. Жишээ нь миний бодлоор бол одоо ажиллаж байгаа олон мянган багш, ажилчдыг, ялангуяа залуу багш нарыг орон байраар, орон сууцаар хангах мэдээж бүгдийг нь нэг дор амжихгүй байх. Гэхдээ шалгаруулалт байдаг юм уу, энд ажиллаж байгаа залуу багш нарыг ялангуяа орон сууцаар хангах боломж бололцоог яаж хангаж оруулж өгсөн бэ. Энэ чиглэлээр юм байна уу. Ингээд дараа нь бас тодруулж асууя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг

асуултад хариулъя. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Бат-Амгалан гишүүн Боловсролын хуулийн шинэчлэлийн чухал асуудлыг асууж байна. Тэгэхээр ер нь бол боловсрол дахь ашгийн ба ашгийн бус гэдгийг ялгах, боловсролыг аль болох тэгш хүртээмжтэй хүүхэд хаана төрсөн, эцэг эхийн гарал үүсэл, орлого ялгаа үл хамаараад чанартай боловсролыг олж авах ёстой. Энийг бол манай боловсролын реформын хамгийн гол зорилго байх ёстой гэдгийг бид нар бол өнгөрсөн 3 жилийн хугацаанд маш олон түвшинд хэлэлцэж, эцэг эхчүүд, багш нар, хувийн сургуулиуд, бусад төрийн бус байгууллагуудын саналыг авч явсан. Тэгээд ер нь олон улсын жишгээр бол боловсрол ашгийн бус байх ёстой. Боловсрол бол хүний эрхийг хангадаг, хүүхдийн амьдралын туршид хэн байхыг нь бол тодорхойлж өгдөг, ядуу гэр бүл байна уу, орлого өндөр байна уу, цагаач байна уу гэдгээс хамаараад тухайн боловсролын чанараасаа хамаарч тухайн хүүхэд нийгэм дэх карьер, статусаа өргөх ийм чухал зүйл учраас бүх улс орны төр засаг бол боловсролыг бүх нийтийн сайн сайхны төлөө зорилго гэдгээр нь төрийн нийтийн боловсролыг чухалчилдаг. Өнгөрсөн 30 жилд манайд бол боловсролоор ашиг хөөсөн, боловсролыг бизнес болгосон ийм либерал концепцын дагуу хөгжсөн. Тийм учраас өнөөдөр бид нар боловсрол маань тэгш бус болчихлоо гэдгийг бүгд ярьж байна. Эцэг эхийн орлогоос хамаараад элсэлтийн ерөнхий шалгалтын оноо асар зөрүүтэй байна. Цаашидаа ч гэсэн зөрүү, ялгаа бол улам нэмэгдэх гээд байна. Тийм учраас боловсролын хуулийн суурь концепт дээр бид нар бол зарчим, байр суурийн ялгаатай байгаа. Тухайлбал боловсрол бол ашгийн бус байж болохгүй гэдэг ийм хатуу байр суурьтай байсан. Тэгэхдээ ажлын хэсэг дээр энэ санал маань цөөнх болоод, боловсрол ашгийн ба ашгийн бус байж болно гэдгээр хуульчлагдах гээд явж байгаа юм.

Манай Үндсэн хуулийн 16.7-д төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно гэж заасан. Энэ маань юу гэсэн үг юм гэхээрээ бүх нийтийн боловсролыг олгох үүрэг үнэ төлбөргүй олгох нь төрийн үүрэг. Үүнийхээ дагуу бусад хэвилийн сургуулиуд ч гэсэн тодорхой хэмжээний ийм зохицуулалт үүрэг хүлээлгэх ёстой. Өнөөдөр байгаа Монголын нөхцөл байдлаас харахад боловсролын зарим салбарт хэт өндөр буюу нийгмийн дундаж давхаргын үл дийлэх асар өндөр төлбөртэй сургуулиуд байгаа. Тэгээд тухайн сургуулиудын удирдлагаас төлбөрийг бол жил бүр үндэслэлгүйгээр нэмдэг. Ажлын хэсэг дээр бол бид нарт бас хувь гишүүд болон ажлын хэсэг дээрээ саналууд их олон ирсэн. Тухайн сургалтын төлбөрийг үндэслэлгүй нэмж байгаа тухайд эцэг эхэд мэдэгддэггүй, тэгээд төрийн өмчийн хэлбэрээс үл шалтгаалаад маш олон сургуулиудад хүчирхийлэл дээрэлхэх асуудал байна. Тийм учраас төрийн зүгээс Боловсролын хуулиар дамжуулан бүх сургуульдаа үүрэг хариуцлага ноогдуулах, хүүхэд болгон чанартай боловсрол олгох ийм саналыг тавьж байгаа. Тэгээд хууль дээр маань хуулийн нэг заалт бол тухайн сургалтын байгууллага нь ашигийн төлөө ашигийн бус гэдгээ Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 41.4.1.5-аар үүсгэн байгуулна гэж заасан байгаа. Гэтэл Монгол Улсын Иргэний хуулиар бүх хуулийн этгээд ерөөсөө ашигийн ба ашигийн бус гэдэг хоёрхон өмчлөлийн зорилготойгоор байгуулагдах ёстой байгаа. Тийм учраас бид нар Боловсролын хуулийг хэлэлцэх явцдаа сургалтын байгууллага нь хэрэвзээ өндөр төлбөр олж, тухайн сургалтын зорилгоос бусад хэлбэрээр сургалтын төлбөрийг ашиглаж байгаа бол өөрөөр хэлбэл ноогдол ашиг хуваарилж, эсвэл тухайн сургалтын төлбөрөөс бизнес хийж байгаа бол энэ сургалтын байгууллагад татвар ноогдуулах зохицуулалтыг

боловсролын хуулийг дагуу зөвлөн бид нар өргөн тавих ёстой. Тэгэхээр татварын хуулийг нэмэлтээр энийг цаашид хэлэлцэх шаардлагатай байгаа. Ялангуяа ерөнхий боловсролын тухай хууль дээр. Ер нь ашигийн бусаар үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагыг төрөөс дэмжих зохицуулалтыг бол хийсэн байгаа.

Мөн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тодорхой сургуулиудад хувьсах зардлыг олгохоор хязгаарлаж өгч байгаа. Өөрөөр хэлбэл Монголын үндэсний боловсролын тогтолцоогоо дэлхийн чигт хүргэх.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Бат-Амгалан гишүүн тодруулж асууя. Тодруулгад нь Дамдинням дарга хариулья. Хариултаа нэгтгэчихээрэй

Э.Бат-Амгалан: Яг тодорхой хариулт бол бараг хэлсэнгүй дээ. Ер нь хуучнаараа явна. Иймэрхүү л ойлголт авлаа. Тэгэхдээ Үндсэн хуулиас дээгүүр бусад хууль байх ёсгүй шүү дээ. Үндсэн хуульдаа бид нар 16.7-д нь иргэн бүр үнэгүй боловсрол эзэмших эрхтэй гээд заагаад өгчихсөн байдаг. Гэтэл чинь дахиад Иргэний хууль бусад хуулийн этгээдийн хууль ч гэдэг юм уу бусад хуулиар бид нар ашигийн болон ашигийн бусаар нь ингээд явна гээд ажлын хэсэг дээр цөөнх болсон гээд. Энэ тал дээрээ бас ажлын хэсгийнхэн маань та нар нэлээдгүй ажиллаж, мэдээж 2 жил гаруй хугацаанд та бүхэн хуулийг боловсруулж байна гэж ойлгож байгаа. Мэдээж том өргөн цар хүрээтэй хууль учраас 2 жил ажилласан байх. Тэгээд хувийн хэвилийн сургуулиудтайгаа, төрийн сургуулиудтайгаа ялангуяа иргэдээсээ хэлэлцүүлгийн шатад ямар ямар үр дүнгүүд гарсан юм бэ, ямар санал гомдлууд байгаа юм бэ, иргэдийн чинь дийлэнх хувь нь аль чиглэл рүүгээ байгаа юм бэ гэдэг талаар нэг асуулт асуучихъя.

Л.Мөнхбаатар: Энхтайвангийн Бат-Амгалан гишүүний тодруулгад хариулъя. Гонгорын Дамдинням ажлын хэсгийн ахлагч.

Г.Дамдинням: Манай Бат-Амгалан гишүүн бас Их Үндсэн хуультай холбоотой тодорхой асуулт асууж байна. Мөнхцэцэг гишүүн маань бас хариулт өгч байх шиг байна. Тэгэхдээ энэ дээр ажлын хэсэг дээр бид нар санал хураагаад шийдсэн. Монгол Улс ардчилсан улс. Зах зээлийн тогтолцоонд байгаа. Бид нар коммунист улс биш ээ. Би түрүүн хэлсэн. Өмнөх асуултауд дээр. Төр бүгдийг дааж явдаг тогтолцооноос бид нар салаад 33 жилийн нүүр үзэж байна. Чөлөөт зах зээлийг бид нар дэмжих ёстой. Боловсрол сонголттой байх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 7-г эх бариад яриад байна. Энэ зүйлийн яг дараачийн зүйлийг нь бас уншиж өгөхгүй байгаа байхгүй юу. Би уншаад өгье. Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй болгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно гээд заачихсан байгаа. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар бас хувийн сургууль байхыг дэмжиж байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулъя. 1 минутад багтаагаарай.

Г.Дамдинням: Тэгэхээр бид нар төрийн үүрэх ачааллыг үүрэлцэж байгаа хувийн хэвшлийнхнийгээ ад үзээд байж хэрэггүй ээ. Бага боловсролын түвшинд формоос бусад нь бас үнэгүй байгаа. Хоол нь, хичээлийн хэрэглэл нь бүгд үнэгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бас төрөөс энийг анхаарч байгаа. Дараачийн асуудал залуу багш нарын орон сууцтай холбоотой Бат-Амгалан гишүүн маш зөв асуулт асууж байна. 13.4 дээр багш ажилтаны амьдрах нөхцөлийг сайжруулах орон сууцжуулахыг төрөөс дэмжлэг үзүүлнэ гээд бүр тодорхой заачихсан байгаа шүү Бат-Амгалан

гишүүн ээ. Энэ бол анх удаагаа орж ирж байгаа ийм заалт. Үүний хүрээнд бас Боловсролын яамнаас бид нарт тоо баримтууд, судалгаануудыг гаргаж өгсөн. Та бас нийгмийн хандлагыг асууж байсан. Ер нь бол жилдээ 10 орчим хувийн боловсон хүчиндээ тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг өгөөд байя гэдэг ийм л зохицуулалт явж байгаа.

Л.Мөнхбаатар: Энхтайвангийн Бат-Амгалан тодруулж асууя.

Э.Бат-Амгалан: Үндсэн хуулийн 16.7 бол их ойлгомжтой байгаа шүү дээ Дамдинням гишүүн ээ. Төрөөс үнэ төлбөргүй байна л гэж ингэж заасан. Хувийн хэвшил ажиллаж болно л гэж зааж байгаа юм. Түүнээс хувийн хэвшил тийм, өндөр, бараг олон улсын том их, дээд сургуулиудад суралцах хэмжээний мөнгөөр бага боловсролыг олгож байгаа шүү дээ. Энэ бол үнэн шүү дээ. Зүгээр энэ чиглэл дээр ер нь та нар минь ямар арга хэмжээ авч ажиллаж, ядаж тэр хувийн хэвшлийн сургуулиудтайгаа хамтарч ажиллаж хэлэлцсэн юм байна уу л гэж ингэж асууж байгаа юм. Төр энэ дээр хувийн хэвшлийг ажиллуулж болно. Ман хувийн хэвшлийг ажиллуулахдаа төрийн тэр үнэ төлбөргүй байх зарчмыг баримталж дэмжиж ажиллана л гэж ингэж л зааж байгаа юм. Ингэж ойлгогдохоор байгаа юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад нь тодорхой хариулт өгье. Дамдинням гишүүн хариулъя.

Г.Дамдинням: Боловсролын ерөнхий хуулиар хувийн сургуулиудын удирдлага зохион байгуулалтад эцэг эхийн оролцоог бас нэлээн тусгаж өгч байгаа. Сургуулийн Удирдах зөвлөлд эцэг эх, сургуулийн, хувийн сургуулийн зардлыг хянаж шат шатны байгууллагуудад хандаж хянуулах, гомдол тавих, асуудлаа шийдүүлэх ийм эрхтэй болж байгаа шүү. Тэгэхээр бас тал талын оролцоог бид нар хувийн хэвшлийнхэнтэйгээ болон эцэг

эхчүүдтэй боловсролын салбарын бусад оролцогч талуудтай ярьж шийдэж байгаа. Энэ хууль дээр тодорхой эцэг эхийн үүрэг тэгээд бас тэр дотроо ороод явчихсан байгаа шүү. Амгаа гишүүн ээ.

Л.Мөнхбаатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Өнөөдөр Монгол Улсын үндсэн хуулийн ард жагсах Монгол Улсын хүний хөгжлийн маш том хууль хэлэлцэгдэж байгаа ийм чухал үе байна. Боловсролын хууль бол 2 жил бид орон даяар хэлэлцүүлээд өнөөдөр ингээд Улсын Их Хуралд хэлэлцэж байна. Улсын Их Хурлын гишүүдийн асууж байгаа ихэнх асуулт дотор мэдлэг боловсрол гэдэг чинь яг юу юм бэ. Хүн байх талаас нь яаж анхаарч байгаа юм бэ. Зүгээр л мэдлэгтэй хүнийг боловсролтой гэх юм уу эсвэл хүн болж төлөвшсөн, зөв сайн хүн болж төлөвшсөн байх нь чухал юм уу гэдэг ийм асуултууд нэлээн орж ирж байна. Тэгээд энэ хууль дээр бол бид нарт дэвшил гарч байгаа хуулийн зорилго бол сайн зан чанартай, хариуцлагатай, сайн зан чанартай хүн бэлдэнэ гэдэг ийм зорилго бас орж ирж байгаа. Энэ зорилго нь бол өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрт зорилго болоод ороод ирчихсэн. Мөн алсын хараа 2050-д бас тодорхой Монгол хүн ямар хүн байх юм. Бид ямар хүнийг бэлтгэх гээд байгаа юм бэ гэдэг ийм зорилго явж байгаа. Тэгээд би салбарын сайдад болон энэ хуулийг ахалж байгаа Дамдинням гишүүн ажлын хэсэгт орж байгаа орсон гишүүддээ бас талархаж байгаа. Энэ хуульд энэ зорилго орж ирснээр юу юм бэ гэхээр өнөөдрийн хүмүүсийн бухимдаад байгаа салбар болгонд ёс суртахуун алдагдчихсан. Хүний ёс жудаг зан чанарын мөс чанар алдагдчихсан ийм үед бид хүүхдүүдээ зөв хүн болгох тал дээр боловсролын салбар илүү их хичээх, багш нарыгаа бэлдэх мөн энд эцэг эх гэр бүлийн хүмүүжил илүү чухал үүрэгтэй юм гэдэг өвөг дээдсийнхээ тэр ухааныг эргэн санаж

Монгол хүнийг зөв сайн хүн болгох, бэлтгэх ийм зорилго, мөн Үндсэн хуульд заасан хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах гэдэг том зорилгодоо ингээд нийцээд явж байгаад маш их талархалтай байгаа.

Мөн надад бол асуулт байхгүй дарга аа, би өөрөө ажлын хэсгийн гишүүн учраас тодруулах зүйлээ хэлж байгаа юм. 2 дугаарт нь хэлний асуудлыг нэлээн ярьж байна. Өнөөдөр ганцхан гадаадад байгаа Монгол хүүхдүүдийн асуудал биш, Монголд байгаа тэр тусмаа хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдийн Монгол хэлний асуудал өнөөдөр асуудал болж байгаа. Хэрвээ аливаа улс үндэстэн хэлээ алдах юм бол үндэстэн байх тэр дархлаагаа алдана. Хэл байхгүй бол Монгол Улс байхгүй. Өнөөдөр гар утас бариад хөхөө хөхөж байгаа хүүхдүүд ч байна. Гар утсан дээр дандаа гадаадын контентууд үзэж байгаа. Хөдөө орон нутагт өнөөдөр уес, но гэж хэлд орж байгаа хүүхдүүд маш их. Энэ бол айл болгонд байгаа. Тийм учраас эх хэлээ алдагдуулахгүй байх гэдэг үндэсний хүний хөгжлийн үндэстэн байх хар хайрцгийн бодлого бол Монгол Улсад зав л байх ёстой.

Тийм учраас ажлын хэсгийн гишүүд англи хэл бол үндсэн үзэх гадаад хэл байна гэсэн болохоос биш “А” үсэгтэй зэрэгцүүлээд А, В, С гэж заана гэж ерөөсөө яриагүй юм шүү. Тийм учраас эх хэлээ маш сайн эзэмшүүлж гадаад хэл нь бол англи хэлтэй байна гэсэн ийм шийдэл дээр ажлын хэсэг ажилласан гэдгийг бас хэлье.

Хувийн сургуулиудын талаар бас ярьж байна. Би өөрөө яамны Төрийн нарийн бичгийн дарга байсан. Өнөөдөр төрийн ачаанаас маш олон хувийн сургууль цэцэрлэгүүд үүрэлцэж явж байгаа. Энийг бол бид нар үгүйсгэх аргагүй. Гэхдээ Үндсэн хуульд заасан боловсрол үнэгүй байх өнөөдрийн орчин үед хувийн сургуулиудад бас хүүхдээ өгөх эрх чөлөө болгоныг харгалзан үзэж

Боловсролын хуулиар нэгмөсөн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх тал дээр бас ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгээд хууль хэлэлцэж байх явцад олон шийдлүүд бас гарна гэж үзэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баярсайхан гишүүн ажлын хэсгийн гишүүний хувьд хуулийн төслийг дэмжсэн байр суурьтай үг хэллээ. Таны хэлж байгаа тэр англи хэл үндэсний гадаад хэл байна гэсэн зүйл бол дараагийн санал хураалт дээр буюу 14 дэх санал хураалт байгаа байх. Тэр дээр бас яригдана гэдгийг хэлье. Асуулт биш үг хэлсэн. Одоо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Өнөөдөр орж ирж байгаа Боловсролын ерөнхий хууль гэдэг бол түрүүн бас гишүүний хэлсэнчлэн үнэхээр үндсэн хуулийн аргаар бас орж ирэх монгол хүний боловсрол монгол хүний эрүүл мэнд гээд ер нь боловсрол, эрүүл мэнд 2 маань салиггүй холбоотой хамгийн чухал асуудал шүү дээ. Тэгээд би сайдаас ганц 2 асуулт асууя.

1 дүгээрт. Мөнхбаатар дарга Тэмүүлэн бид хэдийн Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нэг хууль бол байгаа. Энэ хууль юу вэ гэхээр ерөөсөө сургууль, цэцэрлэгийн дарга, захирлыг Засаг дарга нар томилдог, улс төржүүлдэг, тэр тусмаа сонгуулийн ар дээр бүгдийг нь халж, сольдог. Ингэснээрээ сургуулийн үйл ажиллагаа доголдог, жигд бус болдог, боловсролын тэр систем нь алдагддаг чанар алдагддаг гэсэн ийм арга хэмжээ ийм үйлдэл болоод байдаг. Тэгээд энийг засах ёстой. Ер нь энэ дээр ямар бодолтой байж байгаа вэ. Энэ хуулийн юмнууд гол логик концепц нь яаж тусаж орж ирж байгаа юм бэ. Та бас энэтэй хүлээн зөвшөөрч байна уу, үгүй юу. Тэр боловсролтой холбоотой, томилгоотой холбоотой. Энэ томилгоог бол ерөөсөө тэр Засаг дарга томилдог, мэргэжлийн бус хүн томилдог, тэгээд ингээд самарна гэж ярьдаг шүү дээ. Самарч хаяхаасаа л

урьдчилан сэргийлээд боловсролынх нь байгууллага хардаг, үздэг, шинжилдэг, судалдаг, томилдог, халдаг ийм үйл ажиллагааг нь л боловсролын байгууллагад нь өгөх гээд байгаа ийм хууль шүү дээ. Тэгэхээр энэ дээр та нэг хариулт өгөөч ээ гэж.

2 дугаарт Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа гэж. Ер нь ирээдүйн Боловсролын ерөнхий хууль бол Монгол хүнийг төлөвшүүлэх асуудлын гол суурь гэж харж байгаа юм. Жорж Тауны их сургуулийн багш нартай яриад сууж байхад тэр сургуульд элсүүлж авч байгаа хүүхдийнхээ 70 орчим хувийг нь яг цэвэр ямар сурсан юм, ямар дүн авсан юм гэдгийг хардаг гэж байгаа юм. 30 хувь нь тэр ямар чадвартай, ямар чадамжтай, ямар төлөвшилтэй хүүхэд юм бэ гэдгийг нь хардаг. Бие даалт нь ямар юм бэ гээд. Тэгэхээр ер нь хүн болох багаасаа гэж багаас нь бид нар төлөвшлийг нь аваад зөвхөн тооны төлөө биш, зөвхөн дүнгийн төлөө биш, тэгээд томроод ирэхээрээ зөвхөн их сургуульд орохын төлөө биш, ер нь хүн амьдралын төлөө төлөвшлийг нь боловсрол дотор чинь яаж сууж орж ирж байгаа юм бэ. Миний тэр саяын ярьдаг Жорж Таун руу 70 хувь нь дүнг нь хардаг, 70 хувь нь мэдлэг, чадвар, төлөвшлийг нь хардаг. Бие даалтыг нь хардаг. Биеэ даагаад аваад цаашаа сурах боломжийг нь олгодог. Энийг манай хууль дотор хэр оруулсан юм бэ гэж. Энэ талаас нь нэг хэлж өгөөч. Ер нь энэ хуульд би маш их итгэл өгч байгаа шүү. Ер нь энэ 6 концепц чинь нэлээн том суурь өөрчлөлтийг хийж байгаа. Өөрөөр хэлбэл магадгүй зүгээр хууль хэрэгжиж эхэлснээс хойш ер нь Монгол улс ёстой хөгжлийнхөө шинэ гараанд орж байгаа гэж итгэх гээд байгаа шүү. Тийм болохоор энэ дээр бас та ямархуу бодолтой байгаад байгаа юм бэ гэж.

Нөгөөтээгүүр миний түрүүний бас нэг хэлсэн асуудал. Ерөөсөө гараад л ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд л тэгээд л их сургууль л гэдэг ганц ийм юм Монголчуудын нийт толгойн дотор

орчхоод байна шүү дээ. Тэр тусмаа эмэгтэй хүүхдээ яаж ийж байгаад аргалж байгаад дээд сургууль нэг бараадуулчихвал тэгээд л хоолтой болгочихно гэж боддог. Гэтэл тэнд чинь хоолтой болох, амьдралтай болох, ирээдүйн гэрэл гэгээтэй байх чинь шал ондоо юмнаас бас их шалтгаалаад байна шүү дээ. Түрүүний миний чадвартай холбоотой асуудлууд. Тэгэхээр концепцоор нь бид нарын хэвилийг ер нь яг яаж өөрчилж байгаа юм бэ. Энэ чинь маш чухал байгаа зүйл шүү. Энэ зүйл бол энэ дотор орж ирж байгаа болов уу гэж би харж байгаа юм.

2 дугаарт түрүүн тэр яригдсан үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгоно гэж байгаа юм. Ганболд гишүүнтэй би бас санал нэг байгаа шүү. Ер нь бид нар энийг сууриа та өөрөө ч хэллээ. Сууриар нь бид нар хувьсгал хийнэ гэж бас байхгүй ээ. Энийг үе шаттай хийх хэрэгтэй. Гэтэл яг үүний тогтолцооны чинь нэг сөрөг тал захирал дарга нарын, менежерийн үгээр явчихдаг. Зөвхөн. Өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх эд нар гэсэн асуудал нь байхгүй болчихдог. Өөрөө би.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одоо 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Ийм болохоор гишүүд танхимдаа цуглаагаарай. Тамгын газар санал хураах бэлтгэл ажлыг хангахыг хүсье. Бат-Эрдэнэ гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Бид Тэмүүлэн гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Мөнхбаатар гишүүн 3-д бол талархах ёстой. Юугаараа талархах ёстой вэ гэвэл боловсролын багц хуулиар яг хөндөгдөж тавьж байгаа, хийх гэж байгаа 6 реформын хамгийн чухал реформ болох сургууль, цэцэрлэгийн засаглал менежментийн асуудлыг сайжруулах чиглэл рүү Боловсролын багц хуулийг өргөн баригдахаас өмнө энэ нэр бүхий 3 гишүүн маань боловсролын

засаглалын хамгийн их тийм асуудал дагуулж байсан Засаглалын асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн шинэчлэлийг хийх хуулийг өргөн бариад, одоо яг боловсролын багц хуулиар нэг зарчмаар санал хураагдах гэж байна. Тийм учраас энэ 3 гишүүнд манай боловсролын салбарынхан их талархалтай хандах ёстой гэж би ойлгож байгаа. Ер нь ингээд яг үнэнийг хэлэхэд хөдөөгийн сумын Засаг дарга нарын үзгийн үзүүрээр тавигдаж байгаа сургууль, цэцэрлэгийн удирдлагууд бол ямар ч шаардлага хангадаггүй, зөвхөн хэн намдаа үнэнч байх вэ цэцэрлэг, сургуулийн эрхлэгчээр очоод хэн нь намынхаа хүнийг олон ажлын байранд авах вэ гэдэг ийм шалгуур үзүүлэлтээр л тавигдаж ирсэн. Энэ бол гашиун үнэн. Өнөөдөр даам гарчихсан цэцэрлэг, сургуулийн удирдлагууд маш их байна. Өөрийнхөө тэр цэцэрлэг, сургуулийг хувийн өмч мэт царайлдаг. Хувийн компани шиг эзэмшдэг. Сүүлдээ өв залгамжилж өөрийнхөө хүүхдүүдийг цэцэрлэгийн эрхлэгч болгож байгаа ийм тохиолдлууд ч гэсэн гарч байна шүү дээ. Тийм учраас асуудлуудыг нэг цэг тавих эрх зүйн шинэчлэлийг бол манай 3 гишүүн тавьж, өнөөдөр ингээд манай боловсролын салбарын засаглалын шинэчлэлийн нэг том реформ болгож байгаад бас туйлын тархалттай хандах ёстой болов уу гэж бодож байна.

2 дугаар асуудал Бат-Эрдэнэ гишүүн ээ, та бол маш чухал асуудал хөндөж тавьж байгаа юм. Юу гэхээр өнөөдрийн ерөөсөө мэргэжлийн боловсролын тогтолцоо гэдгийгээ манай дээд боловсролын тогтолцоонд залгичихсан. Өнөөдөр манайх шиг 12 дугаар анги төгсөөд бараг үндсэндээ 12 дугаар анги төгсөж байгаагийн 90 хувь нь шууд дээд сургууль руу ордог, 12 дугаар анги төгсөж байгаа 40 мянган хүүхэд төгсөж байхад 60 мянган их дээд сургуулиудын элсэлтийн хуваариуд нь очиж байдаг ийм тогтолцоотой улс орон гэж ер нь дэлхийд би байхгүй болов уу гэж бодоод байгаа. Булганы 1 сум

дээр 12 дугаар анги төгсөж байгаа нэг хүүхэд дээр 3 их дээд сургуулиудын урилга очиж байсан ийм тохиолдол байсан байгаа шүү дээ. Одоо ч байгаа. Тэгэхээр бид нар цаашидаа боловсролын салбарт хийх гэж байгаа өөрчлөлт бол ерөөсөө улс орны хөгжлийн эрэлт хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн ур чадварын эрэлт хэрэгцээнд нийцсэн төрөлжсөн ахлах сургууль, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын ийм шатлалд суралцдаг ийм уян хатан тогтолцоо хоорондоо кредит тооцож суралцдаг уян хатан тогтолцоог нэвтрүүлж байж л өнөөдрийн Монгол Улсад үүссэн байгаа ядуурлыг өдөөдөг, ажилгүйдлийг өдөөдөг дээд боловсролын тогтолцоон дээр шинэчлэл гаргах зайлиггүй ийм шаардлага байна гэж харж байгаа. Тэгээд энэ асуудлыг цөмөөрөө Дээд боловсролын тухай хууль орж ирэхээр энэ дээр нэлээн жич тогтолцооны хувьд бол ярих нь зүйтэй болов уу гэж бодож байна. Өнөөдрийн боловсролын ерөнхий хуулиар бол боловсролын бүх түвшний санхүүжилт, та бүгдийн санаачилсан засаглалын асуудлууд, ингээд үнэлгээний асуудлууд, цахимын асуудлуудаа ингээд шийдээд явъя гэсэн ийм юутай байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд маань боловсролын салбарынхан маань талархах ёстой 3 гишүүн гээд байгаа. Сая сайн сонссонгүй. Хэн 3 гэхэв ээ. Дахиулдаг юм уу. Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Үгүй ээ үгүй ээ, яах вэ ерөнхийдөө би хэлээд байгаа шүү дээ. Хамгийн чухал нь ерөөсөө хуулиар бол реформ хийгдэж байгаа. Ерөөсөө яг энэ хууль хүчин төгөлдөр болсноор ер нь систем тэр чигээрээ өөрчлөгдөх гэж байгаа гэдэгт бүрэн дүүрэн итгэж байгаа шүү гэж. Тэгээд 1 ийм асуудал байгаа. Монгол орон маань өргөн уудам нутагтай, олон сумдтай, 300 гаран сумдтай, тэгээд нөгөө нэг боловсролын жигд бус байдлыг яаж халах ёстой вэ. Энд ер нь ямархуу бодлого барих ёстой

юм. Тэр маань яаж энэ хууль дотор суучхав. Тэгээд жишээ нь тэр Баян-Өлгий ч байж байна. Нөгөө өнцөг Дорнодод ч байж байна. Төвийн бүс гээд харилцан адилгүй сургалтын чанар түгээмж нь адил бус байгаад байгаа. Энэ дээр ер нь ямар байх юм. Ер нь жигд сайхан боловсрол олгож байдаг ерөнхий боловсролоо олгож байх боломж бололцоо хаах нь байх юм. Энэ бодлогод яаж суусан юм. Энэ талаасаа нэг хэлж өгөө. Энэ чинь.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням тодруулгад хариулъя.

Г.Дамдинням: Бат-Эрдэнэ гишүүн бас орон нутгийн хүүхдүүдтэй холбоотой боловсролтой холбоотой их чухал асуулт асууж байна. 1 дүгээрт бид нар алслагаас төвөөс алслагдсан байдлаас хамаараад хүүхдэд өгдөг хувьсах зардлыг нэмэгдүүлж байгаа. Индекс тооцоод нэмэгдүүлж байгаа. Энэ нь бол өөрөөр хэлбэл хөдөөгийн сургуулийн санхүүжилт нэмэгдээ гэсэн үг.

2 дугаарт хөдөөгийн сургуульд очиж багшилсан багшийг эхний 5 жилд нь 6 сартай тэнцэх хэмжээний үндсэн цалингийн урамшуулал, түүнээс хойш 3 жил тутамд 6 сартай тэнцэх хэмжээний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг өгдөг болж байгаа.

3 дугаарт орон байрны дэмжлэгийг үзүүлэх гэж байгаа юм.

4 дүгээрт цахим сургалтыг хууль ёсны болгож байгаа. Өөрөөр хэлбэл цаг хугацаа орон зайнаас үл хамаарч Монголын хамгийн шилдэг багш нарын тавьж байгаа мэдээллийг хичээлд суух боломжтой болж байгаа. Энэ хэрэгжээд эхэлчихсэн явж байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Ширнэнбандийн Адьяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Боловсролын багц хуулиудыг өнөөдөр Улсын Их Хурал 2 жилийн дараа анхны хэлэлцүүлгийг хийж байна. Энэ хуулийн төсөл энэ хуулийг батлах нь Монголын ирээдүйн төлөө хийх том үйл хэрэг байгаа. Энэ 2 жилийн хугацаанд олон зүйлийг үзсэн, олон гацааг давсан гэж ойлгож байгаа. Энд маш их том ашиг сонирхол байдаг. 30 жилийн тогтолцооны гажгийг Монголын ирээдүй үе маань үүрч байгаа. Энийг тогтолцооны өөрчлөлтийг, гажгийг арилгахын төлөө бас хичээл зүтгэл гаргаж ажилласан Боловсролын сайд Энх-Амгалан, Байнгын хорооны даргаар ажиллаж байсан Дамдинням нарт бас би талархал илэрхийлье. Маш их хүнд нөхцөлийг давж гарч ирсэн. Одоо ч ийм ашиг сонирхол байна. 2 жилийн хугацаанд олон замыг туулсан, аргагүй үнэнд гүйцэгдэж энэ зүйл өнөөдөр Улсын Их Хурал дээр орж ирж хэлэлцэгдэж байгаад би бас боловсролыг дэмжих бодлогыг бодож явдаг аав хүний хувьд их баяртай байна. Энийг олон талаас нь ярьж хэлэлцэх нь Монгол Улсын эрх ашиг байгаа. Монгол хүний эрх ашиг байгаа. Монголын ирээдүйн эрх ашиг байгаа. Бид өнөөдөр уул уурхай, алт мөнгөнөөс илүү ирээдүйн Монгол хүн байхын утга учир, боловсролтой Монгол хүн, түүний дотор амьдрах чадвартай Монгол хүнийг бид төлөвшүүлэх асуудалд Монголын төр, Монгол иргэн бүр сурган хүмүүжүүлэгч, багш, эцэг эхийн үйл хэрэг байх ёстой. Би энд асуулт надаа байхгүй. Би бас ажлын хэсэгт байдаг юм. Тэгэхдээ энэ хуулийн төслийг бас боловсруулахад ажилласан Боловсролын яамны баг хамт олонд бас талархал илэрхийлье. Маш их хүнд нөхцөлийг давж гарч ирсэн. Сайн үр дүн маань 10 жилийн дараа гарна. 20 жилийн дараа гарна. Ийм учраас энэ хуулийн төслийг яаралтай хэлэлцэж батлах нь Монгол Улсын эрх ашиг байгаа шүү. Бид нарын үр хүүхдийн эрх ашиг байгаа шүү гэдгийг би хэлэхийг энд хүсэж байгаа юм. Тэгээд хуулийн төслөө батлахад идэвхтэй оролцоорой гишүүд ээ. Энэ танхимд 10 хүрэхгүй л хүн байна шүү.

Олон зарчмын зөрүүтэй санал байгаа шүү. Тэр Чинзориг гээд хүн хаачсан бэ. Тэр Чинзориг гишүүнийг энд орж ирж санал өгөхийг би хүсэж байна. Арай эсэргүүцэхгүй байгаа байлгүй дээ. Танхимын, зарчмыг барих байх гэж найдаж байна шүү. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Адьяа гишүүн ажлын хэсгийн гишүүнийхээ хувьд дэмжиж, дэмжсэн байр суурьтай үг хэллээ. Одоо 1 гишүүн үг хэлэлцсэний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглая. Тамгын газар санал хураах, зохион байгуулалтын арга хэмжээ аваарай. Хаянгаагийн Болорчулуун гишүүн асуултаа асууя.

Х.Болорчулуун: Би санал хэлье ээ. Боловсролын ерөнхий хууль орж ирж байна, дэмжиж байна. Тэгэхдээ Боловсролын ерөнхий хууль дээрээ бас журмаар зохицуулж болох олон зүйл заалтыг энд оруулсан байна. Энийгээ бас ажлын хэсгийн явцад бол хасаасай гэж хүсэж байна. Боловсрол гэдэг хамгийн чухал л даа. Гэхдээ боловсрол бол гадаад хэл, тоо, физик биш ээ. Энэ бол зөвхөн нэмэлт боловсрол. Хамгийн гол нь Боловсролын ерөнхий хуульдаа хүүхдийг хүн болох, хүн болгож төлөвших талын зүйл заалтыг оруулмаар санагдаж байна. Гадаад орнууд ч гэсэн тэр тал дээр бол түлхүү бас ажилласан байдаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Ер нь эх орноо хайрлах, хүн амьтныг хайрлан хамгаалах, энэрэнгүй сэтгэлийг суулгах, энийг хүүхдэд багаас нь бас төлөвшүүлэх нь юу юунаас чухал шүү. Энэ бол хамгийн чухал боловсролын нэг. Тэрнээс биш яагаа ч үгүй хүүхдийг тоогоор балбаад, гадаад хэлээр балбах нь бас бага нас балчир хүүхдийн энэ түрүүний зорилт биш баймаар юм. Энэ 2 талцаа нийгэмд бага наснаас нь хүүхдүүдийг гадаад хэл, англи хэл үзүүлэх нь гэж явж байна. Зарим нь зөв гээд, зарим нь буруу гээд. Мэдээж энийг 1, 2 дугаар ангиас нь үзүүлэхгүй байх гэж бодож байна. 1, 2 дугаар ангиас нь үзүүлж болохгүй л дээ. Хөтөлбөрөөрөө явах ёстой. Сургалтын

хөтөлбөрөөрөө. Та бүхэн мэднэ. Бямбын Ренчин гуай гэж Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, Судар бичгийн хүрээлэнгийн захирал байсан хүн. Өөрөө орос, англи хэлтэй. Тухайн үедээ бол Монгол улсын номер нэг сэхээтэн. Энэ хүн яаж эх хэлээ дээдэлдэг байсан.

Чихний чимэг болсон аялгуу сайхан
Монгол хэл минь

Чин зоригт өвөг дээдсийн минь өв
их уламжлал

Сонсох бүрийн яруу баялгийг гайхан
биширч

Сод их билигт түмэн юугаа магтан
биширмүй гэж хэлсэн байдаг.

Тэгэхээр хүүхдийг бага балчраас нь Монгол хэлнийхээ гүн гүнзгий үг, өгүүлбэр, утга энэ болгоныг ойлгуулах нь юу юунаас чухал шүү. Харин тэр 3, 4 дүгээр ангиас нь англи хэлээ ч байна уу, орос хэлээ ч байна уу, хятад хэлээ ч байна уу тэрийгээ хөтөлбөрөөрөө түлхүү ордог л юм байгаа биз. Хамгийн гол нь би түрүүний хэлдэг эх орноо хайрлан хамгаалах, Байгаль орчин, хүн амьтнаа хайрлан хамгаалах сэтгэлгээг л Боловсролын ерөнхий хууль дээр бүр зааж суулгамаар байна. Энийг нэмэлтээр оруулъя гэж бодож байна.

Ер нь сүүлийн үед 30 жилд манай боловсролын системд гаднын гар, хөл дэндүү дүрэгдсэн шүү дээ. Тэгээд сурах бичгүүдэд түүхийг гуйвуулсан агуулга бүхий бичвэр зохиолууд их бичигдсэн. Энэ болгоныг засах ёстой шүү. Хамгийн гол нь боловсролын ерөнхий хууль маань юунд чиглэгдэх вэ. Хүүхдийг хүн болгон хүмүүжүүлэхэд чиглэгдэх ёстой шүү гэдгийг бас хэлэх байна. Санал хэлж байна.

Л.Мөнхбаатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Гишүүд танхимдаа орж ирье. Зарчмын зөрүүтэй 76 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй санал хураая. Санал хураалтуудыг явуулна. Танилцуулъя.

Боловсролын ерөнхий хууль хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал:

1.Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундрал, С.Чинзориг, Т.Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт явуулъя. Гишүүд ээ, санал хураалт.

Горимын санал гаргах юм байна. Аубакир гишүүн горимын санал гаргая.

Т.Аубакир: Миний аппарат уг нь ажиллаад байгаа. Төхөөрөмж ажилласангүй дахин санал хураалт авч өгнө үү.

Л.Мөнхбаатар: Аубакир гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 53.5 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалтдаа оръё. Үндсэн санал хураалтаа явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт 55.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ,

Л.Мөнхбаатар нараас өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх. Санал гаргасан ажлын хэсэг: Санал хураалт 54.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт” гэснийг “зорилго, зарчим, тогтолцоо” гэж “холбоотой” гэснийг “холбогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хуул болон түүнтэй” гэснийг “Сургуулийн өмнөх болон дээд боловсролын тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай, Дээд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль хууль болон эдгээр хуультай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54.5 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “нэр томьёо” гэснийг “нэр томьёоны тодорхойлолт” гэж, мөн зүйлийн 3.1.1 дэх заалтын “12 жилийн сургалтын агуулгын түвшинг” гэснийг “бага, суурь, бүрэн дунд, боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсролыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг санал. Санал хураалт. 56.8 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “төлөвшилийг” гэснийг “төлөвшилийн цогцыг” гэж, 3.1.3 дахь заалтын “мэргэжлийн болон дээд гэсэн ангиллыг” гэснийг “мэргэжлийн болон техникийн дээд боловсролыг” гэж, 3.1.5 дахь заалтын “танхимын бус хэлбэрээр явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 3.1.6 дахь заалтын “олгох” гэснийг “эзэмших” гэж, 3.1.7 дахь заалтын “бүх насны иргэн албан боловсролоос гадна хэрэгцээ шаардлага сонирхолтой”

гэснийг “хүний хэрэгцээ сонирхол, боломж нөхцөлтэй” гэж, мөн заалтын “албан бус” гэснийг “албан болон албан бус” гэж, 3.1.8 дахь заалтын “хэрэгцээг ханган, тухайн түвшиний” гэснийг “үр дүнг” гэж, 3.1.11 дэх заалтын “иргэнийг” гэснийг “хүнийг” гэж, 3.1.13 дахь заалтын “түүний үнэлгээ” гэснийг “зорилго, зорилт, үнэлгээ” гэж, мөн заалтын “багц” гэснийг “цогц” гэж, 3.1.15 дахь заалтын “хандлагыг” гэснийг “хандлага, эрхэмлэх үнэт зүйлийг” гэж, 3.1.16 дахь заалтын “иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшилийг” гэснийг “хүний эзэмшсэн чадвар, чадамжийг” гэж, “эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдлийг” гэснийг “эрэмбэлсэн бүтцийг” гэж, 3.1.18 дахь заалтын “мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан явуулах” гэснийг “цахим технологи ашиглан зохион байгуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.11 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 3.1.8 дахь заалтын “хөтөлбөрийн” гэсний өмнө “сургалтын” гэж нэмж, 3.1.11 дэх заалтын “элсэн” гэснийг, мөн зүйлийн 3.1.14 дэх заалтыг төслөөс хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 58.1 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 3.1.10, 3.1.17, 3.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.9.“албан бус боловсрол” гэж иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.10.“амьдралын орчинд суралцахуй” гэж хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.17. “хувьсах зардал” гэж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэг суралцагчид ногдох шууд болон шууд бус өртөгт суурилсан зардлын дундаж хэмжээг;

3.1.19. “цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.20-3.1.25 дахь заалт нэмэх:

“3.1.20. “боловсролын үнэлгээ” гэж боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, цахим технологи ашиглан тайлагнах үйл явцыг;

3.1.21. “чанарын баталгаажуулалт” гэж боловсрол, сургалтын чанарыг хууль тогтоомжид заасан шаардлага, чанарын шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх, сайжруулах, үр дүнг баталгаажуулах үйл явцыг;

3.1.22. “хөндлөнгийн үнэлгээ” гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг;

3.1.23. “магадлан итгэмжлэл” гэж боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар нь эрх бүхий байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж буй эсэхэд мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшилийг мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг;

3.1.24. “эндаументын сан” гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг;

3.1.25. “ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байрилын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 61.9 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршидаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 68.3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “шинжлэх ухаан, олон улсын” гэснийг “шинжлэх ухааны” гэж, 5.1.5 дахь заалтын “оролцоо” гэснийг “оролцоог хангасан” гэж, 5.1.7 дахь заалтын “үндэслэсэн” гэснийг “нийцсэн” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.3 дахь заалтын “уялдаатай” гэсний дараа “уян хатан” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.11 дэх заалт нэмэх.

“5.1.11.хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх;”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдэд саналаа өгөөрэй. 66.7 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 5.1.1, 5.1.8, 5.1.9 дэх заалтыг төслөөс хасаж, 5.1 дэх хэсгийг

өөрчлөн найруулж, 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмэх:

“5.1.Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд бодлого, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил, тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.3 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшний” гэж, 6.2 дахь хэсгийн “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн” гэснийг “монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.6, 6.7 дахь хэсэг нэмэх:

“6.6.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.7.Боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.8 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “албан бус” гэсний дараа “боловсрол” гэж нэмж, мөн 7.1 дэх хэсгийн “орчноос суралцах боловсролоос” гэснийг “орчинд суралцахуйгаас” гэж, 7.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол” гэж, “шаттай” гэснийг “түвшинтэй” гэж, 7.3 дахь хэсгийн “орчноос” гэснийг “орчинд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66.7 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66.7 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5, 8.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 8.3 дахь хэсгийн “дэмжигч болон явуулын багшийн, цахим” гэснийг “хувилбарт болон цахим, дадлага” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.7 дахь хэсэг нэмэх.

“8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь энэ хуулийн 8.1-д зааснаас гадна хосмог болон ажлын байрны сургалтын хэлбэртэй байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хосмог гэнэ үү. Нэр томъёоны хувьд ийм ойлголт байх уу. Энийгээ ажлын хэсэг дээрээ та нар ярьсан юм байгаа биз дээ тээ. 65.1 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хороон дарга Мөнхцэцэг дарга ажлын хэсэг дээрээ бас энийгээ нягталж үзээрэй дээ. Нэр томъёоны хувьд хуулийн нэр томъёо болоод цаашаа явах нь байна шүү дээ. Ингээд хуульдаа нэг удаа ингээд орох юм бол цаашидаа ингээд хуулиас эшлэгдээд явдаг учраас

энэ зүйлээ ажлын хэсэг дээрээ эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай.

18.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “мэргэжлийг” гэснийг “мэргэжил болон чадамжийн түвшнийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Суурь, бүрэн дунд боловсрол эзэмисэн төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн боловсрол эзэмисэн төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон дээд боловсрол эзэмисэн төгсөгчид диплом олгоно.” Найруулгын хувьд сайн уншигдахгүй л байна даа. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тоочоод л явчихсан. 68.3 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Боловсролын” гэсний дараа “болон сургалтын гэж, “олгох” гэсний өмнө “түүнийг хөтлөх,” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “ хувийн хэрэг” гэснийг “бүртгэл мэдээлэл” гэж, 9.6 дахь хэсгийн “боловсролын” гэснийг “боловсролын болон сургалтын” гэж, 9.7 дахь хэсгийн “болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс” гэснийг “эххүл, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас” гэж, “сургалтын баримт бичгийг” гэснийг “суралцагчийн эзэмисэн чадамжийг үнэлж,” гэж, 9.8 дахь хэсгийн “шатлалын” гэснийг “түвшний” гэж, “олгохыг хориглоно” гэснийг “олгохгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.10 дахь хэсэг нэмэх.

“9.10.Боловсролын баримт бичиг цаасан болон цахим хэлбэртэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтын “байгууллага” гэсний өмнө

“сургалтын гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.12, 10.1.13, 10.1.14, 10.2.7, 10.2.8 дахь заалт нэмэх.

“10.1.1.эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;

10.1.12.хөгжлийн бэрхиээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш, боломж нөхцөлөөр хангагдах;

10.1.13.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сорилд хамрагдахгүй байх;

10.1.14.ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах.

10.2.7.ерөнхий боловсролыг заавал эзэмших;

10.2.8.бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72.1 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмисэн мэдлэг, ур чадвар хандлагаа” гэснийг “чадамжаа” гэж, 10.1.6 дахь заалтын “төлөөллийн” гэснийг “өөрийн удирдлагын” гэж, 10.2.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилтэй холбоотой боловсролын байгууллага, багшаас тавьсан” гэснийг “багш, ажилтны” гэж, 10.2.4 дэх заалтын “багш, суралцагч, анги” гэснийг “багш, ажилтан, суралцагч,” гэж өөрчилж, мөн төслийн 10.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 10.2.1 дэх заалтын “хугацаанд нь бүрэн” гэснийг, 10.2.5 дахь заалтын

“сургуулийн дотоод журам” гэснийг хасаж, мөн төслөөс 10.1.4, 10.1.10, 10.2.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71.4 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад” гэж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “нэн шаардлагатай” гэснийг эрэлттэй” гэж, “тэтгэлэг” гэснийг “хөнгөлөлт, тэтгэлэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “зардлын дундаж нормативт” гэснийг хасаж, 11.3, 11.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Гадаад болон дотоодын мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно.

11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71.4 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “Хууль тогтоомжид” гэсний өмнө “Холбогдох” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.7 дахь хэсэг нэмэх.

“11.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат хэрэглэгдэхүүн, дэмжих үйлчилгээгээр хангагдана.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 74.4 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл. Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1.Багш, ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, багш бэлтгэх хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандарт болон энэ хуулийн 5.1.4-д заасан тэгш хамруулан сургах зарчимд үндэслэсэн байна.

12.6.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Багишийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.7-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.

12.9.Аймаг, сум, дүүргийн захиалга, эсхүл өөрөө хүсэлт гаргаж 3 буюу түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багишийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багишид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.10.Багишийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

12.11.Багишийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, багш, мэргэжлийн бүлэг, судлаач, эрдэмтдийн оролцоотой зохион байгуулна.

12.12.Багишийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна.

12.13.Багишийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.10-д заасан сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.14.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно. Энэ нэг л уншигдахгүй байна. Агуулгыг нь бол ойлгож байна. Төрийн болон орон нутгийн гээд гүйцээн боловсруулах чиглэл авахуу. Тэгэхгүй бол найруулгын хувьд бол уншигдахгүй байна.

Ажлын хэсэг болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 12.14 дэх заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. 1 л хүн үг хэлье. Хэн хэлэх вэ. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Хуулийн бас зүйл заалтууд дээр нэлээн сайн найруулга дээр нь анхаарахгүй бол болохгүй зүйлүүд байна. Зарим нь үндсэндээ журмаар зохицуулчих боломжтой заалтууд энэ дээр яг хуулийн заалт болоод орчихсон зүйлүүд чинь ажиглагдаад байна. 12.17-той холбоотой би нэг санал хэлэх гэсэн юм. Багш үндсэн ажлын цагийн бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой аливаа хэлбэрийн гэрээ байгуулж нэмэлт орлого олж болно гэсэн байгаа юм. Гэтэл 13.9 дээр багишийн хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно гэгчихсэн байгаа юм. Энэ 2 хоорондоо яаж авцалдах юм бэ. Тэгээд сургалтын чанартай нэмэлт орлого олно гээд явчихаар нөгөө үндсэн сургуулийнхаа үйл ажиллагаа, хүүхдийн сургалт, семинарын ажилд хэр эерэг, сөргөөр нөлөөлөх вэ. Энийг сайн бодож тооцсон юм байна уу. Энд багшилж байгаа нэртэй тэнд бас хэд хэдэн ажил давхар хийгээд явдаг. Өөрөө өөрийгөө хөгжүүлж чаддаггүй, өрөөлийн хүүхдийг сургаж чаддаггүй, ингээд өөх ч биш, булчирхай ч биш хаа хаанаа хүч тарамдсан ийм асуудал болохгүй юу. 13.9 дээр багишийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно гэдэг заалттай зөрчилдөхгүй юу. Энийг тодруулах гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Байж байгаарай. 14 хүртэл би бас гүйцээгээд уншихъя. Тэгээд нэгтгээд саналаа тайлбарлаад Учрал гишүүн үг хэлье. 12.15-ыг танилцуулъя.

12.15.Энэ хуулийн 12.14-д заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг

боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.16.Багилах хүний нөөц хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.17.Багш үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой аливаа хэлбэрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно.” Санал гаргасан ажлын хэсэг байна. Энэ дээр сандаргасан Учрал гишүүн үг хэлье. Дараа нь Чинзориг гишүүн үг хэлье.

Н.Учрал: 12.8 буюу Багишийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багилах эрхийг 12.7-д заасан багилах эрхийн гэрчилгээтэйд тооцно гэдэг заалт, 12.17 буюу багш үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой аливаа хэлбэрийн гэрээ байгуулж нэмэлт орлого олж болно гэдэг 2 санал бол миний гаргасан санал. Нөгөө саналууд нь ажлын хэсгийн санал юм байгаа юм. Тэгээд би саналаа тайлбарлая. Багш нар авч байгаа цалин, нийгмийн баталгаа өндөр биш байна. Өнөөдөр 1 дүгээр ангиас нь хэл ус заах гэж жижиг асуудал дээр тойрч ярьсаар байгаад гол концепцоо алдчихаж болохгүй. Тийм учраас би дээр өнөөдөр багш нар амралтын өдрүүдээр ажлын бус цагаараа эцэг эхчүүдийн суралцагч нарын хүсэлт тавьсны дагуу цагийн багшаар ажиллах, нөгөө хоцрогдол арилгах ийм хүсэлтүүд гаргадаг эцэг эхчүүд. Тэгээд хоцрогдол арилгах хүсэлт гаргаад нэг цагийн багшаар ажиллаад, амралтын өдөр чөлөөт цагаараа хүүхдүүдийн хоцрогдол арилгах, нөгөө бие даалтыг нь хийлгэх, тэгээд судалгааны ажил удирдах гээд ийм академик эрх чөлөөтэй холбоотой ажлууд дээр цалин хөлс аваад бас нэг орлогоо нэмэгдүүлэх бололцоог хуулиар нээхгүй бол энэ өөрөө хуулиар

зөвшөөрөгдсөн, зөвшөөрөгдөөгүй нь ойлгомжгүй мөртөө өнөөдөр төрийн өмчийн сургуулиуд дээр багшилж байгаа сайн багш нарыг эцэг эхчүүд хүсэлтээ тавиад 2 цагийн давтлага хүүхдэдээ авдаг, бие даалт хийлгэдэг, гэрийн даалгаварт нь туслаач гээд цагийн хөлс мөнгийг нь төлөөд хийлгэдэг. Энэ нь өөрөө яг хуулиар шууд зөвшөөрөгдөөгүй мөртөө амьдрал дээр байдаг л зүйл. Тэгэхээр өнөөдөр төр өөрөө багш нарыгаа цалин хөлсөөр нь хангаж чадахгүй, авч байгаа цалин нь ийм бага. Тэгээд алс хязгаар нутгуудад очоод сумд ажилла гээд байдаг. Энэ тохиолдолд ядаж багш энэ нарыг цагаар, ажлынхаа бус цагаар эцэг эхчүүд өөрсдөө хүсвэл ажиллах бололцоогоор нь хангах ийм эрх зүйн орчныг нээх л ёстой. Тэгж байж багш нар чинь бас 5, 10 цаасны нэмэгдэлтэй, орлоготой болог л дээ. Эрүүл мэндийн салбар чинь адилхан шүү дээ. Улсын эмнэлгүүдэд ажиллаж байгаа эмч нар зөвлөх үйлчилгээ үзүүлээд, бусад эмнэлгүүдээр цагаар очоод ажиллаж л байгаа нөхцөл байдал зөндөө байдаг. Энийг хуулиар нь дэмжих хэрэгтэй. Төр өөрөө дэмжиж чадахгүй юм бол ядаж бас нэг цагаар ажиллах нөхцөл бололцоогоо нээсэн нь л дээр гэдэг ийм л бодолтойгоор оруулж ирсэн. Энэ тохиолдолд тэр ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулаад л янз бүрийн судалгааны ажил удирдах тэр бол чөлөөтэй шүү дээ. Тэгээд л цагийнхаа хөлсийг тохирно биз.

2-т Багишийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасан багилах эрхийн гэрчилгээтэй холбоотой асуудал бол Багишийн хөгжлийг дэмжих тухай хуулийг би санаачилж батлуулсан. Энэ хуулийн ажлын хэсгийн ахлагчаар Боловсролын сайд Энх-Амгалан сайд ажилласан. Өнөөдөр олон мянган багш нар үүнд сэтгэл хангалуун байдаг. Юу вэ гэвэл 4-ийн 4 жил сурган хүмүүжүүлэх ухааны хичээл үзчихсэн багш нарыг битгий өөр мэргэжлээр суралцсан багш нартай дүйцүүлээч ээ. Тэд нар чинь 2-хон сарын хугацаанд, 3-хан сарын хугацаанд

сертификатын сургалтад суугаад, тэгээд багш болчихоод байна. Бид нар чинь 4-ийн 4 жил багшийн хөтөлбөрөөр сурсан хүмүүс шүү дээ гээд. Энэ тохиолдолд багшлах эрхийг нь нээж өгөхгүй бол өнөөдөр багш олдохоо болилоо шүү дээ. Багш дээр тавигдах шаардлагаа ярихаас өмнө цалин хөлснийхөө асуудлыг ярь гэж байгаа юм.

Дээрээс нь ажлын хэсэгт нэг санал хэлчихмээр байна. Багш бэлтгэх хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг сургууль гэдэг агуулга буруу Дамдинням гишүүн ээ. Багшийн хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг гэж бичихгүй бол 2 өөр ойлголт яваад байгаа юм. Багш бэлтгэх хөтөлбөрөөр их дээд сургууль биш, багшийн хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг гэдэг ийм редакцын засварыг хийхгүй бол их ойлгомжгүй нэр томъёо байна.

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

С.Чинзориг: 12 дугаар зүйл дээр дахиж ажлын хэсэг дээр гүйцээн боловсруулах чиглэл өгдөг юм уу. Шаардлагатай бол Засгийн газраас бид нар дахиж бас санал авах юм уу. Ярмаар л юм байна. Энэ чинь уг нь Засгийн газрын өргөн барьсан төсөл гээд байгаа юм. Тэгээд энд орчхоод чинь тэр анх Засгийн газраас өргөн барьсан төсөл дотор байгаа юм уу асар их олон төрөөс дэмжлэг үзүүлнэ гээд заалт ороод ирж байна шүү дээ. Хэрвээ тэр Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр төрөөс дэмжлэг үзүүлнэ гэсэн заалтууд байхгүй байгаа бол Засгийн газраас дахиж энэ дэмжлэгүүд нь байх юм уу, үгүй юм уу, Засгийн газар зөвшөөрч байгаа юм уу, эсэх гэдэг дээрээ дахиж санал авч эргэж ярихгүй бол болохгүй байх. Энэ чинь дэмжлэггүй юм байхгүй боллоо шүү дээ.

12.2 дээр тэр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их дээд

сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Энэ чинь тэгээд их дээд сургуульд ороход нь төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж байгаа юм уу. Суралцаж байгаа үед нь дэмжлэг үзүүлнэ гэж байгаа юм уу. Тэгээд энэ хүүхдийн чинь бүлэг сонгон ажиллуулаад амжилттай суралцуулна гэдэг чинь тэгээд сонгон шалгаруулалтгүйгээр шууд оруулах гэж байгаа юм уу. Тэгээд төрөөс дэмжлэг үзүүлнэ гээд ийм ойлгомжгүй асар их юм ороод ирчхэж.

12.6 дээр чинь ба тэр багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ гээд.

12.3 дээр аймаг, аймаг, сум, дүүргийн захиалга эсвэл өөрөө хүсэлт гаргаж 3 ба түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багшийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ. Эд нар гээд ингээд асар их олон тийм нэг төрөөс дэмжлэг үзүүлнэ гэсэн ийм юмнууд л ороод ирсэн байна л даа. Тэгэхээр энийг эргэж нэгтгэж дахиж үзэх юм уу, эсвэл шаардлагатай тэр Засгийн газраа дахиж санал авах юм уу. Ийм асар олон. Тэгээд төрөөс дэмжлэг үзүүлнэ гэсэн юмгүй л ийм л хууль болох нь л дээ. Бид нар багш бэлтгэх шаардлагатай байгааг ойлгож байна. Хөдөө, орон нутагт багш дутагдалтайг ойлгож байна. Тэгээд ийм асуудлуудыг яах юм бэ. Энх-Амгалан сайд аа. Энэ чинь Засгийн газраас орж ирсэн төсөл дээрээ байгаа юм уу. Хэрэв байхгүй байгаа бол энийг засаг дээр дахиж ярьж санал авахгүй бол болохгүй байх. Тийм учраас би бол энэ 12-ыг ер нь гүйцээн боловсруулах чиглэл өгөөд ажлын хэсэг, Байнгын хороонд нь чиглэл өгөөд буцаах ийм саналтай бол байна. Тэгээд 12-ын саяын яриад байгаа 12.13 дээр сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байна гээд. Тэгээд сургууль дээр чинь бас дахиад Багш хөгжлийн асуудал

хариуцсан шинэ бүтэц гарч ирэх гэж байгаа юм уу, яах гэж байгаа юм. Орон тоо нь яах юм. Энэ бүгдийг чинь тэгээд Засгийн газраас санал авч байж, дахиж ярих шаардлагатай байна шүү дээ. Би гишүүнийхээ хувьд саналаа хэлж байна шүү дээ. Тэгээд ийм асар их олон төрөөс дэмжлэг үзүүлнэ гээд ийм юм оруулаад ирчихсэн байна шүү дээ. Тэгээд Багш хөгжлийн асуудлаар сургууль болгон дээрээ нэгжтэй байх асуудлууд ороод ирлээ. Тэгээд энийг чинь тэгээд тэр хэрэв шаардлагатай бол тэр орон тоо, тэр төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой Засгийн газар дээрээ дахиж санал авах шаардлагатай юм биш үү. Би саналынхаа дагуу үгээ хэлж байна. Би гишүүнийхээ хувьд үгээ хэлж байна шүү дээ.

Хэрвээ та Засгийн газрын өргөн барьсан төсөл, Засгийн газрын гишүүд юм ярьж болохгүй гэж загнаад байх юм. Бас хэт их түрэмгий байж болохгүй шүү дээ. Энх-Амгалан сайд. Би Засгийн газрын төслийг чинь өргөн барьсан гэдгийг чинь ойлгож байна. Тэгээд гишүүнийхээ хувиар санал хэлэх эрхтэй шүү дээ. Хэрвээ хөгжлийн асуудал хариуцсан нэгж байхгүй байна гээд Засгийн газрын төсөл дээр байхгүй байсан бол энэ бүтэцтэй холбоотой, орон тоотой холбоотой, тэр дэмжлэгтэй холбоотой асуудал Засгийн газар дээр дахиж ярьж санал.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Энэ 12 дугаар зүйл бол Засгийн газраас өргөн баригдсан боловч ажлын хэсгээс өөрчлөн найруулсан төсөл байгаа шүү дээ. Өөрчлөн найруулсан төсөл байгаа юм. Раднаасэд гишүүн үг хэлнэ. Гэхдээ ийм шүү. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүртэл гишүүн л үг хэлж болно. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Засгийн газрын гишүүд Засгийнхаа хурал дээр энийгээ ярьдаггүй юм уу. Энд орж ирчхээд санал гаргаад л, энд орж ирчхээд л юмнуудаа яваад байх юм. 1 дүгээрт.

2 дугаарт давхар дээл нь эд нарт арай хүнддээд байгаа юм уу эсвэл их юу байгаа юм байна л даа. Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэхгүй бол эд нар чинь ингээд нэгнийх нь ард 20 хүн суучихсан. Тэгээд бие биеийгээ хамгаалдаг, ардаасаа энийг нь хамгаалдаг гишүүд, Байнгын хороонуудтай. Мэргэжлийн байнгын хороод дээр ч юм ярих боломжгүй болчихсон. Тэгээд орж ирсэн танхимынхаа юмыг ингээд тал талаасаа яриад муулаад байдаг. Одоо энэ бол нэгдэх тохиолдол, эхний тохиолдол биш шүү дээ. Аялал жуулчлалын хууль дээр явсан. Тэр үнийн юун дээр бас явсан. Хэн нь илүү мундаг вэ гэдгээ өрсөлдөх гээд байгаа юм уу. Гишүүд юм ярихаар бүгд мэддэг. Тэгээд ямар сонирхлын зөрчил бүх юмаа хавчуулаад энэ дотор ороод ирчихсэн Тэгээд тэрийг нь хамгаалдаг хэдэн гишүүд энэ дотор байгаад байдаг. Энэ юмнуудаа засаж янзлахгүй бол энэ чинь болохгүй байна шүү дээ. Энэ хууль чинь өнөөдөр орж ирснээсээ бүүр хэд дахин өөр болчихсон байна шүү дээ. Тэгээд энэ дотор чинь зүгээр төлөвлөгөө дотор тусчихмаар ч юмнууд байна. Тэр төсөл дотор чинь агентлагийн даргын эрх ч гэж байх шиг. Тийм ямар юм байдаг юм. Хэзээ хууль дээр тэгж 1 их бүтцийг хуульчлаад. Ер нь сүүлийн үед орж ирж байгаа хуулиуд чинь их бүтэц хуульчилсан хуулиуд орж ирж байгаа шүү. Ийм агентлагтай байна. Дарга нь ийм эрхтэй байна. Ийм газар хэлтэстэй байна. Энэ нь ийм чиг үүрэг хэрэгжүүлнэ гээд ингээд дараа нь засаг өөрөө байгуулагдаад хуулиа бүтцээ хийх гэхээр энэ хуулиуддаа бүгдэд нь гар хүрдэг ийм юм руу явах гээд байна шүү. Одоо энэ Засгаас орж ирж байгаа бүх хуулиуд тийм. Байгууллагуудын эрх ашгийг хангасан ийм хуулиудаа 1 дүгээрт татах хэрэгтэй. 2 дугаарт үнэхээр боловсролоо дэмжье гэж байгаа юм бол тэр үндсэн агуулга руу нь чиглүүлэхгүй аваачаад дэлгэрүүлээд, задлаад дарга цэргийнх нь эрх ямбыг нь, эрх үүргийг нь бичээд явчихсан. Энэ юмнуудыг нь харахгүй бол ажлын хэсэг дээр их хариуцлагатай ажиллах ёстой байхгүй юу. Орж ирсэн

санал болгоныг нь оруулаад байх биш, заримыг нь хасаад хаях ёстой байхгүй юу. Энэ дотор хоорондоо зөрүүтэй Амарсайханы яриад байгаа бас зөв л байна шүү дээ. Нэг болно гээд, нэг болохгүй гээд. Тэнд нэг сайд нь улсын салбарын сайн сургуулийн багш нарыг хувийн салбарт бас давхар ажиллаж болно гээд ингээд зүтгүүлээд байдаг. Тэгээд зарчмын ийм бодлогын юмнуудаа хагалахгүй бол энэ хууль чинь өөрөө боловсролын хууль биш. Ерөөсөө боловсруулахгүй байх тухай хууль шүү. Боловсрол гэдэг үгийн чинь цаана түүхий биш л гэсэн утга явах ёстой байх. Боловсорсон, болсон Монгол хүний тухай л асуудал байгаа байх. Тэгээд хуулийнхаа үндсэн амин сүнснээс хазайлгаад ингээд ийш тийш нь жаал суваг татаад хаячихлаа л даа. Энэ том хуулийг уг нь их л нухацтай ярьж хөөрч явах ёстой. Тэгээд Засгийн газрын гишүүд энэ дээр юм бодохгүй бол танхимын зарчим гэж юм байгаа ч юм уу, байхгүй ч юм уу болчихоод байна шүү. Маш олон тохиолдол дээр энэ чинь харагдаж байгаа шүү. Бүх сайд нарыг хамгаалдаг, өөрсдийнх нь эрх ашгийг хамгаалж дуугардаг хэдэн гишүүдтэй. Тэд нар нь орж ирээд юм ярьдаг. Тэгээд санал зөрөлдөхөөр сайд нар нь хоорондоо муудалцдаг. Тэгээд энэ чинь нөгөө 26 хүн сууж байгаад бүх хуулийг явуулах нь байна шүү дээ. Батлахад яах вэ. 39 гээд л явчихсан. Тэр бүгдэд нь уншиж чадахгүй, хүрэхгүй гишүүд ч бас байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан. 12 дугаар зүйл чинь өөрөө багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо гээд ийм зүйл байж байгаа. Энэ дотроо өөрөө бас агуулгын хувьд ч бас хоорондоо нэлээн зөрчилтэй юмнууд бас байгаад байх шиг байна. Багш бэлтгэх хөтөлбөрийн тухай яригдаад, багшийн өгөх тэтгэмж, дэмжлэгүүдийн асуудал, дээр нь бас сэлгэн шилжиж ажиллах эд нар гэсэн нэмэлт орлого гэсэн ийм зүйлүүд бас нэг хамтатгаад биччихсэн юм байна. Ийм учраас Улсын Их Хурлын

гишүүн Амарсайхан, Учрал, Чинзориг, Раднаасэд гишүүдийн саналыг харгалзан үзээд Ажлын хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

25.Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.11 дэх заалт нэмэх.

“13.1.11.цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Б.Энх-Амгалан гишүүн үг хэлье.

Б.Энх-Амгалан: Төслийн 13.1.11 дэх заалт цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин нөхцөлөөр хангагдана гэхээр тэгээд хүүхдүүд бүгд л цахим утастай болох нь. Дэлгэцийн хамралаас салах гээд эцэг эхчүүд үзэж тараад, үйлээ үзээд байдаг. Тэгээд энэ чинь хичээл хийхээсээ илүү түрүүгээрээ есөн шидийн юм руу орж тоглоод байдаг. Тэгэхээр ингээд нэг цахим хөгжлийн орчин нөхцөлөөр хангана гээд л нэг юм яриад яваад байх нь зөв юм уу. Тэгээд л энийгээ хангана, энийг ингээд бүгдийг нь улсын төсвөөр шийднэ гэдэг ч юм уу ингээд яваад байх нь ямар учиртай юм. Уг нь тэр сургалтын программаа л хангаж байвал тэгээд уг нь болмоор санагдах юм. Тэгээд дэлгэцийн хамаарал гээч юм чинь л их болоод байна даа. Энийг яаж шийдэх юм.

Л.Мөнхбаатар: Гонгорын Дамдинням гишүүн үг хэлье.

Г.Дамдинням: Энх-Амгалан гишүүн ээ, энэ 13 дугаар зүйл өөрөө юу юм. Сурагчидтай, хүүхэдтэй хамааралтай хэсэг биш юм. Та хэрэв хуулийн төслөө бүтнээр нь харах юм бол багшийн эрх үүрэг, багш, ажилтны нийгмийн баталгаа гэсэн асуудал юм. Тэгэхээр

багш хүн өөрөө ажлаа явуулахад нь тэр дижитал орчинд хичээлээ заах боломж нөхцөлөөр нь хангах, өөрөөр хэлбэл, компьютероор хангах, камераар хангах, интернэтээр хангах тухай л асуудал байхгүй юу. Сурагчид, хүүхдүүдтэй холбоотой асуудал биш. Тэгэхдээ таны ярьж байгаа дэлгэцийн хамааралтай холбоотой асуудал нэлээн чухал шүү. Тийм болохоор гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэллээ. Санал хураалт. 72.1 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “албан тушаалын тодорхойлолтод” гэснийг “хууль тогтоомжид” гэж, “ажлын үр дүн, гүйцэтгэлд” гэснийг “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ” гэж, 13.2.7 дахь заалтын “эрхэмлэн, ажил амьдрал үйл ажиллагаагаараа үлгэрлэх” гэснийг “эрхэмлэх” гэж, 13.2.9 дэх заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийг” гэснийг “цахим технологи, хэрэглэгдэхүүнийг” гэж, мөн заалтын “платформыг” гэснийг “цахим системийг” гэж, 13.2.10 дахь заалтын “багшийн мэргэжлээ дээшлүүлэх” гэснийг “ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж” гэж, 13.2.3 дахь заалтын “мэдлэг, чадвар, дадлыг” гэснийг “чадамжийг” гэж, 13.2.11 дэх заалтын “цэцэрлэг, сургуулийн” гэснийг “сургалтын” гэж, 13.3.3, 13.3.5 дахь заалтын “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 13.3.4 дэх заалтын “дэмжлэг үзүүлэх” гэснийг “дэмжлэг авах” гэж, 13.3.3 дахь заалтын “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын” гэж, 13.3.5 дахь заалтын “сургуулийн захирал” гэснийг “ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал” гэж, 13.3.6 дахь заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн

боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, 13.3.5 дахь заалтын “5” гэснийг “эхний 5 дахь жил болон дараагийн 3 дахь” гэж, 13.5 дахь хэсгийн “бүх шатны” гэснийг “бүх түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.2.2, 13.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.2.суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;

13.2.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Цэндийн Сандаг-Очир гишүүн үг хэлье.

Ц.Сандаг-Очир: 13 дугаар зүйл дээр багш ажилтны нийгмийн баталгаа дээр 13.3.5-д сум, тосгон, баг дахь төрийн болон төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийн эрхлэгч нарт 5 жил тутмын 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуул гэж байгаа юм. Тэгээд энэ дээр би бол нийслэл Улаанбаатар хотын алслагдсан 3 дүүрэг Налайх, Багануур, Багахангайг оруулах гэж байгаа юм. Энэ нь өөрөө эргээд 3 дүүрэг дээр бас л багшийн тогтвортой байдал, хүний нөөцийн дутагдалтай байдал гээд тэнд тогтвортой ажиллуулах тал дээр бас асуудал байгаа. Тэгээд төрийн албаны хуульд яг энэ заалт ороод 2024 оноос хэрэгжихээр тусчихсан байгаа учраас бас боловсролын хуульд энэ 3 дүүргийг бас оруулж өгөөч. Тийм учраас сум, нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх тосгон баг гэж ингэж оруулж өгөөч гэсэн ийм санал байна. Зарчмын зөрүүтэй саналаа албан ёсоор ажлын хэсэгт өгье.

Л.Мөнхбаатар: Үг хэллээ гэж ойлголоо. Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Дарга аа, энэ заалтыг дэмжиж байгаа юм. Түрүүн нэг ингээд нөгөө бидэнд чинь эхнээсээ ингээд явж байгаад түрүүн нэг чухал заалт яваад өгсөн байна лээ. Тэрийг эргэж хармаар байна. 14 дэх санал буюу 6.7 дахь заалт байхгүй юу. Боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна гээд. Заавал энийг хуульд тусгах хэрэггүй байхгүй юу. Сургууль бүр өөрийнхөө хөтөлбөрөөр явах ёстой байхгүй юу. Тэгэхгүй ингээд шууд хуульд тусгахаар энэ бол цаанаа 1 дүгээрт иргэдийн сурах эрхэд, нөгөө талаас нь Монгол Улсын аюулгүй байдалд нөлөөлнө. Тэгэхээр би бол юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Энх-Амгалан сайд аа, таны гаргасан тэр сургалтын хөтөлбөр агуулгаараа л явъя. Энийг заавал хуульд албан ёсны болгож ингэж суулгаж ерөөсөө болохгүй. Тийм учраас би бол юу гэж хэлэх гэж байна гэхээр энэ 6.7 дахь заалтыг та бүхэн эцсийн хэлэлцүүлэг дээрээ дахиж нэг авч үзээд, болж өгвөл энийг хасчихмаар байгаа юм. Заавал бид нар хуульд хэлийг онцолж, бичиж огт болохгүй ээ. Яах вэ, олон улсын мэдээж нэг номерын хэл гэдгээр нь ойлгож байгаа. Хуульд бичиж хэрэггүй. Сургалтын агуулга хөтөлбөрөөрөө л явъя. Тийм учраас Мөнхбаатар дарга аа, 14 дэх санал буюу 6.7 дээр нэг чиглэл өгчхөөрэй. Тэгээд ажлын хэсэг дахиж авч үзнэ биз ээ гэж би зориуд энэ саналыг хэлье гэж уг нь бодож байсан юм. Тэгээд нөгөө шуурга эхэлчихсэн шуурган дотор явж байгаад нөгөө саналаа хараагүй явуулчихсан байна. Энэ бол Монгол Улсын аюулгүй байдалтай холбоотой асуудал байгаа юм шүү. Түрүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн өглөө асуулт асууж, үг хэлэхдээ энийг тодорхой хэлчихлээ л дээ.

Л.Мөнхбаатар: Энхтүвшин гишүүн үг хэлье.

Т.Энхтүвшин: Баярлалаа. 5 жил тутам 6 сарын тэтгэмжтэй холбоотой ийм заалт орж ирсэн байна. Энийг заавал хуульд тусгах шаардлага байна уу, байхгүй байна уу. Ер нь Монгол Улсын Засгийн газраас ч гэсэн цалин хөлстэй холбоотой, урамшуулалтай холбоотой, тэтгэмжтэй холбоотой асуудлыг нэгдсэн журмаар шийдэж явъя гэдэг ийм асуудлуудыг л ярьж байгаа шүү дээ. Салбар болгоны хууль дээр ингээд 5 жил, 6 жилийн 6 сарын тэтгэмж өгнө гээд ингээд төрийн албан хаагчдыг хооронд нь ялгасан, ялгаварласан ийм асуудал чинь л яваад байгаа шүү дээ. Тэгэхээр цалин хөлс, урамшуулал, тэтгэмжтэй холбоотой асуудлыг Засгийн газар нэгдсэн журмаар оруулж ирээд ингээд явбал дараа нь төсөв төлөвлөгөө ч гэсэн батлахад амар юм биш үү. Тийм учраас одоо юу гэдэг юм онцгой байдал дээр гэхэд чинь бас байж байгаа шүү дээ. Алслагдсан бүс нутагт байж байгаа онцгой байдалд 5 жил 6 сарын тэтгэмж гээд биччихсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага гээд байдаг. Эсрэгээрээ хөдөө аж ахуй ч гэдэг юм уу, соёлын байгууллагууд дээр байхгүй байх жишээний гээд. Тэгээд хэрэв хийх гэж байгаа бол бүхий л хууль дээр Засгийн газар нэгдсэн журмаар тэр 5 жил алслагдсан бүс нутагт амьдарч байгаа болон бусад төрийн албан хаагч нартаа 5 жил тутамд нь 6 сарын тэтгэмж өгдөг заалтаа нийт төрийн албан хаагчдаа хийгээд ингээд хэрэгжүүлээд явбал илүү их үр дүнтэй юм биш үү л гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Мөнхбаатар дарга аа.

Б.Бат-Эрдэнэ: 26 дахь санал буюу төслийн 13 дугаар зүйлтэй холбоотой юм. Тэгэхээр төслийн 13 дугаар зүйл бол багшийн эрх үүрэг, багш, ажилтны нийгмийн баталгаа гэсэн бүлэг байгаа юм л даа. Түрүүн Энхтүвшин гишүүн тодорхой хэллээ. Ерөөсөө бидний зовлон

бол ийм л байгаа юм. Би Их Хурал дээр олон бүрэн эрхийн хугацаанд энэ асуудлыг л ярьж байгаа юм. Төрийн алба салбар болгоны нийгмийн хамгаалал, баталгаа, цалин урамшуулал, тэтгэмжтэй холбоотой юмыг ингээд л ерөөсөө 1 салбарын хууль оруулж ирэхдээ л ингээд л эвдээд л энд тэндээс нь сэглэсээр байгаад л оочин цоочин болгоод л тэгээд л ерөөсөө сүүлдээ бүүр учраа олохоо байсан. Тэгэхээр арга байхгүй багш нар энэ талбай дээр суухаас өөр үг байхгүй. Эрүүл мэндийн салбарынхан суухаас өөр үг байхгүй. Одоо дараа нь ямар салбарынхан суух юм. Соёл урлагийн салбарынхан суух гэж байх шиг байна лээ. Дараа нь биеийн тамирын салбарынхан гарна. Өөр арга байхгүй ийм нөхцөл байдал руу оруулаад байна. Манай биеийн тамирын салбарынхан бол 1990 оны жагсаал цуглаанаас эхлээд өнөөдрийг хүртэл аливаа юманд уужуухан тэсвэртэй, тэвчээртэй ингэж л хандаж ирж байгаа хүмүүс. Нийгмийн тогтвортой байдлыг хангах үүргээ биелүүлээд, тэр стадиондоо байдаг юм уу, спортын ордондоо байдаг юм уу биеийн тамир спортынхоо үйл ажиллагаанд бол үнэнчээр зүтгээд элдвийн юманд оролцохгүй л явж байгаа. Гэхдээ нийгмийн хамгаалал, баталгаа нь бүр хамгийн адагт нь. Тэгэхээр сая Засгийн газрын хурал дээр чинь ярьсан шүү дээ. Ерөөсөө салбар болгоны цалин, нийгмийн баталгаатай холбоотой юмыг ялгамжгүй байлгая. Хэт зөрүүтэй, ялгамжтай, тогтоочихсон салбаруудаа ойртуулах, ялгамжгүй байлгах ийм чиглэл рүү нь бодлого чиглэл гарья гэж байгаа юм. Нэг үгээр хэлэх юм бол нэг улс орон даяар энэ бүх салбаруудад үнэлгээ хийгээд, ингээд нэг цэгцэд нь орохгүй бол нөгөө чөтгөрийн тойрог гэдэг шиг энэ чинь хэзээ ч зовлон бол шийдэгдэхгүй. Ингээд л яваад байх ийм нөхцөл байдалтай. Түүрүүн Энхтүвшин гишүүн тодорхой санал хэллээ. Энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байна уу. Тодорхой нэг чиг хэлэх юм уу, яах юм. Засгийн газрын чиглэлээр. Тэгэхгүй бол ингээд л ерөөсөө дур

дураараа салбар болгон оруулж ирж ингэж өм цөм, энд тэндээс нь сэглэсээр байгаад энэ чинь ерөөсөө бүр болохоо больсон шүү. Зүгээр боловсролын салбарынхныхаа цалин, нийгмийн баталгаатай холбоотой юмыг нэмэхгүй авч үзэхгүй гэж байгаа асуудал биш шүү дээ.

Л.Мөнхбаатар: Үгүй ээ асуулт, хариулт биш л дээ. Үг хэлнэ. Дэмжсэн болон дэмжээгүй 3 хүртэл гишүүн л үг хэлэх боломжтой. Гишүүд үг хэлж дууслаа. Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл өгье. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн тэр 14 дэх санал хураалт дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя гэсэн. Энэ зүйл дээр Тогтохсүрэн гишүүний гаргасан саналын хүрээнд гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Ажлын хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт анхаарч, гүйцээн боловсруулъя.

Саяын санал хураалтыг томъёоллыг уншиж танилцуулсан. Одоо санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Г.Занданишатар: 58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш,” гэж, “саад учруулах” гэсний өмнө “зориуд” гэж нэмж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9, 13.10, 13.11 дэх хэсэг нэмэх.

“13.2.17.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18.ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль болон политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

13.9.Багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Ямар хэцүү боловсруулсан хүмүүс вэ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Нэг зүйл 5 гишүүн үг хэлэх юм бол өнөөдөр дуусахгүй. Маргааш дуусахгүй.

Б.Энх-Амгалан: 13.9 дээр багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно гээд биччихсэн. Тэгсэн хэр нь 12.17 дээрээ багш үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой аливаа хэлбэрийн гэрээ байгуулж нэмэлт орлого олж болно гээд заачихсан. Ингээд энэ чинь нэгхэн заалтын цаана нь ингээд нэг

нь зөвшөөрөөд, нэг нь хориглоод, нэг нь зөвшөөрөөд, нэг нь хориглоод ингээд яваад байж болох юм уу. Тэгээд одоо энийг чинь зөвшөөрөөд явуулчихвал өмнөхийг нь гүйцээн боловсруулах үүрэг өгчихсөн. Өмнөх чинь ороод ирнэ шүү дээ. Тэгээд алийг нь барих юм яг энэ хууль дээр чинь. Ингээд хууль чинь өөрөө ингээд боловсруулагдахдаа өөрөө ийм болчихсон байгаа байхгүй юу. Түүнээс энд нэг багшийн нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлс, урамшуулал нэмэхийг дэмжиж байгаа юм. Багш олдохгүй байна. Дэмжиж байгаа юм. Тэгэхээр энийг яаж зохицуулах юм энийг нэг хэлээдхээч. Энэ чинь 2 өөр заалт орж ирээд байна шүү дээ. Яг ингээд хуулийнх нь заалтаар унших юм бол багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно гээд л хэлчихсэн байна шүү дээ. Мааш тодорхой заалт. Тэгэхээр чи хуулиараа өөр ажил гүйцэтгэж болохгүй, нэмэлт орлого олж болохгүй гээд л ингэхэд нөгөө урдах заалт чинь уначхаж байгаа байхгүй юу. Үгүй ээ, ажлын бус цагаар гэдэг үг энд чинь алга байна шүү дээ. Алга байна. Багшийг хуулиар зөвшөөрсөн бусад ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно л гэсэн байна шүү дээ. Тайлбар аваадахъя. Та тэгвэл тайлбарлачих.

Г.Занданшатар: Тайлбар гэж байхгүй. Цэндийн Сандаг-Очир гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй үг л хэлнэ. Энх-Амгалан гишүүн дэмжээгүй үг хэлсэн.

Ц.Сандаг-Очир: Би 13.3.8 дахь заалтыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ энд сургууль, цэцэрлэгийн багш 15-аас доошгүй жил ажилласан багш нарт нэг хүүхдийг нь их, дээд сургуульд үнэгүй сургана гэдэг дээр насан туршийн боловсролын төвийн багш ажилчдын гэж оруулахыг хүсэж байна. Тэгээд саналаа ажлын хэсэгт албан ёсоор Байнгын хороонд хүргүүлэе.

Г.Занданшатар: Дэмжсэн үг хэллээ. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Нэг үг сольчихсон байх юм. Энэ одоо ямар ч утгатай үг юм бэ дээ энэ чинь. Ажил хаялт гэснийг суралцагчийн эрхийг зөрчих гэх юм. Энэ чинь ажил хаялт гээд энд ямар заалт байж байгаа юм. Ажил хаялт суралцагчдын эрхийг зөрчих эд нар гээд энэ чинь зүгээр нэг ажил хаялт гэдэг үгнээс зугтааж байгаа юм шиг л юм харагдаад байх юм. Тэрийг л гайхаад байна л даа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: 13.9 дээр багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил гүйцэтгүүлэхийг хориглоно гэж. Үгүй эе ер нь яг хуулиар зөвшөөрөөгүй багш нараар яг юу хийлгээд байгаа болоод ийм заалт орж ирж байгаа юм. Энэ чинь тэгээд хүчээр хөдөлмөр эрхлүүлээд байгаа юм уу, хөдөлмөрийг нь мөлжөөд байгаа юм уу, хууль бусаар ажил, хөдөлмөр хийлгүүлээд байгаа учраас ийм хуулийн заалт орж ирж байгаа болов уу гэж ингэж хараад байгаа юм. Нөгөө талаасаа тэр 12.17 дээр бол бас өөр ажил олгогчидтой гэрээ байгуулна гээд ингээд заагаад өгөхөөр ер нь ингээд багшийг ингэж болохгүй гээд. Тэгвэл дараа нь аягүй бол эрүүл мэндийнхэн эмчийг ингэж болохгүй, дараа нь төрийн захиргааныхныг ингэж болохгүй гээд салбарын хууль хууль дээрээ ингэж орж ирээд байвал чинь ер нь юу болох юм. Төрийн алба гэсэн малгай дотроо байгаад төрийн албан хаагчийг ингэж болохгүй гэсэн л нэг юм баймаар юм шиг санагдаад байгаа юм. Ингээд салбар салбарыг суга татсанаас болоод өнөөдрийн цалингийн сүлжээ чинь ийм утга нь олдохгүй юм болчихоод байгаа шүү дээ. Тэгээд 1 салбарын юм ярихаар л тэр салбарынхан таалагдахын тулд тэр салбарыг хайрлаж хамгаалаад байгаа юм шиг юм яриад байгаа юм. Би бол төрийн алба гэдэг том зургаараа хараад төрийн албан хаагчийг хууль зөрчүүлж болохгүй гэдэг юм руугаа ормоор байгаа байхгүй

юу. Тэгвэл багш илүү цагаар ажил хийж болох юм бол тэгвэл сумын Тамгын газрын малын эмч ажлын бус цагаараа мал тариад яваад байж болох уу. Ийм л юм орж ирнэ шүү дээ. Тэгэхээр энийг хэдүүлээ бас их бодолтой хандахгүй бол боловсролын хууль ярьж байгаа учраас боловсролынхондоо их хайртай хандана гэсэн байдлаар бас болохгүй байх. Төрийн алба гэсэн нэг ийм үндсэн малгай дотроо байя. Одоо ер нь Засгийн газраас тэр төрийн албаны цалин цагааг өсөөд сайжруулна л гэж ирээдүй цаг дээр сайн төсөөлөл байж байхад төрийн албаныхны цалин хүрэхгүй байгаа учраас гэдэг ийм ойлголтоор бас бүх юм руу хандаж болохгүй байх гэсэн ийм л бодол байна.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Бид нар бас Засгийн газар дээрээ яриад төрийн албан хаагчдын цалин хангамжтай холбоотой асуудлуудыг салбарын хуулиудаар ялгаатай тогтоомооргүй байна. Үүнтэй холбоотойгоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ч гэсэн бас мэдээлэл хийсэн байж байгаа. Энэ салбарын хуулиудаар ялгаатай тогтоогоод байхаар төр төрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бодлого боловсруулж төрийн захиргааны төв байгууллагуудад ажиллаж байгаа хүмүүсээ бүгдийг нь нэг ийм ялгаатайгаар хандаж байгаа юм шиг яг иргэдэд тусаад байгаа юм. Тэгээд хөдөө орон нутагт сая жишээлбэл босоо, хэвтээ гээд л цалин хангамж нь ялгаатай байсан. Дээрээс нь нэмээд л ахиад салбарын хуулиудаар боловсролын салбар чухал уу чухал. Тэгэхдээ айлын хүүхдийг өнөөдөр онцгой байдлын ажилд оруулаад үер лүү гал руу оруулчихаад та чухал биш ээ гэж хэлж болохгүй байхгүй юу. Тэгэхээр ингэж салбарын хуулиудаар цалин хангамжийнх нь асуудлуудыг ингэж тус тусад нь оруулж ирэхийг Засгийн газар дээр бид нар бас яриад удахгүй Улсын Их Хурал дээр энэ асуудал

бас танилцуулагдах байх. Тэгэхээр ингэж салбарын хуулиудаар үүнийг зохицуулмааргүй байна. Үүнийг манай ажлын хэсэг, Боловсролын сайд, Засгийн газрын гишүүний хувьд та сайн мэдэж байгаа байх. Яах вэ өмнө нь хуулиуд дээр нь байсан гэдэг биш сая хэд хэдэн гишүүд санал хэлснээр Төрийн албаны тухай хуулиа нэгдсэн байдлаар хэдүүлээ сайн болгоод, энэ асуудлаа шийдээд явбал яасан юм бэ гэдэг ийм саналыг хэлэх гэсэн юм. Тэгээд энэ дээр шаардлагатай бол Их хурлын дарга аа дахин боловсруулах чиг үүрэг өгөөч гэдэг саналыг гаргах гэсэн юм.

Г.Занданишатар: Дахин боловсруулах чиглэл өглөө. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Засгийн газар дээр ч ярьж шийдсэн. Одоо энэ цалингийн тогтолцоо хөрөөний ир, шүд шиг ийм ялгаатай болчихсон. Тэгээд боловсролын салбарын асуудал чухал. Гэхдээ ингээд нийгмийн баталгааны тэр асуудлыг замбараагүй болгож бол болохгүй. Ингээд дараагийн асуудалд орёё.

28.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3, 13.1.7, 13.2.13, 13.3.1, 13.3.2 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлийн 13.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 13.2.3 дахь заалтын “суралцагчийг идэвхжүүлсэн сургалтын арга зүйг сургалтад ашиглах,” гэснийг хасах.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61.7 хувийн саналаар санал дэмжлээ.

29. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 дэх заалтын “хэл зохиол” гэснийг “монгол хэл, уран зохиол” гэж, 14.4.4 дэх хэсгийн “ёс зүйн” гэснийг “ёс зүйн болон зан төлөвийн” гэж, “14.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын” гэж, 14.3 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол болон” гэснийг “мэргэжлийн болон техникийн,” гэж, “нарийвчилсан харилцааг” гэснийг “харилцааг” гэж, 14.5, 14.9 дэх хэсгийн

“шатны” гэснийг “түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.4, 14.6, 14.7, 14.8 дахь хэсэг, 14.4.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.4.Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, өмчийн хэлбэр харгалзахгүй боловсролын сургалтын байгууллага хэрэгжүүлнэ:

14.4.6.хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол;

14.6.Гадаад улсад монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулах, Монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг байгуулж болно.

14.7.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байна.

14.8.Цахим сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 14.2-т заасан хөтөлбөрт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Боловсролын сургалтын байгууллага нь” гэж, 14.4.3 дахь заалтын “жендэрийн” гэсний өмнө “хүний эрхийн боловсрол,” гэж, 14.4.9 дэх заалтын “сэргийлэх” гэсний дараа “талаар” гэж, 14.9 дэх хэсгийн “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.Санал хураалт. 68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “албан боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, мөн зүйлд доор

дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмэх.

“15.3.Албан бус боловсролын сургалтыг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага бүртгэж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “багшийн” гэснийг “эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дэмжлэг үзүүлнэ гэдэг тунхаглалын шинж чанартай санхүүгүй бол хэрэгжихгүй л заалтууд байх юм. 70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмэх.

“16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дадлага сургалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.” Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр найруулгыг нь анхаараарай. Тэр тухайн хуульд заасан техникийн зохицуулалтыг мөрдөнө гэж бичнэ шүү дээ. Заасны дагуу холбогдох техникийн зохицуулалт гэж техникийн зохицуулалтыг чинь энэ хуульд зааж байгаа шүү дээ.

34.Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”**-ийн нэрийг **“БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА”** гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн

найруулж, төслийн 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

“17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв болон сургалтын байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага байх бөгөөд дэргэдээ боловсролын сургалтын байгууллага, ажил олгогчийн түншил хамтын ажиллагаа хариуцсан төвтэй байна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохириц, нийцлийг шалгах, турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.4.1.энэ хуулийн 17.4-д заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас тохириц, нийцлийг шалгах, турших үед сонгосон цэцэрлэг, сургууль хэрэгжүүлэх;

17.5.Насан туршийн суралцахуйн төв нь хүний насан туршийн суралцахуйг чиглүүлэх, түгээн дэлгэрүүлж, дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын харьяанд байна.

17.5.1.энэ хуулийн 17.5-д заасан төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшиүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах;

17.5.2.эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага, эсхүл төрийн бус байгууллага гэрээгээр гүйцэтгэж болох бөгөөд шаардагдах зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

17.5.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших, тасралтгүй сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллуулж болно.

17.5.4.Дэмжих төвийн хүний нөөц болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

17.5.5.энэ хуулийн 17.6-д заасан төв нь сургалт, үйлчилгээний хамрах чиглэлээс хамаарч салбар дундын санхүүжилттэй байх;

17.6.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүрэгтэй байна.

17.7.Энэ хуулийн 17.8-д заасан үнэлгээ болон элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.8.Боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага нь сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасан байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, гадаадын хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийг бүртгэх, дүйцүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

17.10.Энэ хуулийн 17.8-д заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Хүрэлбаатарын Булгантуяа нараар тасаллаа. Содномын Чинзориг сайд гишүүнийг нэмлээ. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ. Гонгорын Дамдинням гишүүнийг нэмье.

Б.Бат-Эрдэнэ: Энэ чинь өнгө зүс нь их өөрчлөгдчихөөд байгаа хуулийн төсөл учраас асуух гээд байна. 3 дугаар бүлгийн нэрийг боловсролын байгууллага болгож өөрчилнө гээд байх юм. Тэгэхээр 3 дугаар бүлэг бол төсөл дээрээ боловсролын байгууллага тэдгээрийн ангилал гээд

байсан. Ямар учиртай ингээж өөрчилж байгаа юм бол. 3 дугаар бүлэг гэдгээ бүгд бүгдийг нь тэр чигээр нь авчхаж байгаа юм уу, эс үгүй бол 3 дугаар бүлэг тэгээд боловсролын байгууллага гэдгээрээ орж байгаа юм уу гэдэг нэг ийм асуулт байгаад байгаа юм.

Дараагийнх нь юм бол боловсролын байгууллага тэдгээрийн ангилал гээд боловсролын байгууллага 17 дугаар зүйл 17.1, 17.2 гээд байсан. Одоо энэ бол сая орж байгаа өөрчлөлтөөр чинь 17.6 лав хүртэл ингээд нэмэгдээд явчхаж байна шүү дээ. 17-гийн бүр 10 хүртэл явж байна. Тэгэхээр энэ дотор насан туршийн суралцахуйн төв нь хүний насан туршийн суралцахуйг чиглүүлэх, түгээн дэлгэрүүлж, дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяанд байна гэж. Энэ насан туршийн суралцахуйн төв гэж ямар байгууллага, юу байгуулагдах гээд байна. Ямар чиг юутай юм ороод ирэв. Тэрийгээ өөрчилж нэрлэж байгаа юм уу. Тэрийгээ нэг жаахан тодруулах уу. Сайхан нэртэй устай зөндөө олон зүйлүүд байдаг л даа. Тэгтэл үр дүн ямар байна вэ гэдэг дээр л энэ чинь ямар үр дүн юу гаргах гээд байгаа юм.

Г.Занданишатар: Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Асуулт, хариулт байхгүй. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Товч тодорхой.

Х.Булгантуяа: 17.5.5 дээр энэ хуулийн 17.6-д заасан төв нь сургалт үйлчилгээний хамрах чиглэлээс хамаарч салбар дундын санхүүжилттэй байна гээд. Энэ дээр Сангийн яамнаасаа юу авсан юм болов уу, үгүй юм болов уу. Энэ дээр тодруулга. Одоо бол төсөв чинь төсвийн ерөнхийлөн захирагч нарт л хуваагдаж байгаа юм. Тэгэхээр салбар дундын зохицуулалттай гэхээр Эрүүл мэндийн сайдынх байх юм уу, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дор байна гэж байгаа юм уу. Яг Боловсролын

сайдын дор байна гэж байгаа юм уу. Энэ чинь хаа нэгэн газар л харьяалагдаж таараа. Тэгээд салбар дундын санхүүжилттэй зохицуулалт гэж миний мэдэхээр бол байхгүй л баймаар юм. Ийм байгууллага. Энийг яг яг яаж явуулъя гэж байгаа юм бол. Энийг хармаар байх юм.

Тэгээд манай боловсролын багц хууль бид нар бас нэлээн удаан ажилласан их чухал хууль л даа. Тэгээд эцэс сүүлд нь энэ хууль нэг англи хэл, хувийн сургууль байх уу, үгүй юу гэдэг ийм л асуудал дээр сүүлдээ гол маргаан яваад байх юм. Уг нь эсрэгээрээ боловсролын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, боловсролын салбар маань дэлхийн түвшинд хүрсэн Монгол хүнийг бэлдэж гаргах гэдэг гол агуулгуудаасаа заримдаа бид нар ингээд нөгөө нэг ийм жижиг, сажиг сошиалын юманд автагдаад явчих гээд байх шиг байх юм. Тэгээд энэ дээр эс үгүй бол ингээж байгаад нэг ийм хүн ойлгохгүй олон заалтуудаар аваад гарчихъя гэж бодоод байгаа юм уу бас гайхаад байх юм. Энэ чинь уг нь нийгэмд их тийм чухал ач холбогдолтой хууль болох гээд байдаг. Тэгээд маш олон дэмжинэ. Манай олон хуулиуд тийм шүү дээ. Тийм тунхгийн шинж чанартай. Дэмжинэ, халамжилна, хайрлана гээд. Тэгээд өөрийнхөө салбарыг дэмждэггүй, халамжилдаггүй, хайрладаггүй сайд ч гэж юу байх вэ. Тэгэхдээ ингээд явах юм бол их л хавтгайрсан дараагийн тийм хавтгайрсан хууль л болох гээд байдаг. Тэгэхээр дундын санхүүжилттэй байна гэдгийг чиглэл өгөөд Сангийн яамнаас байдаг юм уу тодруулга авах уу Их хурлын дарга аа. Харин тийм. Одоо бол би үүнийг асуусан юм. Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа доор явж байгаа юм байна лээ. Бид нар Боловсролын яамнаас, Эрүүл мэндийн яамнаас хүмүүс оруулж ажиллуулах бол сонирхол байгаа. Тэгэхдээ одоогоор дундын санхүүжилтийн тогтолцоо гэж одоогоор тухайн нэг төсвийн ерөнхийлөн захирагчид л хамруулна уу гэхээс биш энэ байгууллага бол та 3 3-уулаа

санхүүжүүлнэ шүү гэдэг тийм тогтолцоо байхгүй байгаад байгаа юм байна л даа. Тэгэхээр харин үүнийг Сангийн яамнаасаа нэг тодруулах уу л гэж л асуугаад байгаа юм.

Г.Занданиатар: Содномын Чинзориг гишүүн. Сайд нар санал нэггүй байвал ер нь буцааж татаад, Засгийн газар дээрээ ярьж нэг болгох хэрэгтэй.

С.Чинзориг: 17.5.1 дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших, тасралтгүй сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх төвийг яамнуудтай хамтран ажиллуулж болно гээд байгаа юм. Би бас энэ дээр гайхаад байгаа юм. Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд л боловсрол олгох асуудал нь байх ёстой. Харин тэр шаардлагатай бол Эрүүл мэндийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж бас ажиллаж болно гэдгээр бас томъёоллыг нь өөрчлөх юм уу. Тэгэхгүй бол хамтран ажиллуулж болно гэдэг чинь байгуулж бас болохгүй л байна л даа. Тэгвэл хамтран байгуулах тухай асуудал яриад байгаа юм уу. Суурь боловсрол олгох асуудал нь боловсролын сайдын эрхлэх асуудлын асуудал мөн. Харин тэр эрүүл мэндийн болоод Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дэмжлэг авч ажиллуулах, мэргэжлийн зөвлөгөө авч ажиллаж болно гэдэг томъёоллоор ажиллуулах юм уу. Энийг эргээж хармаар байх юм.

Тэр 17.5 чинь дундын санхүүжилттэй байна гэдэг асуудал бол одоо Төсвийн тухай хуулиараа болохгүй шүү дээ Дамдинням гишүүн ээ. Одоо төсвийн ерөнхийлөн захирагч сайд чинь өөрийнхөө багцад туссан асуудлыг өөрийнхөө тэр багцдаа л санхүүжүүлнэ. Төсвийн ерөнхийлөн захирагчаас нөгөө төсвийн ерөнхийлөн захирагч руу төсөв шилжүүлэн зарцуулах эрх бол бид нарт бол байхгүй шүү дээ Дамдинням гишүүн ээ. Тэгээд энийгээ яаж зохицуулах юм.

Үндсэн төсөв нь Боловсролын сайдын багцдаа тусаад явах юм уу эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусаад явах юм уу эсвэл Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайдын багцдаа тусаад явах юм уу. Энийг нэг талд нь шийдэж өгөхгүй бол дундын санхүүжилт гэсэн асуудал. Энэ чинь сүүлдээ тэгээд төсвийн хуультай зөрчөөд, төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд санхүүжилт хийхийг чинь бол хориглодог шүү дээ Төсвийн тухай хуулиар. Энийгээ Төсвийн тухай хуультайгаа нийцүүлж авч үзэхгүй бол аль нэг талд нь шийдэхгүй бол болохгүй шүү дээ.

Г.Занданиатар: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: 1 дүгээрт би түрүүн Раднаасэд гишүүний хэлснийг бас сануулчихмаар байна. Засгийн газраас өргөн барьсан хууль. Засгийн газраас өргөн барьсан хуулийг ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Тэр тусмаа манай Чинзориг гишүүн бол манай ажлын хэсгийн гишүүн шүү дээ. Ажлын хэсгийнхээ хуралд сууж байх хэрэгтэй шүү дээ. Тэгээд орж ирээд шүүмжлээд байх юм. Тэгээд зүгээр Боловсролын байгууллага гээд байгаад бол бид нар боловсролын салбарын бүхий л байгууллагаа хамруулж оруулж байгаа юм. Тэр Булгантуяа сайдын яриад байгаа юм бол хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудал юм байгаа юм. Салбар дундын санхүүжилтийн асуудлыг Сангийн яамтай, Боловсролын яам урьдчилсан байдлаар зөвшилцсөн. Урьдчилсан байдлаар зөвшөөрчихсөн байгаа. Одоо ч гэсэн салбар дундын санхүүжилтийн асуудал байдаг юм байна лээ шүү дээ. Боловсролын яаман дээр. Эрүүл мэнд, Боловсролын 2-ын дунд уламжлалт анагаах ухааны эрдэм шинжилгээний төв гээд байж байна. Байгууллагын нэгэн дээр нь заавал байна гэсэн тийм ойлголт бол байхгүй л юм байна лээ. Тэгэхээр энэ жишигийн дагуу л орж ирж байгаа юм.

Болохгүй юм ерөөсөө байхгүй. Тэгээд байгаа юм дээр нь л хийж байгаа юм. Тэгээд тусгай сургууль, цэцэрлэгүүд байгаад байгаа. Эд нардыг концепцынх нь хувьд дэмжих төв болгоё л гэж байгаа юм. Хөөрхий хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан л заалт л даа. Байхгүй юм биш ээ. Тэгээд ийм л байна. Гишүүд дэмжээд өгвөл сайн байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн горимын санал гаргана.

Б.Пүрэвдорж: Хуулийн төслийг 2021 оны 6 сард буюу Хүрэлсүхийн Засгийн газрын үед өргөн барьсан байна. Тэгээд тэрнээс хойш шинэ Засгийн газар байгуулагдсан байна. Тэгээд давхар дээлээр баахан шинэ сайд нар томилогдсон байна. Энэ хугацаанд Эдийн засгийн яам гээд ер нь бол хуулиар гарч байгаа үр дагавраар ямар эдийн засгийн үр дагавар гарч байгааг тооцоолдог яам шинээр байгуулагдсан байна. Тэгээд энэ дотор сууж байгаа сайд нар нь тал тал тийшээ зарим нэгэн заалтыг авч давхиж байна. Ажлын хэсэг сайн сайн, багш нарт ээлтэй олон олон заалтуудыг оруулсан боловч зарим нэгэн заалтыг унагааж байна. Тийм учраас Монгол Ардын намын бүлэг, дарга нар, сайд нар хоорондоо учраа олтол Ардчилсан намын бүлэг 7 хоногийн завсарлага авлаа.

Г.Занданишатар: Туваан гишүүнээ орлож байгаа юм уу. Тэгвэл тэгээд 7 хоногийн завсарлага гэж байхгүй л дээ. 5 хоногийн завсарлага. Завсарлага өглөө Ардчилсан намын бүлэгт. Энэ юмнуудынхаа учрыг ол. Тэгэхгүй бол ингээд салбар дундын санхүүжилт гэдэг чинь Төсвийн тухай хуулиар байхгүй шүү дээ. Төсвийн нэг л ерөнхийлөн захирагч байна.

Дараагийн асуудалд орно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Төсөл санаачлагч байхгүй учраас, хууль санаачлагч байхгүй учраас асуудлыг хойшлууллаа.

Дараагийн асуудал орно. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Зочин орж ирнэ. Гишүүд суудлаа сууцгаая. Ганибал гишүүн хамт явж байгаа л даа. Гишүүд суудалдаа суугаарай.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Улсын Их Хурлын урилгаар албан ёсоор Монгол Улсад айлчлал хийж байгаа Унгар Улсын Үндэсний Ассамблейн дарга эрхэмсэг Ноён Көвер Ласло тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж байна. Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хамгийн сайн сайхныг хүсэн ерөөж, Монгол Улсад тавтай зочлохыг урьяаа.

16.16 цаг.

Гурав.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна аа. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Ард түмний төлөөлөх эрхийн илэрхийлэл болсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль Монголын ард түмэн бид хэмээн эхэлж, мэдэгтүн, сахигтун гэсэн үгээр төгсдөг билээ. Энэ нь Үндсэн хуулийн үг үсэг, цэг таслал бүхэн гүн гүнзгий утга илэрхийлж бүх нийтээрээ нийгмийн соёл эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэхийн төлөө эрмэлзэх агуулгатай.

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална хэмээн заасан байдаг. Эл агуулгаар Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд бол эрх мэдэлтэн, албан тушаалтан гэхээс илүү олон нийтийн үйл хэрэг, нийгмийн сайн сайхны төлөө өөрийн сайн дурын үндсэн дээр иргэдийг төлөөлж буй ард түмний элч, төр иргэнийг холбосон итгэлцлийн гүүр юм.

Улс орнуудын урагшлан хөгжсөн, уруудан доройтсон түүхэн сургамжуудын үндэс ч төр, иргэний итгэлцлийн цөм болсон авлигаас ангид засаглалтай шууд холбоотой байдаг нь ойлгомжтой. Ард түмнээ төлөөлөх эрхэм үүргийг хувийн эрх ашгаа хангах эрх мэдэл хэмээн андуурсан авлигачид, тэдний эрх ашгаар томилогдсон бусармаг этгээдүүдийн харалган үйлдлээс болж, ардчилсан эрх зүйт төрийн амин сүнс болсон хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын нэр хүндийг унагаж буй үйлдлүүдийг нэн яаралтай

таслан зогсоож, төр, иргэний итгэлцлийг эргэн сэргээж чадахгүй бол авлига л ардчилсан парламентын засаглалын аминд хүрэх аюултай юм.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд өмч хувьчлалаас эхлээд ашигт малтмалын лицензүүд, нийслэл Улаанбаатар хотын газрын наймаанаас эхлээд төрийн тендерүүд, Хөгжлийн банкнаас эхлээд жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл, нүүрс, зэсийн хулгай зэрэг олон асуудалд төрийн өндөр дээд албан тушаалтнууд оролцож, өөртөө болон гэр бүл, хамаарал бүхий этгээдүүддээ давуу байдал олгож, төлөөлөх ёстой иргэдийнхээ өнөөдрийн болон ирээдүйн болгоомжийг хулгайлсан ноцтой баримтуудыг Монгол Улсын Засгийн газар ил болгож системийн авлигын эсрэг тууштай тэмцээр байна.

Монгол Улсын Засгийн газрын энэхүү бодлогыг дэмжиж Улсын Их Хурал хаврын чуулганаа авлигын эсрэг чуулган байх болно хэмээн тодорхойлсон Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танд болон энэхүү шударга ёсны үйлсийг тууштай дэмжиж буй парламентын эрхэм гишүүд, төрийн түшигэд та бүхэндээ баярлалаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тусгаар тогтнол ардчиллын амин сүнс болсон хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалыг хамгаалж, өнгөрсөн 30 жилийн алдаа завхралыг цэглэж, ард түмний ашиг сонирхлыг дээдэлсэн иргэний төлөөлөх эрхийг жинхэнэ утгаар хангасан, ёс зүйн манлайллаар хүлээн зөвшөөрөгдсөн шинэ 30 жилийг эхлүүлэх түүхэн үүрэг хариуцлага өнөөдрийн парламентын гишүүд та бидэнд ноогдож байна.

Ёс суртахуун, сахилга хариуцлага, ардчилсан эрх зүйт, төрийн нийгмийн манлайлал та биднээс, энэ танхимаас эхлэх учиртай. Ингэж чадахгүй бол баталсан хууль тогтоомжоо ягштал мөрдөхийг төрийн албан хаагчдаас ард

түмнээсээ бид хэрхэн шаардах билээ. Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлаж, авлигын гэмт хэргийг илчлэн шүгэл үлээж, хууль зөрчсөн албан тушаалтнуудыг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэж, хилийн чанадад оргон зайлсан авлигачдыг эргүүлэн авчрах шувуу ажиллагааг зохион байгуулж, оффшор бүс болон гадаад улсад нуун дарагдуулсан хууль бус хөрөнгийг шилжүүлэн авчрах, төрийн байгууллагыг ил тод шилэн байдлыг хангах зорилго бүхий “5 ш” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Олон жил салаалж ургасан, суурь нь газрын хөрснөө бэхжиж томорсон системийн авлигын аварга том царс мод нүд ирмэх зуур нурчихгүй нь ойлгомжтой. Худал мэдээллээр олон нийтийг төөрөгдүүлэхээс эхлээд хууль шүүхийн байгууллагад шигтгэсэн хувалзуудаараа цаг хугацаа хожих, улмаар хулгайг хамгаалах зохион байгуулалттай тогтолцоо үүсгэх зэргээр авлигын эсрэг тэмцлийг саармагжуулахын тулд бүхий л эцсийн мэхээ хэрэглэх болно. Бусад улс орнуудын авлигатай хийсэн тэмцлийн түүх ч ийм л байсан. Гагцхүү бид тууштай байж энэхүү тэмцэлд ялалт байгуулах учиртай.

Мэдээлэл ил тод, нээлттэй болж, иргэд мэдээлжин, хэрсүүжих тусам авлигын систем задран унасаар байх болно. Зөв зүйл үнэн байдал ялах нь цаг хугацааны л асуудал байдаг нь ардчилсан, нээлттэй засаглалын хамгийн том давуу тал билээ. Шинэ сэргэлтийн бодлогын төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд авлигын эсрэг эрх зүйн багц шинэчлэлийг эхлүүлж, Үндсэн хуулийн өөрчлөлт, Улс төрийн намын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүх байгуулах тухай хууль болон

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг та бид хамтдаа энэхүү хаврын чуулганаар хэлэлцэн батлах болно.

Өнөөдөр энэхүү багц эрх зүйн шинэчлэлийн хуулиудын нэг болох Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурал, Засгийн газраас өргөн барьж байна. Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол улсын ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга болон түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, хамаарал бүхий этгээдүүд нь төрөөс болон төрийн өмчит компани төртэй хамтран хэрэгжүүлж буй олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрөөс санхүүжих бүх төрлийн худалдан авалтад оролцох, аливаа хөнгөлөлттэй зээл, тусламж, тэтгэлэг, батлан даалтад хамрагдахыг тус тус хуульчлан хориглохоор тусгалаа.

Энэхүү хуулийн төсөлд дурдагдсан албан тушаалтнуудаас гадна Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намын дарга нар Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч нар, Улсын ерөнхий прокурор, Төрийн албаны зөвлөл, Монгол банк, Сонгуулийн ерөнхий хороо, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар зэрэг Улсын Их Хурал болон

Засгийн газарт ажлаа тайлагнадаг байгууллагуудын дарга, орлогч нар тэдний хамаарал бүхий этгээдүүдэд мөн адил үйлчлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Энэхүү хууль батлагдсанаар улс төр бизнесийн эрх мэдэл зааглагдаж төр нь төр шиг бизнес нь бизнес шиг байх. Мөн цаашид энэхүү хууль батлагдсанаар ирээдүйн олон улс төрчдөд өнөөдрийн нөхцөл байдал давтагдахгүй байх томоохон дархлаа болно гэж бас үзэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданишатар: *Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьяа танилцуулна. Индэрт урьж байна.*

Ш.Адьяа: *Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 3 сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч улс төрд нөлөө бүхий этгээдэд хамаарах субъектэд Монгол Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадагаас гадна, танилцуулдаг байгууллагын дарга, тэдгээрийн орлогч нарыг нэмж эдгээр албан тушаалтан болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд бүх хэлбэрийн тендер шалгаруулалтад оролцохгүй байх. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол улсын ерөнхий

сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн, эсхүл түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, төрөөс хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр, эсхүл төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байхыг хориглох, эдгээр хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээд болон эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг parliament.mn цахим сайтад байрцуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэсэн бөгөөд уг хуулийн төсөлтэй нэгтгэж хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг заалтад заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй зөрчилдөж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, хуулийн төсөлд хүний сонгох, сонгогдох эрхэд хязгаарлалт тогтоох эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан гишүүдэд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хориглолт, хязгаарлалт үйлчилдэг бөгөөд

түүний хамаарал бүхий этгээдийг сурч боловсруулах эрхэд хязгаарлалт үйлчлэхээр заасан Үндсэн хуулийн зөрчил мөн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг нэр бүхий гишүүдтэй хамтран санаачлан боловсруулж, батлуулж байсан бөгөөд энэ хуулийг баримтлан ашиг сонирхлын зөрчлийн хэмжүүр шалгууртай болсон талаар онцлоод, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа бөгөөд улс төрд нөлөө бүхий этгээдэд давуу байдал олгох нөлөөллөөс ангид байлгах санаа зөв боловч хэлэлцүүлгийн үед төслийн зарим заалт Үндсэн хуулийн зөрчил байгаа эсэхийг дурдсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Хуулийн төслийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасны дагуу эрх зүйн дүгнэлт гаргуулах асуудлаар, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасны дагуу горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Мөнхдэлгэрийн Цолмон, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга Батмөнхийн Баярсайхан.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээс тасалсугай. Цэвэгдоржийн Туваан гишүүн асууна.

Ц.Туваан: Энэ хуулийн төслийг дэмжиж байна. Одоо ингээд ард түмний амьдрал үнэхээр хүнд байна. Хэцүү байна. Ард түмний ч гэлтгүй төрийн захиргааны байгууллага, ер нь цалинтай ажил хийж байгаа хүмүүс ч гэсэн ерөнхийдөө маш хэцүү байна. Яагаад хэцүү байна гэхээр тэд нар юмны үнэ

өндөр байна. Авч байгаа цалин хөлс нь амьдралд хүрэхгүй байна. Товчхондоо хэлбэл ажиллаж байгаа хүмүүс нь ажиллангаа ядуурал руу яваад байна. Малчид өнөө хавар бүр онцгой хүнд нөхцөлд байна. Яагаад гэхээр энэ өвөл ойрын хэдэн жил тохиолдоогүй хатуу өвөл болсон. Саяын 4 сар бол ер нь нэг ч өдөр өөдөлсөнгүй. Маш хэцүү хавар болж байна. Малын хорогдол бол мэдээлэгдэхгүй л байгаа болохоос биш нэлээн их хэмжээтэй гарч байна. Товчхондоо хэлэх юм бол бид нар бэлчээрийн доройтол, цөлжилттэй бүр нүүр тулаад ирсэн байна. Гамшиг явж байна. Ногоочид, тариаланчид ч гэсэн ер нь хаврын тариалалт даа бэлтгэж байгаа ч гэсэн маш олон зовлонгуудыг ярьж байна. Тэгэхээр энэнээс гарахыг бол би маш амархан гэж харж байгаа. Ер нь бол. Тэгэхээр яагаад амархан гэхээр Монгол Улс хавар хачиг хувалздаа баригдсан хамуутай төлөг ч юм уу борлон шиг болоод байна. Энэ нь юу вэ гэхээр энэ бол системийн авлига гэж ингэж харж байна. Саяын ерөнхий сайдын үгэнд ч гэсэн гарч байна.

Цалин хөлсний асуудал дээр гэхэд өнөөдөр сая Боловсролын хууль орж ирээд явж байгаад завсарлага авлаа. Тэгэхээр ерөөсөө бүх юм ялгамжтай. Ямар байгууллагад ямар сайдтай, ямар байгууллагад байгаагаас шалтгаалаад цалин хөлс, тэтгэмжүүд бүгд ялгамжтай ондоо, ондоо. Боловсролын байгууллагын багш нарын үндсэн цалин, эрүүл мэндийн байгууллагын үндсэн цалин 2 хоорондоо 200 мянган төгрөгийн зөрүүтэй байх жишээтэй. Ингээд хаа хаагүй нэг иргэдээ бухимдуулсан, алагчлалтай, шударга бус юмнууд яваад байна. Тэгэхээр ийм шударга бус, тэгш бус, алагчлалтай, ялгамжтай ийм зүйлд ард түмэн маш бухимдалтай байна. Дарга нар Монголын төрд байгаа дарга нар, төрийн өндөрлөгүүд, Их Хурлын гишүүд, сайд нарт дургүй байна. Яагаад гэхээр энэ дээр өөрсдөө иргэд маань ядуу байгаа учраас тэнд бас ажиллаж байгаа дарга, цэрэг арми илүү амьдарч байна,

баян амьдарч байна гэдэгт үнэхээр дургүй байна. Тэгэхээр өнөөдрийн энэ хууль бол энэнээс нэг алхам ч гэсэн холдсон ийм асуудалд оруулж ирж байгаад нь үнэхээр их талархаж байна.

Тэгээд дээрээс нь бид нар ер нь түрүүн би хэлсэн энэ байдлаасаа гарах нь Монгол төрийн эн тэргүүний зорилго байх ёстой. Гарахад бол маш амархан. Системийн авлига, системийн хээл хахууль, асуудлууд л задарчих юм бол ийм том газар нутагтай, ийм цөөхөн хүн амтай, ийм ариун мал сүрэгтэй ийм орон бол ард иргэд нь баян чинээлэг амьдрахад үнэндээ болохгүй гэх юм алга. Тэгэхээр энэ асуудал руу чиглэсэн ийм хуулиуд орж ирж байна гэдэгт дахин талархал илэрхийлье.

Тэгээд тэр хамрах хүрээн дээр нэг хууль санаачлагчаас яг тодорхой яаж оруулж ирж байгаа юм бэ. Ямар, ямар албан тушаалтнууд нэр заагдаж орж ирж байгаа юм бэ. Энэ цаашаа бас хамрагдах албан тушаалтнууд нэмэгдэх үү. Тэгээд ер нь бол бас дарга гээд даргын гэр бүл, хүүхэд гээд бас нэг ялгамжлагдах Үндсэн хуулийн концепцтой зөрчилдөх асуудал байна уу гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Туваан гишүүний асуултад хариулъя. Бид нар парламентад сонгогдоно. Засгийн газрын гишүүн байна гэдэг агуулга уг нь Үндсэн хуулиараа энэ бол төлөөлөх эрхийн мандат. Харамсалтай нь маань нэг тийм эрх мэдлийн төвлөрөл юм шиг ойлгогдоод ингээд олон жил явчихсан учраас тэгээд олон асуудалд нэр бүхий улс төрчид холбогдоод, сүүлийн 30-аад жил янз бүрийн ийм асуудал болсон учраас ерөөсөө л яах гэж сонгогддог юм. Өөртөө давуу байдал олгох гэж сонгогддог юм байна. Яах гэж сонгогддог юм. Тендерт орох гэж сонгогддог юм.

байна гэдэг нэг ийм агуулга руу нийгэм өөрөө орчхоод байна л даа. Тэгэхээр энийг бид нар л цэг тавихгүй бол цаашидаа парламентын засаглал, цаашидаа яг төлөөлөх эрхтэй холбоотой яг энэ асуудал ард түмний итгэлцлийн гүүр энэ бүх зүйл ингээд маш тийм хүнд байдалд орно. Ингээд удвал бол энэ бол өөрөө парламентын засаглалд үл итгэсэн ийм нийгмийн том уур амьсгал улам бэхэжнэ. Тэгэхээрээ олон удаагийн сургамж боллоо. Энийг зүгээр хуульчлаад ингээд хаачихъя л гэж байгаа юм. Төр, улс төр нь тусдаа бизнес нь тусдаа байх ийм том агуулга өнөөдөр ингээд тавигдаж байна гэсэн үг. Парламентад орж ирснээрээ бизнестэй хүмүүст бол хуулиар хүндрэл л учирна. Төрийн ямар ч тендерт оролцохгүй. Мөн ингээд төрийн өмчит компаниудын ямар ч тендерт оролцох боломжгүй болно гэдэг бол тухайн хүн улс төрд оролцохын тулд гэр бүлтэйгээ, компанийнхаа удирдлагуудтай нэлээн уулзаж, ярилцаж нухацтай шийдвэр гаргах хэрэгтэй л болно. Урд нь бол парламентын гишүүн байна гэдэг бол өөрөө бараг өөртөө давуу байдал олгох ийм лобби боломж гэж хардаг байсан энэ ойлголтыг л хэдүүлээ хамтдаа цэглэчихье л гэж байгаа юм. Цэглэчихье. Жинхэнэ иргэдийн төлөөлөх агуулгаараа гээд. Тэгээд яах вэ, энэ дээр албан тушаалтан гээд нэлээн олон нэрүүдийг бид нар бас дурдсан. Яах вэ хэт хавтгайруулж болохгүй гэдэг ийм агуулга бол бас байгаа. Тэгэхлээрээ өнөөдөр бол нэлээн тийм өргөн агуулгаар өргөн баригдаж байгаа. Улсын Их Хурал өөрөө эцэслэн шийдэх онцгой бүрэн эрх бол байж байгаа. Гэхдээ ингэж байж л ер нь бол юм цэгцэрнэ. Ингэж байж авлигын олон скандал цаашидаа гарахгүй байх ийм хамгаалалт болно. Бас энэ бол нэг талаараа ирээдүйд олон төрийн албан хаагчдыг, олон төрийн түшээдийг болзошгүй эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж байгаа ийм эрх зүйн орчин гэж бас үзэж болно. Бусад улсуудад бол эрх ашгийг зохицуулах ийм conflict of interesting эд нар гээд ийм бодлогууд

хуулиуд бол байдаг. Тэр жишигт л бидний хувьд оруулах ийм агуулгаараа нэмэлт, өөрчлөлт хийж байгаа. Тэгээд цаашидаад бид нар нэмээд явах ийм боломжууд өргөн байж байгаа. Хамгийн гол асуудал бол сан, зээл, тэтгэлэг гээд л их олон асуудлууд, энэ бүх зүйл дээр эрхийг нь хязгаарлачхаж байна л гэсэн үг. Тэгэхээрээ Улсын Их Хуралд сонгогдохоосоо өмнө Засгийн газрын гишүүн болохоосоо өмнө төрийн өндөр албан тушаалд ажиллахаасаа өмнө нухацтай шийдвэр гаргах тэр сонголтыг өгч байгаа л ийм агуулгатай хуулийн концепц юм гэж ойлгож болно.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьшаа: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Би Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд төрөөс баталгаа гаргасан зээл, хөтөлбөрөөс улс төрд хамаарал бүхий этгээдүүд авахыг хориглосон хуулийн төслийг өргөн бариад Улсын Их Хурал дээр хэлэлцэхийг дэмжсэн ийм дэмжлэг авсан байгаа. Монгол Улсын Засгийн газраас энэ хуулийг их олон хэлбэрээр өөрчлөх гэж оруулж ирсэнд би бас их талархалтай хандаж байгаа юм. Энэ хуулийг бол баталж гаргах нь өнөөдөр нийгмийн шаардлага байгаа шүү. 30 жилийн хугацааны булхай, луйвар илэрч, тендер, төсвийн хөрөнгө мөнгөөр бизнес хийдэг. Улс төрд нөлөөлөл бүхий хүмүүс өөрсдийн хамаарал бүхий компаниудаар дамжуулж мөнгө угаадаг, амьдралын эх үүсвэрээ бий болгодог ийм гажуудлыг бид засах нь Монголын ард иргэдийн зүгээс шаардаж байгаа. Улс төрийн өнөөдрийн тогтолцоонд гарсан гажуудлыг засах ийм бодлого гэж ойлгож байгаа. Өнөөдөр энэ хэлэлцүүлгийн явцад зарим Улсын Их Хурлын гишүүдээс Үндсэн хууль зөрчсөн, хүний эрх зөрчсөн байна гэдэг ийм юм яриад байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх ярихаас өмнө бид Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөсөн хүмүүс. Нийт улсын ашиг сонирхлыг хүндэтгэнэ. Нийт улсын ашиг сонирхлын өмнө хууль дээдлэх зарчмын өмнө бид үүрэг биелүүлэх л гэж тангараг өргөсөн. Үнэхээр тэр эрх ашиг нь зөрчигдөөд, өөрийнх нь ах дүү, хамаатан садан, үр хүүхдийнх нь эрх, ашиг зөрчигдөөд байвал энэ өндөр албан тушаал хашихаа больчих. Сонголт нь байгаа шүү дээ. Тэр Үндсэн хууль зөрчсөн асуудлын юу ч байхгүй. Дээр нь Монгол Улс өнөөдөр авлигын эсрэг конвенцид нэгдэж орсон. Олон улсынхаа өмнө хүлээсэн үүргээ Монголын төр биелүүлэх ёстой. Өнөөдөр нийгэмд шударга ёсыг, хууль дээдлэх зарчмыг шаардаж байгаа шүү дээ. Тийм учраас энд тэр Үндсэн хууль зөрчөөд миний үр хүүхдүүд, хамаарал бүхий компаниуд сонгогдох, сонгох эрх, албан тушаал дэвших эрх зөрчигдөөд байгаа бол нийт улсынхаа ашиг сонирхлын өмнөөс, нийт ард иргэдийнхээ өмнө тангаргаа хүлээгээд тэр Их Хурлын гишүүнээс, Засгийн газрын гишүүнээсээ, тэр өндөр албан тушаалаа хашиад тэр тендерээ хийгээд, бизнесээ хийгээд л төр төсөл хөтөлбөртөө хамрагдаад явах нь нээлттэй байгаа. Тийм учраа энд тэр Үндсэн хууль зөрчсөн хүний эрх гэдэг юмыг бид нийт улсын ашиг сонирхлын өмнөөс энд зарчимтай хандаж, энэ хуулийг баталж явах нь шударга ёсонд, нийгмийн шаардлагад өнөөдөр нийцнэ гэж үзэж байгаа. Ийм учраас энэ хуулийн төслийг өргөн барьсан. Харин Монгол Улсын Засгийн газраас энийг өргөтгөсөн хэлбэрээр орж ирж, хэлэлцүүлэг хийж, нэлээн хэсэг гацаж байж орж ирсэн гэж үзэж байгаа. Өргөн баригдаад 2, 3 сар болсон. Тэгээд янз бүрийн шалтгаан байдал л биз. Гэхдээ энийг зайлигүй баталж гаргах нь өнөөдөр төрд итгэх итгэл гэдэг юм чинь үүнээс л эхэлнэ шүү гэдгийг хэлье. Ингээд энэ хуулийн төслийг хэлэлцэж, дэмжихэд өөрийн биеэр хүчин чармайлт гаргаж ажиллана гэдгээ хэлье.

Г.Занданшатар: Санал хэллээ. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Миний бие Ерөнхий сайдын санаачилсан энэ хуулийг дэмжиж байгаа. Ер нь энэ захын хайлтаас манай улс төрийнхний эрх мэдэлтнүүдийн төрийн алба хамгийн чухал албан тушаалтнуудад мөчирлөн томилогдсон энэ ургийн модны төгс төгөлдөр загварыг бид харсаар, нийгэм жигшсээр удсан. Тэгээд энийг халахын тулд энэ хуулийг оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Энэ агуулгаар нь миний хувьд бас дэмжиж байгаа юм. Байнгын хороо дээр хэлэлцэх үед бас хүний эрхийн асуудлыг хөндөх эсэхийг анхаарах ёстой гэж бас үзэж байна. Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар баталгаажуулсан хүний ажил мэргэжлийг чөлөөтэй сонгох эрх зөрчигдөх вий. Цаашилаад шийдэгддэггүй маргаан болж хувирах вий, хэрэгждэггүй хууль болох вий гэдэг тал дээр хууль санаачлагч болон Байнгын хороод анхаарлаа хандуулна биз. Чуулганы завсарлагааны хугацаанд миний бие Сэлэнгэ аймагт ажиллаад ирсэн. Ард иргэдтэйгээ уулзаад ирж байхад ер нь нийтлэг хэд хэдэн асуудлуудыг тавьж байгаагийн хамгийн чухал асуудал нь бол энэ албан тушаалтнууд тэр дундаа төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүйтэй, сахилга хариуцлагатай байх асуудлыг хамгийн хатуу шаардаж байгаа асуудал байгаад байгаа юм. Ер нь би хувьдаа бол ёс зүй гэдэг бол хувь хүний улс төрчийн өөртөө бий болгох сонгодог засаглал гэж бол ойлгодог. Ер нь мэдээлэлд ойр, эрх мэдэлд ойр байгаа ойрын ач тусаар ч гэх үү эсвэл хар гайгаар ч гэж үзэх юм уу бүх шударга бус томилгоо, ар өврийн хаалганы дэвшүүлэлтийг бол төрийн эрх мэдэлтнүүд өөрсдөө хийж ирсэн. Өнгөрсөн хугацаанд мэдээлэлд ойр, нөлөө бүхий албан тушаалтан боломжийг илүү их хүртэж ирсэн гэдэг нь бол сая Энхбаяр гишүүний хийсэн нээлттэй сонсголын үед бол маш тодорхой харагдсан. Хөгжлийн банк, Жижиг, дунд

үйлдвэрийг хөгжүүлэх сан, нүүрсний гээд ард түмний өмч баялгийн өнгөтэй өөдтэй бүхнийг цөлмөсөн энэ бүх асуудлуудтай улс төрд нөлөө бүхий этгээдүүд холбогдож бүр ёс зүйгээс хальж, энэ нь өөрөө гэмт хэргийн бүлэг дээрмийн шинжтэй болж иржээ. Тэгээд энэ бүхнээс улс орны хөгжил ухарч байна. Олон нийтийн төрд итгэх итгэлгүй болж байгаа ийм нөхцөл байдалтай болж байна. Тийм учраас бол өөрсдөө шударга бусыг хийчхээд ард түмнээс шударга ёс, тэгш эрхийг нэхэх нь ямар ч боломжгүй зүйл юм гэдэг энэ зүйлтэй бол би санал нэг байгаа. Тийм учраас миний бие ёс зүй сахилга хариуцлагыг дахин дахин яриад байгаа юм. Ер нь дахиад хэлэхэд ёс зүй гэдэг бол хувь хүний улс төрчийн өөртөө бий болгох сонгодог засаглал. Тийм ч учраас хуулийн төслийг би хувь хүнийхээ хувьд үнэхээр дэмжиж байгаагаа бас илэрхийлье гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Асуулт биш байна. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Харин зарим нэг гишүүдийн өргөн барьсан төслийг гайхаад байгаа. Тэгээд хулгайч хүн хулгайчийг бариарай гэж хаширдаг. Авлигач хүн авлигачтай тэмцэнэ гэж ярьдаг. Тэгээд энийг би жоохон гайхаад байгаа юм л даа. Тэгээд иймэрхүү юм бас байж болохгүй байх. Тэгээд ер нь хуулийн төсөл бол зөв. Уулын мод урттай, богинотой. Олон хүн сайнтай, муутай. Олон жил юу гэдэг юм би бас тендер, концесс, Хөгжлийн банк гээд л хэлүүлж байгаа. Яг үнэндээ эргэн тойронд гэр бүл, үр хүүхэд, ах дүү, хамаатан садан бүгд л зүдэрдэг юм байна лээ. Зовдог юм байна лээ. Тэгээд хууль зөрчөөгүй, хулгай хийгээгүй болохоор тухай бүрд нь шалгуулаад хамааралгүй байна гэдэг нь тогтоолгочихсон. Сүүлдээ ах дүү нар, гэр бүлийнхэн бүр төртэй холбоотой бизнес хийхээ больсон. Огт хамаагүй

болсон л доо. Сүүлийн 5, 6 жил 1 ч тендер аваагүй байна. 1 ч төрийн өмчит компанид шахаа хийгээгүй байна. Хөгжлийн банкны зээл цементийн үйлдвэр байгуулахад оролцоогүй, би нөлөөлөөгүй байна. Гэтэл намайг л нөлөөлчихсөн юм шиг хардаад л, хартай хүмүүс нь өөрөө хулгай хийдэг хүн хартай байдаг л даа. Тэгээд л хардаад л ингээд хуулийн төсөл санаачилсан юм шиг байгаа юм. Энэ хууль эргэж үйлчлээсэй харин. Эргэж үйлчлээсэй. Тэр хулгайч хүн хулгайчийг бариарай гэж хаширсаар байгаад 76 хулгайч болчихсон. 76 хулгайч бид нар. Энэ 76-уулаа хулгайч биш ээ. Энэ дотор цөөхөн хулгайч байгаа. Тэр цөөхөн хулгайч нарыг ил тод болгохын тулд энэ хуулийг эргэж үйлчлүүлээр байна. Эргэж үйлчлэх үү. Энийг бас асууя 1 дүгээрт.

2 дугаарт нь бас зарим хүн хүний эрхийг бас хязгаарлах юм биш байгаа. Нөгөө сурч боловсрох эрх. Одоо юу гэдэг юм Төрийн өндөр албан тушаалтны хүүхэд гэхээрээ сурч боловсрох эрхгүй байж болохгүй, эрхийг хязгаарлуулж болохгүй байх. Төрийн өндөр албан тушаалтны гэр бүлийн хүн гэхээрээ төрд ажиллахгүй байж болохгүй байх. Энийг уг нь бас нэг харж үзмээр байгаа юм. Харчихмаар байгаа юм. Эргэж бодох ёстой юм шиг байгаа юм. Яагаад хамааралтайгаар, шууд хамааралтай ажиллахгүй төрд ажиллаж болно шүү дээ бас. Ганцхан төрд шахаа хийдэг, төрийн өмчит компанид шахаа хийдэг, сайд дарга нарын үүдийг онгойлгоод, шантаачлаад гүйж байгаад төсөл, тендер авдаг. Төрийн өмчит компаниудаар явж баахан шахаа хийдэг. Нүүрсний хулгай хийдэг. Энэ бол байж болохгүй. Энэ бол албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглаж болохгүй. Төрийн хамааралтай, төсвийн хамааралтай тендерт оролцож болохгүй. Төрийн өмчит компанид шахаа хийж болохгүй. Энэ бол зайлигүй байх ёстой. Их Хурлын гишүүд сонгогдохдоо уулыг эргүүлнэ, усыг нураана. Би ёстой төр түмэндээ шударгаар ажиллана гэж

сонгогддог. Тэгээд сонгогдсон хойноо эрх мэдэл, албан тушаалаа ашиглаад байхаар чинь ард түмэн төрд итгэх итгэл нь унаад, биднийг үндсэндээ 76-уулаа хулгайч гэдэг болсон байгаа юм.

Тийм болохоор энийг ялгаж, салгахын тулд энэ хууль байх ёстой. Хэлсэн үгэндээ хурдэг байх ёстой. Тэр өргөсөн тангарагтаа үнэнч байх ёстой. Хэн нь тийм биш вэ гэдгийг энэ хууль бас ялгаж, салгаж өгөөсэй. Энэ үүднээсээ асууж байгаа асуулт маань энэ хуулийг эргээж үйлчилдэг баймаар байна. Ингэх юм бол эндээс бас хөөрхөн юмнууд гарч ирнэ. Хулгайч нь хэн байна. Хулгайч биш нь хэн байна гэдэг нь харагдана. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Г.Занданишатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Хууль эргээж үйлчилж болох эсэхийг бол сайн мэдэхгүй байна. Нямбаатар сайд магадгүй энэ дээр дэлгэрэнгүй хариулж болох байх. Зүгээр нэг ийм өнцөг байгаад байгаа юм л даа. Улсын Их Хурлын гишүүд бол иргэдтэй адилхан, Засгийн газрын гишүүд бол иргэдтэй адилхан. Тийм учраас Үндсэн хууль зөрчих гээд байна гээд. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүд бол иргэдтэй адилхан биш л дээ. Иргэдээс хамаагүй давуу байдалтай шүү дээ. Халдашгүй байдалтай. Иргэн бүхэн халдашгүй байдал байхгүй. Мэдээлэл авах эрхтэй. Тийм учраас нэгэнт парламентын гишүүд, Засгийн газрын гишүүд иргэдээсээ хамаагүй давуу эрх мэдэлтэй юм чинь иргэдээсээ хамаагүй давуу хариуцлагыг хүлээх нь шударга ёсонд нийцнэ.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүн бол өөрийн сайн дурын үндсэн дээр таныг төлөөлье гэж байгаа нийтийн албан тушаалтан. Хэн ч Их Хурлын гишүүнийг хүчээр сонгоогүй. Өөрөө сайн дурын үндсэн дээр би таны сайн сайхны төлөө үйлчилье. Би таны

сайн сайхны төлөө таныг төлөөлье гэж байгаа л албан тушаалтан шүү дээ. Тийм учраас нэгэнт сайн дурын үндсэн дээр энэ шийдвэрийг гаргаж байгаа юм бол сайн дурын үндсэн дээр гэр бүлийнхээ гишүүдтэйгээ ярилцаад, өөрийнхөө хувийн компани, өөрийнхөө хувийн давуу байдлыг албан тушаал сахиж байх үедээ татгалзах нь ёс зүй байхгүй юу. Харамсалтай нь ёс зүйгээр зохицуулагдахгүй байгаа учраас арга буюу хууль орж ирж байна гэсэн үг. Гэхдээ энэ маань өөрөө цаашидаа парламентын нэр хүнд, Засгийн газрын нэр хүнд, мөн парламентад төлөөлье гэж байгаа яг Үндсэн хуулийн агуулга жинхэнэ агуулгаараа хэрэгжихэд туйлын чухал ач холбогдолтой ийм нэг соёлын эхлэл цэг тавигдаж байна гэж бидний хувьд үзэх ёстой. Улсын Их Хурлын гишүүний, Засгийн газрын гишүүний компани төрөөс тендер авчихлаа гэж бодъё. Тэр шударга явж. Гэхдээ хэн итгэх вэ. Нөлөө үзүүлээгүй гэдэгт. Эхнэр нь хамт ажиллаад байдаг. Салбарын сайд байдаг. Салбарын сайдын доод албан тушаал дээр эхнэр нь очоод ажиллаад байдаг. Яаж удирдах вэ.Тэр төрийн өмчит компанийн захирал орой очоод гэр бүлтэйгээ уулзаад суугаад байхаар.Тендерийн сонгон шалгаруулалт хийе гэж бодъё. Яаж үнэн зөв хийсэн гэдэгт иргэд итгэх вэ. Ийм асуудал өөрөө эрх мэдэл хэт төвлөрөөд байна гэдэг маань өөрөө 76 гишүүн миний төлөөлөл биш, 76 гишүүн бол дарга гэж хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ойлголтоо бидний хувьд буцаах нь Үндсэн хуулийнхаа яг зарчим дээр аваачаад илүү Улсын Их Хурал бол Улсын Их Хурлын гишүүн бол миний төлөөлөл. Засгийн газар бол тэр төлөөлөл дундаас сонгогдсон миний төлөө үйлчлэх ёстой албан тушаалтан гэдэг харах ийм концепц л өөрөө хамгийн чухал байгаа юм. Энийг бид нар цаашаа хийхгүйгээр бол улам л хүндэрнэ. Эдийн засаг тэлнэ. Тэлэх тусам ашиг сонирхол нэмэгдэнэ. Улам их Улсын Их Хурал руу орох гэсэн хүсэл эрмэлзэл, лобби нэмэгдэнэ. Энийг хязгаарлачихвал жишээлбэл томоохон

бизнестэй хүмүүсийн хувьд бол сонголт үнэн шүү дээ. Хэн заавал энд орж ирж суу гээд байгаа юм.

Тэгэхээрээ яг Үндсэн хуулийнхаа суурь концепц дээрээ л ирэх нь зүйтэй юм. Нэг үгээр хэлбэл энийг Засгийн газрын түвшинд ч бай, Их Хурлын түвшинд ч бай бид нар өөрсдөө манлайлж байж бид бидний баталсан хуулийг мөрд гэж төрийн албан хаагчдад хэлэх ёс зүйн эрх үүснэ. Бид иргэддээ.../минут дуусав/

Г.Занданишатар: Цогт-Очирын Анандбазар гишүүн асуулт асууна.

Ц.Анандбазар: Баярлалаа. Төрд ажиллана гэдэг бол эрх мэдэл авахын тулд ажилладаг гэж ойлгодог хүмүүс байдаг байх. Тэгэхдээ төрд ажиллахдаа юм бүтээж, улс орон нийгмийг хөгжүүлэхэд маш чухал байдаг ийм туршилага бүхий хүмүүс гэж ер нь байдаг. Сингапур Улс, Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс гээд олон оронд хувийн хэвшлийн өндөр боловсролтой хүмүүс ажиллаж байж, тэр улсууд хөгжсөн ийм түүхтэй байдаг. Тэгээд ер нь хуулийг хийхдээ хараад байхад дараа нь хуулийн байгууллага мушигж ашиглаж болохоор ийм заалтууд их хийх юм. Ажлын хэсэгт орсон хүмүүс Нямбаатар сайд маань энийг бас их бодож бодож ажилламаар байна. Энэ заалт дээр их олон янзын давхар санаа байна л даа. Яаж ч мушигж болохоор. Төрд ажиллаж байгаа хүмүүсийн сонгодог жишээ бол Сингапур улсын төр байдаг шүү дээ. Сайд нь том бизнесмен хүн байдаг н Нэрийн хуудасныхаа ард сахрын үйлдвэрийн эзэн гээд биччихсэн байдаг. Ингээд сонирхлын зөрчлөө өөрсдөө хязгаарлаад явдаг. Их Хуралд сууснаас хойш би нэг зүйлийг ерөөсөө ойлгохгүй байгаа. Их Хурлын гишүүн гэдэг бол хулгайч, худалч, муу бүхний толгой юм шиг ийм байдлаар ярьдаг асуудал хэрээс хэтэрлээ. Яг үнэндээ бизнесменүүд шиг шударга хүмүүс их ховор байдаг юм. Монголын нийгэмд. Асар их хөдөлмөрлөж

байж тэр 1990-ээд оны үеийн бизнесменүүд чинь өнгөрсөн шүү дээ. Одоо маркетингтай, мэдлэгтэй, боловсролтой, чадалтай ийм залуучууд улс нийгмийг, энэ төсвийн бүрдүүлэлтийг чинь бүрдүүлж байдаг. Хувийн хэвшил Монгол Улсын нийт төсвийн 80 гаруй хувийг бүрдүүлж байна. Юм болгоныг хааж хорино гэдэг ийм попорсон хууль хийснээрээ ерөөсөө сайн үр дагавар авчрахгүй ээ. Жишээ нь би нэг жишээ хэлье. Монгол Улсын Засгийн газрын нэр нүүр болсон нефтийн үйлдвэрийг би 2016 онд ахалж ажиллаж байсан. Манай Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд мэдэж байгаа байх. 6 сарын дотор 1 тэрбум долларын зээлийг бүтээж, цэвэр усны нөөц, дэд бүтэц, төмөр зам, авто замын ажлыг эхлүүлсэн. Тодорхой улс төрийн шалтгаанаар энэ төслийг удирдахгүй байх ийм чиглэл ирсэн учраас хөндийрсөн. 2023 он гарчхаад байдаг, энэ үйлдвэр ороогүй байна. Уг нь үйлдвэр ашиглалтад 2022 онд орох байсан. Төр гэдэг бол хувийн хэвшил төрийн туршилагатай хүмүүсийн хамтын бүтээл байх ёстой. Микрофон харахаараа энхийн цагаан тагтаа шиг ярьдаг. Хумсаа нуусан ийм дүртэй хүмүүсээс харин төр хол байх ёстой юм. Насаараа зүтгэчихээд унаж чадахгүй машиныг нь хулгай хийгээд уначихсан өндөр үнэтэй машин унаад явж байдаг төрийн албан хаагчид байна шүү дээ. Тэр хүмүүстэйгээ зүйрлэж ярьдгаа болимоор байгаа юм. Шударга ёс гэдэг бол хааж хорихоор тогтдоггүй юм. Шударга ёс гэдэг бол хууль мөрдөхийг л тогтдог. Тэр тендерийн тухай хууль чинь байна. Төрийн албаны тухай хууль чинь байна. Асар олон төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс ах дүү, хамаатан нь ажилгүй болно шүү. Надад бол төрийн албанд ажилладаг ах дүү, хамаатан байхгүй. Нэг их мундаг юм хийж байгаа юм шиг ингээд хамаагүй нэг тийш нь авч яваад, дараа нь энийг нь хуулийн байгууллагынхан ашигладаг ийм гох дэгээ болгоод, хүнийг мушигадаг, янз янзаар гүтгэдэг ийм юм руу ороод байна шүү дээ. Хөгжилд саад болсон хууль хийхээ болимоор байгаа юм. Би хууль

хэтэрхий олон төрж гараад, Монгол Улсын хөгжлийг чөдөрлөөд байна гэж боддог хүн. Энэ байдал чинь Монгол Улсын хөгжлийг гацаадаг ганц юм болоод байна. Яах вэ ерөнхий санааг бол ойлгож байна. Ийм хууль гарчих юм бол тэр төрд юм шахдаг хүмүүс байхгүй болно л гэсэн санаа.../минут дуусав/

Г.Занданишатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

Л.Оюун-Эрдэнэ: 1 дүгээрт Сингапурт гишүүд нь төрийн өмчит компанид аливаа тийм бүтээгдэхүүн нийлүүлдэг зүйл бол үнэхээр байхгүй шүү. Байхгүй. Харин ч бүр ил тод нээлттэй байгаа. Сингапурт би Хэрэг эрхлэхийн сайд байхдаа ч очиж байсан. Ерөнхий сайд болоод ч айлчилсан. Энэ айлчлал дээр нийтийн эрх ашиг, сонирхлыг зохицуулахтай холбоотой олон асуудлуудыг бидний хувьд бол суралцаж, бас үлгэр жишээ авах ёстой улс орнуудын юм бол нэг мөн үү мөн. Тэнд төрийн албаны цалин өндөр байгаа. Гэхдээ ямарваа нэгэн байдлаар жишээлбэл ашиг сонирхол бол огт давхцахгүй тийм л байгаа. Тэгэхээр урагшлан хөгжсөн бүх л улс орнууд том том эдийн засагтай ашиг сонирхлоо тодорхой хэмжээнд ил тод болгож байж далд эдийн засгаа багасгаж байж л урагшилсан. Тэгэхгүй бол нэг хэсэгхэн хүмүүс далд эдийн засгаар бүх зүйлийг удирдаж жолоодно гэдэг ийм концепцоор бол аль ч улс орон явахгүй. Урагшлан хөгжсөн, уруудан доройтсон улс орнуудын 100 гаруй кэйстэй том бүтээл байдаг. Бид бүгдээрээ мэднэ. Бүгдээрээ л далд эдийн засаг ийм жам ёсны биш ийм тогтолцооноосоо болоод л иргэд нь төрдөө итгэхээ болиод л ингээд л дампуурсан. Тийм учраас харин бол өнөөдрийн их тийм чухал зааг юм. Мэдээж парламент дээр олон талаас нь шүүн хэлэлцэх ёстой. Эцсийн мөчид батлах, хэрхэн батлах, эсэх нь бол гагцхүү Их Хуралд энэ онцгой эрх хадгалагдаж байгаа.

Тэгэхээр бидний хувьд энийг зөв, буруу гэхээс илүүтэйгээр ер нь биднийг төлөөлүүлж сонгосон ард иргэд маань энэ ёс зүйн манлайлал дээрээсээ эхлэхийг л хүсэж байгаа гэдгийг л бид нар ухамсарлан ойлгомоор байгаа юм. Тэгэхгүй энэ танхимаас бид нар энэ хэм хэмжээг зохицуулахгүйгээр цаашилаад бид нар дунд, анхан шатанд энийг хэвшүүлнэ гэдэг бол үнэндээ бараг боломжгүй ойлголт шүү дээ. Хэн ч дагахгүй шүү дээ. Яаж торгуулиа төл гэж хэлэх юм. Яаж хууль жишээлбэл мөрд гэж хэлэх юм. Яагаад гэхээр энэ чинь өөрсдөө нүдэн дээр нь ийм эрх ашиг болоод ийм олон асуудлууд болоод ингээд байгаад байхад. Тэгэхээр энийгээ хэдүүлээ цэгцлээд, төрд Их Хурал төлөөлж сууна гэдэг бол эрх мэдэл биш бол үйлчилж байгаа иргэдийн төлөөлөл болж тангараг өргөж байгаа юм гэдэг концепц руугаа бид нарын хувьд буцахгүй бол хэчнээн шударгаар Их Хурлын гишүүд тендер авлаа гээд тэрийг яг шударгаар нээлттэй тэр тендерийг авсан гэж ер нь хэн итгэх юм бэ. 76-хан хүн байж байдаг. Тэгэхээр энийг бид нар цэгцлэхгүйгээр цаашаа бас явж болохгүй ээ. Тэгээд энийг олон жил хэдүүлээ ярьсаар л ирсэн. Одоо хэдүүлээ энэ ёс зүйн өндөрлөг дээрээ, энэ манлайллын төв цэг дээрээ өөрсдөө байж байж ингэж байж бас Монголд эрх зүйт төр тогтоно. Төр иргэний итгэлцлийн гүүр эргэж сэргэнэ. Төрд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ. Ингэж байж дунд, анхан шатанд авлига байхгүй болно. Энийг Их Хурлын гишүүд маань агуулгаар нь ойлгох ёстой.

Дээрээс нь гишүүний ярьж байгаа нэг зүйлтэй бол санал нэг байна. Тэр нь юу вэ гэхлээр ер нь төрд энэ данхайсан төрийн өмчит компаниуд их мөнгө бол эргэх нь бол буруу. Бид нар энийг хувийн хэвшил рүүгээ шахаж гаргах ёстой. Төр өөрийнхөө л нийгмийн сайн сайхны төлөөх тэр үйлчилгээг л үзүүлэх ёстой болохоос биш төр заавал давхар бизнес хийгээд байх ийм зорилготой байгууллага бол огт биш. Ийм олон 4 хүн тутмын нэг

нь ажилладаг байх ёстой газар ч бас биш.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Засгийн газраас өргөн барьсан хуулийг бол дэмжиж байгаа юм. Тэгээд бид нар өнөөдөр төрийн албанд дээрээс нь нэмээд улс төрд хүмүүс яагаад ингэж ажиллах гээд байдаг юм, орох гээд зүтгээд байдаг юм, энд аягүй их ийм мэдээлэл ил тод байх ёстой мэдээллүүдийг та бүхэн түрүүлж аваад, ашиг хонжоо хүртээд байгаа юм биш үү гэдэг ийм хардалт хүмүүсийн дунд маш их байгаад байгаа юм. Гэхдээ яах вэ хүн болгон, төрийн албан хаагч болгон авлига ч биш ээ. Гишүүн болгон хээл хахууль аваад, авлига, хээл хахуульд идэгдээд байгаа юм биш ээ. Гишүүн болгон, улс төрч болгон, өндөр албан тушаалтан болгон төрийн сангуудыг тоноод байгаа юм биш ээ. Эндээс бүгдээрээ ашиг хонжоо хүртэх гэж очоогүй ээ. Гэхдээ ийм болгохын тулд би гишүүдийн тоог нэмэх асуудлыг ярьж байгаа юм болов уу гэж би ойлгоод байгаа юм. Европын зарим улс орнуудад гишүүний гудамжинд явж байхад ч таньдаггүй. 300 гаруй хүнтэй хэн ч тоохгүй. Зүгээр л өөрөө алхаад л, дугуйгаа унаад л, ажилдаа очоод л, ажилдаа суугаад л, бичиг цаастай ноцолдоод л зүгээр л жирийн ажилтан. Зүгээр л жирийн яг ард түмний төлөөлөл. Тийм байх ёстой юм байна лээ. Одоо бид нарыг ингээд нөгөө хүмүүс юу гэж хардаад байна вэ гэхээр ийшээ ингээд л зүтгээд л байдаг. Энд нэг л аягүй том ашиг сонирхол л байх шиг байна. Эндээс ямар нэгэн юм олж хүртэх гээд л байх шиг байна. Тийм болохоор л ийшээ зүтгээд байна гэж хардаад байдаг юм шиг байгаа юм. Тэгээд 4, 5 мянган еврогийн цалинтай хүн 20 хэдэн мянган еврогоор би сонгуулиа хийдэг гэж ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр тийм болгохын тулд магадгүй гишүүдийн тоо олон болоод байдаг юм уу, тэгээд сонгуульд гишүүн болно гэдэг нэг их

сонирхолтой биш болоод, Улсын Их Хурал зүгээр л мэргэжлийн, салбар салбарын хүмүүсийн, жирийн эмч нарын, багш нарын, малчдын, хөдөө аж ахуйн салбаруудын төлөөлөл болох юм бол жинхэнэ шударга ёс тогтох болов уу гэж би бодож байгаа юм. Жинхэнэ шударга ёс тэнд тогтох ёстой. Тэгэхийн тулд магадгүй өнөөдрийн хууль бол хэрэгтэй байх. Тэгээд авлигатай ийм хатуу тэмцэнэ гэгчхээд бид нар хаа нэгэн газраас эхлэх ёстой. Нөгөө өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэдэг шиг. Бид нар өөрсдөө хамгийн түрүүнд дээрээсээ л үлгэрлэхээс өөр аргагүй болчихоод байгаа юм. Тэгээд магадгүй би бол үүнийг ийм шилжилтийн үеийн хатуу зохицуулалт юм болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд ёстой жинхэнэ жирийн ард түмний төлөөлөл нь ороод ирэхээр 20, 30-хан сая төгрөгөөр жишигээр 20, 30 сая төгрөгөөр хүн 2, 3 жилийнхээ цалингаар сонгуулиа хийдэг болчихсон байгаа цагт жирийн яг ард түмний төлөөлөл Улсын Их Хуралд орж ирээд суусан гэж ард түмний итгэл төрсөн цагт харин таны хүүхэд боловсролын зээлийн сангаар сурч болно. Таны нөхөр бизнес хийдэг бол тэндээс хөнгөлөлттэй зээлд хамрагдаж болно ч гэдэг юм уу ингээд буцаагаад зохицуулалт хийгээд тавьж болох байх. Одоо бол ингэж хийхээс өөр аргагүй ийм нөхцөл байдал бас үүсчхээд байгаа юм болов уу гэж гэж бодоод байгаа юм.

Тэгээд би Нямбаатар сайд манай олон улсын авлигын индексийг бууруулах ажлыг Засгийн газар дээр ахалж байгаа юм. Тэгээд Транспаренси интернэйшнл дээр ер нь энэ асуудлаар Монгол Улсын бидэнд ер нь ямар зөвлөгөө өгсөн юм бэ. Бусад улс орнууд энийг хийвэл манай авлигын индекс хэрхэн яаж буурах юм бэ. Бид нар энийг бууруулахгүйгээр үнэнийг хэлэхэд улс эх орон, эдийн засаг хөгжинө гэдэг хэцүү юм байна лээ. Яагаад гэвэл энэ чинь нэг жижигхэн ертөнц дотор эд нар маш их авлигач шүү, хулгайч шүү, хуурамч шүү гэгчхээр хэн бид нартай бизнес хийх юм бэ. Яг л бид нартайгаа

таарсан бас л нэг юм юм хийчихээр зөв бурууг айхгүйгээр хийчихээр ийм хүмүүс бид нартай ирж бизнес хийх гээд байгаа байхгүй юу. Бүх зөв, буруу мөнгийг эс үгүй бол байршуулдаг газар болчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Монгол Улс олон улсад өөрсдийнхөө нэр хүндийг өсгөхийн тулд ялангуяа олон улсын авлигын индексийг бид нар бууруулах хэрэгтэй байгаад байдаг. Тэр нь бид нар үнэнч шударга улс, хамтран ажиллахад асуудалгүй улс гэдгийг бид нарт уг нь дэлхий даяар зарлан харуулах гээд байгаа юм. Тэрнийг бид нар өөрөө өөрсдөө хэчнээн яриад нэмэргүй л дээ. Ингээд л олон улсын байгууллагууд чинь нэг индекс гаргаад л үнэлээд л дуусаа. Тэгээд энэ хуулийг баталбал энэ асуудал бид нарт тус нэмэр болох уу. Үүн дээр ямар зөвлөмж өгсөн юм бэ гэдгийг Нямбаатар сайдаас асуух гэсэн юм.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Трансперенси интернэйшнл олон улсын байгууллага улс орнуудын авлигын төсөөллийн индексийг гаргадаг. Монгол Улс 2022 онд авлигын төсөөллийн индексээр НҮБ-д бүртгэлтэй 180 орноос 116 дугаар байранд байр эзэлсэн байгаа. Авсан оноо 33 оноо. Авлигын төсөөллийн индексийг уг байгууллага гаргахдаа нийтдээ 13 индикаторуудаас мэдээллүүдийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, тооцоолол хийсний үндсэн дээр улс орнуудын төсөөллийн индексийг гаргадаг. Жишээлбэл нэг индикатор нь гэхэд Дэлхийн банк байгаа. Дэлхийн банкны Монгол Улсын шалгуур үзүүлэлтийг гаргадаг нийт өгсөн зөвлөмжүүд 49 зөвлөмж байгаа. Ингэхээр бид нар 13 байгууллага ойролцоогоор 40-50 ийм Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа байдлаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийг гаргадаг. Өнгөрсөн жилийн тайлан илтгэлд дурдсанаар Монгол Улсад дараах зөвлөмжийг өгсөн.

1 дүгээрт байгалийн баялгийн хуваарилалтыг тэгш шударга хийх, олон нийтэд хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтаа боловсронгуй болгох,

2 дугаарт нийтийн албан тушаалтнуудынхаа хандлага, хандлагыг өөрчлөх,

Дараагийн дугаарт төрийн худалдан авалтынхаа ил тод байдлыг бий болгох,

Төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулах,

Иргэдийн үндсэн эрхийн хэрэгжилтийг хангуулах тал дээр Монгол Улсын Засгийн газрыг 2023 онд томоохон ахиц гаргана гэсэн ийм хүлээлттэй байдлаар өнгөрсөн оны тайлан илтгэлийг гаргасан байгаа.

Бид өнөөдрийн байдлаар 7 хоногт ойролцоогоор 1 байгууллагад индексийн талаар мэдээллүүдээ хүргэдэг ийм тогтолцоог бий болгоод явж байгаа. Засгийн газар, Их Хурлаас гаргаж байгаа шийдвэрүүд Трансперенси интернэйшнл олон улсын байгууллагын тэр мэдээллүүдээ хуваалцдаг олон улсын байгууллагуудад бид нар жил, сар болгон 7 хоног болгон мэдээллээ шинэчилж өгдөг ийм шинэ системийг бүрдүүлээд ажиллаж байгаа гэдгийг товчхондоо хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хуулийг дэмжиж байгаа. Тэгэхдээ хамгийн гол нь энэ хуулийг батлахаас өмнө ч гэсэн өөрөөр хэлбэл өнгөрсөн дөө 7 жилийн хугацаанд сөрөг хүчний үүрэг гүйцэтгэхдээ яг энэ агуулгаар бүх асуудалд өөрийгөө ямарваа нэгэн сонирхлын зөрчилгүй ажиллаад ирж болсон гэдгийг бас 1 дүгээрт хэлье гэж

бодож байна. Ер нь бол сөрөг хүчний гишүүд бол ийм асуудалд оролцох тийм нөхцөл бол байхгүй л дээ. Яагаад гэвэл тэдний хамаатан садан төрийн өндөр албан тушаалд ажиллаад байгаа юм ерөөсөө алга. Тэгээд Нямбаатараяа, 1 зүйлийг хэлэхэд бол нэг ийм юм байгаа юм. Суучих. Тэгэхээр 1 зүйлийг хэлэхэд бол миний хамаатнууд бол ингэж л боддог. Пүрэвдорж ингээд нэг Их Хуралд явж байна. Үгээ хэлээд явж байна. Үгүй ээ, хажуугаар нь ороод л янз янз болоод л, тэгээд л нэг жижиг сажиг албанд ажиллаж байгаа хүмүүс байна. Тэд нар бол ерөөсөө Пүрэвдоржийн нэрийг л гаргачихгүй юм сан гэсэн бүр ингээд тэр чигээрээ миний төлөө ингээд байдаг. Хэл аманд оруулчихгүй юм сан. Чөлөөтэй тэр үгээ хэлээд явж байг гэдэг байдлаар. Тэгээд ер нь бол Их Хурлын гишүүдийн хамаатнууд ерөнхийдөө тийм байдаг юм. Үгүй ээ, манай тэр эгч тийм л, тэгээд болохгүй байна энэ тэр гэдэг ч юм уу ингээд тэгдэг байхгүй юу даа. Тэгэхээр гол асуудал юун дээр гардаг вэ гэхээр найз нөхдийн сүлбээн дээр их гараад байгаа юм. Найз нөхдийн сүлбээ. Өөрөөр хэлбэл найз нөхдөөрөө дамжуулаад янз янзын тендер, арга хэмжээ янз янзын тэр сонирхлын зөрчлүүд чинь найз нөхдийн хүрээнд маш их гараад байдаг байхгүй юу даа. Энэ холбоо сүлбээг бас тодорхой хэмжээгээр шийдэхгүй болохоор энэ чинь бас болохгүй байгаад байгаа юм. Хамаатнууд бол тэртээ тэргүй манай нэг, манай угсаагаа 1 юм Их Хурлын гишүүн боллоо гээд л ингээд л бид нарын төлөө л байж байгаа. Тэгэхэд бол өөр газраар бас зөндөө их сонирхлын зөрчил явдаг шүү гэдгийг бас 1 дүгээрт хэлье.

2 дугаарт нь. Тэгээд энэ асуудлыг бас тодорхой хэмжээгээр найз нөхдийн сүлжээгээр яаж сонирхлын зөрчлийг хаах юм. Тэрүүгээр болж байгаа зүйлийг яаж хаах юм гэдгийг бас тэр дээр энэ хууль хэлэлцүүлэх явцад бас анхаараарай гэж бас та бүхэнд хэлмээр байна.

2 дугаарт нь, Засгийн газар, Ерөнхий сайдаас явуулж байгаа шударга ёсны тэмцэл, би дэмжиж байгаа. Тэгэхдээ заримдаа хэрээс хэтрээд байна. Бизнесүүдийг бүгдийг нь айлгаж байна. Ерөөсөө энэ чинь бизнес гэдэг чинь тэр чигээрээ нэр хүнд байдаг. Тэр нэр хүндийг шороотой холих зүйлийг эрх баригч нар хийгээд байна. Ингээд сонсгол гээд л энэ дээр чинь бүх тэр нөгөө Монголын бүх компаниудыг бүгдийг нь хог новиш болгоод л ингээд л хаячхаж байна.

Дээрээс нь Хөгжлийн банкны шүүх хурал гээд ингээд л явж байна. Тэгээд ерөөсөө ингээд сүүлийн үеийн нөхцөл байдлыг харахаар ингээд л ямарваа нэгэн албан тушаалтантай аль болох хол байх юм сан гэдэг ийм хандлага маш их гарчхаж байна. Тэгээд төрийн томоохон худалдан авалт, төрийн томоохон бүтээн байгуулалтын ажил дээр орох сонирхолтой компаниуд бүгдээрээ буруу хараад сууж байна. Энэ чинь Монголын хөгжилд хортой байхгүй юу даа. Тийм учраас яг тэр нөгөө ямарваа нэгэн асуудалгүй тэр компанийн үйл ажиллагааг дэмжих, тэр хүмүүсийн ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Яах вэ, энэ, хамтдаа л хэдүүлээ үүнийг нэг аль нэг нам эд нар гэхгүйгээр тэгээд хэдүүлээ нөгөө зөв жишгээ л тогтоох тал руугаа л уул нь төвлөрвөл их зүйтэй л байгаа юм л даа. Хөгжлийн банкны асуудал гэхэд тэгээд л Хөгжлийн банкны тэр зээлүүдийг зүгээр хувийн хэвшлийнхэнд нь өгчихсөн бол ийм зүйл болохгүй л байсан. Дундуур нь тэгээд л бөөнөөрөө хувааж авах гээд л. Тэгээд л шалгуур хангадаггүй компаниуд аваачаад л асуудлууд гаргаад л нөгөөдөх нь төлөгдөхгүй дефолт болох хэмжээний эрсдэл дээр ирж байгаа учраас л ийм асуудал болчхож байгаа шүү дээ, ер нь бол. Тэгэхээр хувийн хэвшил, хулгайн сэдэл 2-ыг хэдүүлээ ялгах ёстой. Хувийн хэвшил, хулгайн сэдэл 2-

ыг. Бид нар олон төрийн өмчит компаниудыг татан буулгахыг нь татан буулгаад, ай ни өү хийхийг нь, ай ни өү хийлгээд бид нар төрөөс ингээд гаргах ёстой байхгүй юу даа. Эсвэл менежментийг нь бид нар өөр байдлаар хийлгэх ийм зүйл рүү л явах ёстой.

Энэ л өөрөө хувийн хэвшлийг дэмжих жинхэнэ дэмжлэг болно, 1 дүгээрт.

2 дугаарт, яг эрх зүйт төр тогтоод нэг үгээр хэлбэл хувь хүн биш яг хууль засагладаг болох үед зарим нэг компаниудад төр давуу байдал олгоод байж болохгүй. Бизнесийн чөлөөт өрсөлдөөн жинхэнээсээ бүрдэх үед л хувийн хэвшлийг дэмжсэн дэмжлэг болно. Түүнээс биш ингээд л барьцаагүй зээл зарим компани нь ингээд авчихсан байдаг. Түүний ард талд нь хэдэн улс төрчид байдаг. 10 хувийг нь юм уу, 20 хувийг нь авна гээд л байгаад байдаг. Зөв зүгээр өргөдлөө өгөөд явж байгаа хувийн хэвшлүүд тэдэнтэй яаж өрсөлдөх юм. Эсвэл нэг компани нь томоохон орд газруудыг эд нар ингээд авчихдаг. Банк, бизнес рүү давхиад орчихдог. Шууд гэрээ байгуулчихсан байдаг. Түүний цаана улс төрчид байдаг. Үгүй ээ, тэгэхээр чинь бусад компани нь яаж өрсөлддөг юм. Тэгэхээр бид нар харин ч хувийн хэвшлийг төрийн оролцоог багасгаж байж, улс төрийн оролцоог багасгаж байж, улс төрөөр давуу байдал олгож байгаа асуудлыг хязгаарлаж байж, бид хувийн хэвшлийг дэмжих байхгүй юу. Хөрөнгө оруулагчдыг дэмжинэ. Тэгэхгүй тэгээд л нэг эргэн тойрон хэдхэн хүний утасдсан, эсвэл эргэн тойрны хэдхэн хүн тендер авдаг. Тэгээд түүн дотор нь парламентын гишүүд нь, сайд нар нь өөрсдөө нөлөөлчихсөн байдаг. Ийм байдалтай байгаад байхаар чинь харин жам ёсны, бизнесийн эрүүл орчин бүрдэхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр л хэдүүлээ нэг ийм нэгдсэн байдлаар таслал тавиад тийм өөр, тийм шинэ соёлыг бүрдүүлэхгүй бол

яг байгаа байдлаар яваад бол их тийм хүндрэлтэй зүйл болно. Үүнийг хэдүүлээ тэгээд нөгөө өмнөх бүх зүйлийг ярьж, улс төржсөөд бол яах вэ. Зүгээр л хэдүүлээ нөгөө ирээдүйгээ илүү тийм зөв болгох, ирээдүйг илүү эрх зүйн хувьд хамгаалах, илүү чөлөөт өрсөлдөөн бий болгох, Хөгжлийн банкны зээлд хэзээ ч улс төрчид нөлөөлдөггүй байх. Хэзээ ч парламентын гишүүд ЖДҮ-лэлийн зээл авдаггүй байх. Харин жинхэнэ ЖДҮ-лэгчид нь авдаг байх тэр зүйл рүү л хийхийн тулд л ийм эрх зүйн орчин хэрэгтэй л болчихоод байна л даа.

Тэгэхээр агуулга талаас нь л хэдүүлээ харах нь зүйтэй болов уу гэсэн тийм л агуулгаар хандаж байна.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн 1 минут.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Хөгжлийн банк дээр бол асуудалтай компаниуд байгаа нь үнэн. Тэгэхдээ түүн дээр бол нэг зүйлийг л, тэр компаниуд бол мэдээж асуудал шалгах нь зүйтэй байх. Тэгэхдээ компаниуд нэг л зүйлийн төлөө зүтгэдэг. Тэр бол бага хүүтэй эх үүсвэрийн төлөө л явдаг юм. Түүнийг ялгах нь бол ямар ч утгагүй ээ л гэдгийг бас 1 дүгээрт хэлмээр байна.

2 дугаарт нь, ерөөсөө хувийн компаниуд төрийн өмчийн компанитай ноцолдсоор байгаад л дуусчихна. Хамаг бизнес нь тийшээ ингээд бүгдээрээ явчихдаг. Тэгээд энэ Засгийн газрын хүмүүс болохоор ерөөсөө ингээд л эрх баригч нар төрийн өмчийн компанийг багасгах хэрэгтэй л гэдэг. Тэгсэн мөртөө өнөөдрийг хүртэл тэд тэдээр багасгасан гэсэн тоо байхгүй байна шүү дээ. Түүнийгээ ярих биш энэ сард тэдээр багасгалаа, энэ жил тэдээр багасгалаа гэдгээ л хамгийн гол нь тунхаглаж ярьж, түүнийгээ чөлөөт зах зээл рүү шилжүүлэх тэр зүйлийг л хамгийн сайн хийх хэрэгтэй байна.

Г.Занданишатар: Үг хэлчихлээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Би зарчмын хувьд энэ хуулийг үнэхээр 2 гараа өргөөд дэмжиж байгаа. 4 жилийн өмнө би өөрөө анх Улсын Их Хурлын гишүүн болчихоод дараа нь Өргөдлийн байнгын хорооны дарга байхад яг энэ улс төрийн ашиг сонирхолтой асуудлууд гарч, хүний өөрийн намын ах, эгч нарын хорхойтой шүдэнд зуугдаж байсан л даа. Жишээлбэл Туул голын эргэн тойрон дахь тэр баахан хууль зөрчөөд барилга, байшин барих гээд авна. Дандаа сайд юм уу, Их Хурлын гишүүн эсвэл хотын том удирдлагуудтай холбоотой, тэдний найз нөхөд юм уу, компаниуд нь гараад л ирсэн. Тэгээд л ямар ч юм хүлээгээгүй яваад л өгсөн. Сая би Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхдаа эмийн асуудал дээр ард түмний амьдралтай, хувь заяатай, эрүүл мэндтэй холбоотой асуудал учраас тэнд нь улс төрчид, сайд нар холбогдоогүй байх гэсэн бүрэн итгэлтэйгээр тэмцээд орсон. Холбогдоод л гараад ирсэн. Дараа нь би бараг гэр бүлээрээ буруудаад л дууссан. Тийм учраас энэ хуулийг би гараасай гэж бодож байгаа. Харин гарахдаа хүний эрх зөрчихгүй, Үндсэн хуулийн заалтуудыг зөрчихгүйгээр хуулийн зөв зохицуулалттай гарах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

Сая Пүрэвдорж гишүүн 1 зүйлийг яг үнэн хэлчихлээ. Энд бол дандаа Улсын Их Хурал, Засгийн газар, яам тамгын аймгийн Засаг дарга нарын хамаарал бүхий нөхөр, хүүхэд гэгчихсэн байна. Гэтэл найд нөхөд юм уу эсвэл тойрон хүрээлэгчдээрээ дамжуулан яг ийм бизнес хийж байгаа тохиолдол байгаа бизнесийн бараг 70, 80 хувь нь байгаа шүү, Ерөнхий сайд аа. Сая та энэ асуултад бас яг тодорхой хариулсангүй. Ах дүү, төрөл төрөгсөд гэсэн хүрээлэл дотор энэ орчихсон байна. Яг үнэнийг хэлэхэд бид нар бүгдээрээ мэдээлэлтэй байгаа. Засгийн газрын гишүүдийн энэ бол Ардчилсан намын үед ч засаглаж

байх үед Монгол Ардын нам засаглаж байгаа үед ч гэсэн яг үнэн. Их Хурал, Засгийн газарт ялангуяа Засгийн газрын яам Тамгын газар, тэр агентлаг, төрийн өмчит компани дээр, тэр аймаг, сумын Засаг дарга дээр хамгийн их мэдээлэлд ойр байгаа хүмүүс нь өөрийн ах дүү, төрөл төрөгсөд дээр бараг цөөхөн байх. Ёстой нөгөө нэг ичих нүүрээ элгэндээ наасан бүр ширэн нүүрлэснүүд нь л ийм компаниараа явж байгаа олон жил. Харин сүүлийн үед ихэнх нь найз нөхөд юм уу тийм тойрон хүрээлэгчдийнхээ хүрээнд тендерт орлог, төсвөөс, төрөөс зарлаж байгаа хөрөнгө оруулалт руу ордог явдал бол хавтгайраад байгаа шүү дээ. Үүнийг яаж зохицуулах юм, үүнийг яаж мэдэх вэ.

Бид яг үнэхээр ийм юм гаргаж л байгаа бол дахиад хуулийн зааг юм уу хуулийн цоорхойг ашиглаад нөгөө бизнесийг өөр төрөл рүү оруулчихгүй чагтыг бас хааж өгөх нь өөрөө ёстой нөгөө саяын хэлээд байгаа дахиад энэ улс төрчидтэй холбоотой авлигын скандал гарахгүй байх хамгаалалт нь болно гээд таны хэлж байгаатай би санал нийлнэ. Юм бол шударга л байх ёстой гэсэн би байр суурьтай байгаа. Яагаад гэвэл яг үнэнийг хэлэхэд ийм хууль гарах үнэхээр хэрэгтэй байгаа. Үүнээс болоод Улсын Их Хурал, Монгол Улс парламентын засаглалтай орон. Парламентын нэр хүндийг яг иймэрхүү зүйлээс болоод унагаах оролдлого сүүлийн жилүүдэд сүүлийн бараг 10, 20 жил зөндөө явлаа шүү дээ.

Гэтэл үнэн хэрэгтээ энэ Их Хурал дотор байгаа гишүүдийн хэдэн хувь нь тийм байгаа билээ. Хэдэн хувь нь огт тийм юманд оролцдоггүй явж байгаа билээ гэдгийг ч иргэд мэдэж л байгаа байх. Ер нь уг нь бол би ийм хууль Их Хурлын гишүүдийн нөхөр, эхнэр ч юм уу ах дүү нарын компанийн ийм тендер хөрөнгө оруулалт ордоггүй байх гэж би жишээ нь бодож ирж явсан. Би сая Нямбаатар сайдаас бүр асууж байгаа байхгүй юу. Үгүй ээ, энэ хууль чинь

үйлчилж байгаа биз дээ гэсэн чинь нээлттэй тендерт оролцдог юм. Тийм учраас үүнийг нь хааж өгч байгаа юм гээд хэлж байна л даа. Тэгээд бид нар нээлттэй тендерийг нь энэ хааж өгч байгаа юм бол саяын асуугаад байгаа өөр бусад нөгөө хуулийн цоорхойг ашиглаад өөр арга барилаар тэр найз нөхдийн юм уу эсвэл бүлэглэл эсвэл туслах тэр нэг янз бүрийн шалтгаанаар албан тушаалд чамайг тавилаа. Чи үүнийг хийх ёстой гээд хийсэн юмнууд бол зөндөө гарч байна шүү дээ. Хөгжлийн банкны энэ шүүх хурлыг харахад тэр бүхэн тодорхой харагдаж байна л даа. Үүнийг яаж зохицуулах вэ? Энд хариулт аваад тодотгоё гэж бодож байна.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Бид нар ямар ч байсан дүгнэлт хийгээд эхэлчих нь л чухал байгаа юм л даа. Юутай ч өөрийнхөө эзэмшлийн компани дээр өөрийн тийм ээ, эхнэр, нөхрийн компани дээр төрийн тендерт орох, ТӨК-уудаас тендер авахаас авхуулаад ингээд зээл гээд хязгаарлачихъя. Яах вэ найз нөхөд гээд яригдаж байна. Тэгээд тэр аяндаа л ил болно шүү дээ. Эцсийн өмчлөгчөөр. Тэгээд цахимжуулаад эхлэхээр мэдээж яах вэ арга нарийсах байх. Дагаад л хуулийн эрх зүйн орчин дагаад л нарийсаад л явчихна шүү дээ, ер нь бол. Тэгээд яах вэ, би нэг зүйлтэй бол санал нэг байгаа. Тэр нь бол парламентын гишүүн бүхэн л ийм асуудалтай холбогдоод байгаа юм байхгүй гэдэгтэй бол санал нэг байгаа. Гэхдээ л нэг ийм 4, 5 кэйс гарчихаар тэр нь тэгээд л нийт ийм парламентын, Засгийн газрын асуудал болж хувираад л тэгээд парламентын нэр хүндэд нөлөөлөөд байгаа гэдэгтэй бол би бас санал нэг байгаа юм. Тэгэхээр энэ дээр л хэдүүлээ улс төрийн манлайлал үзүүлэхийн тулд л энэ хууль хийгдэж байна л гэсэн үг. Бид эхэллээ. Ийм зүйл цаашидаа байхгүй. Энэ өнцгөөс бид нар хармаар байгаа юм.

Тэгэхгүй бол ингээд гэр бүлийнхнийг маань ингээд хуулиар хориглоххож байгаа юм байна, найзууд маань үлдэж байгаа юм байна энэ тэр гэдэг ийм агуулга руу бид нар ингээд нөгөө өөрсдөө ингээд сэдэл өгөөд сэдэлжүүлээд байх бол дэмий л байгаа юм л даа.

Ерөөсөө бид нар энэ хуулийн гол зүйл бол Их Хурал, Засгийн газрын гишүүд манлайлал үзүүлж энэ хуулийг баталлаа. Бид төрд төлөөлөх нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоосоо ангид тавилаа. Үүнийг бид нар гэр бүлийн гишүүдтэйгээ ярилцсан, ах дүү, хамаатан саднуудтайгаа ярилцсан. Би төрд тангараг өргөсөн. Ийм л ёс зүйн манлайллыг л нийгэм хүсээд байгаа байхгүй юу даа. Тэгээд үүнийг л бид нар өнөөдөр хуульчилж байна.

Цаашилаад тэгээд энэ асуудлыг зогсоож чадахгүй бол тэгээд энэ бол их л тийм төвөгтэй байдал руу орно. Би чин сэтгэлээсээ хүсэж байна. Дараа дараагийн парламент нэг ч авлигын скандал байхгүйгээр бүрэн эрхийнх нь хугацаа дуусаасай. Тэгэх тусам төр иргэний итгэлцлийн гүүр эргэж сэргээсэй. Манай Монголын ард түмэн бол бас төрийнхөө сүлдэнд сүү өргөдөг бас эзэнт гүрний уламжлалтай ийм сайхан ард түмэн шүү. Тэр том итгэлцлийг нь хэдүүлээ ингээд сонгосон парламентаасаа, парламент дотроосоо томилогдсон Засгийн газраасаа л эхэлчихье. Аяндаа ийм асуудал байхгүй болоод ирвэл төрийн албан хаагчид дагаад л явна. Хувийн хэвилийнхэн ойлгоод үүнийг дэмжээд л явна. Тэдэнд маш ойлгомжтой тоглоомын дүрэм үйлчилнэ. Энэ бүх зүйл эрх зүйн хувьд, ёс зүйн хувьд цэгцрээд ирэхээр аяндаа жам ёсны бизнесийн орчин өөрөө бүрдэнэ. Энэ нь хөрөнгө оруулалтын орчинд нөлөөлнө. Яг ийм асуудлуудаа цэгцэлснээс хойш л Солонгос улс шиг л маш хурдан ДНБ нь тэлсэн. Сингапур улс ч тэгсэн. Хөрөнгө оруулагч ч гэсэн бид нарт итгэх хэрэгтэй. Энэ агуулга дээр бид нар ерөөсөө л бид нийтийн эрх ашгийн төлөө

үйлчилж байгаа юм. Парламентын гишүүн болно гэдэг бол Засгийн газрын гишүүн болно гэдэг бол. Тийм учраас бид нар бүх шуналаасаа татгалзаж байгаа юм. Бүх боломжоосоо бид нар нийтийн сайн сайхны төлөө татгалзах шийдвэр гаргасан юм гэдэг энэ заагийг бид нар бүрдүүлэх нь л эрх зүйт төрийн хувьд, ардчилсан тогтолцооны хувьд, цаашидын парламентын засаглалын нэр хүнд дархлааны хувьд л туйлын чухал юм л гэдэг л зааг гэдэг агуулгаар нь л энэ хуулийг л концепцын хувьд хэдүүлээ ойлгочихмоор байгаа юм. Тэгээд парламент дээр тэлж бас болно шүү дээ.

Г.Занданишатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Төрийн өндөр албан тушаалтнууд авлигаас ангид байх ёстой гэдэг бол бүүр угаасаа байх ёстой зүйл. Тийм учраас үүнийг өнөөдөр яах вэ, хуульчилж оруулж ирж байгаа гэдэг нь зөв. Гэхдээ нөгөө нэг хүний эрх зөрчих юм уу хэт нэг туйлирвал манайхан чинь бүр туйлираад явчихдаг. Тийм учраас бас бид хуульд зааж өгөхдөө туйлирахгүй байх, тэр бизнес нь бизнесээ, төрийн албанд ажилладаг нь төрийн албанд, харин тендер хөрөнгө оруулалт гээд үүнийгээ зааглаж өгөхгүй бол бүр тэр түрүүн Үндсэн хуулийн 14.4 дэх тухайн хүн ажил мэргэжлээ сонгоход нь хүртэл бүр туйлираад садаа болоод юм уу тэрийг нь бүр хориглоод өгчих энэ тэр нь эргээд энэ нь асуудал дагуулах вий гээд бас шүүмжлэлүүд нийгэмд өрнөж байна л даа. Тэгэхээр бид нар яриад байна шүү дээ. Хэт юм туйлирах биш. АНУ-ын конгрессын гишүүд юм уу Сайд нар нь хөрөнгө оруулгын мэдүүлэг, олсон орлого, түүнээсээ татвар төлж байгаа энэ бүхээ үнэн зөв мэдээлсэн бол тэр нь явдаг, худлаа мэдээлсэн бол ёстой хариуцлагаа хүлээгээд ингээд явчихдагийг бид нар харж байна. Тэгэхээр бас яг энэ бол боловсролтой, мэдлэгтэй, зөв үеийн хуулиа гаргах нь өөрөө амьдралд хэрэгжихэд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Санаа хэлчихлээ. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ирцэд байхгүй байна шүү дээ. Энэ картыг нь сугалаад байгаа байхгүй юу та нар. Түрүүн санал хураалт дээр хэн нэг нь сугалаад буцаагаад хийчих юм. Тэгээд ирцд байхгүй, одоо орж ирнэ. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Нийтийн албан, нийтийн болон хувийн ашиг сонирхол зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх янз бүрийн арга хэмжээ авах нь зөв байх гэж ингэж бодож байна. Тэгээд энэ хуулиар олон төрлийн хязгаарлалтууд тогтоож байна л даа. Нэр заагаад. Тэгээд яг ижил төстэй албан тушаалтнууд яах юм. Жишээлэх юм бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга гээд л эдгээр хязгаарлалт байж байна. Тэгвэл Дээд шүүх яах юм? ҮХЦ яах юм, прокурор яах юм, ЦЕГ-ын дарга яах юм, аймаг нийслэлийн Засаг дарга нь орж байгаа бол иргэдийн хурал нь яах юм гээд ийм асуултууд гарч ирж байгаа юм. Энэ чинь өөрөө ялгаварлан гадуурхах асуудлууд болох уу, үгүй юү гэж.

Хуультай тэмцэхэд жишээлэх юм бол УҮГ-ын гүйцэтгэх захирал гэж. Үүнийг хязгаарлах нь зөв юм уу. УҮГ-гүй болох нь шаардлагатай юм уу гэж. Ингээд хараад байхад улсын үйлдвэрийн энэ албан тушаалтнуудын хамаарал бүхий хүн нь улсын УҮГ-ын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглож байгаа болохоос биш УҮГ-ын захирлын доор ах дүү, хамаатан садан нь ажиллахыг хориглоогүй шүү дээ. Тэгвэл Монгол Улсын сайдаас илүү эрх мэдэлтэй Эрдэнэс Тавантолгой ч гэдэг юм уу, Оюутолгой ч гэдэг юм уу, Хөгжлийн банк ч гэдэг юм уу, тэнд очсон захирлууд чинь дүү нараа, ах нар, дүү нараа хүүхдүүдээ авах, найз нөхдөө авах боломж нь

нээлттэй шүү дээ. Тэгэхээр ингэж алаг цоог үзэхээр яах юм? Жишээлэх юм бол өнөөдөр дэд сайдаас Эрдэнэс Тавантолгойн хэлтсийн дарга хамаагүй том эрх мэдэлтэй байна шүү дээ.

Сая энэ нүүрсний хулгайн үед ингээд сонсоод байхад Монгол Улсын төсөвтэй тэнцэхүйц бид нарын энд үйл тамаа бараад баталдаг тэр 18 их наядыг чинь нэг хүн гарын үсэг зурдаг юм шүү. Тэгвэл түүний доор ажиллаж байгаа хэлтэс, тасаг, алба, агентлаг, мэргэжилтнүүдийг энд хориглоогүй шүү дээ. Тэгэхээр энд юу гэж харагдаад байна вэ гэхээр би хэдийгээр хориглох, зохицуулах нь зөв боловч арга нь буруу талаасаа яваад байгаа юм биш үү? Өнөөдөр УҮГ-гүй болох зорилтыг тавих, орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар зорилтыг тавих юм бол энэ авлига чинь өөрөө аяндаа байхгүй болчих юм биш үү. Олон нийтийн компани болох, хувийн компани болчих юм бол өөрийнхөө юмыг хулгайлуулаад сууж байдаг, өөрийнхөө юманд өөртөө авлига аваад сууж байдаг хүн байхгүй шүү дээ. Тэгэхээр би энэ хязгаарлалтын зарчмыг нь хараад байхад бол ингээд бараг нэр зоогоод тавьчихсан, тэр хавиар л нэг авлига явдаг, энэ хавиар явдаггүй гэсэн байдалтай хандаж байгаа байхгүй юу. Жишээлэх юм бол аймаг, нийслэлийн Засаг даргаас чинь аймаг, нийслэлийн Иргэдийн Хурлын дарга нь том шүү дээ гэх мэтчилний ийм хуулийн цоорхойнууд бол байна гэж.

Тэгэхээр би энэ хуулийн концепцыг УҮГ-ын даргыг нь хориглохоос гадна доошоо хориглож нэг болно, үгүй бол УҮГ, орон нутгийн өмчийн газаргүй болох энэ концепцыг илүү оруулж ирвэл сайн юм биш шүү гэж.

Дээр нь энэ төрийн албан тушаалтнуудын ах дүү, хамаатан садан юу авч болохгүй юм бол, хөнгөлөлт авч болохгүй юм бол бас УИХ давхар дэвшиж болохгүй байхыг хориглох ёстой шүү дээ. Энэ парламент чинь ах дүүсээрээ, хадам хүргэнээрээ суучихсан ийм 8 сонгуулийг

бид нар харж байсан шүү дээ. Тийм учраас яг адилхан төрөөс бодит хөнгөлөлт олгож болохгүй гэдэг шиг бодит нэр дэвшилт өгөхгүй байна ч гэдэг юм уу. Жишээлбэл ах дүү 2 сууж байвал яах юм, эгч дүү 2 сууж байвал яах юм, хадам хүргэн 2 сууж байвал яах юм, ийм нөхцөлүүд нь бол ингээд хараад байхад тийм цоорхой ихтэй байна. Үүнийг нягталж үзэх боломж бий юу гэсэн ийм санааг илэрхийлж байгаа юм. Тэгээд тодруулъя.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Аль аль талаас нь л явъя. ТӨК-уудынхаа засаглалыг ил тод байлгах талаас нь ч явъя, Их Хурал, Засгийн газрын гишүүд болон аймаг, Нийслэлийн Засаг дарга нар өөрөө тендер авахгүй байх талаас нь ч явъя, шилэн данс болох талаас нь ч л явъя. Нээлттэй ил тод байх мэдээлэл авах талаас нь ч л явъя, шүгэл үлээх эрх зүйн орчноо сайжруулах талаас нь ч л явъя. Ингээд л тал талаас нь л цогцоор явъя. Яагаад гэхээр авлига гэдэг бол өөрөө нэг зүйлээс болдог зүйл биш шүү дээ. Энэ бол өөрөө цогц асуудал. Тэгэхээр авлига өөрөө цогц асуудал учраас шийдэл бас цогц л байх ёстой. Өнөөдрийн их чухал зүйл бол энэ танхимаас Засгийн газрын гишүүдээс өөрсдөөс нь манлайлал гарч байгаа нь л их чухал юм. Сайд нар нь хориглогдчихоод байж байхад дэд сайдууд энэ асуудалд орооцолдоно гэдэг бол бараг боломжгүй зүйл. Өөр нэг зүйл нь бас Засаг дарга байна, Иргэдийн Хурал илүү эрх мэдэлтэй шүү дээ гэж байна. Мэдээж ийм маргаанууд их гарна л даа. Гэхдээ ийм маргаан гарч байгаад өнөөдөр би бол баяртай байгаа юм. Яагаад гэхээр Их Хурал, Засгийн газрын гишүүд энэ дээр хатуу заагтай болчихвол төрийн албан хаагчид зориглож тийшээ ингээд л оролцоод байх бол маш багасна даа. Ер нь бол маш багасна. Яагаад гэхээр дэг журам, ёс суртахуун дээрээсээ

л эхэлнэ. Энэ ингээд төлөвшөөд нэг 5-8 жил ингээд явчихад бол аяндаа л анхан, дунд шат биднийг дагаад л явна. Эндээ ингээд асуудал байгаад байна гэж бодохоор төрийн албан хаагч ч гэсэн ер нь болдог юм байна гэдэг ийм агуулга руу л ингээд л шат шатдаа орчхоод байгаа байхгүй юу. Тэгээд асуудал тавихаар эхлээд та нар дээд талдаа асуудлаа ярихгүй юу. Ийм бас асуудал байна.

Дээрээс нь яах вэ, хэд хэдэн хүмүүс хөндөж байна. Энэ бас хуулийг хэрэгжүүлэх шатанд бас завхруулах вий гэдэг ийм агуулга. Үүнийг бол бид нар маш сайн тооцох ёстой. Үнэхээр санал нэг байна. Хүний эрхийн зөрчлүүд гаргахгүй байх ёстой, үүнийг бид нар маш сайн тооцож үзэх ёстой. Гэхдээ нэг ийм асуудлууд бас манай иргэд бол ялгаж, салгаж харж байгаа болов уу л гэж бас боддог юм. Яг ингээд л нэг ийм асуудал гараад ирэнгүүт л барьж унах ийм 2 сэдэв байдаг юм шиг байгаа юм. Одоо ингээд хараад байхад. Нэг нь учир зүггүй хүний эрх ярьдаг болдог, нөгөөдөх нь өөрөө авлигалаад баригдчихангуутаа учир зүггүй хувийн хэвшил рүү халдаад байна гэдэг. Гэхдээ яг үнэндээ бол авлига чинь өөрөө хүний эрхийн хамгийн том зөрчил шүү дээ. Авлига өөрөө хүний эрхийн хамгийн том зөрчил. Хүний боломжийг өмнөөс нь хулгайлаад байна гэдэг чинь. Нийтийн эзэмшлийн талбайд тоглоомын талбай барихад авлигад дийлэнх хэсгийг нь авчхаад тэр тоглоомын талбай чанаргүй баригдаж байна гэдэг чинь өөрөө хүний эрхийн зөрчил мөн шүү дээ.

Хувийн хэвшил сая бас ярьж байна. Ийм нөлөөлөл байхгүй байх нь харин бид нар хувийн хэвшлийг л дэмжих гэж байгаа л хэлбэр шүү дээ, ер нь бол. Түүнээс биш зөвхөн ингээд улс төрд нөлөө бүхий этгээдүүдийнх нь компани давуу эрхээр тендер ч авдаг, орд газар ч авдаг, Улаанбаатар хотын газруудыг ч бүгдийг нь авдаг. Энэ нь болохоор жишээлбэл ингээд эрх, бусад компанийн зөрчигдөж байгаа эрх нь болохоор эрх

биш гэж үзэж болохгүй шүү дээ. Тэгэхээр үүнийг л бид нар ил тод, нээлттэй болгочихно. Цаашидаа их тийм туйлын чухал юм гэдэг агуулгаар.

Тэгэхээрээ гишүүний асуултад хариулахад тал талаас нь л хэдүүлээ яваад үүнийг ингээд цэгцэлчихвэл аяндаа ДНБ бол маш хурдтай тэлнэ. Саяхан ингээд болсон хэд хэдэн арга хэмжээн дээр л макро эдийн засгийнхаа тоонуудыг хараарай. Яаж өссөн байна. Тэгэхээрээ бид нар энэ далд эдийн засгийг ил болгох дээр бол нам ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн 1 минут тодруулъя.

Ж.Батсуурь: 1 минутад ч амжихгүй. Тэгэхдээ энэ бол хөнгөлөлт, төсөл хөтөлбөр, зээл олголт гэж яриад байгаа юм. Би юунд тодорхой хариулт авсангүй л дээ. Их Хурлын гишүүний дүү нэр дэвших, Ерөнхий сайдын нэр дэвших ч гэдэг юм уу энэ Засаг даргад тэнцүү хэмжээний. Энэ юутай заавал мөнгөөр илэрхийлэгдэхгүй ийм хориг саад хязгаарлалтууд тавигдах уу гэсэн дээр би тодорхой хариулт авч чадсангүй л дээ.

Г.Занданшатар: Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль бас Үндсэн хуулийн өөрчлөлт гээд хэдүүлээ яг энэ цаашидаа яаж ёс зүйн хувьд илүү парламентаа төгөлдөржүүлэх вэ гэдэг сэдвүүд хуулиуд орж ирнэ. Тэр үеэр хэдүүлээ хамтдаа энэ сэдвээр илүү ярилцъя.

Өнөөдөр бол яг энэ хүрээн дотроо бол энэ бол нөгөө нийтийн албан тушаалтантай холбоотой л асуудал.

Г.Занданшатар: Одоо чинь нэг гадаад арга хэмжээтэй учраас сая байр сууриа илэрхийлж. Энэ Жамбын Батсуурь гишүүн асуусан төрийн өмчийн компанийн удирдлагууд ажилтнууд

хамаарахгүй байна гэж. Ер нь бол Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зөрчлийг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар нийтийн албан тушаалтан гэдэг төрийн бүх өмч, төрийн өмчийн бүх компаниуд хамаарч байгаа бөгөөд тэнд хувийн ашиг сонирхол гэж тодорхойлсон, хувийн ашиг сонирхлыг хийж болохгүй гэдгийг бүгд байгаа. Хувийн ашиг сонирхол гэдэгт энэ зээл, хууль, тендер, хамаарал бүхий этгээд зөвхөн өөртөө төдийгүй зөвхөн авгай, нөхөр, хүүхдээр хязгаарлагдахгүй бүр хамаарал бүхий этгээдүүд. Хамаарал бүхий этгээдүүд чинь бүр бараг нэг анги, нэг нутаг ингээд найз нөхөд, нэг ангийн хүүхдүүдэд ч гэсэн дамжуулан энэ давуу эрх олгохыг хориглочихсон. Эрүүгийн хуулийн 22.1-ээр энэ давуу байдал олгох хэлбэрийн бүрэлдэхүүнтэй материаллаг бүрэлдэхүүнгээр хуульчилчихсан. Тэгэхээр энэ бол зарчмын хувьд ингээд бүгдэд нь болохгүй гэдэг заалт байгаа. Нөлөөлж болохгүй. Одоо үүгээр ч гэсэн эрүүгийн хэрэг үүсгээд шалгагдаад болохгүй гээд яваад байгаа нь бол бас нөлөөлж байгаа, дагаж байгаа гээд. Харин гагцхүү үүнийг хэрэгжүүлэх ийм босоо хяналтын тогтолцооны хууль бол ингээд хэрэгжихгүй байх, түүнийг хянах шалгах асуудал хүндрэл учирч байгаа учраас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар энэ хэвтээ хариуцлагын тогтолцоо бүрдүүлсэн. Ёс зүйн зөвлөл тэрийг төрийн албан хаагчид мэдээлэх ёстой тэр чинь өөрөө гэнэт зээл унаад ирэхгүй, тендер унаад ирэхгүй.

Тэгэхээр энэ хүний ийм юм хамаарал бүхий юм, дээрээс албан шахалтаар юм уу хажуугийн нөлөөллөөр олгох гээд байна гэсэн юмыг 3 талт ёс зүйн зөвлөлүүдийг бүх төрийн албаны байгууллагууд дээр байгуулж байгаа шүү дээ. Тэгээд тэр бол мэдээлдэг, хянадаг энэ ард иргэд, олон нийтийн хяналттай ийм систем механизмыг төрийн бүх албан тушаалтнуудыг нэг чангаруулах, төрийн албан хаагчийн ёс зүй энэ дарамт шахалт үзүүлж, зээл олгуулах

байдаг юм уу аль эсвэл төсөл хөтөлбөрт хамруулах, тендерт шалгаруулах энэ шаардлагуудыг бол төрийн албаны ёс зүйн зөвлөлүүд байгуулагдсанаараа 3 талт байна гэж байгаа. Энэ дээр татвар төлөгчид, хэрэглэгчдийн төлөөлөл орсон ийм механизмаар энэ хуулийн хэрэгжилтийг хангах ийм механизмыг бүрдүүлж, цаашаа харин бүүр хамаарал бүхий этгээдүүдийг нь оруулах хэрэгтэй болж байгаа юм. Үүнийг бол зөвхөн бас юугаар хязгаарлах болчихоод байгаа юм, ах дүү хамаатан садан. Тэгэхээр үүнийг бас Үндсэн хуультай нь нийцүүлэх нэг талаас, нөгөө талаасаа хамаарал хүрээг өргөтгөх тэгээд ажиллах механизм санхүүгийг нь яг үүнийг яаж хянах вэ гэдгээр. Ингэж байж бид авлигаас ангижирч, бидний яриад байгаа шатыг дээрээс нь эхэлж шүүрдэх хэрэгтэй. Тийм учраас төрийн өндөр албан тушаалтнуудаасаа эхэлж байна шүү дээ. Ийм үүрэг хариуцлага ухамсарлаж энэ авлигад идэгдчихээд байгаа гэсэн нийгмийн ойлголтыг ер нь энэ байдал байгааг засаж залруулах ийм санаачилга гэж ойлгож дэмжиж энэ хуулийг хэлэлцэж батлах, нийгэмд бас ийм ойлголт өгөх ийм шаардлагатай байна.

Тэгэхгүй бол ингээд нэг л юм болохоор ерөөсөө л цаана нь Их Хурлын гишүүд байгаа гэж бодоод байна шүү дээ. Нийгэм чинь. Тэгээд заавал шалгахгүй бол Их Хурлын гишүүн л гаргаж ирэхгүй бол түүнийг илрүүлсэн гэж үздэггүй ийм нийгмийн сэтгэл зүй байна. Тийм учраас үүнийг бол бас тэмцэж энэ үйлдэл, үйл ажиллагаагаараа бид харуулах ёстой.

Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Баярлалаа. Би энэ хуулийг бол үнэхээр дэмжиж байгаа. Өнөөдөр яг энэ цагт ажиллаж байгаа УИХ, Монгол Улсын Засгийн газар өмнө өмнө жилүүдэд туулж байгаагүй хүнд цаг үеийг туулж байгаа. Бид нар ковид гээд геополитикийн асуудал, эдийн

засгийн хямрал, мөн дотооддоо хийж байгаа энэ авлигатай тэмцэх энэ тэмцэл. Өнөөдөр энэ олон олон нийгэм дээр илэрч байгаа хэргүүдийг харахаар Монголчууд маань гутармаар юм шиг, цөхөрмөөр юм шиг. Гэхдээ нөгөө талаас нь харахаар энэ хэзээ ингэж илрэх байсан юм. Илрээгүй байсан бол яах байсан юм гэмээр ийм цаг үеүдийг бид нар туулж байна. Нэгэнт илрээд ингээд явж байгаа юм чинь идээ бээр нь шахагдаад ингээд эдгэрэх, цэвэрлэгдэх байх гэсэн ийм итгэлтэй байна. Тэгээд хамгийн харамсмаар нь энэ цаг үеийн үр дүнд нь хойч үе маань бидний залуу үе маань төрдөө итгэх итгэл алдарч байгаа. Өнөөдөр Солонгос явах визний материал авах газрууд дээр хэчнээн мянган залуучууд очерлоод зогсож байгааг харах нь энэ бол энэ цагийн нотолгоо байгаа. Тэгэхээр би ер нь бол Монгол Улсын ЗГ Ерөнхий сайдад энэ тэмцлээ үргэлжлүүлэх нь зүйтэй. Энэ тэмцлийн үр дүнд орж ирж байгаа бас нэг ийм хууль гэж харж үүнийг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлж байна.

Тэгээд хэд хэдэн хэлэх зүйл байна. Сая бас гишүүд хэлчихлээ. Хэт туйлшираад хэн нэгэн хүмүүсийг хэлмэгдүүлэх вий гэдэг нэг болгоомжлол байна.

2 дугаарт нь, энэ олон улсын жишигт нийцүүлэн энэ улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалт гэсэн хэсэгт эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд гэсэн хүрээнд хязгаарласан байгаа нь хангалтгүй. Тийм учраас ах дүү, төрөл садан, бизнесийн болон бусад хамтрагч нараа томилсон, нутаг усныхан. Өнөөдөр ч гэсэн яам, Тамгын газар ийм асуудлууд зөндөө л байгаа шүү дээ. Энэ жишгээр энэ хамрах хүрээг бол тэлэх нь зүйтэй гэж ингэж үзэж байна.

3 дахь асуудал бол хууль хяналтын байгууллага маань яг энэ үед үнэхээр энэ тэмцэлд нэгдээд, ашиг сонирхолгүй өөрсдөө, шударга ажиллаж чадах уу

гэдэг асуудал байна. Өнөөдөр хууль хяналтын байгууллагад шударга биш хүмүүс олноороо шургаснаараа бас мөн энэ төрдөө итгэх итгэл үнэхээр алдарсан.

Засгийн газрын, Их Хурлын хийж байгаа энэ тэмцэлд өнөөдөр хууль, хүчний байгууллагууд маань цэвэр тунгалаг ажиллах шаардлагатай байна гэдгийг бас хариуцлагатайгаар хэлмээр байна. Тэгээд асуух асуулт бол байхгүй.

Ерөнхий сайд байгаа дээр хэлэхэд, өнөөдөр Их Хурлын гишүүд л хулгайч нар юм шиг ингээд яриад байгаа боловч яам, Тамгын газар ажиллаж байгаа дунд шатны дарга нар хэзээ ч сонгуульд өрсөлдөхгүй, хэн ч танихгүй, юугаа ч алдахааргүй ийм хүмүүс хэсэг бусниулж байгаад, төрийн албыг бусниулж байгаад, идэж уугаад ингээд явдаг жишиг бол тогтсон. Хамгийн харамсалтай нь энэ хүмүүсийг зүгээр ажлаас халснаа хариуцлага тооцсон гэж үзээд байгаа. Өнөөдөр энэ явуулж байгаа “5 Ш” ажиллагааны үр дүнд төр яаж хариуцлагаа тооцож, яаж энэ гарсан хохирлоо буцааж төлүүлдэг гэдгийг маш сайн ингээд хариуцлага тооцож чадах юм бол дараа дараагийн төрд орж ирж байгаа, улс төрд орж ирж байгаа энэ залуучууд бол үнэхээр хариуцлагатай байж чадна гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ асуултад хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ асуудлууд ил тод болж байгаа бол яах вэ, энэ цаг үед нийгмийн бухимдлыг төрүүлж байгаа байж болох ч энэ бол өөрөө ирээдүйд төрд итгэх иргэдийн итгэлийг сэргээж байгаа. Монгол Улс зөв замаар замнаж байгаа юм байна гэдэг ирээдүйдээ итгэхийг энгийн төрийн албан хаагчдын итгэлийг сэргээж байгаа зүйл. Тэгэхээрээ бид нар энэ зүйлийг зориглоод эхлүүлэхээс өөр сонголт байхгүй л дээ. Тийм сонголт байхгүй. Мэдээж аль ч улс

орны яг ийм далд эдийн засаг, авлигыг цэгцлэх тэмцэл бол тийм амар байгаагүй. Тэгэхээрээ энэ дээр бид нар тууштай л байх ёстой, тууштай байх ёстой, алхам, алхмаар урагшлах ёстой, алдаа дутагдал гарвал түүнийг бид нар засаад олон улсын байгууллагуудтай хамтраад зөвлөгөө аваад л явах ёстой.

Иргэдтэй уулзахад Их Хурлын гишүүдээс шударга ёсыг шаарддаг. Бид нар иргэдээс сонгогдож байгаа парламентын гишүүдийн хувьд шударга ёсыг шүүхээс шаардах эрхтэй. Гэтэл сая ШЕЗ дээр шүүх шударга биш байна гэж хэлсэн гэдэг ийм агуулгаар над дээр чинь огцруулах санал хураалт хүртэл явуулж байна лээ. Үүнээс авлигатай хийх тэмцэл өөрөө тийм бас хялбар биш. Энэ бол өөрөө тийм цаг хугацаа шаардсан зүйл гэдэг нь бол маш ойлгомжтой харагдаж байгаа юм. Гэхдээ бид нар үүнийг эрх зүйн хувьд нь цэгцлээд л ингээд явах л ёстой. Тэгээд парламентын гишүүд шударга ёс гэдэг энэ асуудлыг хөндөхгүйгээр ёс зүй гэдэг асуудлыг хөндөхгүйгээр тэгээд яах вэ? Дуугарахгүй шүүх гэж дохиогоор харьцдаг болох юм уу? Тэгэхээр ийм түвшинд бид нарын хувьд нийгмийн энэ нөхцөл байдлууд ирчхээд байна. Үүнийг бид нар сэтлээд ард нь гарах л зайлшгүй л ийм шаардлагатай. Ингэж байж л төрд итгэх итгэл энэ бүх асуудлуудын хувьд бол цэгцэрнэ. Энэ дээр иргэд, ААН-үүд, хувийн хэвшлийнхэн, олон улсын байгууллагууд бүгд санал 1-тэй байгаа гэдэгт бол би итгэлтэй байгаа.

Хууль харин Үндсэн хуультай хэрхэн нийцэж мөн хамаарах цар хүрээ нь ямар байх вэ гэдгийг бол манай УИХ онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд ажлын хэсэг байгуулаад сайтар нягталж үзээд тэгээд энэ асуудлыг мэдээж шийдэх нь бол ойлгомжтой. ЗГ дээр бол бид нар бас нэлээн удаан хугацаанд ярьсны эцэст энэ хуулийг бол өргөн барих нь зүйтэй. Энэ маань өөрөө ёс зүйн хувьд бас нэг тийм зааг болох, таслал болох, шинэ 30 жилийн соёлыг бий болгох энэ агуулга

дээр бол агуулга талаасаа чухал юм л гэдэг агуулгаар нь орж ирж байгаа юм.

Ингээд Улс төрийн намын тухай хууль дээр хэдүүлээ хамтдаа дахиад энэ сэдвийг ярилцъя. Сонгуулийн тухай хууль дээр дахиад энэ сэдвийг хамтдаа ярилцъя. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль дээр энэ асуудлыг хамтдаа ярилцъя. Авлигын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр орж ирнэ. Хүний эрхийн сая бас 22 дахь удаагийн тайлан яригдана. Энэ бүх асуудал дээр хэдүүлээ хамтдаа ярилцаад л, юутай ч өнгөрсөн 30 жилийнхээ ололт, алдаа оноо, дутагдал бүх зүйл дээр үндэслээд шинэ 30 жил өмнөх 30 жилээс илүү дэвшилттэй байгаасай гэдэг энэ агуулга дээр л хамтдаа нэгдээд үлгэр дуурайлыг хэдүүлээ бусдад тулгах биш үлгэр дуурайлыг өөрсдөөсөө эхэлчихье гэдэг энэ агуулга дээр л нэгдэх ийм үзэл санааны хувьд энэ хууль маань өөрөө их тийм чухал юм л гэж үзэж байгаа юм л даа.

Л.Мөнхбаатар: Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг асуултаа асууя.

Ц.Цэрэнпунцаг: Хуулийг дэмжиж байгаа. Ингээд нийтийн албанд ажиллаж байгаа улс маань энэ нийтийн болон хувийнхаа эрх ашгийг ялгаж салгая, тодорхой болгоод өгье. Тэгээд энэ шударга ёс энэ хариуцлагыг дээрээс нь эхэлье гээд энэ Ерөнхий сайд манлайлал үзүүлээд ингээд өнөөдөр хүртэл хуулиа танилцуулж байна. Ингээд Засгийн газрын энэ хийж байгаа ажлыг бол бүрэн дэмжиж байгаа.

Тэгэхдээ бид нар нэг асуудал яваад байгаа. Хууль хийхэд бид нар яах гэж хууль хийгээд байдаг юм гээд, тоо гүйцээх гэж байгаа бол хангалттай тоотой хуультай, тийм ээ. Тэгэхээр бид нар энэ хуулийн зорилго бол бид нар тэр төрийн энэ авлига, хээл хахууль гэдэг юмыг л салъя, үүнээс л энэ төрийг холдуулъя л гэж ингэж зорьж байгаа. Энэ чиглэл бол энэ хууль бол ач

холбогдлоо үр дүн гаргах байх л гэж энэ хуулийг хийх гээд энэ цөмөөрөө батлах гээд сууж байгаа юм. Сонсоод сууж байгаа юм. Тэгэхээр зэрэг хамгийн гол яах вэ, энэ хуулийг ингээд хийгээд хэрэгжүүлээд явахаар зэрэг цааш нь ойлгомжтой энд ажиллаж байгаа хүмүүс маань бизнес хийж болохгүй, эхнэр хүүхэд нь, гэр бүл нь бизнес хийж болохгүй. Болж байна. Бусад орны жишиг энэ зах зээлийн чиг баримжаатай орнуудын жишгээр бол 25, 30% нь төрийн оролцоо байна. Энэ эдийн засаг дахь төрийн оролцоо нь ийм 30% 25, 30 орчим хувь бол ер нь дундаж юм байна, энэ олон улсын жишгийг харахад. Тэгтэл манай Монголд энэ төрийн эдийн засагт оролцож байгаа оролцоо, төрийн өмчтэй компаниудыг нь оролцуулах юм бол 60 гараад явсан, хэд болсон бүү мэд.

16 онд гэхэд онд гэхэд бол энэ янз бүрийн тоо баримт 16 он гэсэн байх аа. Энэ бол энэ төрийн өмчтэй компаниудын үнэлгээ гаргахад бараг дотоодынхоо нийт бүтээгдэхүүнээс илүү үнэлгээтэй байна гэсэн ийм үнэлгээ гаргасан байдаг юм байна. Тэгээд одоо хэд ч болсон юм үнэлгээ нь өсөж л байгаа байлгүй дээ. Бүх юм ингээд энэ үнэ хани, инфляц явж байгаа үед бол тэд нарын үнэ явж л байгаа, өсөж л байгаа. Тэгэхээр зэрэг энэ эдийн засаг чинь ингээд төр нь ингээд 60% нь, 70% нь ч юм уу ингээд бодит тоо гарахаар зэрэг төр нь эдийн засгаа ингээд зүгээр хувийн хэвшлийнхээ шахаад гаргачихлаа. Төр ер нь эдийн засгаа тэр чигээр нь авч явахаар болчихлоо шүү дээ. Тэгэхээр энэ төрд нь орж ирээд ямар ч бизнес хийдэггүй, бизнест холбогдож болохгүй улсууд маань энэ шийдвэрүүдийг гаргаад явах юм байна. Тэгэхээр зэрэг бид нар уул нь энэ хуулийг хэрэгжүүлээд энэ төр энэ хувийн ашиг сонирхлыг нь төрөөсөө төрийнхөө нийтийн ашиг сонирхлоос нь ялгах гэж байгаа бол уул нь хувийнхаа энэ салбарыг дэмжээд, эдийн засаг дахь оролцоог нь нэмэгдүүлээд, төрийнхөө оролцоог багасгаад явъя. Үүнийг нь цуг хийе ээ гээд

түрүүн Ерөнхий сайд хэлж байна. Үүнийг бол 100% дэмжиж байна.

Тэгэхээр үүнийгээ бид нар аль аль талаас нь зөвхөн энэ хуулийг гаргачхаад тэгээд үр дүнг нь хараад зогсож байх биш. Энэ хуулиа гаргаад зэрэг нөгөө талаасаа энэ төрийн өмчтэй компаниудаасаа хувьчлах, олон нийтийн компани болгох, ард түмэндээ нээлттэй энэ ард түмний нийтийн өмчлөлтэй компаниуд гээд байгаа жинхэнэ эздэд нь тэр хувьцааг нь өгөөд, эзэмшүүлээд тэд нар нь компанийнхаа үйл ажиллагаанд оролцоод ингээж явдаг боломжийг нь нээгээд энэ жинхэнэ олон нийтийн нийтийн энэ публик компани болгоод явах энэ чиглэл рүү нь явуулж энэ төрөөс жсоохон энэ бизнесүүдээ багасгах ажлыг нь цуг хийгээд яваад явмаар байгаа юм. Үүнийг бол яг зэрэг хийж явж байж, энэ ажлын, энэ хуулийн гарсан хэрэг гарч, энэ авлига, хээл хахуулиас энэ төрийнхөн маань, төрийн өндөр албан тушаалтай улсууд маань, энэ сонгогдсон гишүүд маань, Засгийн газрын гишүүд маань хол байх гэж бодож байна.

Дээрээс нь бас энэ ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулсны дараа тодруулах шаардлагатай гэж үзвэл асууна. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ асуултад хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Бизнес бол хийж болно гэж байгаа шүү дээ, энэ хууль дээр. Гагцхүү төрийн тендерт л орж болохгүй гэдэг л зааг.

2 дугаарт, төр том байна, үүнийг багасгаж хувийн хэвшил хөрөнгө оруулалтын орчноо бол илүү тэлнэ ээ. Төрийн албан хаагчдаа ч гэсэн бидний хувьд цалинг нь нэмээд, цомхон чадварлаг ийм бүтэцтэй байх ийм реформыг хийнэ гэдэг энэ агуулга бол ингээд давхар явж байгаа.

Өнөөдрийн бас орж ирж байгаа энэ хууль батлагдаад ингээд зааглагдчихвал энэ өөрөө парламентын нийт уур амьсгал өөрөө хувийн хэвшил рүү гаргах тал дээр маш том ийм хөшүүрэг болно, хөшүүрэг болно. Тэгэхээрээ бол цаашилаад энэ ТӨК-уудын асуудал, нэгтгэхийг нь нэгтгээд, заримыг нь олон улсын менежменттэй болгоод ингээд явах энэ асуудлуудыг бол бидний хувьд хийгээд явж байгаа юм. Одоо бас энэ дээр бид нар хамтдаа л ойлголцох л ёстой асуудал. Юутай ч бид нар Хөрөнгийн бирж дээр үүнийг хийчихлээ. Хөрөнгийн бирж маань өөрөө цаашидаа энэ асуудлуудыг гаргаж шийдэх ийм гол байгууллага маань өөрөө олон нийтийн асуудал, олон нийтийн Ай Пи Өү хийгдэх асуудал амжилттай хийгдлээ. Төрийн банк ингээд хийгдэнэ. МИАТ-тай холбоотой асуудлуудыг бидний хувьд бол оруулаад Их Хурлаар бол гаргачихсан байж байгаа юм. Одоо бид нар энэ Тавантолгойтой холбоотой асуудал, энэ уул уурхайтай холбоотой асуудлууд дээр менежментийг нь яаж явах вэ гэдэг асуудлыг бид нар намар УИХ дээр оруулж ирж нэлээн ярина. Тэгэхээр өнөөдөр бид нар ярьж байгаа зүйлээ яг тэр үедээ л илүү их тийм зоригтой Улсын Их Хурлын гишүүд маань, Засгийн газрын энэ ажлуудыг бас дэмжиж өгөхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсье.

Ер нь энэ хаврын чуулган, намрын чуулган дээр бай, орж ирж байгаа энэ хуулийн жагсаалтыг та бүхэн харвал энэ бол дандаа л ийм суурь реформын асуудал байгаа юм. Төрийн албан хаагчид маань ч гэсэн цалингийн шатлал нь бараг 100 гаруй өөр цалингийн шатлалтай явж байна шүү дээ. Тэгэхээр цалинтай холбоотой асуудлыг ярихаар ингээд доргилт өгчхөөд байдаг. Сая ҮАБЗ дээр бас хуралдаад төрийн бүх байгууллагууд цалингийн нэг системтэй байна гэдэг ийм зөвлөмжийг гаргасан. Одоо болохоор бид нар 3 талт хэлэлцээрийн хүрээнд төрийн албан хаагчдын цалинг амьдралд хүрэхүйц хэмжээнд нэмэгдүүлэх. Гэхдээ үүнийг бид нар ойчин цоочин биш яг том

хэмжээнд суурь реформ хийх байдлаар, тэтгэвэртэй холбоотой асуудлыг бас суурь реформ хийх байдлаар, ингээд үйлдвэрчинтэй, ажил олгогч эзэдтэйгээ хамтраад ярилцаад явах ийм асуудлыг бол хийгээд явж байгаа.

Нийгмийн даатгал, өнөөдөр яригдаж байгаа боловсролын багц хууль ч бас тийм агуулгатай байгаа гэдгийг бол та бүхэн мэдэж байгаа. Тэгэхээр бидний хувьд дахиад ярихад энэ бол 30 жилийн хугацаанд ололт амжилт, алдаа оноон дээр тулгуурласан дүгнэлтээ л бидний хувьд хийгээд цаашидаа хэдүүлээ улс төржихгүйгээр засаад явах нь л бидний хувьд бол маш их тийм чухал байгаа юм. Тэгэхээрээ хамтарч ярилцаад л, ажлын хэсэг гараад л, хоорондоо ярилцаад л, улс төрийн намууд хамтраад л, зөв гэж байгаа зүйлээ хэдүүлээ цаг алдахгүй хийгээд л, шүүмжлэлтэй хандаад л ингээд л явчих нь зүйтэй. Мэдээж алдаа оноо гарвал түүнийгээ засаж залруулаад л явчихна.

Тэгээд ардчилсан нийгмийн нэг давуу тал ил тод болоод мэтгэлцэж ярилцах тусам зөв байгаа хандлага дандаа л ялдаг жамтай. Тийм учраас өнөөдөр бид нар нэгэнтээ л нийгмийн дүгнэлт болохгүй байгаад байна, эрх мэдлээ ашиглаад байна гэдэг ийм дүгнэлт байгаа учраас үүнийг бидний хувьд энд хүрээд цэг тавиад шинэ хуудас эхлүүлэх нь та бидний хувьд бол хамтын ийм зорилго болж байна гэдгийг л ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Маргааш Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ. Тийм болохоор өнөөдөр хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудаа бүгдийг нь өнөөдөр цаг сунган хуралдаж хэлэлцэнэ. Одоо энэ хуулийн төслөөс гадна 3 төсөл байгаа.

Ингээд 18 цаг болсон байна. Хэлэлцэх асуудал дуусаагүй байгаа тул

чуулганы нэгдсэн хуралдааныг цаг сунгаж байна.

2 гишүүн үг хэлэлцсэний дараа санал хураалт бол явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Яах вэ, би дэмжиж баяр хүргэж, үг хэлэх гээд байгаа юм. Би энэ 5 удаа Их Хуралд суугаад ажилласан энэ жилүүддээ энэ хуулийн агуулгад багтаж байгаа энэ асуудлыг л тавьж ирсэн ийм хүн байгаа юм. Ээ дээ та минь, та нар энэ төсөл тендерээс ангид байж үзээч. Төр ард түмний нэр барьж авсан зээл бондоос битгий авч үзээч дээ. Үгүй ээ, энэ төрийн албыг төрлийн алба болгодгоо болиоч дээ энэ эхнэр, нөхрөө ажил албан тушаалд тавих юм, үр хүүхдүүдээ угсаа залгамжлуулаад ингээд ажиллуулах юм. Үгүй ээ, энэ чинь хүн төрөлхтөн феодалын угсаа залгамжлах бурангуй ёсноос салаад 200 гаран 200 шахам жил, Монголчууд чинь 100 жилээ тэмдэглэх гээд байна шүү дээ л гээд л ингээд л яриад шаардаад ингээд ирсэн хүн байгаа юм.

Тэгэхдээ энэ нэг зарчимтай, жудагтай, авлига, ашиг сонирхлоос л ангид байх бол энэ улс орны оршин тогтнохуй цаашидаа хөгжиж дэвшихийн баталгаа, энэ төр цэвэр тунгалаг байхын үндэс гэдгийг бол мэдэхийн дээдээр мэдэж байгаа. Гэхдээ үүнийг бол би үзэхгүй юм байна гэдэг нэг жаахан тийм ойлголттой байсан хүн байгаа юм. Үүнийг ч бол тэгээд сайн цагийг ч үзэхгүй юм байна даа гэж бодож. Гэтэл бол энэ намын дарга Ерөнхий сайд энэ асуудлыг тавилаа, тавих байтугай шийдвэрээ гаргах гээд ингээд хуулийн төсөл санаачлаад оруулаад ирж байгаа. Ингэж байж нэг жаахан газрын дээд талд гарч зогсох хэрэгтэй юм байгаа юм. Энэ улс төрийн ууган хүчин бол ингэж байж ёс зүйн өндөрлөг дээрээ баттай зогсож

байж дараагийн асуудлаа ярих хэрэгтэй. Энэ бол үнэхээр зөв зүйтэй асуудал.

Энэ Засгийн газрын хурлаар хэлэлцэж байхад ч би дэмжсэн байр сууриа хэлж байсан. Ингээд бас Их Хурлын бүтцийн байгууллагуудаар хэлэлцэж байхад байр сууриа илэрхийлж байсан. Гэхдээ бол энэ дотор ер нь ард нь гарахад бол амаргүй ийм нөхцөл байдлууд байсан, одоо ч байгаа. Энэ Үндсэн хуулийг зөрчиж байна, хүний эрхийг хөсөрдүүлж байна олон зүйлүүдийн сайхан сайхан нэр хаягтай тайлбарыг үндэслэлүүдийг бол гаргаж байгаа. Тийм ч учраас намын дарга бол энэ Их Хурлын чөлөөт цагт эрх барих тэр намын Бага хурлаараа хэлэлцүүлээд энэ хуулийн төсөл энэ шийдвэрийг бол дэмжихээр ингэж тогтсон байх гэж ингэж бодож байгаа.

Тэгээд тийм учраас энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг нь шийдэж санал өгөхийг хэдүүлээ харцгааж байя. Ард түмэн харж байгаа. Ингэж байж нэг жоохон цэгц журамдаа орвол орно. Үнэхээр бол хэрээсээ хэтэрсэн шүү. Их Хуралд сонгогдох л юм бол эхнэрээ юм уу, нөхрөө заавал дарга болгоно. Тэгээд л өөрийнхөө нүүс, компанийг дэмжсэн, энэ төр ард түмний нэр барьсан зээл, бонд элдэв туухай юмнаас авна. Магадгүй тэр төсөл нь зөв байж болно. Гэхдээ Их Хурлын гишүүн, энэ засгийн сайд, ажил хариуцаж байгаа улсууд болбол ийм юманд ороход болохгүй ээ л гэдэг байр суурийг би энэ бүх Их Хуралд сууж байх хугацаандаа би хэлж, зарим улсад ад болж ингэж явсан. Гэхдээ тэр миний тавьж байсан шаардлага энэ бол зүй, ёсны зарчмын, зөв юм гэдэг нь алхам тутамд батлагдаад явж байгаа юм.

Ингээд энэ дараа дараагийн Их Хурал болбол төлөвших, энэ парламентын засаглал сайжрах, энэ улс орон нэг нар үзэх, энэ ард түмний аж амьдрал байдал нэг дээшлэхэд бол бодитой ийм бололцоо гарах байх. Би энэ бизнес хийж байгаад Их Хуралд орж

ирсэн улсуудыг би бүгдийг нь хэлдэггүй шүү дээ. Үнэхээр тэнд хуримтлуулсан туршилагаа энэ улс орны сайн сайхны төлөө зориулж байгаа хүмүүсийг би хэлээгүй шүү дээ.

Л.Мөнхбаатар: Хуулийн төсөлтэй холбогдуулан Бат-Эрдэнэ гишүүн байр сууриа илэрхийлж, үг хэллээ.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Одоогоос бараг 2 жилийн өмнө 2021 оны 12 сарын 06-нд МАН-ын 30 дугаар Их Хурал хуралдаж энэ авлигатай тэмцэх ажлыг ер нь бол бас эхлүүлнэ ээ гэсэн том мессежийг өгч байсан. Магадгүй тэр үед бас олон хүн эргэлзэж байсан байх. Өнөөдөр бол энэ авлигатай тэмцэх үйл явц энэ эрх зүйн хүрээнд бол бас маш том эргэлтүүд ирж байна гэж ингэж харж байгаа. 30 жил үүнийг ярьсан боловч 30 жил зүгээр ярьснаас өөр юм хийгээгүй байсан энэ үйлдэл өнөөдөр харин ажил хэрэг болж байна.

Өнгөрсөн оны 12 сард баталсан тэр Эрүүгийн хуулийн өөрчлөлт гэдэг бол өөрөө авлигатай тэмцэх маш том эрх зүйн том өөрчлөлт орсон юм байна лээ. ЖДҮ-ийн гэмт хэрэгт оролцсон гишүүн хэдэн жилийн ял авлаа. Өнөөдрийн Эрүүгийн шинэ хуулийн өөрчлөлтөөр хэрвээ тийм зүйл хийх юм бол 12-20 жил гэдэг маш том зүйл ингээд яригдаж байх жишээтэй. Тэгээд ард түмний дунд энэ ургийн мод, энэ ууж идэж ханадаггүй энэ сан, сан нээгдэх болгонд л ард түмний үс босож байсан юм шүү дээ. Бүх сангаас л энэ улс төрд нөлөө бүхий этгээдүүд, түүний ар гэр, ах дүү, амраг садан, үр хүүхэд, бүгдээрээ шавчихсан. Олон боломжуудыг үгүй хийсэн юм байна лээ. Би энэ Хөгжлийн банкны жишээг бүүр нэг жишээ татмаар санагдаад байдаг юм. Монгол Улсын Ерөнхийлөгч энэ Хүнсний хувьсгал хийнэ ээ гээд 5 жил хийхэд Монгол Улсын хэмжээнд энэ 3 сая 300 мянган хүний хүнсийг хангахад 1,8 их

наяд төгрөг хэрэгтэй юм байна лээ шүү дээ. Гэтэл Хөгжлийн банкны энэ салаагаар урсгасан мөнгө нь 1,8 их наяд байх жишээтэй. Тэгэхээр ийм их боломжууд энэ ашиг сонирхлоо зохицуулж чадаагүйгээс бас байсан юм билээ. Тэгээд ард түмэн бол өвөл тойргоороо яваад уулзаж байхад үнэхээр энэ ЖДҮ-ийн, энэ нүүрсний, энэ Хөгжлийн банкны хулгай гээд ер нь Монгол Улсад ирээдүй байна уу, үгүй юү гэдэг дээр маш их эргэлзээтэй, ээ мөн яана даа гэсэн ийм байдалтай байсан. Энэ харин Эрүүгийн хуулийн өөрчлөлт энэ бүх зүйлүүдийг хараад ер нь бас нэг юм наашаа эргэх гээд байна уу даа гэсэн ийм бодолтой байж болж байсан юм билээ. Тэгээд энэ үеэр ч гэсэн энэ хуулийг ард түмэндээ бас ярьж танилцуулж байсан ийм хууль өргөн бариад хэлэлцүүлж эхэлж байгаа. Тэгэхээр нэг хүү минь наадхаа нэг яаралтай батлаарай, дэмжиж өгөөрэй гэсэн ийм зүйлийг ард иргэд хэлж байсан. Тийм учраас энэ хуулийг бол энэ парламентаас дэмжиж, ингэж гаргах нь зүйтэй байх гэж ингэж бодож байгаа.

Ер нь бол тэгэхдээ явж явж төрд ажиллаж байгаа хүн болгонд мэдээлэлд ойрхон байх энэ боломжийг нэг ашиглавал өөрт ашигтай байх ийм юмтай алхам тутамдаа өдөр тутамдаа тулж л явдаг. Тэрийг өөртөө ашиглах уу, ард түмэндээ тэр боломжийг нь ашиглуулах уу гэдэг энэ сонголтын өмнө төрийн бүх албан хаагч нар л байдаг юм. Тэгэхээр энэ төрийн алба өчигдөр баталсан тэр төрийн албан хаагчийн ёс зүйн хууль ч гэсэн үүнтэй бол би бас цаагуураа уялдаж байна гэж ингэж харж байгаа. Эрүүгийн хууль, энэ ашиг сонирхлын хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль гээд энэ бүгдээрээ энэ төрийн албан хаагч нар бол бас энэ ашиг сонирхлоос хол байх энэ том зүйлийг бас нээж өгч байна гэж ингэж бас харж байна.

Ер нь бол тэгээд Монголын ард түмэн, энэ ЖДҮ, энэ Хөгжлийн банк, энэ

нүүрсний хулгай, тэр ТЭДС гээд яригдаж байгаад таг болчихсон. Тэр бас л бөөн булхай л байгаа. Тэгээд энэ болгоныг хараад үнэхээр тэвчихээ болиод энэ талбай дээр гарч жагссан, ямархуу юм болсон бүгд та бүгд бүгд бэлхнээ мэдэж байгаа. Гэхдээ энэ бол зүгээр намжчихсан байгаа болохоос биш энэ зүйлийг ийм зүйл болж байгаа гэдгийг энэ Монголын ард түмэн бол мартаагүй байгаа. Мартах ч үгүй байх аа. Тэгэхээр цаашид ийм зүйл гаргахгүйн төлөө энэ Монголын төр ард иргэдийнхээ өмнө бас нэг хүндлэгдэх тийм орон зайтай байх энэ л том зүйлийг энэ хууль, эрх зүйн хувьд бас өөрчлөлт орж байна л гэж ингэж бас харж байгаа гэдгээ би дэмжиж үг хэлье гэж ингэж бодсон юм байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүн дэмжиж үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүртэл гишүүн л үг хэлж болно шүү. Учрал гишүүнээр тасаллаа. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

С.Бямбацогт: Тийм, яах аргагүй л бас гарцаа байхгүй цаг үеэ олсон асуудал байх гэж бодож байгаа. Өнөөдөр бас төрд итгэх ард түмний итгэл их унасан байна. Их Хурлын гишүүдийг, Засгийн газрын гишүүд, сайд нарыг, төрийн дарга нарыг, албан тушаалтнуудыг, ер нь ТӨК-ийн захирлуудыг гээд ер нь л бүгдийг нь харахаараа л нэг дарга харахаараа л Их Хурлын гишүүд сайд харахаараа л бараг л бүгдээрээ л нэг хулгайч юм шиг хардаг болчихсон ийм болчихоод байгаа. Үүнийг болбол тийм үү, нөгөө нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино гэж. Нэг цөөхөн хэдэн нөхөд ийм байдалд үндсэндээ бол төрийн үнэлэмжийг доош нь ортол нь унагааж байгаа юм л даа. Тийм болохоор гарцаа байхгүй энэ юу гэдэг юм,

албадлагын арга хэмжээ авч байж, нөгөө гэрийг цэвэрлэхдээ дээрээс нь эхлээд шүүрддэг, хог тоосыг цэвэрлэхдээ түүнтэй адилхан дээрээсээ эхлээд тийм үү. Төрийн өндөр албан тушаалтнаасаа эхлээд албадлага энэ хуулийн хатуу хариуцлага, ёс зүйгээр шийдэж чадахгүй асуудлаа шийдэх асуудлыг хуульчилж байж шийдэхгүй бол ингэж байж бас төрд итгэх ард түмний итгэл сэргэх ёстой цаг болсон байгаа. Тийм учраас энэ хуулийг дэмжиж байгаа.

Жоохон тарган хүн толинд харахаараа турчих юм сан, хоолой сойно гэж боддог. Эргэж хараад л хоол харахаараа нөгөө турахаа мартаад, хоолоо сойхоо мартаад л хоолоо ховдоглоод иддэг. Яг түүнтэй адилхан авлигач хүн чинь ерөөсөө 1 авлига аваад сурчихсан хүн чинь тэгээд авлига авахгүй байж чаддаггүй юм байна. Хулгайч хүн чинь бас нэг хулгай хийгээд сурчихсан хүн чинь бол ядаж тийм үү эхнэрийнхээ ч юм уу тийм ээ, хүүхдийнхээ юмыг хулгай хийж байж унтдаг, нойр нь хүрдэг гэдэгтэй адилхан хулгай хийж чаддаггүй юм байна л даа, хулгай хийхгүй байж. Тийм болохоор ийм хүмүүс л энэ төрд орж ирээд, энэ төрийн үнэлэмжийг, энэ төрд итгэх ард түмний итгэлийг унагаагаад байгаа юм. Унагаагаад байгаа юм. Тийм болохоор энэ хуулийг бол зайлиггүй бас батлах ёстой байх.

Өнөөдөр хулгай бий болчихсон юм биш ээ. Өнгөрсөн 30 жил бас энэ байсан. Алдартай, алдартай авлигач, алдартай, алдартай хулгайч нар бас төрд үеийн үед байсан шүү дээ. Бүр байнга л яригдаж байдаг байсан 20 жилийн өмнө яригдаж л байдаг байсан. Энэ асуудлыг цэгцлэх гээд, цэгцлэх гээд Монголын төр бас олон жил явж байгаа. 2010 онд, 11 онд, 12 онд ХОМ гаргадаг болсон. Нийтийн албан тушаалд хамаарал бүхий этгээдийг хориглодог, хязгаарладаг болсон. Шилэн дансны хуулиар бас төсвийн мөнгийг бас үр ашигтай зарцуулах ёстой хууль гарсан. Дараа нь бид нар Улсын бүртгэлийн багц хуулиудыг батлаад

мэдээллийг нээлттэй болгоод хүмүүсийн эзэмшдэг хувьцаа, компани, хамаарал бүхий этгээдүүд бүгд тодорхой ил тод болсон. Үүнтэй холбоотой нэг ЖДҮ гээд олон асуудлууд ил тод болсон. Иймэрхүү байдлаар ингэж үе үедээ л бас амьхандаа л хичээгээд л яваад байгаа. Хичээгээд. Одоо эцэст нь арга буюу юу гэдэг юм, төрийн өндөр албан тушаалтнуудын хамаарал бүхий хүмүүсийг төртэй холбоотой бизнес, тендер, төрөөс зээл, хөтөлбөрт хамрагдах, ТӨК-д шахаа хийх энэ бүгдээс хориглосон, хязгаарласан хуулийг батлах гэж байгаа. Ийм учраас энэ хууль зайлшгүй гарах ёстой байх. Ингэж албадлага бас хэрэглэх нь зөв байх.

Ер нь бол бас Их Хурлын гишүүн, төрийн өндөр албан тушаал хаших гэж байгаа хүн тийм үү, бусдын эрхийн төлөө, бусдын сайн сайхны төлөө бас өөрийнхөө эрхийг хязгаарладаг, хязгаарлуулж чаддаг байх ёстой. Их Хурлын гишүүнээр сонгогдохдоо л уулыг эргүүлнэ, уулыг нь нурааж усыг эргүүлнэ гэдэг тийм үү. Үнэхээр би төр түмний төлөө хоёргүй сэтгэлээр шударга ажиллана гэж сонгогддог, сонгогдсон хойноо хийсэн ажил, бүтээсэн юм юу байна гэхээр хийсэн ажил ч байхгүй, бүтээсэн юм ч байхгүй. Тэгээд л нэг бэлэг, хачиг тараасан энд тэндээс хүн амьтан шантаажилж, сайд дарга нь нэг үүд хэсэж, ажил хувийнхаа ажил хэргийг амжуулсан ийм л байдалтай яваад байгаа шүү дээ, харагдаж байгаа шүү дээ, хүмүүс мэдэж байгаа шүү дээ. Тэгээд иймэрхүү юмнуудыг таслан зогсоох ёстой, таслан зогсоох ёстой.

Их Хурлын гишүүн юм бол тэр өргөсөн тангарагтаа үнэнч, амласан амлалтаа биелүүлж, тэр улс орноо хөгжүүлэх, тэр сонгогдсон тойрогтоо хийж бүтээх ажлаа хийж бүтээх, энэ зүйлдээ илүү анхаарч хийсэн ажилтай хэлэх үгтэй бас нэг тийм хүнд харагдах үзэгдэх нүүртэй амьдрах ёстой. Ингээд бас энэ хуулийг бас дэмжиж бид нар бас батлах ёстой байх. Ингэж байж бас

төр итгэх ард түмний итгэлийг бид нар сэргээнэ. Тийм учраас дэмжиж байгаа.

Л.Мөнхбаатар: Цэрэнпиллийн Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр хуулийн төслийг бол дэмжиж байна, дэмжиж үг хэлж байгаа юм. Ер нь яалт ч байхгүй нэг ийм хууль хэрэг болсон л доо. Тэр цаг нь ч болсон байна. Өнөөдөр нийгэм юунд дургүйцэж байна гэхээр эрх мэдэлтэй улсууд төрийн эрх мэдлийг ашиглаад ард түмнийхээ боломжийг хулгайлж байна гэж. Энэ үнэн. Түрүүн Бямбацогтын хэлдэг ч үнэн. Нэг цөөхөн хэдхэн хүн л холбогддог байхгүй юу. Би ингээд л ЖДҮ-г харж байхад тийм ээ, Хөгжлийн банкнийг харж байхад, нүүрсний хулгайг харж байхад, тэгээд нөгөө олонхоо чирчихдэг. Тэгээд нийгэм юу гэж хардаг вэ гэхээр нөгөө Их Хурлын хэдэн гишүүн гэж ингэж хардаг. Тэгэхээр энэ хууль гарснаараа бол төрийн өндөр албан тушаал, эрх мэдлээ ашиглаж энэ ард түмний боломжийг хулгайлж байгаа улсуудын хулгай бол би багасна гэж ингэж бодож байна. Ямар ч гэсэн эрх зүйн хувьд нэг том алхам болно. Бас энэ эрх мэдлээ ашиглаж байгаа, энэ улс төрчтэй тэмцье гэж байгаа энэ тэмцэл ч гэлээ гэсэн энэ бол нэлээн том бодитой түлхэц болох байх гэж би ингэж бодож байна.

Бас энэ нөгөө талаасаа энэ нэг төрд орж ирээд манайх чинь нэг зах зээл нь өөрөө их муу юм. Тэгээд төр лүү ороод л ирдэг. Ерөөсөө бизнес хийж байгаад л төр лүү ороод л ирдэг. Тэгээд нөгөө энэ гайгүй яваа хэдэн бизнесменүүд нь үндсэндээ ер нь нэг хэдхэн бизнесээс бусад нь бараг Их Хурал руу ороод ирлээ шүү дээ. Энэ нөгөө төр барих байгууллага биш бизнес хийдэг байгууллага болоод хувирчихсан. Тэгэхээр ингэж хязгаарлахаас өөр арга байхгүй. Одоо харин хүмүүс улс төрийг сонгох уу, бизнесийг сонгох уу гэдгийг чинь л ялгаж өгөх л ийм хууль болж өгөх байх гэж ингэж бодож байна.

Нэг хэсэг нь бол тэгээд бизнесээ хөөгөөд яв, бизнесийнхээ амьдралаар яв, нэг хэсэг нь бол төрдөө ор гэж яг ингээж зааглаж өгөхгүй бол угаасаа болохгүй байгаад байна шүү дээ. Төрөө бизнесийн машин болгож байна шүү дээ. Тэгээд энэ асуудалд цэг тавьтал мэдээж хугацаа шаардагдана. Тэгэхдээ энэ бол нэг том алхам болно. Олон ч хүн сонголтоо хийх байх цаашидаа гэж бодож байна. Одоо 24 оны сонгууль гэхэд. Бизнесээ хийх нь бизнесээ хийгээд л явцгаа. Бизнес төр 2 тусдаа байх ёстой. Тэгэхгүй бизнесээ амжилтгүй болсныг төрд орж ирж нөхнө гээд байх юм бол яг л ийм л юм болж байгаа байхгүй юу. Би бол тэр Хөгжлийн банк, энэ нүүрсний энэ асуудлыг үзчихээд бол гайхаж л байсан л даа. Заримыг нь ч би бүр нэр дурдаад л хэлж л байсан. Тэгээд сая зарим нь тэгээд чив чимээгүй л байна. Тэгэхдээ ер нь бол цаашидаа энэ хуулиар хязгаарлах нь нэг өөр. Мөн би хэлээд байгаа шүү дээ. Ер нь нэг төрөөс эд нарыг хязгаарлах юм бол бас тэр ард түмнээр шүүрдэх шүүр мөн шүү. Ард түмэн чинь бас сонгуулиар яг энэ хулгайч нарыг чинь шүүчхээд байгаа шүү. Харин пропорциональ тогтолцоо оруулж ирээд дараагийн сонгуульд энэ хулгайч нар чинь энд малйгаад сууж байх юм бол ард түмэн эсэргүүцнэ шүү. Энэ нэг алхам болог. Тэр ард түмний шүүр нь ч би байгаасай гэж бодож байгаа юм. Ард түмэн шүүрддэг байг. Тэгж байж энэ энэ Их Хурал, энэ төр чинь өөрөө яг төрийн жинхэнэ төрийн төлөө сэтгэлээ гаргаж зүтгэдэг улсуудын байгууллага болно шүү дээ. Бизнес хөөдөг хүний байгууллага биш байхгүй юу энэ чинь. Энэ асуудлыг л бид нар нэлээн төрийн ажил тусдаа, бизнесийн ажил тусдаа ийм л болох нэг алхам өнөөдөр бас Монголын төрд хийгдэж байна гэж би харж байна.

Тийм учраас хуулийн төслийг болбол дэмжиж байна.

Л.Мөнхбаатар: Ням-Осорын Учрал гишүүн үг хэлье.

Н.Учрал: Энэ хулгай хийх боломж өөрөө хулгайчийг төрүүлж байгаа юм. Тийм учраас боломжийг уг үндсээр нь устгахгүйгээр цаашидаа энэ төрд нүүрлэсэн хулгайтай тэмцэнэ гэж байхгүй. Тийм учраас энэ хууль, эрх зүйн шинэчлэл нь гүйцэтгэх засаглалаас явуулж байгаа бодлоготойгоо параллелийн байдлаар ингээд урагшлах ёстой. Тийм ч учраас өнөөдрийн энэ хууль бол нэлээдгүй бас дэвшил авчирна. Тэгээд төрд ажиллах, хувьд ажиллахаа өөрөө сонгох сонголтыг өгөөд ирэхээр бүгдээрээ Их Хуралд нэр дэвшиье гэдэг сонирхол нь мэдээж байхгүй болно шүү дээ. Тэгэхээр өглөө нь төрийн хүн, үдэш нь компанийн захирал хийнэ гэдэг бол энэ өөрөө байж боломжгүй зүйл. Тэгэхээр сонголтоо хийх л ёстой. Тэгэхээр үнэхээр сонголтоо хийгээд төрдөө зүтгэнэ гэсэн бол төрийнхөө төлөө тэгээд хоёргүй сэтгэлээр зүтгээд, бусдад тэгш боломжийг олгох л ёстой. Тэгэхээр энэ хууль, эрх зүйн орчин бол бас өөрчлөлтийг авчирна.

Энэ Засгийн газрын энэ жилийн энэ авлигатай тэмцэх жил болгож зарласан ажил бол нэлээдгүй эрчтэй явж байгаа. Энэ Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан энэ “5 Ш” ажиллагаа, миний хариуцаж байгаа энэ шилэн ажиллагааны хүрээнд бол 7 хоног болгон энэ индексийг зарлаж байгаа юм. 3 сарын 27-ноос хойш 1 сарын хугацаанд энэ shile.gov.mn гэдэг ил тод байдлын веб хуудсанд сая 384968 удаагийн хандалт хийгдсэн байгаа юм. Засгийн газрын тусгай сангуудаас 2 сан нь нээгдсэн. Шилэн индекс зарлаад эхэлсэн чинь ХАА-н сан дээр 150 орчим тэрбум байсан. ЖДҮ-ийн сан дээр энг 200 орчим тэрбум байсан төлөлт нь сар хүрэхгүй хугацаанд 500 саяар өсчихсөн. Энэ дотор 4, 5 тэрбум төгрөгийн зээлтэй зарим компани, ААН-үүд, зарим улс төрчидтэй хамаарал бүхий, компаниудтай хамаарал бүхий байна гээд янз бүрийн мэдээллүүд түгсэн. Үүний дараа иргэд юу гэсэн бэ гэхээр өнөөдөр банкны зээлтэй, цалингийн зээлтэй, тэтгэврийн зээлтэй,

бид нарыг 7 хонуулдаггүй байж ямар нь ингээд хэдэн 10 тэрбумаар нь зээлчхээд хэдэн 10 жилээр нь яваад байдаг юм бэ. Төрд байгаа албан хаагч нар шударга ажиллая гэхээр энэ тэгш боломж чинь бий болохгүй байна шүү дээ гэдгийг эсэргүүцэж байгаа юм. Тийм учраас иргэд мэдэх эрхээ авахыг хүсэж байна.

Хэрвээ бүх үйл ажиллагаа, төрийн үйл ажиллагаа ил тод нээлттэй болоод эхлэх юм бол хэн ч тэнд хулгай хийх боломжгүй болно.

Дээрээс нь төрийн төлөө зүтгэж байгаа энэ төрийн албан хаагч нар шийдвэр гаргахдаа урам зоригтой болно. Хэн нэгэн нөлөөлөхгүй болно. Ил тод технологид суурилсан шийдлээр асуудлыг шийдээд хүнээс хамааралгүй шийдлээр энэ бэрхшээлүүдийг даваад ирэх юм бол үүний цаана ийм ил тод байдал болоод эхлэхээр шударга байдал тогтоно л гэж үзэж байгаа. Өнөөдөр шилэн ажиллагааны хүрээнд энэ ашигт малтмалын хайгуулын лицензүүд, ашиглалтын лицензүүд бүгд ил болсон. Дархан цаазтай газрууд бүгдээрээ ил болсон. Хэн гэдэг компани, ААН ямар иргэн, хаана ямар газар аваад байгаа юм, зөвшөөрөл хэн хэн ямар компани эзэмшээд байгаа юм. Үүний хүрээнд энэ үндэсний томоохон компани, ААН-үүдийгээ бид нар шилэн индексийн хүрээнд хамгаалж байгаа. Хэн нэгнийг худлаа мэдээллээр битгий гүтгээч ээ, бодитой асуудалд дата дээр анализ хийж дүгнэлт гаргаач ээ гэж байгаа юм. Тэгэхээр энэ Засгийн газрын авлигатай тэмцэж байгаа бодлого бол иргэдэд тэгш боломжийг хүртээх болоод чөлөөлөлт нэг ёсондоо, шилэн ажиллагаа ч бай ил тод байдал гэдэг бол чөлөөлөлтийг бий болгоно. Тэгээд өнөөдөр төрийн өмчийн байр ямархуу менежментүүдийг хийж байна гэдгийг нь 5 мянга гаруй квадратныг нь гаргаад л тавьсан. Хэн гэдэг этгээд ямар үнэ хөлс төлөөд төрийн өмчийн байрыг эзэмшиж байна бүгдээрээ л ил болгож байгаа. Бид нар олон жил энэ асуудлыг шийдээгүй

байсан. Хууль гараад 68 мэдээлэл ил болсон. Ингээд шилэн индекс урагшилж байгаа.

Ерөнхий сайдын албан даалгаврын дагуу 5 дугаар сарын 31-ний өдөр Ерөнхий сайдад энэ шилэн ажиллагааныхаа талаар мэдээллийг хийнэ. Нөхцөл байдал ямар болсон бэ гээд. Ингээд албан даалгаврын дагуу бас энэ чинь тодорхой хариуцлага хүлээлгэх асуудлуудыг энэ албан даалгавар дээр дурдсан байгаа. Ирэх 7 хоногт бид нар энэ Хөдөлмөр эрхлэлтийн сан, энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сан. Энэ олон жил хулгай дээрэм тонуулд баригдсан энэ нийгмийн даатгалын санг ил болгоно. Ингээд л иргэд хяналтаа тавь. Төрийн үйл ажиллагаа алган дээр нь байгаа юм шиг иргэд хянадаг болсон цагт цаашидаа энэ төрд зүтгэх хүмүүс өөртөө итгэлтэй, урам зоригтойгоор ажиллах нөхцөлийг л энэ авлигатай тэмцэх бодлого л бас бодитоор харуулж байгаа гэж ойлгож байгаа.

Тийм учраас энэ хууль, эрх зүйн шинэчлэлтэй Засгийн газрын гүйцэтгэх засаглалын ажил зэрэг явж байж бид нар энэ олон жил бугшсан асуудлаас хамтдаа гарах ёстой. Тийм учраас энэ авлигатай тэмцэх энэ ил тод байдлыг дэмжих бодлогыг хүн болгоныг бас дэмжээсэй л гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёолоор санал хураая. Санал хураалт. 90,4 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

18.25 цаг.

Дараагийнхаа асуудалд оръё. Одоо 3 асуудал байгаа.

Дараагийнхаа асуудалд оръё.

Дөрөв. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Мөнхцэцэг гишүүнийг индэрт урьж байна.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улс дахь хүний эрх чөлөөний байдлын талаар 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдөр, Улсын Их Хурал 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцсэн

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар илтгэл тайлан хэлэлцэх үед хуралдаан даргалагч Монгол Улсын

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах чиглэлийг ХЗБХ-нд өгсөн болно. Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасныг баримтлан “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах болон ахмадын эрхийн зөрчилтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар иргэдийн үг хэлэх, халдашгүй зүйл байх эрх, жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчлэн найруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгаа, цалин хөлсний асуудал, улсын хил дээр үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийн гэр бүл, нийгмийн асуудлыг анхаарах шаардлага үүссэн талаар, түүнчлэн дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох, хөгжих эрхийг зөрчиж байгааг холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны яам онцгойлон анхаарах, мөн иргэний үндсэн эрхийн суурь үзэл баримтад нийцүүлэн жагсаал цуглаан хийх журмын тухай хууль тогтоомжийг шинэчлэх, эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц яаралтай байгуулах талаар, Улсын Их

Хурлын гишүүн Энхбаяр Хууль зүйн байнгын хороо Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн 2 олон нийтэд нээлттэй, ил тод, олон талаас нь сэдэв тус бүрээр хагас сонсгол хэлбэрээ дэлгэрэнгүй хэлэлцүүлсэн талаар онцолж, илтгэл, тайланг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн тусгаж, тогтоолын төслийг боловсруулсан талаар үг хэлсэн болно.

“Монгол Улс дахь хүний эрх, эрх зүйн байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу юу 66,7 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Жаргалсайханы Хунан, Хүний эрхийн Үндэсний Комисс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Ядамжавын Цэлмэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батцэцэгийн Энхболд нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Даваасүрэн гишүүн, Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, энэ хүний эрхийн комиссыг би нэг энэ томилж байгаа Их Хурлынхаа байгууллагад хандаж хэлэхэд байна шүү дээ. Нэг энд нэг сэтгэл гаргаад ажиллачихмаар улсууд тавимаар байгаа юм. Одоо би эд нарыг буруутгаж чадахгүй. Эд нар нөгөө угаасаа энэ хүний эрхийн комиссыг тавихдаа нэг хэл үггүй ажиллачих гэсэн, нэг үгэнд орно гэдэг шалгуураар ч юм уу нэг хүмүүс тавьдаг юм шиг байгаа юм. Тэгээд тэр эрх ямбанд нь болгодог юм уу? Ингээд л нэг хүн тавьчихдаг. Нөгөөдүүл нь тэр янз бүрийн асуудалд холбогдож байгаа улсуудынхаа төлөө явж байгаа юм бол маш бага юм. Би та нарт нэг асуудал тавьсан. Тийм ээ, 8 сард тавьсан.

Улсын Их Хурлын гишүүн чинь асуулга, асуултынхаа хариуг хуулийн хугацаанд авдаг юм шүү дээ. Тэгэхэд та нар тэрийг нь өнгөрөөчхөөд хэдэн сарын дараа надад хариу өгч байгаа байхгүй юу. Яагаад гэвэл, тэр үед талбай дээр байсан хэдэн залуучуудыг барьж хорьсон. Тийм ээ, 2, 3 ч хүнийг бариад хорьчихсон. Тэгээд би та нарт асуулт явуулсан байхгүй юу. Одоо энэ асуудлыг ингээд шалгаад үнэхээр тэрэнд нь гранат тэр юунд нь байсан юм уу, тэр сейфэд нь байсан юм уу, үүнийг нь шалгаад явуулаач, байхгүй. Тэгээд би бол бүрэн итгэл алдарсан. Монгол оронд бол хүний

эрх гэдэг бол үнэхээр зүгээр тоглоом, ярианы сайхан сэдэв. Ийм л юм юм байна лээ. Өнгөн дээрээ сайхан хүний эрх ярьдаг, яг үйлдэл дээрээ болбол хүний эрхийг энэ байгууллага нь тэгж хөөцөлдөж, сэтгэл гаргаж явдаг ийм юм бол огт байхгүй юм байна лээ. Огт байхгүй юм байна лээ. Тэгэхээр энэ хууль хүчний байгууллагын юун дээр жирийн иргэд бол маш ихээрээ бол хэлмэгдэж байгаа гэдэгт бол би эргэлзэхгүй байна.

Нөгөөдүүл нь гарч ирээд дуугарч чадахгүй байгаа байхгүй юу. Хөөрхий амьтас. Одоо юу гэж гарын үсэг зуруулаад тэд нарыг гаргачихдаг юм мэдэхгүй, дуугарч чадахгүй. Уулзахаар нэг тийм юу байдалтай, нэг айсан байдалтай, тэгээд надыг юм ярьж болохгүй гэсэн гээд л ингээд л хөөрхий нэг юм буюунаад л, ийм л хүний эрхийн орчин Монголд байна. Тэгээд би хүний эрхийн байгууллагын Их Хуралд гол Их Хурлын байгууллагын хувьд болбол энэ хүмүүсийг тавихдаа бас нэг сэтгэл гаргаад ажиллачихмаар ийм улсууд тавья. Одоогийн энэ ажиллаж байгаа улсуудынхаа асуудлыг ер нь нэг ойрын үед нэг эргэж харъя. Би тийм асуудлыг Байнгын хороонд оруулъя. Энэ улсууд ажиллаж чадахгүй байна. Тэгээд энэ худлаа үнэн тайлан гээд л нэг ийм юм оруулж ирээд л ёс төдий. Та нар ч гэсэн ингээд л ёс төдий хэлэлцсэн болоод цаана чинь жирийн иргэний эрх хохирч байна шүү дээ. Олон хүний эрх хохирч байгаа шүү дээ, тэр чинь хэцүү шүү дээ. Энэ хууль хүчнийхэн байгууллага нь ч гэлээ гэсэн нөгөө хуучин арга барилаасаа салж чадаагүй. Тэгээд миний нэг итгэл алдарсан юм бол саяын тэр Зоригийн амь настай холбогдолтой асуудал тийм үү? Одоо би бүр итгэхээ больсон. Хэн нь зөв шүүдэг юм, хэн нь зөв ялладаг юм, хэн нь зөв ял оноодог юм. Би итгэхээ больсон. 3 шатны шүүхээр шийдсэн юмаа өнөөдөр хүн үгүй ээ хэрвээ хэлмэгдсэн юм бол яагаад тэр шүүх прокурорууд нь ял авахгүй байна? Тэгээд хүн хэлмэгдүүлчихсэн юм болбол. Яагаад түүн дээр нь таг болчхов? Одоо төрөөс

нэхэмжлэх юм яриад л байгаа болохоос биш тэр хэлмэгдүүлсэн улсуудыг яллах юм нь байхгүй. Нэг ийм л Монгол орон байна. Тэгээд та хэдэд би юу хэлэх вэ? Та хэд бас тэгээд л энэ нэг дарга нарын юугаар тавигдчихсан хөөрхий, тэгээд үг хэл яг энэ сэтгэл гаргаад, зориг гаргаад явж чадахгүйг чинь би ойлгож байна. Та нарт юу хэлэх вэ?

Тэгэхдээ бид нар тийм хүн тавимааргүй байна. Бүр нэг зориг сэтгэл гаргаад ингээд яваад байхаар, тэнд очоод энэ эрхээ эдлээд, хэрвээ эрхийг нь зөрчигдөөд байгаа бол бид нар руу хандаад, тэгээд Их Хурал нь энэ тэр ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Даваасүрэн гишүүн үг хэллээ. Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Надад энэ хүүхдийн эрхтэй холбоотой хэд, хэдэн асуулт байна. Ер нь бол хүүхэд эцэг эхээ сонгохгүй, тэгээд бурхны тааллаар тэгээд л аав, ээж дээрээ төрөөд ирдэг. Манай БЗД-т бол гэр хороолол ихтэй, амьжиргааны түвшин доогуур өрхүүд их байна. Мөн нийгмийг хамарсан нэг энэ архидалт, согтууралт гэдэг нэг бүр өвчин газар авсан. Тэр гэр бүлд өсөж байгаа хүүхдүүдийн эрх асар их зөрчигдөж байгаа. Тэгэхээр та бүхэн энэ архидан согтуурах өвчин бүр эмгэгтэй болчихсон хүмүүсийн үр хүүхдүүдийг нь аав, ээж нь бүр хоёулаа тийм болсон хүүхдийг эцэг эхийг нь эрхийг нь хасаж, буцаагаад эмчилгээнд ороод тэр эцэг эх нь буцаад эрүүл болоод хүүхдээ буцаагаад авсан тийм тохиолдлууд байна уу? Тийм судалгаа байна уу, хэлж өгөөч. Энэ согтууруулах, согтуурах, мансуурах, энэ өвчинд өвчтэй болчихсон, эмгэгтэй болчихсон улсуудын хүүхдүүдийг хамгаалах чиглэлд та бүхэн ямар ажил хийж байна? Энэ Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл дотор бол хүүхдийн эрхийн талаар энэ талаар ер нь ямар нэгэн дурдагдсан зүйл алга байна. Тэгэхээр энэ та нарт

хамааралгүй асуудал уу? Энэ чиглэлээр ямар судалгааны ажлууд, ямар хайлтууд, ямар дэвшилүүд, юу хийх ёстой юм бэ гэдгийг хэлж болох уу?

Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Эрүүл Монгол хүн хөтөлбөр дотроо оруулсан нэг чухал асуудал бол энэ архидан согтуурахтай тэмцэх асуудал байгаа юм. Тэгэхээр үүнтэй холбоотой нэг ч энэ өгүүлбэр алга байна. Тэгэхээр энэ хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудал энд хамааралгүй юм болов уу? Энд хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя 81 дүгээр микрофон уу. Хунан дарга хариулъя.

Ж.Хунан: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Хүний эрхийн Үндэсний Комисс Хүүхдийн эрхийн асуудалд бол онцгой анхаарал хандуулдаг гэдгийг бас хэлье, юуны өмнө. ХЭҮК 21 дэх илтгэлдээ энэ хүүхэд хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хамтарсан багийн үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байрны үйлчилгээтэй холбоотой асуудлыг хөндөж 21 дэх илтгэлдээ тусгаж оруулсан байгаа. 22 дахь илтгэлд бол энэ хүүхэд хамгааллын бас нэг бүтэц болох одоо яг таны хэлээд байгаа энэ гэмт хэргийн хохирогч, холбогдогч, гэрч болсон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх энэ бүтэц хэрхэн яаж ажиллаж байгаа талаар энд тулгамдаж байгаа асуудлын талаар тусгаж оруулсан байгаа.

Энэ тогтоолын төсөлд хүүхдийн эрхийн чиглэлээр бол 3 асуудал орсон. Энд бүгдээрээ энэ хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн стандартын шаардлага хангахгүй байгаа дотуур байрыг шинэчлэх асуудлыг хөндсөн.

2 дахь нь, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, энд шаардлагатай

төсвийг нь шийдвэрлэх гэдэг ийм зөвлөмж асуудал орж ирж байгаа.

3-д нь, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүнд хяналт тавих, боловсрол эзэмших эрхийг нь хангах чиглэлээр асуудлыг оруулж ирсэн.

Энэ жилийн хувьд бол ХЭҮК-оос бүтэн өнчин, хагас өнчин хүүхдүүдийн эрхийн судалгааг эрхийн асуудлыг хөндөж дараагийн илтгэлдээ тусгахаар ажиллаж байна. Яг архины хамааралтай гэр бүлийн хүүхдийн асуудал, хүүхдийн судалгаа Хүний эрхийн Үндэсний Комисс дээр бол одоогоор байхгүй байгаа гэдгийг танд хэлье.

Л.Мөнхбаатар: Тодруулж асууя. Гишүүд танхимдаа ороорой. Санал хураалт явагдана шүү. Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр энэ дээр хариулт бол хангалттай гэж үзэхгүй байна. Ер нь архидан согтуурах энэ өвчин болсон зүйл, энэ асуудлыг бүр ажлынхаа гол цөм болгохгүй байгаа нь л эндээс харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр эцэг эх байх эрхгүй болсон тохиолдол, хажууд нь согтуу аав, ээж нь хоёулаа, согтуу хүүхэд нь хөөрхий шалдан, нүцгэн даарчихсан, нус нь гоожчихсон, хөлдчихсөн, идэх хоолгүй сууж байгаа тийм өрхүүд зөндөө байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хороодын нийгмийн ажилтнуудтай хамтарсан энэ судалгааг гаргаж, үүнтэй тэмцэх үйл ажиллагааг энд бүр зориуд оруулж өгөх хэрэгтэй. Энэ дээр анхаарч ажиллахыг хүсье.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй

холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ, байраа эзлээрэй. Санал хураалт. 57.1 хувиар санал батлагдлаа.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа.

18.39 цаг.

Дараагийнхаа дараагийнхаа хэлэлцэх асуудал оръё.

Тав.Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал

Санал, дүгнэлтийг чинь Засгийн газрын танилцуулгыг хэн юм. Амарсайхан сайд уу? Монгол Улсын Засгийн газрын саналыг Монгол Улсын Шадар сайд Амарсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Амарсайхан: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 21.5-д Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөл нь 15 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 4-ийг ЗГ-аас нэр дэвшүүлэхээр заасан. Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлд Засгийн газраас нэр дэвшүүлэх 2 гишүүний тоо гарсантай холбогдуулан орон тоо гарсантай холбогдуулан сонгон шалгаруулах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарласны дагуу олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлд 9 нэр дэвшигч материалаа ирүүлсэн болно. Эдгээр нэр дэвшигчдээс 4 нь Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 21.3-д заасан шаардлагыг хангаагүй тул

шаардлага хангасан 5 төрийн бус байгууллагаас Монголын менежментийн манлайлал форум төрийн бус байгууллагаас санал болгосон Нямдаваагийн Монсор, Монголын Үндэсний Маркетингийн Холбоо төрийн бус байгууллагаас санал болгосон Жаргалсайханы Золзаяа нарыг Монгол Улсын Засгийн газраас Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөлд нэр дэвшүүлж байна.

Олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нарыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. ЗГ-аас нэр дэвшүүлсэн Нямдаваагийн Монсор, Жаргалсайханы Золзаяа нарын дэлгэрэнгүй танилцуулга материалыг та бүхэнд тараасан болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Шаравын Мөнхцэрэн нар оролцож байна. Мөн нэр дэвшигч Жаргалсайханы Золзаяа, Нямдаваагийн Монсор нар хүрэлцэн ирсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Гочоогийн Ганболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны

дагуу Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ. Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Нямдаваагийн Монсор, Жаргалсайханы Золзаяа нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Байнгын хороонд ирүүлсэн болно.

Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 26 дугаар зүйлд 21.6 Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах эдийн засаг, бизнес, техник, технологи, удирдлага, менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг ЗГ-т тус тус санал болгоно. 21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. 21.8.Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг УИХ нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж, Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн нэр дэвшигчийн сонсголыг үе шатыг баримтлан дараах ажил явуулав.

2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын

товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолыг баталж, 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилигийг томилсон.

2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн 1/3-аас доошгүйн хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар хүрэлцэн ирж, ирц бүрдэж нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд сонсголд оролцсон гишүүд сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалд шаардлага хангасан эсэх дүгнэлт түүний үндэслэлийг тусгана. Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, Улсын Их Хурлын цахим хуудаст байриуулна гэж заасны дагуу 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргасныг Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу хаалттай хуралдах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Нямдаваагийн Монсор, Жаргалсайханы Золзаяа нарыг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэр дэвшигчдийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно. Мөн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Хайдавын Чилаажавыг Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох асуудлаар гаргасан Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийн хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлт болон эрх бүхий албан тушаалтны санал, нэр дэвшигчдээс асуулт асууж, уг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ундрам, Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Чинбүрэн гишүүн асуултаа асууя. Дараа нь их олон санал хураалтууд байгаа шүү.

Ж.Чинбүрэн: Би асуулт асуухгүй, зүгээр юу хэлэх гэсэн юм. Ер нь бол энэ Олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж энд орж байна гэдэг бол маш их хариуцлагатай ажил. Ялангуяа энэ Монгол иргэдийг эрүүл чийрэг өсгөх асуудал бол өөрөө их чухал аа. Ялангуяа манай энэ Олимпизм спорт хариуцсан гишүүн Бат-Эрдэнэ бол байнга ярьдаг. Энэ нийтийн эрүүл мэнд, нийтийн биеийн

тамирыг хөгжүүлэх чиглэлд яаж анхаарах вэ гээд. Тийм учраас энэ олон нийтийн радио телевизийн тодорхой төсвийг нийтийн эрүүл мэндийн чиглэлд тэр дотроо энэ анхдагч урьдчилан сэргийлэлт гэж яриад байгаа эрүүл өсөх, бие бялдар нь чийрэг байх, дээрээс нь энэ хорт зуршилуд болох архи тамхи хэрэглэдэггүй байх. Энэ соён гэгээрүүлэх үйл ажиллагааг илүү их анхаарч, хүүхдийг бага балчир наснаас нь эрүүл саруул өсгөх энэ үүрэгт ажлыг илүү нөлөөллийн ажлуудыг бүр бодитой ажлууд хийгээсэй гэж хүсэж байна. Тийм учраас та бүхэн энд төсөв баталж, ажлын гүйцэтгэлийг шалгах улсууд. Тийм учраас энэ төсөв дотроо нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн эрүүл амьдрах ухааныг хүүхдүүдийн балчир наснаас нь авхуулаад цэцэрлэг, бага анги, дунд анги, ахлах анги хүртэл нь сургаж заах энэ нөлөөллийн ажил дээр илүү их манлайлалтай ажиллаасай гэж хүсэж энэ үгээ хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн уг хэллээ. Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууя.

Ж.Батсуурь: Энэ Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг байж байгаад л чөлөөлдөг л дөө. Үүнийг чөлөөлөөд томилох болгонд л нэг зүйл яригддаг. Монголын Үндэсний радио телевиз бол Монголын ард түмний өмч, татвар төлөгчдийн мөнгөөр ихэнх санхүүжилтээ аваад ингээд явдаг. Бусад арилжааны телевизүүдийг бодох юм бол асар том бүтэцтэй, асар том хөрөнгөтэй, улсаас дэмжлэг авдаг ийм байгууллага. Ингэхэд хувийн жижиг телевизүүдтэй харьцуулахад түүгээр гарч байгаа зүйл, ярьж байгаа зүйл нь бол эрх баригчдын дуу хоолой. Намын нэг жижиг студи шиг л ийм л зүйл хийж байх юм. Үнэхээр иччих юм. Дээр энэ та нарын үзэгч энэ тэр гэж байдаг юм уу, байдаггүй юм уу, бараг байхгүй болсон байх даа. Энэ гарч байгаа нэвтрүүлгүүд нь бүгд хөтөлсөн асуулттай,

өөрсдийнхөө дуу хоолойг гаргах гэсэн хүмүүсийг л оруулдаг, хэлэлцүүлэг энэ тэр гээд бүр нэг ядчихсан. Тэгээд саяхан би нэг яаж байгаад ч Монгол телевиз дээр суваг таарсан чинь нэг кино гарч байна. 2 мянгаад оны Золбоот энэ тэр тоглоод ямар ч найруулга байхгүй, дүрсийн бүр юу ч байхгүй. Би бүр ичээд, ингээд харсан чинь Үндэсний телевиз гарч байгаа. Тэгээд яах гээд байгаа юм? Монгол орныг бүр дууссан гээд байгаа юм уу, юу болсон гээд байгаа юм. Тэгэхээр энэ байдал дээр бол анхаарах ёстой. Тэгээд үүнийг олон дахин ярьж байгаа юм.

Би энэ Амараа даргас асуух гэж байгаа юм. Үндэсний зөвлөлийг бол хэд ч солиод нэмэргүй юм байна гээд. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо дээр энэ Нямаагийн Энхболд дарга бид нар яриад гүйцэтгэх удирдлагын тайлан орж ирэх ёстой гэж ярьсан шүү дээ. Энэ гүйцэтгэх удирдлагын олон хууль шүүх дээр байгаа зүйлүүд, АТГ дээр байгаа зүйлүүд бие биеэ матсан, мурьсан эдгээр зүйлүүдийг ер нь нэг оруулж авчирч тайланг нь сонсъё гэж уул нь нэг тохирсон юм байгаа юм. Тэгээд тэр ерөөсөө орж ирэхгүй л Үндэсний зөвлөлийн гишүүдийг нь л солиод байх юм. Цаг хугацаа нь дуусаад сольдог юм уу, нөхцөл байдал нь болоод тэгдэг юм уу. Тэгэхээр би зүгээр энэ үндэсний зөвлөлд орж байгаа од сайхан залуучууд байна. Үнэхээр очоод өмнө нь үзэж харж байсан юм уу, үгүй юм уу. Монгол телевизэд бол эрс шинэчлэл хийхгүй бол болохгүй. Бараг үзэхээсээ ичиж байна, санаа зовж байна, хайран татварын мөнгө тэнд урсаж байна.

Тэгээд та нарт бол зүгээр амжилт хүсье. Асуух зүйл алга. Ер нь нөгөө гүйцэтгэх удирдлагын тайлан энэ төрөөс авсан санхүүгийн тайлангаа ер нь нэг тайлагнахгүй юм уу. Амарсайхан дарга аа. 20 оноос гэдэг юм уу, хэдэн оноос хойш байдаг юм, жилд хэдэн төгрөг төсвөөс авдаг юм, хэдийг зарцуулдаг юм, аудитынх нь дүгнэлт

ямар байдаг юм, цаашид яах чиглэл өгсөн байдаг юм. Үнэхээр санаа зовмоор юм. Тэгэхэд маш олон телевизтэй. Телевизийн тоог бол мэдэхгүй байна. Тэгэхэд бусад хувийн телевизүүдийн тэр хөгжөөнт нэвтрүүлэг, гадна дотнын тэр контентыг худалдаж аваад хийж байгаа зүйлүүд гээд үнэхээр үзүүштэй, харууштай, залуучуудыг уриалан дуудсан ийм зүйлүүд байдаг. Тэгээд хуучин бидний хүүхэд байхад, залуу байхад энэ тэр бол үндэсний юуны цагийн хүрд үзэх юм сан, Монгол телевизийн гоё гоё сайхан нэвтрүүлгүүдийг үзэх юм сан гэсэн ийм мөрөөдөлтэй, хүсэлтэй, сэтгэлд хоногшсон нэвтрүүлгүүд байдаг. Одоо бол аль ч талаасаа байхгүй болсон шүү, бүр нураад унасан, дууссан. Тэгэхдээ тэгж Монголын ард түмний хөрөнгийг үрэн таран хийж, энэ хэдэн арилжааны телевизтэй өрсөлдөх хэрэг байна уу, байхгүй юу? Үнэхээр үүргээ гүйцэтгэж чадахгүй бол татан буугдвал яасан юм. Тэр намынхаа хажууд очвол яасан юм ийм л зүйлийг хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Жамбын Батсуурь гишүүн үг хэллээ. Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөлийн гишүүд Засгийн газрын санал болгож байгаа гишүүд нэр дэвшигчид орж ирж байна гэж ойлгож байна. Тэгээд энэ үндэсний зөвлөлд Ерөнхийлөгчийн институт, Засгийн газар, Улсын Их Хурал гээд энэ 3 институцээс төлөөллийг санал болгож ингэж оруулж ирдэг. Тэгээд сая энэ Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож байхад анх удаа энэ асуудлаар сонсгол зохион байгуулсан юм байна. Тэгэхээр энэ бол нэлээн дэвшилттэй ийм сонгон шалгаруулалт болж байна гэж миний хувьд бодож байна. Өнгөрсөн 3 жил бас үндэсний зөвлөлийн гишүүн нэлээн хэдэн гишүүн чөлөөлөөд, шинээр нэр дэвшээд ингээд орж ирж байсан процессыг харах юм бол энэ удаагийнх бол нэлээн дэвшилттэй байгаа юм байна.

Тэгээд залуу хүмүүс орж ирж байгаа нь бол нэлээн шинэ салхи орж ирж байгаа гэж би бодож байна. CV-г нь харахаар менежмент, маркетинг, технологийн ийм хүмүүс орж ирж байна. Тэгэхээр энэ Үндэсний олон нийтийн радио телевизийг менежментийн талаас нь бас нэлээн хүмүүс шүүмжилдэг. Одоо энэ яг мэргэжлийн энэ чиглэлийн холбоодыг төлөөлж орж ирж байгаа хүмүүс учраас энэ байгууллагыг илүү цомхон, сайн менежменттэй, хэрэгтэй юмандаа бол маш сайн хөрөнгө оруулах ёстой шүү дээ. Цалин пүнлүүгээ ч гэсэн нэмэх ёстой. Гэхдээ данхайсан үр ашиггүй тийм байдлыг бол халах ёстой. Тийм учраас үйл ажиллагааны төлөвлөгөөг нь батлахдаа, төсвийг нь батлахдаа зөв юманд нь мөнгө төгрөгийг нь зарцуулдаг, хэрэггүй юмыг нь хасдаг, тэгж байж дараа дараагийн контентыг нь сайжруулах улам чанартай болгох асуудал үр дүн гарна гэж бодож байгаа. Тэгээд энэ шинэ салхи орж ирж байгаа учраас энэ залуучуудыг бол дэмжиж байна. Цаашдынх нь ажилд амжилт хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Ундрам гишүүн нэр дэвшигчдийг дэмжиж үг хэллээ. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ оройны амгаланг айлтгая. Ямар ч гэсэн Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлд бас 2 залуу төрийн бус байгууллагын төлөөлөл болгож, Засгийн газар нэр дэвшүүлэн оруулж ирж байгаа юм байна. Яг өнөөдөр Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа сая Батсуурь гишүүний хэлсэнчлэн гүйцэтгэх удирдлагын тайланг та бүхэн ер нь яг харж үзсэн үү? Танд тийм боломж байсан уу? Ер нь ямар зорилгоор энэ Үндэсний зөвлөлд орж байна гэж та бүхэн өөрсдийгөө дүгнэж хэлэх вэ? Ямар тийм судалгаа харсан. Яагаад би ингэж асууж байна вэ гэвэл үнэхээр сая

гишүүдийн хэлж байгаачлан тэр шинэ салхи байгаа болбол яг өнөөдөр энэ үүсээд байгаа нөхцөл байдлыг засах тэр боломж байна гэж харж байна уу? Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөл нь Радио телевизийн тухай хуульд зааснаараа ерөнхий захирлыг томилж, байгууллагын бүтэц зохион байгуулалт төсвийг баталдаг эрхтэй байгууллага байгаа. Үүний дагуу баталсан бүтцэд нь хэрэгжиж байгаа эсэх, төсөв үйл ажиллагаанд нь хяналт тавих, эргэж олон нийтэд мэдээлэх үүрэг ч хүртэл Үндэсний зөвлөл байдаг, хуулиар хүлээсэн үүрэгтэй. Гэтэл өнөөдөр Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, радио бол 88 жилийн түүхтэй, телевиз 55 жилийн түүхтэй энэ том байгууллага өнөөдөр хүний нөөцийн хомсдолд ороод байна гэдэг ийм мэдээллээр өгч байна. Уран бүтээлчид нь ажиллаж уран бүтээл хийх тэр боломжгүй болсон байна. Техник, тоног төхөөрөмжийн уналтад орсон байна. Телевизийн удирдлага, захирлууд нь, радио, телевизийн удирдлага, захирлууд нь уран бүтээлчдээ ажиллах боломжоор хангаж өгөхгүй байна. Төсөв зарцуулалт нь хаана байгаа нь уран бүтээлчдээ тодорхой бус байна. Мэдээлэл өгдөггүй, ийм гомдол ирсэн уран бүтээлчдээс нь ирсэн. Тэгвэл энэ бүхэн дээр хяналт тавих ажиллах тэр боломж нь өнөөдөр байна уу, үгүй юу. Та бүхэн ер нь яаж харж байна вэ?

Зүгээр MNB 1 дүгээр сувгийн захирал сүүлийн 2 жилийн хугацаанд 3 удаа солигдсон, Тамгын дарга нь 3 удаа солигдсон, Монголын мэдээ сувгийн захирал нь 2 удаа солигдсон, радиогийн захирал нь 2 удаа солигдсон, маркетинг хариуцсан захиралд нь 4 удаа солигдсон гэдэг ийм мэдээлэл ирж байна. Зүгээр хэн нэгнийг захирлаар тавьж тоглоод байдаг юм уу, ер нь яадаг юм. Гишүүд нэхэж байна шүү дээ. Хөтөлбөрийн бодлого гэж юм байна уу? Хөтөлбөрийн бодлого хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа үндэсний олон нийтийн зөвлөлд нь байдаг, шинэ контент тийм ээ, хүүхэд

багачуудад зориулсан контент, эрүүл мэндэд чиглэсэн контент хэрэгтэй л гээд, нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн контент байдаг аа, байдаг. Би үгүйсгэхгүй. Тэгэхдээ цөөн тоогоор байдаг. Тэгвэл энэ бүхэн уран бүтээлчдийг хийх тэр сэдлийг төрүүлж өгөх тэр боломжийг нь Үндэсний зөвлөл нь хангаж өгдөг юм уу, үгүй юү? Энэ дээр ер нь яаж ажиллах ёстой юм бол оо?

Би өөрөө 92-96 онд Үндэсний олон нийтийн телевизэд ажиллаж байсан л даа. Үнэхээр зах зээлийн яг юу руу шилжээд хүндхэн үе байсан. Юмацка пестикам камер ингээд л үүрээд л бид нар тийм ээ, уран бүтээл хийдэг байсан. Тэгэхэд уран бүтээлч сэтгэлгээтэй бид нар ажиллах тэр сэдлийг нь тодорхой хэмжээр бид нарыг ингээд урамшуулж дэмждэг байсан байхгүй юу. Тэр сэтгэлээр бид нар уран бүтээл хийж олон нийтээ зөв зүйлийг зөв, тийм ээ, урсгалыг бий болгох юм сан, уран бүтээлийг хүргэх юм сан, уран бүтээлээрээ дамжуулаад тэр хүмүүжил, боловсрол, төлөвшилийг бий болгох юм сан гэж ажилладаг байсан. Одоо гэтэл тэр боломж нь уран бүтээлчдийгээ хөглөж чадахгүй байна гэдэг ийм гомдол ирж л байна л даа. Ингэснээр тэр бусад хувийн телевизүүд чинь тэр контентыг хийх боломжийг нь олгож өгөхгүй байна шүү дээ. Тэгвэл яах ёстой юм бэ? Та 2 залуу хүний хувьд ер нь яаж харж байна. Та 2-ыг дэмжээд явуулна. Очоод юу хийх вэ гэдгийг чинь би асуумаар байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бадарчийн Жаргалмаа гишүүний асуултад нэр дэвшигчид хариулъя. Эхлээд Нямдаваагийн Монсор хариулъя. Хэддүгээр микрофон байна? 82 дугаар микрофоныг өгье. Гишүүний асуултад нэрээ хэлээд хариулаарай.

Н.Монсор: Баярлалаа. 2005 онд батлагдсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 21 дүгээр

зүйлийн дагуу бол бид нар баримталж ажиллах ёстой байгаа. Энэ маань өөрөө бидний Үндэсний зөвлөлд хийх ажлыг маань маш тодорхой заачихсан. Олон улсын сайн засаглалын стандартаар бид нар бол ТУЗ-ийн гишүүн болж орж ирж байгаа, нэг талаасаа.

Нөгөө талаасаа бол бид нар олон нийтийг төлөөлж орж ирж байгаа. Тэгэхээр бид нарын зүгээс бол миний хувийн зүгээс хэрвээ өнөөдөр ингээд дэмжигдээд очих юм бол хийх ажил маань гэвэл, түрүүн хэллээ, энэ зорилтот стратеги дээр нь бид нар жил болгон баталж, улиралд нэгээс доошгүй удаа хуралдах ёстой. Энэ хуралдаа ямар ч байсан идэвхтэй оролцоод тэгээд тэнд байгаа бусад гишүүдтэйгээ асуудлаа ярилцаад тэгээд түрүүн ярилаа. Чинбүрэн гишүүний хэлснээр эрүүл мэндтэй холбоотой контент, дээрээс нь нэмээд энэ санхүү, эдийн засагтай холбоотой энэ боловсролын контентыг бас нэлээн стратегийн түвшинд төлөвлөгөөнд нь оруулж ажиллана гэсэн бодолтой байгаа.

Санхүүжилтийн хувьд бол энэ хуулиараа 3 эх үүсвэрийг заасан байгаа. Нэг нь болохоороо нөгөө өрхийн, нөгөө нийт ард иргэдийн ард иргэдээс хураадаг хураамж байгаа. Нөгөөдөх нь 2 дахь нь зар сурталчилгаа, 3 дахь нь Засгийн газрын дэмжлэг гэсэн байгаа. Яг өнөөдөр нөгөө томилогдож арай орж ажиллаагүй байгаа учраас зарим мэдээллийг ер нь бол сайн мэдэхгүй байна. Гэхдээ яг одоогийн байдлаар авсан мэдээлэл дээр бол ковидын үеэр нэлээн хүндхэн байсан гэж ойлгосон.

Техникийн хувьд ч гэсэн нэлээн их шинэчлэх шаардлагатай байгаа асуудлууд байгаа юм байна лээ. Хамгийн наад захад гэхэд радиод дамжуулах төхөөрөмжүүдээ бас нэлээн шинэчлэх шаардлагатай байгаа гэж ойлгосон. Тэгэхээр бид нарын хувьд бол хэрвээ томилогдоод ажиллавал энэ төсөв, мөнгөн дээр нь яаж шийдэж өгөх ёстой

юм яг тэр зөвлөлийнхөө хүрээнд ажиллана гэж бол бодож байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Нэр дэвшигч Жаргалсайханы Золзаяа асуултад хариулъя. 84 дүгээр микрофон өгье, ажлын хэсгийн.

Ж.Золзаяа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нэр дэвшигч Монсортой бас санал нийлж байгаа. Үүн дээр нэмээд хамгийн гол нь энэ Үндэсний олон нийтийн радио телевизэд менежментийн сайжруулалт хийх, дээр нь энэ сайн засаглалыг бий болгох нь хамгийн тэргүүний, нэн тэргүүний хэрэгцээ шаардлага байгаа гэж харж байгаа. Тэгээд үүнтэй зэрэгцээд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн хамт олон, уран бүтээлчдийн нийгмийн асуудал дээр маш олон асуудлууд байдаг гэж бас хүмүүсээс мэдээлэл авч, дээрээс нь энэ ажлын хэсгийн дүгнэлтийг бид нар бас уншиж танилцсан байгаа. Тэгэхээр цалин хөлсний хувьд бол дунджаар 800000-ыг авдаг. Тэгэхэд бол хувийн арилжааны телевизүүд бол 200-400 мянган төгрөгөөр илүү авдаг байгаа. Тэгэхээр энэ нийгмийн асуудал цалин хөлс болон хувь хүний хөгжил дээр нэлээн анхаарч, орчин үеийн арга зүйд үндэслэсэн ийм бодлогын түвшинд бас дэмжиж ажиллана гэж бодож байна.

Мөн түүнчлэн сүүлийн үед дэлхий даяар энэ технологийн хөгжил бол асар хурдацтай хөгжиж байгаа. Тэгэхээр яг энэ мэдээллийн энэ цаг үед мэдээллийг хүртээмжтэй байлгах талаас нь анхаараад, дижитал шилжилтийг амжилттай хийх талаас нь бас бодлогын хүрээнд дэмжиж ажиллана гэж ингэж бодож байна.

Тэгээд үүнтэй зэрэгцүүлээд бас мэдээж энэ инновац, технологийн чиглэлийн дэлхий даяар хөгжиж байгаа яг энэ цаг үед энэ чиглэлийн контентыг дэмжих бас бодлого дээр нэлээн бүтээлч

байдлаар ажиллана гэж бодож байна. Баярлалаа та бүхэнд.

Л.Мөнхбаатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Дараа нь үг хэлэх боломж байхгүй байх гэж бодож байна. Одоо бол ер нь захирлын зөвлөл тийм ээ, Үндэсний зөвлөл, захирлын зөвлөл гээч зүйл нь үүрэг гүйцэтгэгчийн зөвлөл болсон гэдэг ийм дүгнэлтийг бас уран бүтээлчид ирүүлсэн байна шүү. Энэ дээр бас анхаараарай. Яагаад гэвэл уран бүтээлчдээ дэмжих тэр бодлого байхгүй, энэ үүрэг гүйцэтгэгчдийн зөвлөл нь хангалттай ажиллаж чадахгүй байна гэдэг ийм шүүмж маш ихээр ирсэн. Яагаад Үндэсний олон нийтийн радио телевизэд ингээд олон нийтийн анхаарал тавиад байдаг юм бэ гэвэл татвар төлөгчдийн мөнгө байдаг байхгүй юу. Хураамжаар цалинжиж байгаа байхгүй юу. Төсөв бид улсаас өгдөг. Бид төлбөрөө хийчхээд дуртай дуу хөгжмөө захиалах тэр боломж нь байхгүй байна гэдэг дээр л үлгэрч олон түмэн шүүмжлэл явуулаад байгаа юм. Тэгвэл энэ дунд яг нэгэнт бид нар захиалсан хөгжмөө сонсох гээд байхад уран бүтээлчид нь хийх тэр боломжийг нь олгож өгөхгүй бол яаж тэр чанартай уран бүтээл гаргах юм бэ гэдэг дээр та бүхэн бас анхаараарай.

Ер нь тэр төсөв санхүүгийн нээлттэй байдал дээр шилэн байлгах гэдэг дээр түрүүний Учрал гишүүний хэлээд байгаа ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: 1 минут нэмж өгье. Асуултаа гүйцээх гээд асуучих.

Б.Жаргалмаа: Одоо дэмжээд явуулах байх гэж бодож байна. Дэмжинэ. Тэгэхээр яг энэ санхүүгийн нээлттэй байх олон нийтийн мэдээлэл өгөх дээр бас анхаарч ажиллаарай. Яагаад гэвэл бид төлсөн мөнгөнийхөө төлбөрийг авах гээд байна шүү дээ. Олон нийтийн эрх ашигт нийцсэн уран бүтээл хэрэгжиж байна. Хийж байна уу үгүй юу

гэдэг дээр. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд тэр боломж нь байна уу, үгүй юү гэдэг дээр та бүхэн бас тэр Үндэсний зөвлөлийг бидэнд бас эргээд ТББХ-н дээр юу тайлагнах тийм ээ, мэдээлэл өгөх тэр боломжоор нь хангаж ажиллаж энэ дээр бас санаачлагчтай ажиллаарай гэж бас та бүхнээсээ хүсье. Амжилт хүсье.

Л.Мөнхбаатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн нэр дэвшигчдэд хандаж үг хэллээ.

Энэ чуулганы танхимд гишүүдийн хэлсэн үгийг та бүхэн томилогдож очоод үйл ажиллагаандаа бас анхаарч ажиллахыг та бүгдэд бас сануулан хэлье. Одоо Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлд шинээр 2 залуу нэр дэвшиж орж ирж байна. Тэгэхээр яах вэ, өөрсдийнх нь бас хэлж байгаагаар асуултад хариулж байгаа байдлыг харахад бол ер нь бас бид нар энэ Үндэсний олон нийтийн телевизэд технологи энэ инновацын томоохон дэвшилтүүдийг гаргахыг эхлээд зорьж ажиллана гэж ингэж байх шиг байна. Энэ ч бас цаг үеийн шаардлага байна. Үндсэндээ бол бас манай радио телевизийн манай энэ тоног төхөөрөмжүүд маш муудсан гэдгийг манай үе үеийн л энд ажиллаж байгаа хүмүүс маань бас хэлээд хэлсээр яваад ирсэн.

Нэг талаасаа энэ Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз гэдэг бол мэргэжлийн уран бүтээлийн байгууллага гэж хардаг. Энд бол авьяастай, чадалтай, мөн дээрээс нь бас маш их сэтгэлтэй хүмүүс ажиллаж явсаар ирсэн. Энэ байдал суулийн жилүүдэд маш их алдагдаж байгаа. Тийм учраас бол уран бүтээлээр нь дэмжих, уран бүтээлчдийг авьяастнуудыг бас цааш нь дэмжих энэ

ажиллах бололцоо нөхцөлийг нь бас сайжрах тал дээр бид нар энэ бодлогоор бас дэмжих ёстой гэж ингэж бас харж явдаг л даа. Тэгэхээр ер нь Үндэсний олон нийтийн телевизийн энэ алтан фонд гэдэг бол тэр чигтээ Монгол улсын түүх. Энэ хөгжлийн том гуу сан архив байж байдаг. Тэгэхээр үүнийгээ бас эргэж ажиллуулах тал дээр, үүнийгээ гаргаж тавих тал дээр бас Монголын Үндэсний радио телевиз бол яах вэ, ер нь үүцээ задлаад ажиллаж л байдаг л даа. Гэхдээ шинээр тийм технологийн гэдэг юм уу, шинээр уран бүтээлийн гэдэг юм уу, шинээр энэ цаг хугацааны тухайд ямар нэгэн байдлаар уран бүтээлийн шинэчлэлийг хийх тал дээр уран бүтээлийн гуу сангаа өөрчлөх тал дээр бол бас анхааралтай ажиллах, боломжийнхоо хэрээр дайчлаад ажиллах ийм бололцоо нөхцөлүүд нь их муу байдаг гэж манай уран бүтээлчид өөрсдөө бас ийм санал санаачилга гаргаад ирдэг ээ. Тэгэхээр бодлогын хувьд уран бүтээлчдээ дэмжих, шинээр уран бүтээл төрүүлэх, энэ соён гэгээрүүлэх, нийгмийн энэ үйл ажиллагааг нь дэмжих тал дээр манай энэ 2 залуу ер нь бас яг юу хийе гэж зорьж бодож байгаа вэ? Өөрсдөд чинь ямар төсөөлөл байна вэ гэж ингэж асуухыг хүсэж байна.

Дээр нь бас энэ өмнө нь та бүгдийн өмнө байсан Чилаажавын хувьд МУСГЗ өөрөө том уран бүтээлчин хүн. Энэ хүн бол энэ дотор ажиллаж өөрийн уран бүтээл энэ дээрээ бас танигдсан хүн. Тэгэхээр энэ бас хүмүүсийн суудал дээр очиж байгаагийнх энэ чиглэлийнх нь бас барьж байсан бодлого юмнуудыг нь цаашиаа үргэлжлүүлээд явах тал дээр та бүхэн ямар санал санаачилгатай ажиллах гэж ингэж зорьж байгаа вэ гэдэг ийм цэвэр уран бүтээлийн асуултыг тавьж байна.

Л.Мөнхбаатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эхлээд Нямдаваагийн Монсар хариулна, дараа нь Золзаяа хариулъя. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгөөрэй.

Н.Монсор: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Соён гэгээрүүлэх тал дээр одоогийн байгаа Үндэсний зөвлөлтэйгөө нэлээн хамтарч ажиллаж, тэгээд үйл ажиллагааны стратеги зорилтод нь нэлээн тусгана гэж бодож байгаа. Тэгээд түрүүн хэлсэн соён гэгээрүүлэх ажил дээр нийтийн эрүүл мэнд дээрээс нь энэ бизнес санхүүгийн яг энэ соён гэгээрүүлэх ажил дээр бол нэлээн түлхүү анхаарч ажиллана гэж бол бодож байгаа.

Гэхдээ Үндэсний зөвлөлийн маань өөрийнх нь ажлын цар хүрээ маань бас тодорхой хэмжээгээр хуульчлагдчихсан. Тэгэхээр бид нар бол энэ хуулийнхаа хүрээнд дэмжиж, бодлого стратегиа гаргах дээр ажиллана гэж бодож байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Нэр дэвшигч Жаргалсайханы Золзаяа асуултад хариулъя. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье.

Ж.Золзаяа: Үндэсний зөвлөлийн эрх үүргийнхээ дагуу мэдээж телевизийн хөтөлбөрт бол хяналт тавьж ажиллахаас гадна миний хувьд урьд нь контент үйлдвэрлэх, уран бүтээлчидтэй бас хамтарч ажилласан ийм туршлагатай учраас бүтээлч сэдээгч, бүтээлч, санал санаачилгыг ажиллахыг нь дэмжих тийм ээ, гүйцэтгэх удирдлага болон телевизээс ирсэн санал санаачилгыг Үндэсний зөвлөл дээр бас багаараа судалж үзээд ингээд дэмжиж ажиллах тал дээр нь анхааран ажиллана гэж хэлмээр байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар эхлээд чөлөөлөх нууц санал хураалтыг явуулах юм байна.

Гишүүд гараа эзэлье. Эхлээд бүртгэлийн нэг санал хураалт явуулчихъя. Бүртгэлийн санал хураалт.

Санал хураалтыг явуулъя.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Хайдавын Чилаажавыг Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58.1 хувиар санал дэмжигдлээ.

Одоо томилох санал хураалтыг явуулъя.

Жаргалсайханы Золзаяаг Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. 65.1 хувиар санал дэмжигдлээ.

Нямдаваагийн Монсорыг Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65.1 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.

21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Нямдаваагийн Монсор, Жаргалсайханы Золзаяа нарыг томилсугай.

2.Монгол Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс Хайдавын Чилаажавыг чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Ажлын хэсэгт баярлалаа.

19.13 цаг.

Дараагийнхаа хэлэлцэх асуудалд орёё.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Васгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ганболдын Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, БХБЯ-ны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах

газрын дарга Доржсаламын Гантулга, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвэлсүрэнгийн Наранчимэг, Наранчимэг дарга ирсэн байгаа юм байна. Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Буянтогтохын Бундхорол нар чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооны хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор саналыг үргэлжлүүлэн хураана.

Эхний санал хураалтыг хэдийн хураагаад завсарласан тийм ээ. Тэгэхээр 2 дахиасаа явах юм байна.

Гишүүд ээ, санал хураалт.

2.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.3.7 дахь заалт нэмэх:

3.3.7 Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагаа. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 69 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалтыг “орон нутгийн өмчит” гэснийг “орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 64.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4.3 дахь заалт нэмэх:

11.4.3 Чанар ба үнийн хосолмол. Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг, санал хураалт.

Раднаасэд гишүүн үг хэлье, санал хураалтыг цуцаллаа. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ 4 сарын 25-нд Байнгын хороо дээр би санал гаргасан юм аа. Энэ эм, эмнэлгийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн чанарын асуудлыг ярьж. Тэгээд үүнийг чуулганаас дахин чиглэл аваад ажлын хэсэг аваад зассан. 1 дүгээрт үүнтэй холбоотой миний санал тэр хойно явж байгаа. Тэр саналаа бол албан ёсоор татаж байгаагаа хэлчихье. Татаж байгаагаа хэлье.

Энэ төслөөр ингээд 70 хувийн чанар, 30 хувийн үнэ хардаг. Эмийн чанар чинь 70 хувь нэмэгдлээ л гэж харж байгаа шүү. Тэгэхээр үүнийг дагаж гарах тэр Сангийн сайдын тушаал, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалууд яг энэ рүүгээ чиглэж эцсийн байдлаар гарна шүү гэдгийг албан ёсоор хэлье. Тэгэхгүйгээс чинь болоод энэ ард түмэн эм нь үйлчлэхээ больчихсон, тэрнээс нь хамаараад элдэв бусын ургамал, ус рашаан ууж, хамаг биеэ баллаж байна шүү. Чанаргүй эмийн чинь хор гай энэ.

4204 эм улсын бүртгэлд бүртгэгдсэн. Би энэ эмийн чинь үнэ болоод чанарын ялгааг Байнгын хороон дээр хэлж өгсөн. Тэгэхээр Худалдан авах ажиллагааны газрынхаа нүүнийгээ сайн мэдэж байгаа байх. Энэ эмтэй холбоотой нийт эмч нарын дунд судалгаа хийж үзэх нь 81.3 хувь нь эм бол чанаргүй байгаа шүү гэсэн тийм судалгаа хүртэл байдаг юм байна лээ шүү. Энэ эмийг эмийн агентлагаас чинь гарсан. Тэгээд энэ нийтдээ нэг 225 тэрбум орчим төгрөгийн ашиг харсан биш чанар харсан энэ хүмүүсийг эдгээсэн, эмчилсэн энэ эмийг авахад та бүхэн минь энэ юмаа зарцуулаарай, зориулаарай л гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхгүйгээс чинь болоод энэ хүнсний шохой идээд энэ ард түмэн чинь эм нэртэй боловч үйлчилгээ байхгүй юмаар хордож дуусаж байна шүү. Тэгээд Эрүүл мэндийн сайд ч байна, Сангийн яамныхан бодвол энэ Худалдан авах ажиллагааны газрынхан үүнийгээ боловсруулах байх. Мөнгө чухал биш энэ дээр хүний амь нас эрүүл мэнд явж байгаа учраас энэ эм дээр та нар минь

онцгой анхаараарай л гэж хэлэх гээд байгаа юм. Тэгээд саналаа албан ёсоор татаж байгаа. Тэр хойд талд байгаа дэмжигдээгүй саналыг Байнгын хороон дээр.

Л.Мөнхбаатар: Энэ эмийн чанартай холбоотойгоор Раднаасэд гишүүн өмнө нь Байнгын хороон дээр санал гаргаад тэрийг нь чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх явцад гүйцээн боловсруулах чиглэл өгөгдөөд тэгээд одоогийн энэ төслөөр орж ирж байгаа. Үүнтэй холбогдуулан Төсвийн байнгын хороо дэмжээгүй энэ саналаа Раднаасэд гишүүн татан авч байгаа юм байна.

Ганболд гишүүн үг хэлэх юм уу, та. Саналаа хураах уу.

Гочоогийн Ганболд гишүүн үг хэлье. 5 дээр юм уу? Тэгвэл энэ чинь 4 дэх асуудал шүү дээ. 4 дэх асуудал.

Саналаа хураачихъя тэгвэл. Санал хураалт гишүүд ээ. 65 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.7, 11.8 дахь хэсэг нэмэх:

11.7 Захиалагч энэ хуулийн 11.4.3-д заасан шалгуурыг хэрэглэх бол чанар ба үнийн шалгуур тус бүрд өгөх оноог тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.8.Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ. Санал хураалт. Гочоогийн Ганболд гишүүн, дараа нь Туваан гишүүн үг хэлье.

Г.Ганболд: Энэ ингээд чанар ба үнийн хосолмолоор шалгаруулах гэж байна л даа. Үүнийг хэрэгжүүлж чадахгүй шүү дээ. Худалдан авах ажиллагааныхан үүнийг мэдэж байгаа.

Чанараа тэгээд хэн тогтоох юм? Одоо тэгээд энэ эмүүд жишээлэх юм бол даралт даралтын эм гэж жагсааж байгаад нэгд хамгийн чанартай нь тэр, 2-т нь тэр гээд манайх гаргаж чадах уу? Даралтын эмийг. Бүх эмүүдээ тэгвэл ингээд чанараар нь жагсаах юм уу? Тэгж байж энэ чинь өөрөө нөгөө чанар, үнийн хосолмол болохгүй болбол яг үнэндээ бол энэ эмийн бүх төрлөөр нь тэгвэл чанараар нь бид нар эрэмбэлэх нь байна шүү. Тэр эрэмбэлж гаргах стандарт юмнууд нь яг манайд яг байгаа юу? Энэ яг өөрөө ингээд яг ойлгомжгүй юм руу аваачна шүү дээ. Энэ чанартайг нь бүх эмийн нийлүүлэгч нар манайх чанартай л гэж хэлнэ шүү дээ. Тэрийг хэн тогтоох юм бэ? Эрэмбэлж гаргаж чадах уу? Энэ бол яг ойлгомжгүй зүйл рүү аваачна. Бид нар бас хөдөө орон нутагт энэ эмийн тендер зарлаж л явсан. Тэгээд үүнийг хэн тогтоож гаргах юм, чанарыг нь. Тэр дээр би нэг тодорхой хариулт аваад энэ үүгээрээ ингээд ойлгомжгүй батлагдчих юм болбол сүүлд нь яг шалгаруулалтын явцад их боломжгүй зүйл болно доо.

Л.Мөнхбаатар: Дэгээрээ угаасаа асуулт, хариулт бол байхгүй шүү дээ. Үг хэлэх боломжтой. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлэх боломжтой юм.

Туваан гишүүн үг хэлье.

Ц.Туваан: Энэ бол маш чухал асуудал аа. Яагаад чухал гэхээр бид нар энэ чанаргүй юмнаас болж бид нар сая эмийн чанарын асуудлаар түр хороо ингээд явсан тийм ээ, сунгаад явсан, энэ юунаас болсон чанаргүй юмнаас л болсон. Тэгэхээр эмийн чанарыг ярихаас өөр арга байхгүй. Эмийн чанарыг чинь бол үйлдвэрлэж байгаа улсаас нь, тэгээд дээрээс нь лаборатори энэ тэр гээд бас тогтоочихдог арга аргачлал зөндөө зүйлүүд байгаа. Бид нар энэ өвөлжингөө л өөрсдийнхөө хүүхэд, өөрсдөө ч гэсэн, тэгээд, ер нь хөдөө гадааг бол салдаггүй нэг баахан өвчинтэй л одоо л нэг юм дулаараад гайгүй болж байна шүү дээ.

Энэ чинь ерөөсөө чанаргүй эм шүү дээ. Уугаад байдаг, эдгэдэггүй. Эдгээд 1, 2 хонолоо, буцаад өвдчихдөг. Тэгээд чанаргүй юмнаас болоод дахиад энэ улсын төсөв дээр ирж байгаа энэ ор хоногийн мөнгө, хэвтүүлж байгаа тэгээд дээрээс нь энэ юуны тэр эмээ худалдаж авах мөнгө энэ тэр гээд тэгээд маш олон сөрөг үр дагаврууд гарч ирээд байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр бол энэ маш зөв соргогоор энэ чанар, үнийн хосолмол байдлыг оруулж ирж байгааг нь бол дэмжиж байгаа.

Ер нь бол чанартай чанаргүй эм бол угаасаа олон улсдаа бол эмийн хатуу стандарт мөрддөг оронд үйлдвэрлэсэн эмийг бол өндөр чанартай эм ээ гээд ингээд аваад явчихдаг. Дунд чанар ч байна. Тэгэхээр энэ чанарыг зааж өгөхгүй болохоор бид нар зүүн өмнөд Азийн орнуудад үйлдвэрлэсэн ямар ч эдгээх чадваргүй тийм эмүүдийг аваад тэгээд 1 эм бичээд уусан болоод ингээд үр дүн гарахгүй байгаа гэдэг нь амьдралаар нэгэнт тодорхой болчихсон. Энэ өвлийн энэ эдгэдэггүй, салдаггүй ханиаднууд дээр ерөөсөө үүнтэй л холбоотой. Тэгэхээр чанар эмийн хосолсон гэдгийг нь яваад харин үүнийгээ тэр бичиг баримтдаа зааж өгөх дээр онцгой анхаараад явчих нь л зөв. Дэмжиж байна. Тийм болно, болно.

Л.Мөнхбаатар: Ингэе, Оюунчимэг гишүүн үг хэлэх юм байна шүү дээ, тийм ээ. Та үг хэлэх юм уу? Тэгвэл Оюунчимэг гишүүн үг хэлсний дараа Чинзориг гишүүн үг хэлэх байдлаар саяын гишүүдийн тавиад байгаа асуудалд нь хариу өгье, тэгэх үү. Оюунчимэг гишүүн үг хэлье.

М.Оюунчимэг: Ер нь манай гишүүд яг үнэн юм хэлээд байна л даа. Одоо яг Монгол Улс эмийн мафидаа бол идэгдчихсэн байгаа, энэ бол яг үнэн шүү. Одоо энд сууж байгаа Гийхнаран гээд залуу ЭМД-ын ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байсан. Эм ямар хуурамч байдаг, яаж тендер явдгийг маш

сайн мэдэх залуу Сангийн яамны худалдан авалтын газар орчихсон сууж байна л даа. Үнэнийг хэлэхэд үнэхээр мафи байгаа 500 тэрбум төгрөг гаруй эргэлддэг энэ эмийн салбар мафидаа баригдчихсан. Сая Туваан гишүүн хэлж байна. Зүүн өмнөд Азид үйлдвэрлэсэн хагас найрлагатай тэр даралтын эм гэхэд 100 хувь биш. 30% нь юм уу найрлага нь солигдсон гэх мэт. Маши хуурамч эм болон энэ эмийн зах зээл бол үнэхээр Монголд замбараагаа алдчихсан байгаа. Үүнийг гүйцэтгэлийн аудитаар ч тогтоочихсон. Дээрээс нь Учрал гишүүнээр ахлуулсан Түр хянан шалгах хорооныхон лаборатори дээр очиж үзсэн. Монголд ганцхан байдаг лаборатори нь өнөөдөр тоног төхөөрөмж нь эвдэрчхээд орж ирж байгаа эм үнэхээр чанартай, чанаргүй байна уу, хүний эрүүл мэндэд хортой юу, хоргүй юу гэхийг тогтооход хэцүү болчихсон байна. Бид нарыг ядахдаа 5 тэрбум төгрөгөөр энэ лабораторийг солиод өгвөл бид нар ядахдаа энэ нь буруу, энэ зөв байна гээд нэг тогтоочих бололцоотой гээд ярьж байсан. Орж ирж байгаа эмүүдийн ихэнх нь хүний эрүүл мэндийг анагаах чадлаараа найрлага нь дутуу, муу байгаа гэдгийг л лабораторийн мэргэжилтнүүд, эд нар, эмч нар нь бид нарт бүгд ярьсан. Туваан гишүүн цуг явж байсан тэгэхэд. Тийм учраас л бид нар түрүүн энэ манай Раднаасэд гишүүн ч гэсэн яг ярьж байна. Яг үнэн.

Монголд байгаа эм үнэхээр чанаргүй байна. Дээрээс нь дэлхийн зах зээлийн үнээс хамаагүй өндөр үнэтэй байна. Тэр гүйцэтгэлийн аудит бол 30-80% гэхчхэн. Тэгээд энэ дээр чанар эмийг яаж тогтоох вэ гээд Ганболд гишүүний асуугаад байгаа бас үнэн. Өнөөдөр Монголд орж ирж байгаа эмийн чанар, үнийг тогтоох газар нь бараг байхгүй байгаа шүү. Эм эмнэлгийн агентлаг гэж байгуулсан. Тэгээд нөгөө салбарын сайдтайгаа бас энэ асуудлуудаас чанартай чанаргүй юм худал хуурмаг гарын үсэг зурахгүй, зурна

гэсээр байгаад ажлаасаа халагдсан. Одоо шүүхдээд явж байгаа, түр орлон гүйцэтгэгч тавина гээд тавьж чадахгүй гээд энэ салбар үнэхээр хэцүү байгаа. Чинзориг сайд маань үүнийгээ өөрөө бас ярих байх. Тийм учраас бид энэ хуулиар ингээд хамаагүй юм гаргаад байж болохгүй. Үүнээс болж маш олон хэлмэгдэж байгаа, сошиалаар гөвүүлж байгаа. Магадгүй ингэж хэлээгээд маргааш гөвөөд сууж байж магадгүй. Гийхнаран гэдэг хүн.

Л.Мөнхбаатар: Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг үг хэлье.

С.Чинзориг: Яах вэ, энэ дээр гишүүд бас анхаарал хандуулж байгаад их баяртай байна. Ер нь бол иргэдийн дунд энэ эмийн чанартай холбоотой, эмийн үнэтэй холбоотой асар их гомдол байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ худалдан авалтын хуульд бас ийм заалт бол оруулбал нэг ахиц дэвшил гарах болов уу гэж бодоод тэгээд энэ хуулийг чинь анхны хэлэлцүүлэгт нь буцааж байж, дахиж бас энэ зарчмын зөрүүтэй санал гаргаж оруулж ирж байгаа юм.

Одоо бид энэ чанар ба үнийн зохиомол шалгуурыг хэрэглэнэ гэхээр гишүүдийн чанарыг нь яаж тогтоох юм бэ гээд. Тэгээд эм болгоны чанарыг бид нар орж ирж байгаа эм болгоны чанарыг үнэлээд, худалдаж авна гэдэг асуудал бол би болбол гэж ойлгохгүй байгаа юм. Ямар үзүүлэлтээр нь чанар, чанарын үнэлгээ өгөх юм бэ гэхээр худалдан авахдаа 1 дүгээрт нь, энэ орж ирж байгаа энэ импорт, манайд худалдах авахаар орж ирж байгаа эм болбол 1 дүгээрт, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын баталгаажуулалтад орсон эм байна уу, үгүй юу гэдгээр нь. Хэрэв Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын баталгаажуулалтад орсон эм болбол нөгөө чанарын үнэлгээг нь өндөр үнэлгээ өгөх.

2 дахь нь, өндөр хөгжилтэй орон буюу нөгөө хатуу зохицуулалттай орон

гээд байгаа нөгөө Европын орнуудаас орж ирж байгаа хатуу зохицуулалттай орнуудаас орж ирж байгаа эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй байгууллагаас орж ирж байгаа эм бол бас чанарын өндөр үнэлгээ авна л гэсэн үг.

3 дахь асуудал нь, тендерт оролцогч нь өөрөө үйлдвэрлэгч байх юм бол бас энэ чанарын өндөр түвшний үнэлгээ авах. Ийм үзүүлэлтүүдээр энэ чанарын үнэлгээг нь тогтооно гэж ингээж оруулж байгаа юм.

Ер нь энэ эм гэдэг бол үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой стратегийн бүтээгдэхүүн. Ний нуугүй хэлэхэд 30 жил хувийн хэвилийн нуруун дээр даатгаад төрийн оролцоогүй, хяналтгүй, зохицуулалтгүй, төрийн дэмжлэг тусалцаагүй явж ирсэн. Үүнийг бид бол засах ёстой гэж үзэж байгаа юм. Энэ бол нэг арга. Эмийн үнэ чанартай холбоотой асуудал дээр эргэлт гарах.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал дээр тэр 36.1.2 дээр бас нэг цоо шинэ арга оруулж ирж байгаа юм. Бэлээхэн бидэнд бэлэн систем байгаа юм байна лээ. НҮБ-ын хүүхдийн сан дэлхийн 138 оронд эм эмнэлгийн хэрэгсэл худалдан нийлүүлдэг худалдааны системтэй юм байна. Тэгэхээр манай орон энэ системийг ашиглаж байгаа. Зөвхөн яаралтай тохиолдолд вакцин худалдан авахдаа л энэ системийг ашиглаад байгаа юм. Одоо бол бид нар энэ хуульд оруулж байгаа тэр 36.1.2-оор бол энэ үйлдвэрлэгч болон ОУБ-аас шууд худалдан авах эрхийг нь бол нээж өгч байгаа. Ингэснээрээ энэ хүүхдийн сангийн энэ 138 оронд худалдан авалт үзүүлдэг системийг шууд худалдан авалт системийг авснаараа чанар үнэ дээр нь маш томоохон эргэлт болно л гэж би бол ингээж найдаж байгаа юм. Тийм учраас энэ чанар ба үнийн хосолмол шалгуурыг хэрэглэнэ гэдэг энэ зарчмын саналыг дэмжээд өгвөл их сайн байна.

Зөвхөн энэ чанар болон үнийн хосолмол шалгуурыг бол зөвхөн эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад л дүгнэнэ ээ гэж. Өмнө нь бол 2 арга байгаа шүү дээ. Харьцуулах үнэ гээд бас нэг шалгуур нь юу билээ? Бас нэг 2 шалгуур байгаа юм. Энэ 2 нь бол эм эмнэлгийн худалдан авах дээр үйлчлэхгүй. Зөвхөн энэ чанар үнийн хосолмол шалгуурыг нь бол эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах дээр нь үүнийг нь бол аваад явъя гэж. Тэгээд энэ чанар үнийн хосолмол үнэлгээ хийдэг энэ журмыгаа бол Сангийн сайд батлахаар бол хуульдаа байгаа юм.

Харин тэгээд энэ хуульдаа тэр чанарын өндөр үнэлгээ авсан бол илүү нөлөөтэй байдаг, үнийн нөлөөлөл нь бол бага хувь эзэлж байх 70 орчим хувь нь чанарын энэ нөлөөлөл нь байх ёстой гэсэн би ийм бол байр суурьтай байгаа юм. Ингээд тэр журмыг нь батлахдаа энэ өөрийнхөө байр суурийг илэрхийлж гол нь үнэ биш чанар энэ худалдан авалтын гол эцсийн бас арга нь байх ёстой гэсэн ийм байр суурьтай бол байх юм. Тэгээд энэ их чухал бас ... /миут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ. 69 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “баримтжуулж тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална” гэснийг “баримтжуулна” гэж өөрчлөн, үүнтэй уялдуулан 48 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 48.4.10 дахь заалт нэмэх:

48.4.10 Энэ хуулийн 13.4-д зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 68.3 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.6 дахь хэсэгт нэмэх:

27.6 Эм эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Чинзориг. Санал хураалт. 70.7 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “тэнцүү” гэсний өмнө “эсхүл оноо” гэж, 27.15 дахь хэсгийн “өртөг” гэсний дараа “Чанар ба үнийн оноо” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Чинзориг. Санал хураалт. 68.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын тайлбар хэсгийн “дуусах” гэснийг “дуусаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.1.3 дахь заалт нэмэх:

35.1.3.Шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямбаатар, санал хураалт.

Даваасүрэн гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлье. Санал хураалтыг түдгэлзүүлье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ заалт бол шүүх шинжилгээний байгууллагын юуг урвалж бодисыг шууд хязгаарлагдмал байдлаар тендер шалгалт хийх ийм заалт л даа. Тэгэхээр

энэ дээр би бас нэг гүйцээн боловсруулах чиглэл нэг зүйл дээр авъя гэж ингэж бодоод байгаа юм. Тэгээд энэ ЗГ-аас нэн яаралтай хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрийн бараа, ажил үйлчилгээний тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулах аргыг бас авч үзээч гэж. Ийм санал оруулах. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өгөөд дараагийн Байнгын хорооны хурал дээр санал хураалгая гэж ингэж бодоод байгаа юм.

Өнөөдөр манай улирлын барилгын сезон маш бага богинохон, зураг тендер шалгаруулалт зураг зурах гэсээр байтал 1, 2 сар, шалгаруулах гэсээр байтал хэд хоног, ингээд нөгөө ажлаа хийх гэсээр байтал дахиад 2 сар. Ингээд ерөнхийдөө болбол ажиглаад байхад нэг барилгын ажил бол нэг 7, 8 сард эхлээд л тэгээд нэг 2, 3 сар яваад л дуусчхаж байгаа юм. Тэгэхээр томоохон хэмжээний стратегийн ийм том төслийн ажлууд чинь бол бас 1, 2 жил шаардсан ийм ажлууд болно шүү дээ. Тэгэхээр энэ ажлуудын хувьд бол хэрвээ ЗГ стратегийн ач холбогдолтой гээд байгаа юм. Тэгэхээр энэ чинь бол 1, 2, гуравхан л юм болно шүү дээ. Стратегийн ач холбогдолтой ийм том төсөл хөтөлбөр энэ дээр чиглэл өгөөд орхичхооч ээ.

Л.Мөнхбаатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Энэ 35.1.3 дээр ямар ч тийм гүйцээн болгох чиглэлээр асуудал байхгүй. Даваасүрэн гишүүний гаргаж байгаа чиглэл өгүүлэх гээд байгаа асуудал бол зарчмын хувьд шал өөр, огт өөр асуудал. ЗГ өөрөө, ер нь ингээд хараад байхад ингээд яам болгон энэ тендерийн хууль руу ашиг сонирхлоо шингээх гэж орж ирдэг. Аливаа юмыг харьцуулалтын аргаар эсвэл шууд аргаар хийх гэдэг энэ санаархлаа болих хэрэгтэй. Бүх ажлуудаа өөрсдөө

төлөвлөж оруулж ирэх хэрэгтэй. Төлөвлөөд оруулж ирсэн асуудлуудыг тендер нээлттэй сонгон шалгаруулалтаараа хийгээд явах эрх нь нээлттэй. Тийм учраас энэ харьцуулалтын арга гэнэ үү, шууд аргуудаа ингэж оруулж ирэх гээд байгаа энэ асуудал болохгүй. Тийм учраас энэ асуудал энэ хуулийн төсөлд ч орж ирээгүй, өнөөдрийн энэ яригдаж байгаа энэ зарчмын зөрүүтэй санал дээр ч энэ асуудал хөндөгдөөгүй учраас дэгээ бариад энэ санал хураалтаа хийгээд явах нь зүйтэй л гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Энэ 35 дугаар зүйл дээрх энэ саналыг энэ зарчмын хувьд угаасаа үүнийг уг нь дэмжээд явж байгаа. Нямбаатар гишүүн энэ асуудлыг хөндөж тавьсан санал нь бол ингээд дэмжигдээд явж байгаа, дэмжсэн санал. Энэ дээр Цэрэнпилийн Даваасүрэн гишүүний гаргасан саналыг эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хороо, ажлын хэсэг бас анхаарч үзээрэй гэдгийг чиглэл болгож байна.

Эцсийн хэлэлцүүлгийн хувьд хэлэлцээрэй. Санал хураалт. Томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. 61.5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

36.1.2 Хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгч Олон Улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдах авах бол. Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг. Санал хураалт.

Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлье. Дараа нь хэн юм. Та хэд үг авахаар бол.

Ц.Туваан: Энэ заалтыг манайхан бас хараад дэмжээд өгөөрэй. Тэр нь юу гэхээр энэ эмийн үнэ бол асар өндөр байгаа. Одоо бид нар ковид дээр энэ мэдсэн шүү дээ. Ковидын хуулийн дагуу явсан тэр Ремдесивир гээд хамгийн гол эмийг бид нар 160 мянган төгрөгөөр балконыг нь хэрэглэсэн. Яг шууд худалдан авалт хийгээд яамнаас зохион байгуулаад аваад ирсэн 38 мянган төгрөгөөр буюу 4,2 дахин хямд үнээр аваад ирж болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ заалт бол аягүй чухал.

Сая ингээд ер нь ахмадууд ингээд ярихаар ер нь судалгаа ч гэсэн байлаа шүү дээ. Тэтгэврийнхээ бараг 3-ны 1-ийг нь эмд өгчхөөд байгаа юм. Тэгэхээр бид нар ахмадуудаа яаж тэтгэвэртээ үлдээе гэж бодлого барья гэвэл эмийн үнийг л ярихаас өөр аргагүй болж байгаа юм. Тэгэхгүй бол энэ чинь үнэтэй эмд хамаг тэтгэврийн ахмадуудын мөнгө ингээд яваад байгаа юм.

Энэ дээр байгаа тэр гадаадын байгууллагууд байгаа юм. Үйлдвэрлэгч. Чанартай эм болгон хямд юу үнэтэй байдаггүй, үнэ багатай эм байгаа. Жишээлбэл Новардис компанийн эм гээд бид нар 2 жил ярьсан, 2 жил яриа, 21 нэр төрлийн эм оруулж ирсэн. Энэ нэг долларын үнэтэй эм, бүх эм нь. Хатуу стандарт мөрддөг орны чанар сайтай эм ийм үнэтэй байж болж байгаа юм. Тэгэхээр энэ эмийг бид нар оруулж ирээд үнэгүй эм гээд сумдын аптекаар, аймгийн аптекаар хэрэглээд эхэлчихсэн байхгүй юу. Энэ бас л нэг үр дүн байгаа.

Түрүүн бас тэр Чинзориг сайд хэлсэн. Энэ ОУБ, НУБ-ын хүүхдийн байгууллага дээр чинь бэлхэн платформ нь байж байгаа. Эндээс энэ юу гэдэг юм, шаардлагатай буурай хөгжилтэй ядуу янз бүрийн улсууд чинь эмээ захиалаад аваад байгаа байхгүй юу даа. Тэгээд манайх энд яагаад ороод, эмээ бас авч болохгүй гэж. Тэгэхээр энэ бол маш ийм чухал заалт. Тэгэхээр энэ дээр бол нэг ийм худалдан авалтын асуудал гарч ирэх

байх. Энэ дээр нь тусгай ЗГ дээрээ ч юм уу яриад энэ худалдан авалтыг нь яаж ямар байгууллага яаж зохион байгуулах юм. Хэрвээ бэлэн жишээ гэх юм бол тэр ковидын үед хэрэглэсэн худалдан авалтын жишээ байгаа, хуулийн гаргалгаа.

Дээрээс нь ер нь бол энэ эмийн энэ худалдан авах, эм ханган нийлүүлэх байгууллага энэ тэр дээр бол ер нь бас энэ заалт орчиход бас нэлээн асуудлыг шийдээд явчихна гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр бол манайхан дэмжиж өгөхийг хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Нийтдээ 36 санал хураалт байгаа шүү. Хэн үг хэлэх гээд байгаа билээ. Булгантуяа гишүүн үг хэлье.

Х.Булгантуяа: Засгийн газраас удахгүй энэ эм, эмийн хэрэгслийн тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулж ирж өргөн барих юм шиг байна лээ. Бид нар анх энэ хуулийг бас баталж байхад батлах гээд хэлэлцэж байхад ялангуяа Мөнх-Оргил гишүүн бас энэ асуудлыг нэлээн их ярьж байсан юм. Бид нар дотоодын стандарт гэж бүр оруулж өгсөн байхгүй юу түүн дээр. Манайх үнэнийг хэлэхэд ихэнх эм тариаг өөрснөө үйлдвэрлэдэггүй, гаднын эмийг л оруулж ирж байгаа юм. Тэгэхээр эсрэгээрээ уг нь бол нэг 3.4-хөн сая хүнд гаднын ямар хамгийн өндөр стандарт байна тэрүүгээр л эм оруулж ирнэ гэж зааж өгмөөр байгаа юм л даа. Тэгээд ДЭМБ-ын Жи Эм Пи гээд Гүүд Манифакчерийн практик гээд угаасаа стандарт байдаг. Европын холбоо үүнийгээ хэрэглэдэг юм байна лээ. Тэгээд л ерөөсөө энэ зарим улс орнуудын шууд веб сайт дээр нь байдаг юм байна лээ. Манайхаар бол эм эмийн агентлагийнх нь веб сайт дээр нь, энэ энэ компаниуд жи эм пи стандартад нийцсэн эм оруулж ирдэг үйлдвэрлэдэг тул зөвхөн энэ компаниудын эмийг л манай улс хэрэглэнэ ээ гээд. Тэгээд бараг тэгээд заагаад өгчихмөөр байгаа байхгүй юу. Бид нар Швейцар шиг, Япон шиг,

Солонгос шиг ийм эм хэрэглэмээр байна шүү дээ. Тэгэхэд чинь энэ заалтаар бол нэг их тийм тодорхойгүй шууд гадаадын худалдан авагчаас үйлдвэрлэгчээс нь авч болно гэхээр ямар ч үйлдвэрлэгчээс нь авч болох юм шиг 1 дүгээрт,

2 дугаарт, дээрээс нь нэмээд хэрвээ олон улсын байгууллагууд, ДЭМБ, НҮБ бид нарт ялангуяа өргөн хэрэглэдэг эмүүдийг аваад хямдхан үнээр аваад өгвөл сайн байна. Тэгэхдээ бас тэгэх юм уу, үгүй юм уу. Тэгэхээр үүнийгээ нэг нэлээн тодорхой сайн зааж өгвөл яасан юм бэ? Бүр стандартаа зааж өгвөл яасан юм? Үүн дээр Эрүүл мэндийн сайд ямар саналтай байгаа юм бэ гээд. Энэ дээр асуулт асуух хэцүү л байгаа байх. Тэгэхдээ бид нар дэлхийн хамгийн сайн стандартын эмийг л хэрэглэмээр байна. Тэгээд үүнийг битгий ингэж задгай орхиоч. Тэгэхээр л ахиад л наадах чинь завхрал болно шүү дээ л гэдэг л эмийн эмийн хэрэгслийн тодорхойгүй байдал тэгээд л муу худалдан авалт л явагдана гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Ням-Осорын Учрал гишүүн үг хэлье. Дараа нь Ганболд гишүүн.

Н.Учрал: Энэ хүний эмийн чанар хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл нийлүүлэлтийн асуудлаар Эмийн хяналт шалгалтын түр хороо байгуулагдаад ажилласан. Тэгээд өчигдөр бол түр хорооны хурлыг хийсэн. Тэгээд тайланг бол Их Хуралд танилцуулах ёстой. Тэгэхээр өнөөдрийн байдлаар эмийн бүртгэлд нэг 4213 эм бүртгэлтэй байгаа юм байна. Энэ манай улсын эмийн бүртгэлд байгаа яг стандартын дагуу үйлдвэрлэл явуулж байгаа 9 үйлдвэр байгаа, нийт үйлдвэрийн 32% нь гэсэн ийм статистик байна. Тэгэхээр энэ Чинзориг сайдын оруулаад байгаа энэ зарчмын зөрүүтэй саналууд бол энэ эм үйлдвэрлэлийн худалдан авах ажиллагаанд маш том бас дэвшилийг авчирна гэдэгт би бол

эргэлзэхгүй байгаа юм. Энэ бол томоохон шинэчлэл мөн.

Тэгэхээр 1 санал хэлэх гээд байгаа нь энэ Эмийн чанарын түр хороо ажиллахдаа нөгөө олон улсын чанарт нийцсэн гээд энэ томьёолол нь өөрөө тийм зохимжтой юм уу? Шууд сая Булгантуяа гишүүний хэлснээр тэр Жи Эм Пигийн шаардлага хангасан батламж авсан гээд шууд томьёолчихвол бараг ойлгомжтой болох юм. Тэрийгээ бол эм үйлдвэрлэлийн зохистой дадал гэдэг үгээр нь тавивал яасан юм бэ? Олон улсын гэж байснаас эм үйлдвэрлэлийн зохистой шаардлагын стандартад нийцсэн гэдэг ийм томьёоллыг нь энэ зарчмын зөрүүтэй санал дээрээ тусгаад өгчихвөл бас илүү их дэвшил гарах юм биш үү л гэдэг санааг хэлэх гээд байгаа юм.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой, хүн амын эрүүл мэндийн чанартай холбоотой эмийн зохистой үйлдвэрлэлийн зохистой дадлын шалгуурт нийцсэн гэдэг байдлаар томьёолчихвол илүү их ойлгомжтой болоод энэ худалдан авах ажиллагааны процесс ч гэсэн ойлгомжтой болох юм биш үү?

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир гишүүн сая томьёоллууд яриад байна шүү дээ. Тийм учраас дараа нь үг хэлнэ биз. Одоо Гочоогийн Ганболд гишүүн үг хэлье.

Г.Ганболд: Үгүй ээ, би сая 2 гишүүний хэлж байгааг л яг зөв л гэж үзээд байна л даа. Одоо яг энэ заалтаар явчихвал манай гишүүд зүгээр яах вэ эргээд нэг харчхаарай. Олон улсын чанарын шаардлага хангасан гэх юм болбол манайх бол бүгдийг нь л гаднаас авч байгаа. Тэгэхээр эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл дээр бол дахиж тендер гэсэн ойлголт байхгүй болж байгаа юм. Бүгдийг нь гаднаас гээд л. Хятадынх ч гэсэн олон улсын шаардлага хангасан гээд л эмнэлгийн хэрэгсэл аваад

ирнэ шүү дээ. Тэгэхээр энэ чинь орон нутгууд ингээд нийслэл л нэг ийм тендер зарладаг юм л даа. Чинзориг гишүүнд ч бас хамаагүй л байх зайлуул. Тэгэхдээ үүнийг бол яг оруулж ирвэл уг нь бол Чинзориг гишүүний хэлж байгаа тэр ОУБ-аар дамжуулаад түүний шаардлагыг хангасан гэж ойлгож байсан чинь гадаад улс орны үйлдвэрлэгч гээд таслал тавьчихаар гадаадын үйлдвэрлэгчээс хаанаас ч авч болж байгаа байхгүй юу. Бүгдийг нь шууд худалдан авалтыг нь нээчихэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол саяын гишүүдийн хэлдэг яг тийм олон улсын стандарт байдаг бол тэрийг нь зааж өгөөд энэ шаардлагыг хангасан эмийг шууд худалдаж авна гэх юм бол болж байна, дэмжиж байна. Түүнээс бол зүгээр яг энэ өгүүлбэрээр орчих юм болбол нэг ч тендер зарлагдахгүй. Энд зүгээр л олон улсын шаардлага хангасан гээд л Хятадаас ч бай, Азийн орнуудаас ч бай шаардлага хангасан байх юм бол эмнэлгийн хэрэгслийг ч тэр, эмийг ч тэр био, бэлдмэлийг ч тэр, вакциныг ч тэр бүгдийг нь шууд худалдаж худалдаж авах эрх нь нээгдэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр л уг нь тэр нэг стандарт гэдэг юм нь яг тэр саяынх шиг зааж өгвөл зөв байна аа. Тэгэхгүй бол энэ өөрөө эргээд бид нар бас сайжруулах гэж байгаа нь энэ гээд тэгээд стандартгүй, зүгээр олон улсын чанарын шаардлага хангасан гэдэг чинь өөр ойлголт шүү дээ, энэ чинь худалдан борлуулагдаж байгаа эмүүд нь бүгдээрээ орох юм бол энэ өөрөө завхрал руу явна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир гишүүн хүрээд ирээрэй, хүрээд ир наашаага. Одоо Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

С.Чинзориг: Яах вэ, гишүүдийн саналыг бол би ойлгож байна. Хамгийн гол нь энэ эмийн чанар, үнэтэй холбоотой асуудал дээр л энэ нэлээн том эргэлт авчирна гээд би бас их горьдоод, найдаад байгаа юм л даа. Тэр эмийн олон

улсын чанарын шаардлага хангасан эм эмийн хэрэгсэл гээд ороход бол тэр заавал Энэтхэгийн эмийг авна, заавал Хятадын эмийг авна гээд байх асуудал болбол нэг их эргэлзээд байх юм байхгүй ээ. Ингээд явчихад болбол болох юм байх болохгүй юм бол байхгүй. Одоо манайх чинь бол гаднаас эм, эмнэлгийн хэрэгсэл оруулах эрхтэй 220 ААН байна, 220 ААН байна. Манай эмнэлгүүд эмийн сангууд чинь энэ эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй 220 ААН-ийн оруулж ирсэн эмийг л эндээсээ нэг дотооддоо нэг тендер зарласан болоод л авч байгаа шүү дээ. Одоо бол би энэ ханган нийлүүлэгчийн зөвшөөрөлтэй ААН-үүдийн оруулсан эмийг авахгүй, тэр олон улсын шаардлага стандарт хангасан үйлдвэрээс нь болоод ОУБ-аас нь шууд худалдан авдаг ийм тогтолцоо руу оръё л гэж байгаа юм.

Би бол ний нуугүй хэлэхэд энэ хувийн хэвшлийнхний ханган нийлүүлэгч байгууллагуудын эсрэг асар их эсэргүүцэл ирнэ гэдгийг би бол маш сайн мэдэж байна. Гэхдээ нийт иргэдийн эрх ашгийн төлөө ийм бас тогтолцоог оруулахаас өөр арга байхгүй байгаа юм аа. Гишүүдийн яриад байгаа, болгоомжлоод байгаа асуудлыг бид нар тэр дараагийн санал дээр нь энэ худалдан авахтай холбоотой журмыг ЗГ батална гээд оруулчихсан юм. Энэ дээрээ бид нар яг бас тодорхой заагаад оруулчихаж болно. Бас учиртай юм байна лээ. Жи Эм Пиг стандарт хангасан бол гээд биччихээр үүнийг чинь энэ бидний шүүмжлээд байгаа Зүүн Өмнөд Азийн орнууд чинь бүгд л тэндээс зөвшөөрлийг нь аваад л хийж байгаа. Тодорхой хэмжээний нөгөө оригинал стандартаас нь эмийнхээ найруулгын хүчийг 20%-аар нэмэгдүүлсэн, 20%-аар сулруулсан тийм бас стандарт мөрдөөд ингээд аваад байгаа асуудлууд бий. Миний бодол бол хэрэв энэ дэмжигдэхэд үндсэндээ тэр хатуу зохицуулалттай орнуудын эмийг л импортлодог байх л тийм л бодолтой бол байгаа юм.

Тэгэхээр энэ стандартыг олон улсын стандарт шаардлага хангасан эм гээд эм эмнэлгийн хэрэгслийг явахад болно. Тэгээд гол асуудлыг нь бид нар тэр журмаараа зохицуулах учраас гишүүдийн яриад байгаа тэр асуудлыг журамдаа тусгаад ямар нэгэн эргэлзээгүйгээр хийнэ. Тэрнээс одоо үүнийг нээххээд би тэгээд Хятадын эм оруулаад ирнэ гэж бодохгүй байна. Надад тийм эрх ашиг байх ч үгүй, тийм Хятадын эм, аль болохоор тэр Хятадын эмийг, Энэтхэгийн эмийг чинь л багасгахын тулд л энэ заалт хийж байгаа шүү дээ. Тийм учраас гишүүд энэ дээр ямар нэгэн эргэлзээгүйгээр үүнийг дэмжээд өгчих. Би энэ бол эмийн үнэ чанар дээр асар том эргэлт авчирна л гэж бодож байгаа юм.

Ханган нийлүүлэгч байгууллагуудыг дамжихгүйгээр би шууд худалдан авах эрхийг л авч байгаа тухай асуудал шүү дээ. Тийм учраас энэ бол ямар нэгэн тийм чанар стандарт дээр ямар нэгэн зөрчил гаргахгүй. Энэ бол маш том та бидний яриад байдаг нэг эмийн чанар, үнэтэй холбоотой асуудал дээр маш том эргэлт авчирна л гэж бол бодож байгаа юм.

Л.Мөнхбаатар: Энэ бас чухал асуудал байгаад байгаа учраас бас ярих нь зүйтэй байх. Энэ олон улсын чанарын шаардлага хангасан гэдэг энэ томъёолол чинь яг ямар агуулгатай юм? Эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл худалдан авахтай холбоотой энэ асуудал чинь өөрөө бас яг мэргэжлийн хүмүүсийнх нь үгийг бас томъёолоод сонсчихъё.

Монгол Улсын гавьяат эмч Чинбүрэн гишүүн үг хэлье.

Ж.Чинбүрэн: Хуралдаан даргалагч Мөнхбаатар даргад баярлалаа. Энэ их чухал сэдэв ярьж байна бид. Үнэхээр энэ бол би бол Чинзориг сайдыг дэмжиж байгаа. Энэ бол зөв асуудлыг оруулж ирж байгаа. Тэгэхдээ хэдүүлээ нэг зүйлийг бас энд анхааръя. Яагаад гэхээр

энэ олон улсын шаардлага хангасан гэхээсээ илүүтэй хатуу зохицуулалттай орон гэхих юм бол бид шууд шаардлагаа хамгийн дээд түвшинд шууд тавиад өгчхөж байгаа юм.

2 дахь бид нэг анхаарах ёстой зүйл бол бид ийм шүү дээ, энэ хувийн хэвшлийн хийж байгаа бизнес рүү бид орох гээгүй. Чинзориг сайд энэ дээр бас тодруулж хэлэх хэрэгтэй гэж би бодоод байна. Энэ бол илүү нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа өвчнийг эмчлэх зорилгоор авах гэж байгаа эмүүд байхгүй юу. Түүнээс хувийн хэвшлийнхний бизнесийг булаах гээд л, тэд нарын бизнестэй төр хутгалдах гээд байгаа зүйл биш шүү. Тийм учраас нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал гэдэг үгийг бүр оруулаад, сайн боловсруулаад, найруулаад яачих юм бол энэ болохоор байна. Тэгээд хатуу зохицуулалттай гэж хэлээд тэгээд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал гэдэг энэ 2 өгүүлбэрийг нэмчихвэл тэгээд л ерөөсөө энэ хамгийн дээд зэрэглэлийн эмийг л шууд худалдан авах боломж бүрдэнэ л гэж харж байна.

Эм болгоныг бид жишээлбэл аспириныг нь зөөж яах юм бэ дээ. Үгүй ээ, тэгнэ ээ, тэгж л хардана шүү дээ, наадуул чинь. Хувийнхан чинь тэгж л хардана.

Л.Мөнхбаатар: Энэ гишүүд бас олон талаас нь ярьж байна. Ажлын хэсгийн ахлагчийн та энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авах юм уу, шаардлагагүй байгаа юу гэдгээ та эцэслээд хэлчих. Тэгээд шийдээд явъя. Ажлын хэсгийн ахлагчийнхаар явъя. Сандаг-Очир гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

Ц.Сандаг-Очир: Гишүүдийн яриад байгаа ажлын хэсэг Төсвийн байнгын хороо нэлээн нухацтай авч үзэж, эмийн асуудлыг ингэж тусгайлан оруулж ирж байгаа гэдгийг нэгд хэлье. Бусад өөр ашиг сонирхлын зөрчилтэй саналуудыг бол энэ

тендерийн хуульд тусгамааргүй байна гэдгийг хэлье.

Тэгээд энэ эмтэй холбоотой асуудал маш олон гишүүдээс ярьж байгаа учраас бид нар уян хатан байдлаар энэ тендер шалгаруулалт юман дээр нь төрөөс зөвхөн худалдан авч байгаа асуудал дээр яригдана шүү дээ, Чинзориг гишүүн. Тэрнээс хувийн хэвшлийнхний өөрсдийн оруулж ирж байгаа тэр эмд бол төрөөс ийм хатуу шаардлага тавих тэр бололцоо боломж хязгаарлагдмал.

Нөгөө талаар энэ маш том бололцоо боломжийг нээж өгч байгаа. Олон улсын тэр НҮБ-ын системийн байгууллагуудаас худалдан авч байгаа энэ системд манай улс нэгдээд орох тэр бололцоо боломжийг нээж өгч байгаа. Ингэснээрээ цаашилаад энэ зах зээл дээр хамгийн хямдаар орж ирж худалдаалагдаад байгаа асуудал нэг талаараа цэгцэрнэ. Нөгөө талаараа ахиад энэ эм эмийн эмнэлгийн хэрэгслийн хууль нь боловсрогдож байгаа юм байна лээ. Түүгээрээ энэ гишүүд яриад байгаа юм маш нарийн яг аль заалтын, аль улс орны, ямар тэр өндөр шаардлага, шалгуур хангасан юмыг хэрхэн яаж оруулж ирэх юм, яаж бүртгэж авах юм, тэр нарийн асуудлуудаа яг тэр өөрийнхөө яг тэр салбар хуулиараа нарийн тусгаж оруулж ирэх нь зүйтэй. Энэ хуулиар бол ерөнхий тэр бололцоо боломжийг нь л нээгээд өгч байгаа гэж ойлгож байгаа шүү.

Л.Мөнхбаатар: Тэгвэл санал хураалтаа явуулах юм. Одоо дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлнэ. Сая 3-уулаа 6 хүн үг хэлчихлээ.

Гишүүд үг хэлчхэж дууслаа. Гүйцээн боловсруулах шаардлагагүй гэж үзэж байгаа юм байна. Гүйцээн боловсруулах шаардлагагүй гэж үзэж байгаа юу, тийм үү.

Санал хураалт. Санал
дэмжигдсэнгүй.

Раднаасэд гишүүн зарчмын
зөрүүтэй санал гаргах юм уу, тийм ээ.

Ш.Раднаасэд: Би уул нь нэг санал гаргаад ингээд 6, 7 санал болж, энэ яам, ажлын хэсэг хамтраад нэг юм гарч ирсэн юм байгаа юм. Анх миний гарсан бол хэмнэлттэй гэдэг юм байхгүй хамгийн бага үнийг хэзээ сонгох уу гэдэг ийм юмыг. Тэгээд энэ дотор энэ Чинзориг сайдын яриад байгаагаар бол нэг эх үүсвэрээс авах тийм үү? ДЭМБ болон тэр Хүн амын сангаас авах, вакцин бусад эмийг ингээд авчих юм бол бид нарт 1 дүгээрт баталгаатай гэдэг юмаа энэ дотор хийчихсэн гэж би ойлгоод байгаа байхгүй юу. Үүнийг унагаагаад алга болгочих юм бол нөгөө л яг хуучин хэлбэр лүүгээ бид нар явчхаж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол айх айдасгүйгээр тэр байгууллагуудаас нь, тэр улсаас нь эмийг нь худалдаж аваад тэр дотор чинь зарлагдаж байгаа авах ёстой эмийн үйлдвэрүүд гэдэг нь эм үйлдвэрлэгч улсууд болон эмийн үйлдвэрүүд гэдэг чинь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн юмнууд стандарт байгаа шүү дээ. Би бол тэрийг чинь ингэж ойлгож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ганцхан гадаад улсын үйлдвэрлэгч гэхээр зөвхөн нэг улсаас энэ улсаас л авах юм байна гэдэг юм. Угаасаа энэ тендерийн хуулиар улс заах болон үйлдвэр заахыг хуулиар хориглочихсон. Энэ хуулийн төсөл дээр бүхэлдээ, бүх тендер дээр. Тэгэхээр энэ бол эм дээр ч гэсэн бас үйлчилнэ гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ саналыг гүйцээн боловсруулах чиглэл өг өө, Мөнхбаатар дарга аа. Үгүй ээ энэ болбол таны эрхийн асуудал байхгүй юу, асуух биш. Энэ дээр харин тэр энэ Чинбүрэн гишүүний яриад байгаа тэр нэг ганц нэр томъёоны өөрчлөлтийг нь нэмэн хийчхэж бас болох болов уу гэж бодоод байна.

Л.Мөнхбаатар: Раднаасэд гишүүний асуудлыг ойлголоо. Одоо сая санал хураалт явагдсан учраас горимын санал гаргах гишүүн байгаа юм уу. Горимын санал гаргах гишүүн. Булгантуяа гишүүн горимын санал гаргая. Түүний дараа гүйцээн боловсруулах эсэх асуудлаар ярих боломжтой болно.

Х.Булгантуяа: Үүн дээр яах вэ, Их Хурлын дарга бас, Их Хурлын дэд дарга энэ эм эмийн хэрэгслийн тухай хуулиа ер нь яаралтай шинэчилж сайжруулж оруулж ирээч ээ гээд бас энэ ЭМЯ-нд чиглэл өгөөд, тэгээд үүнийг энэ ОУБ, үйлдвэрлэгч нараас нь гээд энэ чигээр нь байдаг юм уу батлаад явах нь зүйтэй байх. Тэгээд эм эмийн хэрэгслийн хууль дээрээ тэр стандартуудаа чангатгаад сайжруулаад оруулж ирье. Тэгээд бид нар бүгдээрээ л нөгөө эмийн стандарт санаа зовоод л ингэж яриад байна л даа. Хамгийн сайн эм л хэрэглэмээр байгаа юм. Тэрнээс биш өмнөд азийн бүх үйлдвэрлэгч нар дэлхийн сайн эмийг үйлдвэрлэдэггүй. Зарим улс орнуудын бид нарын аваад байгаа улс орнуудын эмийн чинь 10 хүрэхгүй хувь нь ДЭМБ-ын Жи эм Пи стандартад нийцсэн эм үйлдвэрлэдэг юм байна лээ шүү дээ. Тэр чинь ДЭМБ-ын сайт дээр нь байна лээ, тайлангаар. Тэгэхээр э саяын саналыг би нөгөө дэмжсэн чинь эсрэг гарчихлаа. Их Хурлын дэд дарга аа, тэгээд саяын саналыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Булгантуяа гишүүний гаргасан горимын саналаар саяын хураагдсан саналыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя. Гишүүд суудалдаа суугаарай, санал хураалт. 53.8 хувиар санал дэмжигдлээ.

11 дэх санал хураалт хүчингүйд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Раднаасэд, Туваан өөр хэн Учрал гишүүн үг хэлсэн, Чинбүрэн гишүүн үг

хэлсэн. Эдгээр гишүүдийн саналыг харгалзан үзээд энэ 11 дэх санал буюу 36 дугаар зүйлийг эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Дараагийн санал хураалтад орно.

12.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

36.4 Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална. Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг.

Энэ 36-тай хамтатгаад гүйцээн боловсруулах чиглэлийг мөн өгч байна. Хоорондоо уялдаатай заалт байгаа юм байна.

13.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх заалтын “банкны” гэсний дараа “эсхүл Монгол Улсын даатгагчийн” гэж нэмэн үүнтэй уялдуулж 42.3.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

43.1.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө. Санал гаргасан ажлын хэсэг, Санал хураалт. 64.1 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “энэ хуульд заасан” гэснийг “Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна” гэж, мөн зүйлийн 49.4.5 дахь заалтын “үйл ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах

гэснийг ашиглалт худалдан авах ажиллагааны талаар” гэж өөрчлөн, мөн зүйлийн 49.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

49.4.1 Цахим системийн үйл ажиллагаа худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч оролцогчийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах. Санал гаргасан ажлын хэсэг, Санал хураалт. 61.5 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.10 дахь заалтын “судалгаанд үндэслэн” гэснийг хасаж, мөн заалтын ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж бүрийн доод хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах гэсэн чиг үүргийг 49.4.11 дэх заалт болгон салгаж, үүнтэй уялдуулан мөн заалтын “судалгаа хийж” гэснийг “судалгаа хийх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61.5 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.11 дэх заалтын дугаарыг 49.4.12 гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

49.4.12 Энэ хуульд заасан баталгааг цахим системээр гаргах эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 69.2 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсгийн “өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг” гэснийг энэ хуулийн 49.4.5, 49.4.8, 49.4.10-д заасан чиг үүргийг гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүд сууж, саналаа өгөөрэй. 59 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.8.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

49.8.3 Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 49.4.10-д заасан судалгаа хийх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 64.1 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доош дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7 50.8 дахь хэсгийг хасах.

50.5 үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага төрийн бус байгууллагын төлөөллийг нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6.Үнэлгээний хороонд тухайн бараа ажил үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтыг түдгэлзүүлье.
Батлут гишүүн үг хэлье.

Д.Батлут: Энэ 50.5 дээр нэг үг орчихсон байна л даа. Энэ үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг нийслэл болон улсын зэрэглэлтэй хот гээд оруулчихсан байх юм. Улсын зэрэглэлтэй хот гэсэн статус байхгүй байгаа. Хэрвээ улсын зэрэглэлтэй хот бий болно гэх юм бол Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудал яригдана бас. Тэгэхээр ингэж байхгүй байгаа статусыг оруулж болох юм уу, энэ хууль дээр. Тийм. Тэгэхээр энэ улсын зэрэглэлтэй хот гэдгээ хасчих хэрэгтэй байх. Улсын зэрэглэлтэй хот нь

Үндсэн хуулийн өөрчлөлтөөрөө батлагдсаны дараа бол харин энэ үг энэ хууль дээр өөрчлөлт оруулаад явах боломжтой байх л гэж харж байна.

Л.Мөнхбаатар: Батлут гишүүний гаргасан санал бас үндэслэлтэй байна. Ийм учраас 2 дахь санал буюу төслийн 50.5 дээр гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Цаашаа явъя.

21.Төслийн 50 дугаар зүйлийн 50.15 дахь хэсгийн “урамуулал олгох мэргэшсэн ажилтан бэлтгэх” гэснийг “үнэлгээний хорооны гишүүнд урамуулал олгохтой холбогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 64.1 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 56 дугаар зүйлийн 56.10 дахь хэсгийн “байцаагчид гаргана.” гэснийг “байцаагчид гаргаж болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.69.2 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “гэрээ байгуулах эрх олгохгүй” гэснийг “энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гаргахгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 64.1 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 2023 оны ... дугаар сарын ... өдрөөс гэснийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 12 сарын 01-ний өдрөөс хэрэгжих юм байна. 66.7 хувиар санал дэмжигдлээ.

25.Төсөлд зүйл хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан төслийн холбогдох зүйл хэсэг заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх мөн төслийн үг хэллэг, нэр томъёог жигдлэх, засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61.5 хувиар санал дэмжигдлээ.

26.Найруулгын санал байна. Энэ найруулгын саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “*өргөтгөх,*” гэсний дараа “*буулгах,*” гэж, 56 дугаар зүйлийн 56.5.3 дахь заалтын “*хохирол*” гэсний дараа “*барагдуулахыг*” гэж, 56.11 дэх хэсгийн “*байцаагч*” гэсний дараа “*энэ хуулийн 56.10-т заасан*” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “*хөгжлийн болон хүнд,*” гэснийг “*хөгжлийн, хүнд болон*” гэж, мөн зүйлийн 8.4.3, 8.7.1 дэх заалтын “*хотод хамаарахгүй*” гэснийг “*хотоос бусад харьяалалтай*” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “*аргад үндэслэн*” гэснийг “*аргаар*” гэж, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “*нууцалж, бусад хэсгийг ил болгохоор*” гэснийг “*энэ хуулийн 29.2-т зааснаар ил болгохгүйгээр*” гэж, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “*Засгийн газрын баталсан жагсаалтад*” гэснийг “*энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад*” гэж, 49 дүгээр зүйлийн 49.4.9 дэх заалтын “*дүгнэлт*” гэснийг “*дүн шинжилгээ*” гэж, 49.8.1 дэх заалтын “*хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж,*” гэснийг “*хууль тогтоомжийн хэрэгжилтийн*” гэж, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “*зааснаар улсын байцаагчийн гаргасан санал, дүгнэлтийг*” гэснийг “*заасан дүгнэлт, зөвлөмжийг*” гэж, мөн хэсгийн “*биелэлтийн талаар*” гэснийг “*дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар*” гэж, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “*сонирхолтой*” гэснийг “*хохиролтой*” гэж, төслийн 9, 37, 45, 49, 53, 54, 58 дугаар зүйлийн гарчиг болон холбогдох хэсэг, заалтад тусгагдсан худалдан авах ажиллагааны болон өрсөлдөөний асуудал “*эрхэлсэн*” гэснийг тохиолдол бүрд “*хариуцсан*” гэж, төсөлд тусгагдсан “*энэ зүйлийн*” гэснийг тохиолдол бүрд “*энэ хуулийн*” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “*уг ажиллагаанд*” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтын “*эрх бүхий*” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх

заалтын эшлэлийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “*тохиолдолд*” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсгийн “*санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон*” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.2.13 дахь заалтын “*эрх, үүрэг*” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.4.14 дэх заалтын “*чиг үүрэг*” гэснийг, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “*болон бусад*” гэснийг, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “*зохих*” гэснийг, 55 дугаар зүйлийн 55.1.7 дахь заалтын “*тоо баримт,*” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.8, 56.12 дахь хэсгийн “*худалдан авах ажиллагааны*” гэснийг болон 56.8 дахь хэсгийн “*тушаал гаргаж,*” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2 дахь асуудал байна. Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал байгаа.

Энэ дээрээс Раднаасэд гишүүн саналаа татаад авчихсан. Мөнхцэцэг гишүүний санал байна. Тийм ээ.

Би саналын томъёоллыг уншаад танилцуулчихъя. Тэгээд Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн саналаа тайлбарлаж үг хэлэх юм байна.

Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын Төрийн гэсний дараа болон орон нутгийн гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гомбилдоогийн Мөнхцэцэг.

Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн үг хэлье.

Г.Мөнхцэцэг: Энэ санал өөрөө ингээд уначихсан юм байна, Байнгын хороон дээр, юун дээр ажлын хэсэг дээр уначихсан юм байна лээ. Тэгээд энэ 36.1.5 дээр байгаа юм. Төрийн өмчийн музей болон галерейн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор соёлын өв, дурсгалт зүйлийг нэг өмчлөлөөс худалдан авах шаардлага үүсвэл ингээд зөвхөн төрийн өмчийн музейд үзмэр худалдаж авах ийм эх

үүсвэр нээгдэнэ гээд. Энэ дээр орон нутгийн өмчийн музейг нэмэх шаардлагатай байгаад байгаа юм. Манай гишүүд бас хөдөө орон нутагтаа очоод ажилладаг байлгүй. Хөдөө орон нутгийнхаа музейнүүдийг хэр үзэж хардаг юм байгаа юм, ямар ч байсан очдог байлгүй. Ер нь орон нутгийн музей гэдэг бол тэр тухайн аймаг, сумын бол өв, түүх, соёлын бараг тэгээд том цом төв байдаг. Тэгэхээр энэ музейн үзмэрүүдийг бид нар бас худалдан авалтаар баяжуулахгүй бол музей, хөдөө орон нутгийн музейнүүд маань аль тэр дээр үеийнх нь л баяжилтаар ингээд л нэг хэдэн үзмэртэйгээ байж байдаг.

Тэгэхээр энэ заалт дээр орон нутгийн өмчийн музей гэдэг энэ үгийг нэмэх хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр гишүүд үүнийг дэмжиж өгөөч. Энэ кноптоо хүрэхгүй байж байж, хүрэхгүй байж байж дэмжиж өгөөч гэж та бүгдээс хүсэх гэсэн юм. Угаасаа энэ музейн тухай хууль 2021 онд батлагдсан. Энэ хуулиар ч гэсэн тэгш ердөө харилцаатай байна гээд ингээд заачихсан байдаг. Энэ заалтууд бас зөрчигдөөд байгаа юм. Тэгээд ер нь бол байна шүү дээ. Яг төрийн өмчийн музей бол Монгол Улсын хэмжээнд 11 л байгаа. Монгол Улсын үндэсний музей байна, Дүрслэх урлагийн музей байна, Богд хааны музей гээд. Орон нутгийн музей бол 24 байгаа. Бүх аймагт, бүх сумдад байж байгаа учраас энэ орон нутгийн музейн баяжилтыг бас нэмж өгөх тал дээр энэ заалтыг нэмж оруулж өгөөч гэдэг ийм саналыг оруулсан юм байгаа юм. Тэгээд уначихсан. Тэгэхээр энэ кноптоо хүрэхгүй байж байгаад энэ саналыг дэмжээд өгөөч гэж та бүгдээс хүсэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлаж үг хэллээ.

Одоо санал хураалтыг явуулна. Гишүүд суудлаа эзлээрэй.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал явуулна. Хэрвээ та бүхэн дэмжих юм бол Төсвийн байнгын хорооны санал дэмжигдэнэ, кноптоо хүрэхгүй байх юм бол Мөнхцэцэг гишүүний санал дэмжигдэх нь байна. Санал хураалт.

17.5 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэгийн гаргасан зарчмын зөрүүтэй санал бол дэмжигдэж байна гэж ойлгох хэрэгтэй.

Дараагийнхаа санал хураалтад оръё.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга. Энэ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн мөрдөгдөхөөс гэснийг болохоос гэж, 2 дугаар зүйлийн бүртгэлд бүртгэгдсэн этгээд бүртгэлийн үлдсэн хугацаагаар Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. Одоо энэ шинэчилсэн найруулгыг хэлж байна. Хуулийн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэлтэй гэснийг бүртгэл хүчинтэй хэвээр гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хоёр.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 34 дүгээр зүйлд гэснийг 33 дугаар зүйлд гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67.5 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Хуулийн төслийн нэрийн хуульд өөрчлөлт оруулах гэснийг хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дөрөв.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Хуулийн төслийн нэрийн хуульд өөрчлөлт оруулах гэснийг хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 67.5 хувиар санал дэмжигдлээ.

Тав.Монгол Улсын Ерөнхийлөгч жилийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Хуулийн төслийн нэрийн хуульд өөрчлөлт оруулах гэснийг хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Хуулийн төслийн нэрийн хуульд өөрчлөлт оруулах гэснийг хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох гэж

өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүд сууж саналаа өгье. Учрал гишүүн сууя. 65 хувиар санал дэмжигдлээ.

Долоо.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Хуулийн төслийн нэрийн хуульд өөрчлөлт оруулах гэснийг хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, үүнтэй уялдуулан төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “62.1.5 дахь” гэснийг “62.1.4 дэх” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг 4 гэж, төслийн нэрийн нэмэлт гэснийг нэмэлт, өөрчлөлт гэж, мөн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 112 дугаар зүйлийн 112.10 дахь хэсгийн цахимаар татан авч гэснийг цахимаар авч гэж тус тус өөрчлөх, 3 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтын дугаарыг 62.1.5 гэж өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Гишүүд ээ, саналаа өгөөрэй. 67.5 хувиар санал дэмжигдлээ.

Ес.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2, 3 дугаар зүйлийг хасаж, 4 дүгээр зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх. 1 дүгээр зүйл.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн томилон гэснийг сонгон шалгаруулна гэж өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Арав.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг болон төслийн нэрийн нэмэлт гэснийг тус тус хасаж, үүнтэй уялдуулан 2, 3 дугаар зүйлийн дугаарыг 1, 2 гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Арван нэг.Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 6-гийн иттрих 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6-гийн иттрих 1.6.4 дэх хэсэг нэмсүгэй, 6-гийн иттрих 4 Даатгагч төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гаргах баталгааны үнийн дүн. Даатгалын нөөц сангийн энэ хуулийн 6-гийн иттрих 1-д заасан баталгаанд хамаарах эрсдэлийн сангаас хэтэрсэн бол давхар даатгалд хамрагдаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байхыг шаардана. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Чуулганы өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна.

Маргааш өглөө 9 цагаас Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

12 цагаас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаантай.

Үүнд гишүүд бэлэн ирэхийг хүсье.

Ажлын хэсэгт баярлалаа.

20.26 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ